



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВРЫН
ҮНЭЛГЭЭ**

2025

Судалгааны тайлан

Улаанбаатар хот

Судалгааг захиалагч:

Онцгой байдлын ерөнхий газар

Судалгааг хянасан:

Б.Өлзийсайхан

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
захирал, хууль зүйн доктор, профессор

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Энх-Амгалан

Хүний эрх, олон улсын эрх зүйн
секторын эрхлэгч

Б.Ариунжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын эрхлэгч

С.Нарантунгалаг

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Д.Дэмидханд

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
УДИРТГАЛ.....	7
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....	9
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	9
1.2. Үнэлгээ хийх хүрээ.....	10
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	12
1.4. Харьцуулах хэлбэр	15
1.5. Шалгуур үзүүлэлтийн томьёолол.....	16
1.6. Мэдээлэл цуглуулах арга	23
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	24
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	25
3.1. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт	26
3.2. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа	42
3.3. Гамшгийн үеийн үйл ажиллагаа.....	62
3.4. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт.....	67
3.5. Хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, хариуцлага	83
3.6. Гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж	87
3.7. Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал	92
3.7.1. Онцгой байдлын байгууллагын эрх зүйн байдал.....	92
3.7.2. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал	127
3.8. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт	167
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	175
4.1. Дүгнэлт, санал	175
4.2. Зөвлөмж	199
ЭХ СУРВАЛЖ.....	201

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ГАБТХ	Галын аюулгүй байдлын тухай хууль
ГХТХ	Гамшгаас хамгаалах тухай хууль
ЗТХ	Зөрчлийн тухай хууль
ЗШШТХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
МУИХТХ	Монгол Улсын Их Хурлын тухай хууль
МУЗГТХ	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
НОК	Нийслэлийн онцгой комисс
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОББ	Онцгой байдлын байгууллага
ОБТХ	Онц байдлын тухай хууль
ОК	Онцгой комисс
ХТТХ	Хууль тогтоомжийн тухай хууль
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭХ	Эрүүгийн хууль

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үнэлгээ хийх хуулийн зохицуулалт	11
Хүснэгт 2. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал.....	13
Хүснэгт 3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийн томъёолол.....	16
Хүснэгт 4. Хууль дахь “Гамшиг” хэмээх нэр томъёоны хэрэглээ.	27
Хүснэгт 5. Анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед иргэдийн хайхрамжгүй байдлаас үүдэн гарсан дуудлага мэдээлэл	36
Хүснэгт 6. Гамшгаас хамгаалах сургалтын ангилал, сургалт зохион байгуулах байгууллага, албан тушаалтан.....	43
Хүснэгт 7. Монгол Улсад бүртгэлтэй ААНБ-ын тоо	52
Хүснэгт 8. Гамшгийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ	56
Хүснэгт 9. Бүх нийтийн бэлэн байдал зарласан тохиолдол	58
Хүснэгт 10. Хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн харьцуулалт	70
Хүснэгт 11. Онцгой комиссын чиг үүрэг.....	71
Хүснэгт 12. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага	72
Хүснэгт 13. Дүрэм, журмыг батлах бүрэн эрх	75
Хүснэгт 14. ГХтХ-д заасан журмын жагсаалт	76
Хүснэгт 15. Чиг үүргийн тодорхой байдал	79
Хүснэгт 16. Чиг үүргийн тухай тодорхой бус зохицуулалт	81
Хүснэгт 17. ГХтХ дахь олон улсын харилцаатай холбоотой хэм хэмжээ.....	106
Хүснэгт 18. ГХтХ-ийн алба хаагчийн хувцастай холбоотой хэм хэмжээ.....	139
Хүснэгт 19. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт-харьцуулалт...168	

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага	69
Зураг 2. Монгол Улс дахь Хүмүүнлэгийн тусламжийн багийн бүтэц.	90

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд “Монголын ард түмэн бид: ... хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, ... хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.”, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4 дүгээр хэсгийн 4.4.4.14-т *“Гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулна.”* гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 181 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхээр тусгасан байна.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсонтой холбогдуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахтай холбоотой асуудлыг суурь хуулиар зохицуулах, түүнчлэн цар тахлын нөхцөл байдал гэнэт үүссэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуульд 2020 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн улмаас үүссэн давхардал, хийдэл, зөрчлийг засаж залруулах нь тухайн хуулийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагын нэгээхэн хэсэг юм.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх”, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт *“Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.”* гэж заасныг тус тус үндэслэж 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж

байгаа Гамшгаас хамгаалах тухай хууль¹-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв.

Гамшгаас хамгаалах тухай хуульд 2020-2024 оны хооронд жил бүр (хуульд нэмэлт оруулах тухай хууль-3, хуульд өөрчлөлт оруулах тухай хууль-3, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль-5, хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль-1) нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу 2020 онд 134 хэм хэмжээ, 2021 онд 14 хэм хэмжээ, 2022 онд 8 хэм хэмжээ, 2023 онд 6 хэм хэмжээ, 2024 онд 1 хэм хэмжээнд нэмэлт, өөрчлөлт орсон байх тул тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх, цаашид бэхжүүлэх, шаардлагатай бол боловсронгуй болгох, үр нөлөөтэй хэрэгжих хувилбарыг нээн илрүүлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Судалгааны зорилго. Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, тодорхой шалгуур үзүүлэлтэд үндэслэн дүгнэлт гаргах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны арга зүй. Судалгаанд асуулгын болон баримт бичгийн судалгааны арга, харьцуулалтын арга, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, хууль зүйн техник, хууль тайлбарлах зэрэг судалгааны аргыг ашиглав. Үнэлгээ хийхдээ Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ыг ашигласан.

Судалгааны хамрах хүрээ. Холбогдох онол, арга зүй, туршлагад тулгуурлан холбогдох олон улсын эрх зүйн баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, илтгэл, зөвлөмж зэрэг эх сурвалж, Монгол Улсын болон гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд судаллаа. Гамшиг судлалын онолын асуудлыг тус судалгааны тайланд хамруулаагүй боловч хууль зүйн бодлого тодорхойлоход дэмжлэг үзүүлэх хүрээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн болон онцгой байдлын байгууллагын алба хаагчдын үзэл бодлыг нэгтгэн дүгнэх, өмнө судлагдсан үр дүнг тусгах, судлагдаагүй орон зайг хөндөх зэрэг бүтээлч хандлага баримтлав.

Судалгааны ажлын хүрсэн үр дүн. Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, тодорхой шалгуур үзүүлэлтэд үндэслэн дүгнэлт гаргаж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох ажилд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулав.

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017 оны 02 дугаар сарын 17) №07 /964/.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- 1) Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- 2) Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- 3) Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- 4) Харьцуулах хэлбэрийг сонгох;
- 5) Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- 6) Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдох үер, зуд, салхи шуурга, ой, хээрийн түймэр зэрэг байгалын аюулын давтамж нэмэгдэхээс гадна олон улсын хөл хориот хүн, малын гоц халдварт өвчний шинэ төрлийн аюулууд тохиолдож, олон хүний амь нас эрсдэж, мал, амьтан ихээр хорогдож, эд хөрөнгө сүйрч, улс орны нийгэм, эдийн засагт их хэмжээний хохирол учирч байна. Тодруулбал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн тоо 2015 онтой харьцуулахад 2024 онд 4.8 дахин нэмэгдсэн.

Монгол Улсын хэмжээнд 2014-2024 онд нийт 50215 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 4491 хүн /КОВИД19-1815/ амь насаа алдаж, 991308 хүн /КОВИД19-989816/ гэмтэж бэртэн, өвчилж, 11.5 сая толгой мал, амьтан хорогдож, 544.3 тэрбум төгрөгийн шууд хохирол учирчээ.

Дэлхий нийтэд тохиолдсон коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улс коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой түр хуулийг 2020 онд батлан хэрэгжүүлсэн. Тус хуулийн үйлчлэх хугацаа 2022 онд дуусгавар болсноор цаашид гарч болзошгүй томоохон цар хүрээтэй гамшгийн үед нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг зохицуулах эрх зүйн орчин тодорхойгүй болсон.

Уур амьсгалын өөрчлөлтөөс бий болж буй шинэ нөхцөлд нийцэж амьдрах, дасан зохицох, олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, салбар дундын харилцан ажиллагаа, удирдлага, зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах, гамшгийн улмаас иргэд, тэр дундаа эмзэг бүлгийн иргэдийн эрх чөлөөг хангах, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хариуцлагыг нэмэгдүүлэх замаар гамшиг, ослыг аль болох хохирол багатайгаар даван туулах, гамшигтай тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага улам бүр чухлаар тавигдаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.4.14 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.3 дахь хэсгийн 20 дахь заалтыг үндэслэн Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага үүсэж байна.²

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Засаглалын талаар баримтлах бодлогын 5.4 дэх зорилтын хүрээнд 2050 он гэхэд “төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа сайжирч, амьдралын баталгаа бүрэн хангагдсан байна” гэж заасан. Үүний хүрээнд онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, эрх, үүрэг, ажиллах нөхцөл (тусгай зориулалтын хувцас, хэрэгсэл, алба хаагч үүрэг гүйцэтгэх үеийн хэрэгцээнд зориулсан нөөц бүрдүүлэлт, хангамж), нийгмийн баталгааг сайжруулах эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага бас бий.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэж тусгасан. Гамшгаас хамгаалах тухай хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 8 жилийн хугацаа өнгөрсөн тул хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх хуульд заасан хугацааны шаардлагыг хангаад зогсохгүй хугацааг нэлээд хэтрүүлсэн гэж хэлж болно.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.” гэж заасан нь хууль зүйн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох зарчим юм.

Энэхүү судалгаа Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар, нийгэмд үзүүлж байгаа эерэг болон сөрөг нөлөөллийг илрүүлэх, тулгамдсан хүндрэл, бэрхшээлтэй асуудал, шийдвэрлэх болон үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг дэвшүүлэхэд чиглэсэн. Ингэхдээ хамрах хүрээний хувьд захиалагч талаас өгсөн судалгааны чиглэл буюу практикт тулгарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг түлхүү хөндөхийг эрмэлзсэн болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлахад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.” гэж заасан. Ингэхдээ үнэлгээ хийх болсон шалтгаануудтай харилцан уялдаа, хамааралтай байдлыг харгалзаж, хуулийн

² Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны ажлын даалгаврын “Үндэслэл” хэсэг.

хэрэгжилтэд гарч буй эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон зохицуулалтыг сонгож, Гамшгаас хамгаалах тухай хуулийн зорилт, түүний дотор гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий заалтуудаар үнэлгээний хүрээг тогтоохыг зорьсон болно. Иймд тус хуулийн дараах зүйл, хэсэг, заалтад үнэлгээ хийж, хуулийг боловсронгуй болгоход чиглэсэн хуулийн төсөл боловсруулах ажлын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай гэж үзэв.

Хүснэгт 1. Үнэлгээ хийх хуулийн зохицуулалт

Д/д	Бүлгийн нэр	Үнэлгээ хийх зүйл
1.	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
2.	Хоёрдугаар бүлэг Гамшгийн өмнөх үйл ажиллагаа	7 дугаар зүйл. Гамшгийн эрсдэлийг үнэлэх 8 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх 9 дүгээр зүйл.Гамшгийн эрсдэлийг бууруулах 10 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах 11 дүгээр зүйл.Бэлэн байдлын зэрэгт болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэх 12 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх 13 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах
3.	Гуравдугаар бүлэг Гамшгийн үеийн үйл ажиллагаа	15 дугаар зүйл.Гамшгийн үеийн үйл ажиллагаа 16 дугаар зүйл.Гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах 18 дугаар зүйл.Эрэн хайх, аврах 19 дүгээр зүйл.Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх
4.	Тавдугаар бүлэг Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага	22 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт 23 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага 24 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл
5.	Зургадугаар бүлэг Гамшгаас хамгаалах удирдлагын бүрэн эрх	27 ¹ дүгээр зүйл.Онцгой комиссын бүрэн эрх 28 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх 29 дүгээр зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 30 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх 33 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг
6.	Долдугаар бүлэг Хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг	34 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг 35 дугаар зүйл.Төрийн бус байгууллагын эрх, үүрэг 36 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг 37 дугаар зүйл.Иргэний эрх, үүрэг
7.	Наймдугаар бүлэг Гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж	38 дугаар зүйл.Дотоодын хүмүүнлэгийн тусламж 39 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламж 40 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт

8.	Есдүгээр бүлэг Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал	42 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоо 43 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдэг 44 дүгээр зүйл. Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэг 45 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагч 46 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцас, цол, таних тэмдэг 47 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх 48 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүрэг 49 дүгээр зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох тэтгэвэр, тэтгэмж 50 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа
9.	Аравдугаар бүлэг Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт	51 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход хэрэглэх шалгуур үзүүлэлтийн жагсаалтыг тусгасан. Эдгээр шалгуур үзүүлэлтээс “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал” болон “Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийг тус тус сонгов.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт нь харьцангуй хийсвэр мэт боловч хуулийн үйлчлэлийн үр нөлөөнд ерөнхий дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй.

Хууль тогтоох эрх бүхий байгууллагаас баталж буй хууль тогтоомж нь нийгмийн тодорхой харилцааг бүрэн зохицуулснаар аливаа эрх зүйн хийдэл үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлдэг. Үүнтэй холбоотойгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.3 дахь заалтад хуулийн төслийн эх бичвэр нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад холбогдох баримт бичгүүдэд нийцсэн байхаас гадна тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх шаардлагыг тавьсан. ГХтХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, ОББ болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан тул энэ хуулийн зохицуулах шаардлагатай харилцааг хуулийн бусад зүйл, хэсэг, заалтаар бүрэн илэрхийлж, тусгасан эсэхийг “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтээр тогтоох юм.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Аргачлалд заасан уг шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний эерэг болон сөрөг үр дагаврыг илрүүлж, практикт хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэнэ. Практикт хуулийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, тухайлбал, хуулийг хэрэгжүүлэх этгээдэд хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байдаг эсэхийг шалгаж тооцно.

“Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Аргачлалын “Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлт нь урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагавар байж болохыг тооцоолно. Гамшгаас хамгаалах тухай хуулийн үйлчлэх хүрээ, зорилт зэрэг зарим зохицуулалтын хувьд хууль батлах үед тооцоогүй болон хожим шинээр гарсан, цаашид үүсэх харилцаа, үр дагавар байгааг анзаарч судалгаанд хамруулсан бүтээлч хандлага гэж хэлж болно.

Дээр дурдсан гурван шалгуур үзүүлэлтийг үнэлгээ хийх зүйл, хэсэг, заалтын агуулгаас хамаарч дараах байдлаар сонгов.

Хүснэгт 2. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

Д/д	Бүлгийн нэр	Үнэлгээ хийх зүйл	Шалгуур үзүүлэлт
1.	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ	Зорилгод хүрсэн түвшин Бусад үр дагавар
		4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал
2.	Хоёрдугаар бүлэг Гамшгийн өмнөх үйл ажиллагаа	7 дугаар зүйл. Гамшгийн эрсдэлийг үнэлэх	Практикт нийцэж байгаа байдал
		8 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх	Практикт нийцэж байгаа байдал
		9 дүгээр зүйл.Гамшгийн эрсдэлийг бууруулах	Практикт нийцэж байгаа байдал
		10 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах	Практикт нийцэж байгаа байдал
		11 дүгээр зүйл.Бэлэн байдлын зэрэгт болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэх	Практикт нийцэж байгаа байдал
		12 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх	Практикт нийцэж байгаа байдал
		13 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах	Зорилгод хүрсэн түвшин
3.	Гуравдугаар бүлэг Гамшгийн үеийн үйл ажиллагаа	15 дугаар зүйл.Гамшгийн үеийн үйл ажиллагаа	Зорилгод хүрсэн түвшин
		16 дугаар зүйл.Гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах	Зорилгод хүрсэн түвшин
		18 дугаар зүйл.Эрэн хайх, аврах	Зорилгод хүрсэн түвшин
		19 дүгээр зүйл.Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх	Зорилгод хүрсэн түвшин

4.	Тавдугаар бүлэг Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага	22 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт	Зорилгол хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал
		23 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага	Зорилгод хүрэх түвшин Практикт нийцэж байгаа байдал
		24 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл	Практикт нийцэж байгаа байдал
5.	Зургадугаар бүлэг Гамшгаас хамгаалах удирдлагын бүрэн эрх	27 ¹ дүгээр зүйл.Онцгой комиссын бүрэн эрх	Практикт нийцэж байгаа байдал
		28 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх	Практикт нийцэж байгаа байдал
		29 дүгээр зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	Практикт нийцэж байгаа байдал
		30 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх	Практикт нийцэж байгаа байдал
		33 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг	Практикт нийцэж байгаа байдал
6.	Долдугаар бүлэг Хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг	34 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг	Зорилгод хүрсэн түвшин
		35 дугаар зүйл.Төрийн бус байгууллагын эрх, үүрэг	Зорилгод хүрсэн түвшин
		36 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг	Зорилгод хүрсэн түвшин
		37 дугаар зүйл.Иргэний эрх, үүрэг	Зорилгод хүрсэн түвшин
7.	Наймдугаар бүлэг Гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж	38 дугаар зүйл.Дотоодын хүмүүнлэгийн тусламж	Зорилгод хүрсэн түвшин
		39 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламж	Зорилгод хүрсэн түвшин
		40 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал
8.	Есдүгээр бүлэг Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал	42 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоо	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал Бусад үр дагавар
		43дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдэг	Зорилгод хүрсэн түвшин

		44 дүгээр зүйл.Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэг	Зорилгод хүрсэн түвшин
		45 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагч	Практикт нийцэж байгаа байдал Бусад үр дагавар
		46 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцас, цол, таних тэмдэг	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал
		47 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал
		48 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүрэг	Практикт нийцэж байгаа байдал
		49 дүгээр зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох тэтгэвэр, тэтгэмж	Практикт нийцэж байгаа байдал
		50 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал
9.	Аравдугаар бүлэг Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт	51 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт	Практикт нийцэж байгаа байдал

1.4.Харьцуулах хэлбэр

Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дараах харьцуулах хэлбэрийг сонгож судалгаанд ашигласан. Үүнд:

- 1. Байх ёстой болон одоо байгаа:** Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг хуулиар тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.
- 2. Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш:** Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах нөхцөл байдал буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийнэ.

3. **Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш:** Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нөхцөл байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэнэ.
4. **Тохиолдол судлах:** Хуулийн зүйл, хэсэг, заалттай ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ.

Эдгээр харьцуулах хэлбэрийг сонгож судлах нь ГХтХ-ийг боловсронгуй болгох ажлын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай гэж үзэв.

1.5.Шалгуур үзүүлэлтийн томьёолол

Үнэлгээнд сонгосон шалгуур үзүүлэлт/“Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал”, “Бусад үр дагавар”/ -д тулгуурлан тодорхой таамаглалыг дэвшүүлэх болон асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтийн томьёолол боловсруулсан. Энэ нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг бодитой үнэлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хүснэгт 3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийн томьёолол

Д/д	Үнэлгээ хийх зүйл	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн томьёолол
Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл			
1.	3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ	Бусад үр дагавар	- Гамшгаас хамгаалах албаны зохицуулалт хуульд хангалттай тусгагдсан эсэх (3.1) - “Нэр томьёо” хэсэг бүрэн, боловсронгуй зохицуулагдсан эсэх
2.	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт	Зорилгод хүрэх түвшин Практикт нийцэж байгаа байдал	- Хуульд “гамшиг”, “аюулт үзэгдэл”, “осол”, “аюул” зэрэг нэр томьёог оновчтой тодорхойлсон эсэх (4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.5) - Хүч хэрэгсэл дайчлан гаргах харилцаанд хүндрэл, бэрхшээл бий эсэх (4.1.13) - Мэргэжлийн ангитай холбогдох эрх зүйн зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх (4.1.17) - “Бэлэн байдал” гэсэн ойлголтыг оновчтой тодорхойлсон эсэх (4.1.24)
Хоёрдугаар бүлэг. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа			
1.	7 дугаар зүйл. Гамшгийн эрсдэлийг үнэлэх	Практикт нийцэж байгаа байдал	- Гамшгийн эрсдэлийг үнэлэх болон гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж

			байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх
2.	8 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх	Практикт нийцэж байгаа байдал	- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх болон гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх
3.	9 дүгээр зүйл.Гамшгийн эрсдэлийг бууруулах		
4.	10 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах	Практикт нийцэж байгаа байдал	- Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах болон бэлэн байдлын зэрэг ба олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? - Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх
5.	11 дүгээр зүйл.Бэлэн байдлын зэрэгт болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэх		
6.	12 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх	Практикт нийцэж байгаа байдал	- Гамшгийн эрсдэлийг үнэлэх болон гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх
7.	13 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах	Зорилгод хүрсэн түвшин	- Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх
Гуравдугаар бүлэг. Гамшгийн үеийн үйл ажиллагаа			
8.	15 дугаар зүйл.Гамшгийн үеийн үйл ажиллагаа	Практикт нийцэж байгаа байдал	- Гамшгийн үеийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх
9.	16 дугаар зүйл.Гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах		
10.	18 дугаар зүйл.Эрэн хайх, аврах		
11.	19 дүгээр зүйл.Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх	Практикт нийцэж байгаа байдал	- Хүч хэрэгсэл дайчлан гаргах харилцаа практикт хүндрэл, бэрхшээл үүсгэж байна уу?
Тавдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага			
12.	22 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал	- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын эрх зүйн байдал, чиг үүрэг хуульд оновчтой тодорхойлогдсон эсэх - Удирдлага болон байгууллагын бүрэн эрх хуульд тодорхой, ойлгомжтой тусгагдсан эсэх
13.	23 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал	
Зургадугаар бүлэг. Гамшгаас хамгаалах удирдлагын бүрэн эрх			

14.	27 ¹ дүгээр зүйл.Онцгой комиссын бүрэн эрх	Практикт нийцэж байгаа байдал	- Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо үр дүнтэй, шуурхай хэрэгжиж байгаа эсэх - Удирдлага болон байгууллагын эрх нь тэдгээрт хүлээлгэсэн чиг үүрэгтэй харьцуулахад зохистой, бодитой эсэх - Удирдлага болон байгууллагын чиг үүрэг уялдаатай буюу хуульд давхцал, хийдэлгүй тусгагдсан эсэх
15.	28 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх	Практикт нийцэж байгаа байдал	
16.	29 дүгээр зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	Практикт нийцэж байгаа байдал	
17.	30 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх	Практикт нийцэж байгаа байдал	
18.	33 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг	Практикт нийцэж байгаа байдал	
Долдугаар бүлэг. Хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг			
19.	34 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг	Зорилгод хүрсэн түвшин	- ГХтХ-ийн Долдугаар бүлэгт тусгагдсан эрх, үүргийн талаарх зохицуулалт оновчтой эсэх (34, 35, 36, 37)
20.	35 дугаар зүйл.Төрийн бус байгууллагын эрх, үүрэг		
21.	36 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг		
22.	37 дугаар зүйл.Иргэний эрх, үүрэг		
Наймдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж			
23.	38 дугаар зүйл.Дотоодын хүмүүнлэгийн тусламж	Зорилгод хүрсэн түвшин	- Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжтай холбоотой харилцааг зохицуулах журмыг Засгийн газраас баталсан эсэх? Журам хангалттай, тодорхой эсэх (38.1)
24.	39 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламж	Зорилгод хүрсэн түвшин	- Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зохицуулалтад ойлгомжгүй байдал бий юу? (39.2) - Хууль зүйн техникийн хувьд оновчтой зохицуулагдсан эсэх (39)
25.	40 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж	- Гамшгаас хамгаалах тогтолцоо дахь хүмүүнлэгийн баг, түүний чиг үүрэг юу вэ? (40.3)

		байгаа байдал	- Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зохицуулалтад ойлгомжгүй зохицуулалт бий юу? (40.7) - Хууль зүйн техникийн хувьд оновчтой зохицуулагдсан эсэх (40)
Есдүгээр бүлэг. Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал			
26.	42 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоо	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал Бусад үр дагавар Практикт нийцэж байгаа байдал Практикт нийцэж байгаа байдал	- Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага байх зорилгод хүрсэн эсэх - Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага байх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл бий эсэх - Онцгой байдлын байгууллага гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүргийг гадаадад эсхүл гадаад улстай хамтран хэрэгжүүлэх хүрээг тусгах шаардлагатай эсэх - Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл бий эсэх - Онцгой байдлын байгууллагын бүтэц, салбар, нэгжийг тодорхойлсон зохицуулалтын хэрэгжилт, ололт амжилт, тулгамдсан асуудал - Онцгой байдлын байгууллагын

		Бусад үр дагавар	бүтцэд нэмж салбар, нэгж байгуулах хэрэгцээ, шаардлага бий эсэх
	Практикт нийцэж байгаа байдал	Бусад үр дагавар	- “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг газар зүйн онцлог, хүн амын нягтрал, аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээг харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд Засгийн газрын шийдвэрээр байгуулна.” гэж заасан зохицуулалтын хэрэгжилт, эерэг, сөрөг нөлөөлөл - Төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд үүрэг гүйцэтгэн ажиллаж буй онцгой байдлын байгууллагын харьяа бус нэгж бий эсэх, онцгой байдлын байгууллагатай харилцан хамаарал шаардлагатай эсэх - Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ гэж заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл бий эсэх - Онцгой байдлын байгууллагын төсвийн санхүүжилтийн хэлбэрийг өргөжүүлэх шаардлагатай эсэх
	Практикт нийцэж байгаа байдал	Практикт нийцэж байгаа байдал	- Онцгой байдлын байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна гэсэн зохицуулалт практикт нийцсэн эсэх? - Онцгой байдлын байгууллагын

		Практикт нийцэж байгаа байдал	гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж буй байдал, тулгамдсан асуудал, шийдэл бий эсэх
27.	43 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдэг	Зорилгод хүрсэн түвшин	- Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага бий эсэх
28.	44 дүгээр зүйл. Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэг	Зорилгод хүрсэн түвшин	- Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүргийг ГХтХ-д оновчтой тодорхойлсон эсэх
29.	45 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагч	Практикт нийцэж байгаа байдал	- Онцгой байдлын байгууллагын алба хаагчаар ажиллах иргэнийг сонгон шалгаруулах, томилох харилцаа, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хэрэгжилтэд тулгамдсан асуудал бий эсэх
		Бусад үр дагавар	- Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг оновчтой, бүрэн тусгасан эсэх
		Практикт нийцэж байгаа байдал	- Онцгой байдлын байгууллагын алба хаагчид Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хязгаарлалт нэгэн адил хамаарах нь оновчтой эсэх
			- Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын албан тушаалд тавигдах шаардлагыг ойлгомжтой тусгасан эсэх
			- Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бусад удирдлагад тавигдах шаардлагыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага бий эсэх
			- Төрийн болон албаны нууцад хамаарах бараа, материалыг бүртгэх, хадгалах, хамгаалах асуудал эрхэлж байгаа ажилтны эрх зүйн байдлыг тухайлан тусгах хэрэгцээ, шаардлага бий эсэх
			- Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бусад удирдлагад тавигдах шаардлагыг хуульд тусгах хэрэгцээ, шаардлага бий эсэх

			хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсдэг эсэх
34.	50 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал	- Онцгой байдлын алба хаагчийн нийгмийн баталгааг хуульд оновчтой, бүрэн тусгасан эсэх - Онцгой байдлын алба хаагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд батлахаар ГХтХ-д тусгасан журмын хэрэгжилт, хүндрэл, бэрхшээл бий эсэх - Онцгой байдлын алба хаагчийн нийгмийн баталгааг сайжруулах санал, нөлөөлөх хүчин зүйл бий эсэх
Аравдугаар бүлэг.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт			
35.	51 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт	Практикт нийцэж байгаа байдал	- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт практикт бодитой хэрэгждэг эсэх - Санхүүжилтийн үр дүнг хянах, үнэлэх бодитой механизм бий эсэх (51.2, 51.4)

1.6.Мэдээлэл цуглуулах арга

Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх сурвалжийг ашиглах зорилт тавьсан. Үнэлгээ хийх зохицуулалтын зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдлыг илрүүлэх зорилгоор бодлогын баримт бичиг, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, илтгэл, зөвлөмж уншиж судлах, харьцуулалт хийх, холбогдох байгууллагатай харилцах, мэргэжилтнүүдтэй ярилцах, асуумжийн дагуу бичгээр мэдээлэл авах зэрэг ажлыг гүйцэтгэсэн.

Аргачлалын 3.7.3.1-д заасны дагуу бэлэн байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад баримт бичиг, гамшиг судлалын ухааны сурах бичиг, эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл, Гамшиг судлалын цагаан ном, гарын авлага, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, судалгааны тайлан, зөвлөмж, статистикийн тоо баримт цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан.

Аргачлалын 3.7.3.2-т заасны дагуу холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд: Аргачлалд заасны дагуу боловсруулсан шалгуур үзүүлэлтийн томъёолол ашиглан бэлтгэсэн асуумжийн дагуу болон онцгой байдлын байгууллагын алба хаагчидтай ярилцлага хийх аргаар судалгаа авсан. Түүнчлэн зарим асуудлын хүрээнд ОБЕГ-аас тодруулга мэдээлэл авч энэхүү тайланд эш татаж ашигласан.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Судалгааны “Хэрэгжүүлэх” үе шатанд “Төлөвлөх” үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргын дагуу холбогдох мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэсэн. ГХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардлагатай эх сурвалж судлах, холбогдох субъектээс ярилцлагын аргаар болон тухайлан боловсруулсан асуумжийн дагуу бичгээр судалгаа авах, тодруулах аргаар мэдээлэл цуглуулж, үнэлгээ хийхэд ашигласан.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомжоос гадна сурах бичиг, эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл, ном, судалгааны тайлан, гарын авлага, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, нийтлэл, олон улсын болон үндэсний хэмжээний бодлогын баримт бичиг, зөвлөмж зэрэг эх сурвалж ашигласан. Эдгээрийг ангилж жагсаалт бэлтгэснийг тус тайлангийн Эх сурвалж хэсгээс үзнэ үү.

Хэрэгцээ, шаардлагатай, бодитой, ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулж судалгаанд ашиглах, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан, хуулийг хэрэгжүүлэхэд үүссэн эерэг, сөрөг нөлөөлөл, практикт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодруулах зорилгоор онцгой байдлын байгууллагатай харилцаж, зөвлөлдөх уулзалт хийх, салбарын эрдэмтэн, судлаач, мэргэжилтэнтэй ярилцаж мэдээлэл авах, санал солилцох, асуумжийн дагуу бичгээр тодруулга авах зэргээр ажиллав. Үүнд ОБЕГ, түүний харьяа салбар, нэгж байгууллагын албан тушаалтан, алба хаагчдын идэвх, санаачлагатай оролцоо, дэмжлэг, хамтын ажиллагаа ихээхэн хувь нэмэр оруулсан.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд, Аргачлалын “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал” болон “Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн дагуу боловсруулсан томьёоллын дагуу, Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэв.

Ийнхүү үнэлэхдээ, агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг сонгож хамруулсан болно. Хэрэгжүүлэх үе шатанд цуглуулж судалсан эх сурвалж, онцгой байдлын байгууллагаас ирүүлсэн болон энэхүү судалгааны ажлын хүрээнд холбогдох албан тушаалтан, алба хаагчтай хийсэн ярилцлага болон асуумжийн дагуу авсан мэдээлэлд үндэслэж, гамшгаас хамгаалах харилцааны эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудлыг түлхүү хөндөж тайланд тусгалаа.

ГХтХ-ийн нэг бүлэгт тусгасан эсхүл харилцан хамааралтай бүлгүүдэд тусгасан зохицуулалтуудын хэрэгжилтийн үр дүнг тайлангийн дэд бүлэг болгон багцалж, хуулийн бүлгийн гарчгаар эсхүл тухайн бүлэгт судалсан агуулгыг илэрхийлж нэрлэсэн болно.

3.1. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

Хуулийн нэр томьёоны тодорхойлолт нь тухайн хуулиар зохицуулагдах цөм харилцааны үндэс бөгөөд эрх зүйн хэм хэмжээнд хэрэглэх ухагдахууныг танин мэдэхүйн талаас бүрэн, мэргэжлийн онцлог бүхий үг хэллэг, ойлголтыг оновчтой, тодорхой, ойлгомжтой илэрхийлэх, цаашид боловсруулах эрх зүйн баримт бичгийн төслийн эх сурвалж болох чухал хэсэг юм.

Иймд судалгааны эхний хэсэгт Гамшгаас хамгаалах тухай хууль (цаашид “ГХтХ”)-ийн “Нийтлэг үндэслэл” хэмээх I бүлгийн “Хуулийн нэр томьёоны тодорхойлолт” хэсгийг судалж, үр дагаврыг авч үзье.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтээр зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийн дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, стратеги баталж, холбогдох бүх талын хамтын ажиллагааг сайжруулан, гамшгийн эрт зарлан мэдээлэл, гамшгийн эрсдэлийн талаарх мэдээллийн бүх нийтэд хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх замаар аливаа гамшгийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, хүн амын амьдрал ахуй, эдийн засаг, дэд бүтцэд үзүүлэх сөрөг нөлөөллийг буюу болзошгүй эрсдэлийг бууруулах болон ГХтХ-ийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, ОББ болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах, үндсэн зорилго, зорилтыг үндэслэл болгоход чиглэнэ.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ГХтХ-д “гамшиг”, “аюулт үзэгдэл”, “осол”, “аюул” зэрэг нэр томьёог оновчтой тодорхойлсон эсэх

Үнэлэх зүйл
4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
4.1.1.“ гамшиг ” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;
4.1.2.“ аюулт үзэгдэл ” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавьж, мэрэгч тархах зэргийг;
4.1.3.“ осол ” гэж уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;
4.1.5.“ аюул ” гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг.

Гамшиг гэж аюулт үзэгдэл, осол тохиолдсоны улмаас тодорхой газар нутаг, объектын тодорхой нөөц боломжоос даван гарч хүний эрүүл мэнд, амь нас, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулсан нөхцөл байдал³ гэж “Гамшгийн нэр томъёоны тайлбар толь” бүтээлд тусгажээ. Энэ нь ГХтХ-д заасан тодорхойлолттой төсөөтэй байна. Өөрөөр хэлбэл, гамшиг нь байгалийн үзэгдэл болон хүний буруутай үйлдлээс үүдэлтэй ослын улмаас нийгмийн тухайн хэсгийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрах нөхцөл байдлыг ойлгоно.

Монгол Улсын эрх зүйн орчинд “гамшиг” гэсэн нэр томъёог хэрхэн ойлгож, хэрэглэж байгааг тодруулахын тулд холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтыг авч үзье.

Хүснэгт 4. Хууль дахь “Гамшиг” хэмээх нэр томъёоны хэрэглээ

Д/д	Хууль	Зохицуулалт
1.	Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он	Хорин тавдугаар зүйлийн 2.1. улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг
2.	Онц байдлын тухай хууль, 1995 он	4.1. улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц гамшиг
3.	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 2002 он	34.1.Олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан үрэгдэх, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд их хэмжээний хохирол учруулахуйц гамшиг , аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн тохиолдолд
4.	Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль, 2008 он	8.4.Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан гамшиг
5.	Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, 1997 он	13.3.Иргэд хүн ам, байгаль орчинд ноцтой нөлөөлөх аюулт үзэгдэл, гамшиг
6.	Эрчим хүчний тухай хууль, 2001 он	6.1.4. байгалийн гамшиг
7.	Төмөр замын тээврийн тухай хууль, 2023 он	42.3.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь байгалийн гамшиг
8.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он	36.1.Хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг

³ Гамшгийн нэр томъёоны тайлбар толь, Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэн, (УБ, 2012), 8 дахь тал.

9.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2019 он	79.1.1.байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон
10.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он	10.3.3. байгалийн аюул гамшиг 22. байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутаг
11.	Авто замын тухай хууль, 2017 он	12.1.7.байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюул
12.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, 2020 он	79.1.1.байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул
13.	Ард нийтийн санал асуулгын тухай хууль, 2016 он	21.1.1. гамшиг, гэнэтийн бусад аюул
14.	МУ-ын батлан хамгаалах тухай хууль, 2016 он	5.5. гамшиг, гэнэтийн бусад аюул
15.	МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, 2020 он	76.1.1.байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул
16.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012 он	20.1.2.түймэр унтраах болон байгалийн бусад гамшигтай тэмцэх
17.	Аялал жуулчлалын тухай хууль, 2023 он	15.4. байгалийн гамшигт үзэгдэл,
18.	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2019 он	7.1.Байгаль орчин, уур амьсгалын сан нь байгаль орчныг хамгаалах, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх
19.	Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль, 2016 он	6.1.Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго нь зэвсэгт мөргөлдөөн ба нийтэд учирсан гамшигт байдлын үед 6.3.3.гамшиг, осол, зэвсэгт мөргөлдөөн, нийтэд учирсан гамшигт байдлын үед
20.	Зөрчлийн тухай хууль, 2017 он	15.1.1.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр: 1.1.гэмт хэрэг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан, байгалийн гамшиг гэнэтийн бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн газарт хүрэлцэн очих;
21.	МУ-ын 2016 оны төсвийн тухай хууль, 2015 он	21.2.4 гал түймэр, гамшиг, осол,
22.	МУ-ын 2023 оны төсвийн тухай хууль, 2022 он	23.2.5. гал түймэр, гамшиг, осол,
23.	Татварын ерөнхий хууль, 2019 он	53.1.1. гамшиг болон үер, газар хөдлөлт, гал түймэрт өртсөн;

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно.” гэсний 1 дэх заалтад “улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;” нөхцлийг хамруулсан байна. Тус заалтад “байгалийн гамшиг” гэх нэр томьёо тусгасан нь бусад хууль тогтоомжид тухайн нэр томьёог хэрэглэх үндэслэл болжээ. Гэхдээ тухайн нэр томьёог тодорхойлсон хууль өдгөө байхгүй. 2015 оны Сонгуулийн тухай хуульд “байгалийн гамшиг” гэж хүний үйл ажиллагаанаас үл хамаарах аюулт үзэгдлийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрах буюу байгалийн хүчний үйлчлэлийн үр дагавар болох онцгой нөхцөл байдлыг ойлгоно хэмээн хуульчилсан боловч уг хууль хүчингүй болсон.

ГХТХ-д “гамшиг” гэсэн нэр томьёо хэрэглэж, аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ хэмээн тодорхойлсон.

Монгол Улсын практикт тухайн нөхцөл байдал, хамарч байгаа хүрээ, хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учруулсан хор уршгийг илэрхийлсэн шалгуур үзүүлэлтээр “гамшиг”-ийг тодорхойлж байна. Гамшгийн хор уршгийн нөхцөл байдлыг тодорхойлохдоо нэрвэгдсэн, амь насаа алдсан хүний тоо, хорогдсон болон өвчилсөн мал, амьтан, хамарсан хүрээ, нийгэм, эдийн засагт учруулсан бодит хохирлоор үнэлэх бөгөөд мал, амьтны өвчлөл, хорогдлыг нийт мал, амьтны тоо толгойд эзлэх хувиар, хамрах хүрээг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээ, барилга, байгууламжийн ач холбогдлоор, нийгэм, эдийн засагт учруулсан бодит хохирлыг тухайн орон нутгийн төсөвт эзлэх хувь зэрэг шалгуур үзүүлэлтээр тус тус тооцож, хүснэгтэд нөхдөг.⁴ “Гамшгийн зэрэглэл тогтоох журам”, “Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт”-д тусгагдсан тухайн гамшгийн төрөлд хамаарах нийт шалгуур үзүүлэлтийн 50 хувь нь бүрдсэн байвал гамшиг болсонд тооцдог.⁵

Дээрх хүснэгтээс үзэхэд ихэнх хуульд “байгалийн гамшиг” гэсэн нэр томьёог хэрэглэсэн байна. Үндсэн хуульд тусгасан нэр томьёо, үг хэллэг гэж үзэхийн зэрэгцээ уг нэр томьёог тодорхойлсон боловч хожим хүчингүй болсон хуулийн тодорхойлолтоос ойлголт авч бусад хуульд хэрэглэсэн байх магадлал бас бий. “Гамшгийн нэр томьёоны тайлбар толь”-д байгалийн аюул хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд нөлөөлж хор уршиг учруулсан байдлыг хэлнэ гээд ус, цаг агаарын гаралтай, геологийн гаралтай, биологийн гаралтай гамшиг хэмээн тус тус ангилжээ.

⁴ Маягт, заавар батлах тухай Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 3 сарын 12-ны 22 дугаар тушаал.

⁵ Маягт, заавар батлах тухай Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 3 сарын 12-ны 22 дугаар тушаал.

Гэтэл сүүлийн үед “байгалийн гамшиг” гэх ойлголтыг үгүйсгэх хандлага олон улсад улам нэмэгдэж байна⁶. Учир нь газар хөдлөлт, үер, хар салхи зэрэг байгалийн аюул (natural hazard) нь тухайн аюулд хамгаалагдаагүй, ядуурал, ялгаварлан гадуурхалт, нийгмийн боломж муу зэрэг шалтгаанаар эмзэг болсон нийгэмд нөлөөлсөн үед л гамшиг болно.⁷ Өөрөөр хэлбэл, байгаль орчинд асар их хор хөнөөлтэй ойн түймэр, цөлжилт зэрэг байгалийн аюулаас үүдэлтэй гамшигт үзэгдэл нь экосистем, ан амьтны амьдрах орчныг устгаж, тэдгээртэй хамтран оршдог хүн амын ахуй амьдрал, эдийн засаг, соёл зэрэгт хүчтэй нөлөө үзүүлдэг. Зарим тохиолдолд химийн хаягдал алдагдах, цөмийн осол зэрэг хүний буруутай үйл ажиллагаанаас ч эх үүсвэртэй байдаг. Гэтэл эдгээр нь “байгалийн гамшиг” биш юм.⁸ Мөн Гамшиг = Аюул + Өртөнгө + Эмзэг байдал гэж үзээд ямар нэгэн сүйрлийг “байгалийн гамшиг” гэж нэрлэх нь бодит байдалд хариуцлага хүлээхээс зайлсхийж буй хэрэг гэж дүгнэсэн байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэхэд дэлхий дахинд гарч буй ахиц дэвшлийг хэмжих боломжит шалгуур үзүүлэлтийг боловсруулах зорилгоор Ерөнхий Ассамблейн 69/284 тоот тогтоолоор гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтийн агентлаг хоорондын болон шинжээчдийн бүлгийн үйл ажиллагаатай уялдуулж, Засгийн газар хоорондын нээлттэй шинжээчдийн ажлын хэсэг (OIEWG) байгуулсан. Тус ажлын хэсгээс гаргасан тайлан⁹-д гамшгийг тодорхойлохдоо “Өртөнгө, эмзэг байдал болон чадавхид нөлөөлөх аюултай нөхцөл байдлын улмаас нийтийн эсвэл нийгмийн аливаа хэсгийн үйл ажиллагааг ямарваа нэгэн хэмжээгээр ноцтойгоор тасалдуулж, хүн ам, эд хөрөнгө, эдийн засаг эсхүл хүрээлэн буй орчинд хохирол, нөлөөлөл учруулах үйл явц”¹⁰ гэж үзжээ.

Канад улсын Засгийн газрын Нэр томьёо болон хэл шинжлэлийн өгөгдлийн сан¹¹-д “гамшиг” гэх нэр томьёог “Нийгмийн эмзэг бүлэгт учирсан аюул өөрийнх нь даван туулах чадвараас давсан эсхүл хэтэрсэн байдлаар нөлөөлж, хүмүүсийн аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайхан байдалд ноцтой хор хөнөөл учруулж, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд хохирол учруулахад хүргэдэг үйл явдлыг хэлнэ.” гэж тодорхойлсон бөгөөд гамшиг нь геофизик, биологийн орчноос гаралтай байгалийн үзэгдэл эсхүл технологийн доголдол, террорист ажиллагаа зэрэг хорлон сүйтгэх эсхүл хүний болгоомжгүй үйл ажиллагаа, алдаанаас үүссэн байж болохоор байна. Уг тодорхойлолт ГХТХ-д заасан тодорхойлолттой агуулгын хувьд төсөөтэй байгаа

⁶ No natural disasters, UNDRR, Accessed 4 May 2025, <https://www.undrr.org/our-impact/campaigns/no-natural-disasters>, see also <https://www.undrr.org/news/sendai-framework-6th-anniversary-time-recognize-there-no-such-thing-natural-disaster-were>.

⁷ No natural disasters, UNDRR, Accessed 4 May 2025, <https://www.undrr.org/our-impact/campaigns/no-natural-disasters>

⁸ No natural disasters, UNDRR, Accessed 4 May 2025, <https://www.undrr.org/our-impact/campaigns/no-natural-disasters>

⁹ Report of the open-ended intergovernmental expert working group on indicators and terminology relating to disaster risk reduction, Un General Assembly, 1 December 2016, A/71/644, Accessed 4 May 2025, https://www.preventionweb.net/files/50683_oiewgreportenglish.pdf

¹⁰ United Nations Office for Disaster Risk Reduction (UNDRR), 2017, The Sendai Framework Terminology on Disaster Risk Reduction, "Disaster", Accessed 4 May 2025. <https://www.undrr.org/terminology/disaster>.

¹¹ TERMIUM Plus®, the Government of Canada's terminology and linguistic data bank.

ч музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг эд хөрөнгөөс тусад нь ялгаж зохицуулаагүй байна. Мөн дээр дурдсан эх сурвалжуудад тусгасан тодорхойлолтод ч музейн үзмэр зэргийг эд хөрөнгөөс өөрөөр үзэж хуульчлаагүй болно.

Иргэний эрх зүйн харилцааны суурь ойлголт нь эд хөрөнгө бөгөөд Иргэний хуульд аливаа этгээдийн эзэмшилд байгаа эд юмсыг эд хөрөнгө гэж заасан. Өөрөөр хэлбэл ГХтХ-д тусгасан музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл нь музейн эзэмшилд байх эд хөрөнгөд орох боломжтой байна. Энэхүү зохицуулалт нь хуулийн анхны зохицуулалт дээр нэмэлт, өөрчлөлтөөр орж ирсэн байх тул үндэслэлийг тодруулах нь зүйтэй гэж үзлээ.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Хёогогийн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт тодорхойлсноор “аюул” (hazard) гэж амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал үүсгэх, байгаль орчинд доройтол авчрах эрсдэл бүхий физик үйл явц, үзэгдэл эсвэл хүний үйл ажиллагааг хэлэхээр заасан.¹² Эдгээр аюул нь ирээдүйд аюул занал үүсгэж болзошгүй далд нөхцөл байдлыг ч багтааж болох бөгөөд үүсэл гарлын хувьд:

- Байгалийн (геологийн, уур амьсгалын болон биологийн);
- Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй (байгаль орчны доройтол, технологийн аюул гэх мэт) гэсэн төрлүүдтэй байж болно.¹³ Үүнээс үзэхэд олон улсад тогтсон гамшгийн тодорхойлолттой төсөөтэй нь музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг эд хөрөнгөөс ялгаж тусгаагүй бөгөөд бусад шинжээрээ тохирч байна гэж үзэв. Иймд ГХтХ-д заасан “аюул”-ын тодорхойлолтыг нягталж үзэх хэрэгтэй.

Харин “аюулт үзэгдэл” (hazardous event) нь аюул тодорхой газар, тодорхой цаг хугацаанд илэрч гарах үзэгдэл.¹⁴ Тохиолдсон аюулын тоо болон бусад эрсдэлт хүчин зүйлсүүд нэгдсэний улмаас гамшгийн хэмжээнд хүрэх боломжтой. Үүнээс үзэхэд уг ойлголт нь ГХтХ-ийн 4.1.2-т заасан “аюулт үзэгдэл” тодорхойлолтоос ялгаатай бөгөөд хуульд тусгагдаагүй шинэ ойлголт байх магадлалтай. Дүгнэвэл, ГХтХ-д заасан нэр томъёог олон улсын гол баримт бичгүүдэд нийцүүлэх нь зүйтэй.

1986 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 217 дугаар зарлигаар баталсан Эрүүгийн хуульд ашигласан “нийтэд учирсан гамшигт байдал” гэх нэр томъёог Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн

¹² UN/ISDR. Geneva 2004. World Conference on Disaster Reduction 18-22 January 2005, Kobe, Hyogo, Japan, Hyogo Framework for Action 2005-2015: I S D R International Strategy for Disaster Reduction International Strategy for Disaster Reduction www.unisdr.org/wcdr Building the Resilience of Nations and Communities to Disasters.

¹³ UN/ISDR. Geneva 2004. World Conference on Disaster Reduction 18-22 January 2005, Kobe, Hyogo, Japan, Hyogo Framework for Action 2005-2015: I S D R International Strategy for Disaster Reduction International Strategy for Disaster Reduction www.unisdr.org/wcdr Building the Resilience of Nations and Communities to Disasters.

¹⁴ Report of the open-ended intergovernmental expert working group on indicators and terminology relating to disaster risk reduction, Un General Assembly, 1 December 2016, A/71/644, Accessed 4 May 2025, 20/41 https://www.preventionweb.net/files/50683_oiewgreportenglish.pdf

байдлын тухай хуулийн 6.1 дэх хэсэг, 6.3.3 дахь заалтад ашигласан байна. Мөн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд “байгалийн аюул гамшиг”, “байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутаг” гэх мэтчилэн өөр өөр нэр томьёо хэрэглэсэн байдлыг засаж жигдлэх шаардлагатай.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ (2015–2030 оны) баримт бичгийн 15 дугаар зүйлд заасан хамрах хүрээнд дараах нэр томьёог хамааруулж авч үздэг. Үүнд:

Бага цар хүрээтэй гамшиг: Зөвхөн орон нутгийн хэмжээнд нөлөөлсөн бөгөөд өртсөн орон нутгийн иргэдийн чадамжаас давсан тусламж шаарддаг гамшгийн төрөл;

Их цар хүрээтэй гамшиг: Нийгмийн бүхэл бүтэн системд нөлөөлдөг бөгөөд үндэсний эсхүл олон улсын түвшний тусламж шаарддаг гамшгийн төрөл;

Ойр ойрхон болон ховор тохиолддог гамшиг: Аюул тохиолдох магадлал болон эргэн тохиолдох хугацаанд үндэслэн тодорхойлогдоно. Уг гамшиг нь хуримтлагдсан нөлөө үзүүлж болзошгүй бөгөөд тухайн нийгэмд ноцтой асуудал үүсгэх эрсдэлтэй;

Удаан үргэлжлэх гамшиг: Цаг хугацааны явцад аажмаар үүсэж хөгждөг гамшгийг хэлнэ. Үүнд, жишээлбэл, ган гачиг, цөлжилт, тэнгисийн усны түвшин нэмэгдэх, халдварт өвчин зэрэг хамаарна;

Гэнэт үүсдэг гамшиг: Хурц, гэнэтийн байдлаар бий болсон аюулт үйл явдлаас үүдэн бий болдог гамшгийг хэлнэ. Үүнд, жишээлбэл газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт, гэнэтийн үер, химийн дэлбэрэлт, чухал дэд бүтцийн эвдрэл, тээврийн осол зэрэг хамаарна.

Харин Монгол Улсын хуулиудад “гамшиг”-ийг өөр өөр байдлаар ангилж тусгасныг өмнө нь хүснэгтээр харуулсан. Тухайлбал, аюулгүй байдалд **шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, шууд аюул учруулсан буюу учруулахуйц гамшиг, их хэмжээний хохирол учруулахуйц гамшиг** зэргээр гамшгийн хэмжээ, цар хүрээг илэрхийлсэн байгаа ч ангиллууд хоорондоо ялгаатай байгааг анхаарах шаардлагатай. Түүнчлэн ГХтХ-д байгалийн гамшгаас гадна аюул, гэнэтийн аюул, осол, гэнэтийн осол гэх мэт өөр өөр ойлголт тусгасныг жигдлэх нь зүйтэй.

2016, 2023 оны Төсвийн тухай хууль болон Татварын ерөнхий хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль зэрэг эрх зүйн актад гал түймэр, үер, газар хөдлөлт зэргийг гамшгаас тусад нь авч үзсэн байна. Хэдийгээр дээр авч үзсэнчлэн эдгээр нь тусдаа ойлголтууд боловч зүйл, заалтын агуулгаас үзэхэд тодорхой хохирол учирсан нөхцөл байдлуудыг хэлж байх тул “гамшиг” гэсэн агуулгадаа хамааруулах нь зүйтэй гэж үзэв.

Түүнчлэн Засгийн газрын Журам, жагсаалт, хуваарь батлах тухай 286 дугаар тогтоолоор хөдөө аж ахуй болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой

хохирол учруулж болзошгүй цаг агаарын үзэгдлийг хор хөнөөлийнх нь байдлаар **аюултай, гамшигт үзэгдэл** гэж ангилан Ус цаг агаар, орчны аюултай, гамшигт үзэгдлийн талаар урьдчилан сэргийлэх мэдээ дамжуулах журам, Сэрэмжлүүлэх болон урьдчилан сэргийлэх мэдээнд орох ус цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн жагсаалт зэргийг баталсан. Эдгээр нэр томьёо Аялал жуулчлалын тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай зэрэг хуульд тусгалаа олжээ. Гэвч ГХТХ-д зааснаас өөр байх бөгөөд “аюултай үзэгдэл”, “гамшигт үзэгдэл” гэсэн нэр томьёо хуульд тусгагдаагүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. *“Бэлэн байдал” гэсэн ойлголтыг оновчтой тодорхойлсон эсэх*

Үнэлэх зүйл
4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.24.<i>“бэлэн байдал” гэж гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээ.</i>

Бэлэн байдал нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тулгуурладаг гамшгийн өмнөх үйл ажиллагааны нэг төрөл бөгөөд эрсдэлийн дүн шинжилгээнд үндэслэгддэг. Өөрөөр хэлбэл, бэлэн байдлын стратеги, бодлого, байгууллагын бүтэц, зарлан мэдээлэл, урьдчилан мэдээлэх боломж, чадвар болон заналхийлж байгаа аюул эсхүл гамшигт нэрвэгдсэн үед аюулаас сэрэмжлүүлэх, эрсдэлд зохицох арга хэмжээг ойлгож болно.

Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт тулгуурласан нэр томьёоны тодорхойлолтыг авч үзвэл бэлэн байдал (preparedness) гэж болох нь тодорхой, ойртож буй эсхүл тохиолдсон гамшгийн нөлөөг үр дүнтэйгаар урьдчилан тааварлаж, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох зорилгоор төр, хариу арга хэмжээний болон сэргээн босгох байгууллага, орон нутаг, иргэдийн түвшинд бий болгосон мэдлэг, чадавхын цогц юм.¹⁵

Бэлэн байдал нь гамшгийн эрсдэлийн үндэслэл бүхий дүн шинжилгээ, урьдчилан анхааруулах системүүдтэй үр дүнтэй байдлаар уялдсан байх ёстой бөгөөд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

- Гамшгийн нөхцөл байдлын нөөц төлөвлөгөө боловсруулах;
- Тоног төхөөрөмж, хэрэгслийг нөөцлөх;
- Байгууллагуудын хоорондын зохицуулалт, нүүлгэн шилжүүлэлт, олон нийтэд мэдээлэл хүргэх зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
- Холбогдох сургалт, дадлага сургууль зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа тус тус багтана.¹⁶

¹⁵ United Nations Office for Disaster Risk Reduction (UNDRR). 2017. The Sendai Framework Terminology on Disaster Risk Reduction. "Preparedness". Accessed 6 May 2025. <https://www.undrr.org/terminology/preparedness>.

¹⁶ United Nations Office for Disaster Risk Reduction (UNDRR). 2017. The Sendai Framework Terminology on Disaster Risk Reduction. "Preparedness". Accessed 6 May 2025. <https://www.undrr.org/terminology/preparedness>.

Мөн “Бэлэн байдал”-тай холбоотой нэр томъёо болох “бэлэн байх чадвар” (readiness) гэж шаардлагатай тохиолдолд хурдан, зохистойгоор хариу үзүүлэх чадамжийг илэрхийлнэ. Гамшиг гэнэтийн шинжтэй, олон төрөлтэй тул практикт ГХтХ-д заасны дагуу гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцох боломж хомс байдаг. Үүнийг харгалзан үзвэл ГХтХ-д заасан “бэлэн байдал” гэх тодорхойлолт гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон холбогдох харилцаанд хүндрэл, бэрхшээл үүсгэхээр байх тул Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт нийцүүлэн уг тодорхойлолтыг өөрчилж томъёолох нь зүйтэй.

“Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. *Хуулийн үйлчлэх хүрээнд тусгагдсан гамшгаас хамгаалах албаны зохицуулалт хангалттай тусгагдсан эсэх? Нэр томъёо хэсэг бүрэн, боловсронгуй зохицуулагдсан эсэх*

Үнэлэх зүйл
3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 3.1.Энэ хууль нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшигийн эрсдэлийг бууруулах зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний оролцоог уялдуулан зохицуулах, зохион байгуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ. 30 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх 30.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь ... доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 30.1.1.гамшгаас хамгаалах албаны гүйцэтгэх үүргийг тодорхойлж, мэргэжлийн удирдлагаар хангах;

Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоонд оролцогч талуудын ихэнхийг ГХтХ-ийн “Нэр томъёоны тодорхойлолт” хэсэгт багтааж ойлголтыг томъёолсон ч тус хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах гол субъект болох гамшгаас хамгаалах албаны талаар орхигдуулсан байна. Мөн хүмүүнлэгийн баг (ГХтХ-ийн 40.3 дахь хэсгийн үнэлгээнээс үзнэ үү.), штаб, бүлэг зэрэг бүтцийн талаар тусгаагүй нь хуулийн ойлгомжтой байдлыг алдагдуулж, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд саад, бэрхшээл үүсгэх эрсдэлтэй юм.

Гамшгаас хамгаалах улсын алба нь Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор төрийн захиргааны холбогдох байгууллагыг түшиглэсэн, салбарынхаа хүрээнд гамшгаас хамгаалах үүрэг хүлээсэн орон тооны бус алба байна.¹⁷ Тус албаны талаар Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 347 дугаар тогтоолоор баталсан “Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”, төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагыг түшиглэн Монгол Улсын Шадар сайдын 2025 оны

¹⁷ Гамшигийн нэр томъёоны тайлбар толь, ОБЕГ, Гамшиг судлалын хүрээлэн, (УБ,2012), 9 дэх тал.

1 дүгээр сарын 29-ний 15 дугаар тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах улсын алба, тэдгээрийг түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллагын жагсаалт, чиг үүрэг”, “Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”, “Гамшгаас хамгаалах улсын албаны штабын бүтцийн загвар” зэрэг баримт бичигт тус тус тусгажээ.

Гэвч ГХтХ-ийн 30.1.1-д ОБЕГ-ын дарга гамшгаас хамгаалах албаны гүйцэтгэх үүргийг тодорхойлж, мэргэжлийн удирдлагаар хангах үүрэгтэй гэж заасан ч ОБЕГ-ын даргаас баталсан холбогдох баримт бичиг байхгүй учир Шадар сайдын баталсан Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах журмаар тодорхойлогдож байна. Иймээс уг заалт практикт хэрэгжих боломжгүй.

Мөн хуулийн 33 дугаар зүйлд гамшгаас хамгаалах улсын албаны чиг үүргийг тусгасан хэлбэр нь тухайн албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, бусад улсын алба болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай харилцах үйл ажиллагааг сайжруулах нөхцөл бүрдүүлж байгаа¹⁸ хэдий ч ГХтХ нь ОББ-ын алба хаагч, мэргэжлийн хүмүүст зөвхөн хамаарахгүй, бусад байгууллага, иргэд, олон нийтэд бас үйлчлэх үүднээс зохицуулалт ойлгомжтой байх шаардлагатай. Гэвч тухайн субъектыг хуулиар тодорхойлоогүй нь зохицуулалтыг ойлгомжгүй болгож, улмаар бусад сөрөг үр дагаврыг үүсгэж байна.

Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлого, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, холбогдох стандарт, техникийн норматив, дүрэм, журам, заавар, дэглэмийн биелэлтийг хангуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх, холбогдох эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, төрийн байгууллагуудын харилцан ажиллагааг сайжруулах нь гамшгийн эрсдэлийг бууруулдаг тул гамшгаас хамгаалах улсын албадын үйл ажиллагаа чухал нөлөө үзүүлдэг.¹⁹

Харин штаб нь ОББ-ын тогтолцооны нэг хэсэг болж ГХтХ-д тусгагдсан бөгөөд холбогдох журмаар үйл ажиллагааг нь тодорхойлсон. Улсын онцгой комисс шаардлагатай тохиолдолд улсын хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг удирдан зохион байгуулах шуурхай штабыг, орон нутагт шуурхай бүлгийг байгуулж ажиллуулах эрхтэй. Шуурхай штаб, шуурхай бүлгийн үйл ажиллагааны зардлыг Засгийн газрын, орон нутагт Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус санхүүжүүлдэг. Дүгнэвэл, эдгээр бүтэц нь гамшгаас хамгаалах тогтолцоонд тодорхой үүрэг гүйцэтгэдэг боловч оролцогч субъектуудыг ГХтХ-д тодорхойлоогүй байдлыг засаж шийдвэрлэх шаардлагатай.

“Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. *Хуульд заагаагүй сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй нөхцөл байдал бий эсэх?*

¹⁸ 2025.04.22-ны өдөр ОБЕГ-ын алба хаагчаас авсан асуумжаас.

¹⁹ 2025.04.22-ны өдөр ОБЕГ-ын алба хаагчаас авсан асуумжаас

ОБЕГ-ын мэдээллээр Монгол Улсын хэмжээнд 2022 онд 666, 2023 онд 876, 2024 онд 1097 удаагийн, хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой дуудлага, мэдээлэл бүртгэгдсэн байна.

Анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед иргэдийн хайхрамжгүй байдлаас үүдэн гарсан нийт 2,136 удаагийн дуудлага мэдээлэл /төөрөх, сураггүй болох, цас, шаварт суух, усанд осолдох г.м/-д давхардсан тоогоор 13,547 алба хаагч, 2,768 техник, хэрэгсэлтэй ажиллаж, 3,4 тэрбум төгрөгийг шатах тослох материалд, 1,0 тэрбум төгрөгийг хоол, хүнсэнд, 1,8 тэрбум төгрөгийг эвдэрсэн сэлбэг хэрэгсэлд, нийт 6,2 тэрбум төгрөгийг зарцуулж ажиллажээ. Энэ нь сүүлийн 3 жилд гарсан нийт 12,881 гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлагын 16,5 хувийг, ажилласан хүн хүч хэрэгслийн 10 хувийг, зарцуулсан хөрөнгийн 20 хувийг тус тус эзэлж байна.

Сүүлийн 3 жилд анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед иргэдийн хайхрамжгүй байдлаас үүдэлтэй дуудлагын хувьд цасанд суусан, шаварт суусан, төөрсөн, усанд осолдогчийг эрэн хайх ажиллагаа болон бусад дуудлага хамаарч байна. Бусад дуудлага гэдэгт, тухайлбал төөрсөн боловч өөр айлд байсан, цас, шаварт суусан боловч очих үед өөрсдөө эсхүл бусдын тусламжтайгаар гарсан, өндөр барилга байгууламжид амиа хорлохоор завдсан, нялх хүүхдээ цоожилж түлхүүрээ хаясны улмаас хаалга онгойлгуулах, зам тээврийн ослын газарт ирүүлэхийг хүссэн зэрэг дуудлагыг хамааруулж болно.

Дараах хүснэгтээс 2020-2024 оны хооронд 5 жилийн хугацаанд бүртгэгдсэн 689 дуудлагын талаар нарийвчлан авч үзье.

Хүснэгт 5. Анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед иргэдийн хайхрамжгүй байдлаас үүдэн гарсан дуудлага мэдээлэл

Бусад	2020	2021	2022	2023	2024	Нийт	Хувиар
Автомашин саатсан	26	13	11	12	5	67	9.72
Автомашинтайгаа унах	5	5	6	6	8	30	4.35
Автомашины дэмжлэг хүссэн	1		1	1	4	7	1.02
Бусад	17	24	23	11	17	92	13.35
дулааны шугамын худагт хүн гэмтсэн	3	5	4	1	1	14	2.03
Мөс цөмрөх		10	5	7		22	3.19
Нүхэнд унасныг гаргах	17	24	21	21	32	115	16.69
Усанд боогдсон	7	5	1	3	5	21	3.05
Ухаан алдсан		2	1	3	2	8	1.16
Хаалга онгойлгох	16	12	18	10	43	99	14.37
Хүн дарагдсан	5	4	9	8	9	35	5.08
Цахилгаан шатанд гацсан, унасан	4	3	4	10	4	25	3.63
Цогцос гаргах	17	16	18	22	12	85	12.34
эд эрхтэнээ хавчуулах, гацаах	9	17	11	15	17	69	10.01
Нийт	127	140	133	130	159	689	

Эх сурвалж: 2025.04.22-ны өдөр ОБЕГ-ын алба хаагчдаас авсан асуумж

Анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед иргэдийн болгоомжгүй байдлаас үүдэлтэй буюу ахуйн дуудлага гамшгаас хамгаалах тогтолцооны ачааллыг нэмэгдүүлж, хариу арга хэмжээний үндсэн чиг үүргээс хазайх, санхүүгийн үр ашиггүй байдлыг нэмэгдүүлэх зэрэг хууль зүйн болон бодлогын эрсдэл дагуулж байгаа боловч үүнтэй холбоотой зохицуулалт хангалтгүй байна. Иймээс анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед иргэдийн хайхрамжгүй байдлаас үүдэлтэй дуудлагын улмаас гарах зардлыг багасгах

зорилгоор зардал нөхөн төлүүлэх, хариуцлагын тогтолцоо бий болгох, олон нийтийн мэдлэг, ухамсар, хандлагыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг авч болох юм.

ГХтХ-д тусгаагүй асуудлыг онцгой байдлын байгууллагаас очиж шийдвэрлэх тохиолдлууд практикт цөөнгүй байдаг тул “ахуйн гаралтай дуудлага”-тай холбоотой тодорхойлолтыг нэмж тусгавал зохистой гэж үзэж байна. Үүнийг дараах байдлаар, жишээлбэл “Ахуйн гаралтай дуудлага” гэж иргэдийн өдөр тутмын амьдралд үүсэх, гамшгийн шинжгүй боловч ОББ-ын оролцоо шаардсан нөхцөл байдлыг хэлнэ гэж томъёолж болно. Мөн ГХтХ-д “ОББ-д хамаарах дуудлага” гэсэн агуулгаар хэм хэмжээ нэмж тусган, холбогдох харилцааг журмаар зохицуулах үндсийг суулгах боломжтой. Түүнчлэн төрд учрах зардлыг багасгахын тулд ахуйн дуудлагын хариу арга хэмжээний зардлыг тухайн иргэнээс бүрэн эсхүл тодорхой хувиар гаргуулах, эсвэл энэ ангиллын дуудлагыг бусад/хувийн/ байгууллагууд хариуцахаар тусгаж болох юм. Америк, Швейцарь зэрэг олон оронд энэ төрлийн дуудлагын зардлыг даатгалаар зохицуулдаг байна.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Хүч хэрэгсэл дайчлан гаргах харилцаанд хүндрэл, бэрхшээл бий эсэх?

Үнэлэх зүйл
4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.13.“гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах” гэж эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт хүч хэрэгслийг татан оролцуулах, шаардлагатай барилга байгууламж, газрыг ашиглахыг;
19 дүгээр зүйл.Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх 19.1.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ. 19.2.Энэ хуулийн 24.1-д заасан хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар батална.
20 дугаар зүйл.Гамшгийн хор уршгийг арилгах 20.4.Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.
24 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл 24.1.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч, цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа болон цэргийн жинхэнэ алба хаасан иргэн, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, хуулийн этгээд, эрэлч нохой, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, түүний объект, барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бараа материал байна.
27¹ дүгээр зүйл.Онцгой комиссын бүрэн эрх 27 ¹ .1.8.гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг нөхөн олговортойгоор дайчлан гаргах

Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх ажиллагаа нь гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, аюулт үзэгдэл, ослын үеийн үйл ажиллагаанд хамаардаг. Өдөр тутмын бэлэн байдлын үед гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангадаг бол гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед тус арга хэмжээнээс гадна тухайн нөхцөл байдалд нийцүүлэн хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Гамшгийн аюулын цар хэмжээ, нөхцөл байдал, хамарсан хүрээ, учирсан хор уршгаас шалтгаалж шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг дайчлан гаргах ажлыг бүх шатны Засаг дарга хариуцан зохион байгуулах бөгөөд дайчилгаа зарлах шийдвэр гаргах эрхтэй.²⁰ Харин хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг улсын хэмжээнд, эсхүл нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт Улсын Онцгой комиссын даргын саналыг үндэслэн Засгийн газар гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд хариуцсан салбар, байгууллагыг гамшгаас хамгаалах улсын албаны дарга гаргах эрхтэй. Хүч хэрэгсэл дайчлан гаргах шийдвэрийг ОББ, гамшгаас хамгаалах алба, аймаг, сум, нийслэл, дүүргийн шуурхай штаб хамтран хэрэгжүүлнэ.

Хуулийн 4.1.13 дахь заалтад “нэмэлт хүч хэрэгсэл” гэсэн нэр томьёо тусгагдсан боловч хэрхэн ойлгох талаар хуульд тодорхойлоогүй, ойлгомжгүй байгаа нь зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл учирна гэж үзэж байна. Иймд тухайн хэм хэмжээний ойлгомжтой байдлыг хангаж, “нэмэлт хүч хэрэгсэл” гэсэн ойлголтыг ГХтХ-д тодорхойлох нь зүйтэй.

Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журамд зааснаар хуулийн этгээд, иргэний өмчлөл, эзэмшлийн нисэх онгоц, нисдэг тэрэг, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, өөрөө явагч машин механизм (даатгалд хамрагдсан байх), нисдэг тэрэг хөөрч, буух талбай, барилга байгууламж, газар, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, стратегийн хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох, боох материал, газрын тосны бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэл, бусад эд хөрөнгийг нөхөн олговортойгоор дайчилна. Өөрөөр хэлбэл, үүнд гамшгийн үед дайчлах хүч хэрэгслийн төрөл, мэдээллийг зааснаас гадна эдгээр хүч хэрэгслийг иргэн, хуулийн этгээдээс дайчлан гаргах талаар мөн тусгажээ. Харин хуульд иргэн, хуулийн этгээдээс гадна онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, эрэлч нохой, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги зэргийг гамшгаас хамгаалах хүч хэрэгсэлд тооцохоор заасан. Энэ талаар ОБЕГ-ын холбогдох албан тушаалтнаас тодруулахад, журамд заасныг хүлээн зөвшөөрч байгаа буюу иргэн, хуулийн этгээдээс бусад нэгж нь гамшгийн үеийн дайчилгаанд зайлшгүй оролцох үүрэгтэй тул дайчлан гаргах биш дайчлах ёстой хүч хэрэгсэлд хамааруулах санал гаргасан. Ер нь гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн талаар ГХтХ-ийн 24.1 болон журамд заасан зохицуулалтыг нийцүүлэх шаардлагатай.

²⁰ Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын баримт бичиг, ОБЕГ, 2023, 32 дахь тал.

Улсын онцгой комисс гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг нөхөн олговортойгоор дайчлан гаргах эрхтэй бөгөөд тус комиссын ажиллах журамд заасны дагуу “...гамшгийн үед иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас дайчлан гаргасан эд хөрөнгийн нөхөн төлбөрийн асуудлаар гамшиг үүссэн тухайн аймаг болон яамны гаргасан тооцоог үндэслэн санал боловсруулж Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх” үүрэгтэй.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд зааснаар олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан үрэгдэх, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд их хэмжээний хохирол учруулахуйц гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн тохиолдолд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулан иргэний өмчийн газрыг хуульд заасан журмын дагуу аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын шийдвэрээр түр хугацаагаар дайчлан авч болох ба дайчлан авсны улмаас газар өмчлөгч иргэнд учирсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлөхөөр заасан.

Авто замын тухай хуулийн 12.1.7-д байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас үүссэн авто замын эвдрэл, гэмтлийг шуурхай засварлах шаардлага гарсан үед харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс тээвэр, холбооны хэрэгсэл, машин механизм, эд хөрөнгийг нөхөн олговортойгоор дайчлан гаргуулах, хүн хүчний туслалцаа авах ажлыг зохион байгуулах бүрэн эрх; Төмөр замын тээврийн тухай хуулийн 11.1.4-д шаардлагатай бол гамшиг, ослын болон гологдлын хор уршгийг арилгах болон аюулгүй байдлыг хангахад нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс тоног төхөөрөмжийг нөхөн олговортойгоор гаргуулах, хүн хүчний туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах бүрэн эрхийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргад тус тус олгожээ.

Харин нөхөн олговрыг Засгийн газраас баталсан “Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу зохицуулдаг хэдий ч гамшгийн үеийн дайчилгааны нөхөн олговор олгох харилцаа өдийг хүртэл хангалттай зохицуулалтгүй явж ирсэн.

Практикт иргэн, хуулийн этгээд эд хөрөнгөө гамшгийн үед дайчлан гаргуулах дургүй байдаг. Жишээ нь, 2023 оны үерийн үеэр иргэдийн хөрөнгийг хүч хэрэгсэл болгон дайчлан авсан боловч нөхөн олговроо буцааж авахад ойлгомжгүй процесс үүсэж, олон тооны бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай болсны улмаас иргэд нөхөн олговроо буцааж авч чадаагүй.²¹ Ингэснээр дараагийн удаа дайчлах хэрэг гарахад нөхөн олговроо авч чадаагүй иргэд эд хөрөнгөө дайчилгаанд ашиглуулахаас татгалзах хандлага үүсдэг.

²¹ 2025.04.22-ны өдөр ОБЕГ-ын алба хаагчаас авсан асуумжаас.

Засгийн газрын Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журамд аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын нөөц хөрөнгө болон яам, агентлагийн батлагдсан төсвөөс давсан тохиолдолд нэмэлт санхүүжилт авах хүсэлтийг эдгээр байгууллагууд гаргахад шаардагдах бичиг баримтыг тусгасан боловч гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тусалсан, журмаар зохицуулагдах шаардлагатай гол этгээд болох хуулийн этгээдийн бүрдүүлэх баримт бичиг болон нөхөн төлбөрөө хэрхэн гаргуулж авах талаар тусгаагүй байна. Мөн иргэнээс гарсан зардлыг хэрхэн нөхөн олгох талаар процесс тодорхойгүй, холбогдох журам батлагдаагүй байна. Иймээс ГХтХ-ийн холбогдох хэсэгт иргэнд олгох нөхөн олговрын журмыг батлах зохицуулалтыг тусгаж, журмын дагуу ажиллах шаардлагатай.

Дайчилгааны тухай хуулийн зохицуулах зүйл нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг дайны байдалд шилжүүлэх бэлтгэл, зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулах бэлэн байдлыг хангах, дайчилгаа явуулах үндэслэл, журам, энэ талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүлээх үүргийг тогтоож, дайчилгаа явуулахтай холбогдсон харилцаа буюу дайчилгаа гэдэг нь улс орны эдийн засаг, нийгмийг шаардлагатай үед **дайны байдалд шилжүүлэх, зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулах**ын тулд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээг хэлдэг. Мөн цэрэг-улс төрийн нөхцөл байдал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч бүх нийтийн эсхүл хэсэгчилсэн цэргийн дайчилгааг зарладаг. Өөрөөр хэлбэл, тус хуулиар гамшгийн нөхцөл байдалд хүч хэрэгсэл дайчлан гаргах тухай зохицуулаагүй ба гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчинд дайчилгааны тухай хууль багтдаггүй²². Гэтэл ЗтХ дахь Дайчилгааны тухай хууль зөрчих зохицуулалтад “гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюултай тэмцэх улсын аюулгүй байдал хангахтай холбогдсон хүн хүч, тээвэр, холбооны хэрэгсэл, барилга байгууламжийн дайчилгаанаас зайлсхийсэн, эсхүл саад учруулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заах байдлаар хүч хэрэгсэл дайчлах зохицуулалтыг тусгасан нь оновчгүй юм.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. *Мэргэжлийн ангитай холбогдох зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх?*

Үнэлэх зүйл
4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.17.“мэргэжлийн анги” гэж сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгжийг;

²² Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын баримт бичиг, ОБЕГ, 2023, 5 дахь талд зааснаар Онц байдлын тухай хууль 1995, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль 2001, Гамшгаас хамгаалах тухай хууль 2017, Галын аюулгүй байдлын тухай хууль 2015, Улсын нөөцийн тухай хууль 2007 тус тус багтдаг.

22 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт
22.8. Аймаг, сум, нийслэл, дүүрэг, хуулийн этгээд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангитай байна.

ГХТХ-ийн 4.1.7-д заасан мэргэжлийн анги нь сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдахаар байна. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд томилогдсон иргэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай болон ажил үүргээс чөлөөлөгдсөн үед орлон ажиллах иргэнийг тогтмол тодотгон томилж, бэлтгэл, бэлэн байдлыг хангасан байна. ГХТХ-д зааснаар тухайн шатны Засаг даргын захирамжаар, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн удирдлагын шийдвэрээр тус тус мэргэжлийн ангийг байгуулдаг. Гэтэл дээрх зохицуулалтын улмаас дараах хэдэн асуудал тулгарч байна.

Нэгдүгээрт, энэхүү заалт нь бүхий л хуулийн этгээд буюу иргэний хуульд заасан ашгийн болон ашгийн төлөө бус этгээдийг хамруулж байна. ОБЕГ-ын мэдээлэлд дурдсанаар аймаг, суманд байгуулагдсан мэргэжлийн анги нь 22,559 хүний бүрэлдэхүүнтэй 3,222 техник хэрэгсэлтэйгээр сүүлийн 3 жилд 4,344 удаагийн гамшиг ослын дуудлагаар ажиллаж 8404 хүний амь насыг аварч, 66,6 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хамгаалжээ. Гэтэл хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан мэргэжлийн ангийн үйл ажиллагааны тоон мэдээллийг дурдаагүй байна. Учир нь Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй бүх хуулийн этгээд мэргэжлийн ангитай эсэхэд хяналт тавих нөөц хүрэлцэхгүй бөгөөд зарим хуулийн этгээд мэргэжлийн анги байгуулах боломжгүй байдаг. Монгол Улсад хуулийн этгээд нь гишүүдийн тоогоор цөөн байх нь нийтлэг бөгөөд 1 хүнтэй хуулийн этгээдээс гадна зарим хуулийн этгээд цахимаар үйл ажиллагаа явуулах нь элбэг болж байна. Мэргэжлийн ангитай байх заалтын тухайд хуулийн этгээдийн хувьд орлон ажиллах албан хаагч байхгүй тул хэрэгжих бололцоогүй заалт юм.

Мөн мэргэжлийн анги гэсэн нэр томъёо оновчтой эсэх нь эргэлзээтэй. Учир нь практикт иргэд мэргэжлийн анги гэдгийг хууль хэрэгжүүлэхэд гол үүрэг бүхий онцгой байдлын мэргэжлийн хүмүүс буюу тус байгууллагын салбар, нэгж гэж ойлгож байна. Үүнээс үүдэлтэйгээр хуульд заасан үүргээ биелүүлэхэд саад, бэрхшээл үүсдэг.

Хоёрдугаарт, ГХТХ-ийн 22.8-д зааснаар аймаг, сум, нийслэл, дүүрэг, хуулийн этгээд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангитай байна гэсэн бол тус хуулийн 4.1.17-д зөвхөн сум, дүүргийн дэргэд мэргэжлийн анги байхаар заасан нь хоорондоо зөрчилдөж байна. Иймд мэргэжлийн ангийн нэр томъёоны тодорхойлтод аймаг, нийслэлийг тусгах шаардлага үүсжээ. Эдгээр нөхцөл нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/379 дүгээр тушаалын хавсралтаар баталсан мэргэжлийн ангийн дүрэм хэрэгжихгүй байх шалтгаан болж байна.

Бүлгийн дүгнэлт, санал

Судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан дүгнэлт, саналыг тус тайлангийн Дүгнэлт, санал, зөвлөмж бүлэгт нэгтгэн байршууллаа.

3.2.Гамшгийн өмнөх үйл ажиллагаа

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ГХтХ-ийн 13 дугаар зүйлд заасан гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх

Үнэлэх зохицуулалт
13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах

Улсын хэмжээнд 2020-+2024 онд гамшгаас хамгаалах чиглэлээр дараах сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль **91** удаа, **179875** хүнд ,
- Гамшгаас хамгаалах команд штабын сургууль **164** удаа, **32871** хүнд,
- Удирдах албан тушаалтны сургалтыг **1920** удаа, **102998** хүнд,
- Их, дээд сургууль болон МСҮТ, коллежийн оюутны сургалтыг **1344** удаа, **43827** оюутанд,
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийнханд **1636** удаа, **98481** сурагчид,
- Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийнханд **1544** удаа, **83355** сурагчид,
- Ерөнхий боловсролын сургуулийн бага ангид **1196** удаа, **62875** сурагчид,
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтыг **1374** удаа, **61550** хүүхдэд ,
- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны сургалтыг **12607** удаа, **327623** хүнд,
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалтыг **2536** удаа, **93922** хүнд,
- Иргэний сургалт **2827** удаа, **177475** хүнд,
- Цэргийн дүйцүүлэх албаны сургалтыг **111** удаа, **3038** хүнд,
- Сайн дурын бүлэг, хэсгийн сургалтыг **568** удаа, **11326** хүнд,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сургалтыг **149** удаа, **11192** хүнд буюу 2020-2024 онд нийт 28067 удаагийн сургалтыг зохион байгуулж, 1290408 хүнийг хамруулсан.²³

ГХтХ-ийн 13 дугаар зүйлд заасны дагуу, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах сургалтыг 6 ангилан зохион байгуулж байна. Гамшгаас хамгаалах команд штаб болон иж бүрэн сургууль нь гамшиг, онцгой байдлын нөхцөл байдал тохиолдсон үед иргэдийн аюулгүй байдлыг хангах, гамшгийг хохирол багатай даван туулах, аймаг, сум, нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх ач холбогдолтой.²⁴

2004-2013 онд жилд дунджаар 3102 аюулт үзэгдэл, осол тохиолдож, 210 хүн амь насаа алдсан бол сүүлийн 10 жилд (2014-2023 он) дунджаар 4517 аюулт үзэгдэл, осол тохиолдож, ковид, бусад аюулт үзэгдэл, ослоор 235 хүн амь насаа алдсан нь аюулт үзэгдэл ослын тохиолдлын тоо 45.6 хувь, амь насаа алдсан

²³ ОБЕГ-аас ирүүлсэн мэдээллээс.

²⁴ ОБЕГ-аас ирүүлсэн мэдээллээс.

хүний тоо 11.9 хувиар тус тус өссөн байна. Түүнчлэн, 2024 онд гамшиг, аюулт үзэгдэл, ослын 5118 тохиолдол бүртгэгдэж, 332 хүн амь насаа алдаж, нийт 40.8 тэрбум төгрөгийн хохирол учирсан судалгаа гарсан байна.²⁵

Гамшгаас хамгаалах сургалтыг дараах 6 төрөлтэй байхаар хуульд заажээ.

Хүснэгт 6. Гамшгаас хамгаалах сургалтын ангилал, сургалт зохион байгуулах байгууллага, албан тушаалтан

Д/д	Сургалтын ангилал	Сургалт зохион байгуулах байгууллага, албан тушаалтан
1.	Удирдах албан тушаалтны: - Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтан - Гамшгаас хамгаалах улсын алба, аймаг, нийслэлийн удирдах албан тушаалтан	Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
2.	Онцгой байдлын байгууллагын: - Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн сургалт	Тухайн нэгжийн дарга
3.	Оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн	-
4.	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны: - Хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан - Хуулийн этгээдийн ажилтан	- Орон нутгийн онцгой байдлын байгууллага - Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан
5.	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн: - Орон нутгийн гамшгаас хамгаалах алба - Мэргэжлийн ангийн удирдах албан тушаалтан - Сум, дүүргийн мэргэжлийн анги	- Орон нутгийн онцгой байдлын байгууллага - Тухайн шатны Засаг дарга
6.	Иргэний: - Цэргийн албыг биеэр дүйцүүлэн алба хааж байгаа иргэн - Иргэний сургалт	- Орон нутгийн онцгой байдлын байгууллага - Тухайн баг, хорооны Засаг дарга

ГХТХ-д гамшгаас хамгаалах сургалтыг ангилан авч үзсэн боловч сургалт зохион байгуулах байгууллага, албан тушаалтан сургалтын ангиллаас огт хамааралгүй байгаа нь сургалтыг ийнхүү ангилахын ач холбогдлыг алдагдуулж байна.

Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг нь дээрх сургалтын 6 ангиллын алинд хамаарахыг тодорхой хуульчлаагүй боловч сайн дурын хэсэг нь ГХТХ-ийн 4.1.18-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохоор зохих сургалтад хамрагдсан иргэд гэж тодорхойлсны дагуу иргэний сургалт гэсэн ангилалд хамрагдахаар ойлгогдож байна.

²⁵ Мөн тэнд.

Мөн удирдах албан тушаалтны сургалтад мэргэжлийн анги байгууллагын удирдах албан тушаалтан хамаардаггүй. Учир нь мэргэжлийн анги байгууллага гэдэг нь ГХтХ-ийн 4.1.7-д зааснаар “сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгж” бөгөөд тус хуулийн 24.2-т “Мэргэжлийн ангийг Монгол Улсын харьяат, хөдөлмөрийн чадвартай, 18-60 хүртэлх насны эрэгтэй, 18-55 хүртэлх насны эмэгтэй иргэнээр бүрдүүлэх бөгөөд цэргийн жинхэнэ алба хаагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэй, өрх толгойлсон эх /эцэг/ хамаарахгүй” гэж заасан. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн ангид онцгой байдлын албан хаагчид багтдаггүй бөгөөд ихэвчлэн тухайн сум, дүүрэг, хуулийн этгээдийн албан хаагчдаас бүрддэг. Иймээс мэдлэг, мэдээллийн хувьд зарим тохиолдолд иргэдтэй ижил түвшинд байдаг. Нөгөөтэйгүүр, мэргэжлийн ангийг хуульд ялгамжтай байдлаар зохицуулаагүй боловч практикт хоёр төрөл байна.

Түүнчлэн, ГХтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3.2-т “орон нутгийн гамшгаас хамгаалах алба, **хуулийн этгээд**, мэргэжлийн ангийн удирдах албан тушаалтан ... сургалтыг орон нутгийн онцгой байдлын байгууллага” гэж заасан зохицуулалт дахь “хуулийн этгээд” нь “хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан” байх тул энэхүү зохицуулалтыг тус хуулийн 13.3.7-д заасан хуулийн этгээдээс ялгаатай болохыг тодотгож, тус хуулийн 13.3.2-т заасан зохицуулалтыг ойлгомжтой болгох үүднээс “хуулийн этгээд” гэсний дараа “болон” гэж нэмж оруулах нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл, ГХтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3.2-т заасан хуулийн этгээд нь хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан учир орон нутгийн ОББ, харин тус зүйлийн 13.3.7-д заасан хуулийн этгээдийн ажилтны сургалтыг тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан зохион байгуулна.

Нөгөөтэйгүүр, хуулийн этгээд нь нэг гишүүнтэй бол хуулийн этгээдийн сургалт байх уу, эсвэл иргэний сургалт уу, эсвэл хуулийн этгээдийн удирдах ажилтны сургалтад хамрагдах уу гэсэн асуулт урган гарч байна. Иймд ГХтХ-д заасан хуулийн этгээдийн сургалттай холбоотой зохицуулалтуудыг боловсронгуй болгох шаардлагатай.

Мөн гамшгаас хамгаалах сургалттай холбогдуулан ГХтХ-ийн 13.2.3-т “оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн сургалт”-ыг хуульчилсан боловч тус сургалтыг зохион байгуулах байгууллага, албан тушаалтантай холбоотой тус хуулийн 13.3.6-д заасан зохицуулалтыг 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна. Уг зохицуулалтыг хүчингүй болгосноор тухайн сургалтыг хариуцан зохион байгуулах субъект тодорхойгүй болж, эрх зүйн зохицуулалт практикт хэрэгжихгүй байх, хууль хоорондын уялдаа холбоог алдагдуулах эрсдэл бий болжээ.

2023 онд батлагдсан Боловсролын ерөнхий хуулийн 14.4-т “Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ” гэж, 14.4.7-д

“гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах арга ухаан” гэж тус тус зааснаас үзвэл бүх түвшний боловсрол олгож буй байгууллага /сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, их, дээд, коллеж/-д суралцагчдад тухайн шатны боловсролын байгууллага гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахаар байна. Иймд ГХтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3.6-д заасан байсан буюу хүчингүй болсон зохицуулалтыг агуулгын хувьд сэргээн хуульчлах, мөн тус хуулийн 13.2.3-т заасан “оюутан, сурагч, **сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн**” гэснийг нэр томьёо, үг хэллэгийн хувьд сайжруулж тусгах нь зүйтэй.

Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэхэд практикт дараах асуудал тулгарч байна. Тухайлбал:

- Гамшгаас хамгаалах сургалтыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад үр дүнтэй, хүртээмжтэй зохион байгуулахад хүний нөөц дутмаг, ангиллын сургалт хариуцсан мэргэжилтний ачаалал их;
- Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахад иргэдийн идэвх, оролцоо хангалтгүй;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахад хүндрэлтэй. Жишээлбэл, дохионы хэлмэрч, брайль үсгээр хэвлэгдсэн гарын авлага, ярьдаг ном гэх мэт шаардлагатай сургалтын хэрэгсэл, хэрэглэгдэхүүн дутмаг;
- Гамшгаас хамгаалах сургалтын төв, бааз хүрэлцээгүй. Иймд 116 дугаар ангитай адил утаат орчин, галын орчин, газар хөдлөлтийн үеийн нөхцөл байдлыг харуулсан танхимыг нэмж байгуулах хэрэгтэй;
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургах ажлыг шат дараатай, хүртээмжтэйгээр зохион байгуулах. (хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан сургалт хийхэд оролцогчдыг цуглуулах асуудал хүндрэлтэй, сургалтад хамруулах бололцоо хомс байна.)²⁶

Гамшгаас хамгаалах сургалтыг хүртээмжтэй байдлаар зохион байгуулж гамшиг осол, аюулт үзэгдлийн тухай мэдлэг ойлголтыг өгч, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг авран хамгаалах чадвартай, сөрөн тэсвэрлэх, дасан зохицох арга зүйд суралцах явдал ихээхэн ач холбогдолтой учир цаашид сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Дээрхээс дүгнэвэл, гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахтай холбоотой зохицуулалт нь практикт хэрэгжиж байх боловч зорилгодоо бүрэн хүрч чадахгүй байна. Үүнд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт, сургагч багш, хүний нөөц дутмаг, иргэдийн оролцоо бага гэх мэт. Түүнчлэн, гамшгаас хамгаалах сургалтыг үр дүнтэй, оновчтой, иргэдийн оролцоог хангасан хэлбэрээр зохион байгуулснаар гамшигийн эрсдэлээс хамгаалах, урьчилан сэргийлэх, учирч болох хохирол, хор уршгийг бууруулахад эерэг нөлөөлөл үзүүлнэ.

²⁶ 2025.04.22-ны өдөр ОБЕГ-ын алба хаагчаас авсан асуумжаас.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ГХтХ-ийн 7, 12 дугаар зүйлд заасан гамшгийн эрсдэлийг үнэлэх болон гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх

Үнэлэх зохицуулалт
7 дугаар зүйл. Гамшгийн эрсдэлийг үнэлэх
12 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх

ГХтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийнэ” гэж заасан.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээг ерөнхий болон нарийвчилсан гэж ангилдаг. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг гамшгийн эрсдэлийг тойм, суурь судалгаа байдлаар тодорхойлох зорилгоор хийнэ. Харин гамшгийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр мэргэжлийн түвшинд нарийвчлан тодорхойлох, болзошгүй хохирлын хэмжээг тооцох, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг төлөвлөх зорилгоор гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийнэ. Эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг дараах чиглэлээр хийдэг. Үүнд:

- Уул уурхай;
- Дэд бүтэц;
- Хөдөө аж ахуй;
- Байгаль орчин, түүх соёлын дурсгалт газар;
- Үйлдвэр, үйлчилгээ;
- Эрүүл мэнд.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ” гэж заасны дагуу 2025 оны 4 дүгээр сарын байдлаар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий 38 хуулийн этгээд²⁷ байна.

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийх тусгай зөвшөөрлийг ГХтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.8-д заасны дагуу онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгодог. Гэвч ГХтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д “ОББ гамшгийн эрсдэлийн үнэлгээний гүйцэтгэл, тайланд хяналт тавьж ажиллана” гэж заасан. Энэхүү зохицуулалтаас үзвэл, тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь тухайн эрсдэлийн үнэлгээний тайлан, гүйцэтгэлд хяналт тавьж байна. Үүнийг засаж, сайжруулах шаардлагатай.

²⁷ Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудас <https://nema.gov.mn/ersdeliin-unelgee>, Сүүлд үзсэн огноо: 2025.04.15

Түүнчлэн, ГХтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална” гэж заасан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Дугаар 190 тогтоолоор “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн баталсан.

Энэхүү журамд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой асуудлыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулахаар тусгасан боловч тус хуулийг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон. Гэвч үүнтэй холбогдуулан дээрх журмын зохицуулалтад өөрчлөлт хийгээгүй тул өдгөө хүчин төгөлдөр үйлчилсээр байна.

Мөн тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 40 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм”-ийн 2.1-д “Гамшгаас хамгаалах улсын хяналтыг гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, байцаагч (цаашид нийтэд нь “улсын хяналтын байцаагч” гэх) хэрэгжүүлнэ” гэж заасан. Тус дүрмийн гамшгаас хамгаалах улсын хяналтын чиглэл 3.1.2-т “гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт”-д хяналт тавих зохицуулалт тусгажээ.

Дээрхээс дүгнэвэл, гамшгийн улсын хяналтын байцаагч гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд ГХтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу:

- *Гамшгаас хамгаалах хууль тогтоомж;*
- *Дүрэм;*
- *Журам;*
- *Стандарт;*
- *Гамшгийн эрсдэлийн үнэлгээ;*
- *Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьдаг.*

Гамшгийн улсын хяналтын байцаагчийн хяналт тавих асуудалд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хамаардаг ба практикт гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй тохиолдол цөөнгүй гардаг. Энэ тохиолдолд тухайн хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулж байна.

Хуулийн этгээдийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй шалтгаан нөхцөлийг судлан үзэхэд, зарим тохиолдолд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэхэд харьцангуй өндөр зардал гардаг, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн орон тоо дутмаг, бүх хуулийн этгээдэд хяналт шалгалт хийх боломжгүй, хяналт шалгалт хийж илрүүлэхээс бусад тохиолдол тухайн хуулийн этгээдийг ГХтХ-д заасан үүргээ биелүүлээгүйг тодорхойлох боломжгүй байдаг гэх мэт шалтгаанаар хуулийн этгээдүүд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэхгүйгээр, Зөрчлийн тухай хуульд зааснаар торгуулах сонголтыг хийж байна.

Тодруулбал, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч 2024-2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 21 аймаг, нийслэл, болон хуулийн этгээдийн нийт 2510 гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй хуулийн этгээдэд албан шаардлага хүргүүлж, торгох шийтгэл оногдуулсан²⁸ байна.

Түүнчлэн ГХтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.6-д “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг энэ хуулийн 7.1-д заасан байгууллага өөрөө хариуцна” гэж заасан. Гэвч энэхүү зохицуулалтад тусгасан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг харилцан адилгүй байдлаар тогтоож, практикт хэрэгжүүлж байна.

Судалгааны явцад ОББ-ын алба хаагчдаас авсан асуумж, ярилцлагын үр дүнгээс харвал гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь ажлын хөлсөө тухайн аж ахуйн нэгжтэй харилцан тохиролцож хийдэг бөгөөд үнэлгээ хийлгэх объектын хэмжээ, хамрах хүрээнээс шалтгаалан харилцан адилгүй байдаг.

Нарийвчилсан үнэлгээ хийлгэхэд шаардагдах санхүү, зардлын асуудалд ОБЕГ оролцдоггүй байна. Тус байгууллагаас гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний талаар тодруулахад, Нийслэлийн Засаг даргын тамгын газраас Улаанбаатар хотын нарийвчилсан үнэлгээг 80 сая төгрөг, Дундговь аймгийн Сайнцагаан сум нарийвчилсан үнэлгээг 30 сая төгрөг, Шатахуун түгээх станц нарийвчилсан үнэлгээг 1.5-3 сая төгрөгөөр тооцож хийлгэсэн тухай мэдээлэл байсныг дурдсан.

Дээрхээс үзвэл, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэснээр тухайн хуулийн этгээдээс гарах зардлын хэмжээ хэт өндөр байгаа нь зарим хуулийн этгээд эрсдэлийн үнэлгээ хийлгэх бус, Зөрчлийн тухай хуульд зааснаар торгуулах сонголт хийхэд хүргэж байна.

Иймд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн тухайн объектод үнэлгээ хийхэд шаардагдах зардлын үнийн хязгаарлалтыг тодорхой хэмжээгээр тогтоох нь зүйтэй.

Мөн гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр төлбөртэй гүйцэтгэх зарим ажил үйлчилгээний жагсаалтыг хуульчлах, тухайлбал аж ахуйн нэгж байгууллагад зохион байгуулах гамшгаас хамгаалах сургалт; лабораторийн зарим туршилт шинжилгээ, үйлчилгээ, ОББ-ын техник хэрэгсэл, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг хувь хүний болон хуулийн этгээдийн илт буруутай үйлдлээс шалтгаалан ашигласан тохиолдолд тухайн үйл ажиллагаанд зарцуулагдсан машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, хэмжилт, туршилт хийсэн нарийн мэдрэмжит багаж, бодис урвалжийн төлбөрийг төлүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хуульчлах шаардлагатай²⁹.

Түүнчлэн, ГХтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.3-т гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагч нь онцгой байдлын асуудал эрхэлсэн

²⁸ 2025.04.22-ны өдөр ОБЕГ-ын алба хаагчаас авсан асуумжаас.

²⁹ Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн санал.

төрийн захиргааны байгууллагын дарга байхаар хуульчилжээ. Өөрөөр хэлбэл ГХтХ болон Галын аюулгүй байдлын тухай хууль нь өөр хоорондоо уялдаа холбоотой хуулиуд юм. ГАБтХ-ийн 5 дугаар зүйлд “Гал түймрийн улсын хяналт”, 6 дугаар зүйлд “Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн бүрэн эрх”-ийг хуульчилсан бол ГХтХ-д гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлж тусгаагүй байна.

ГАБтХ-д гал түймрийн улсын байцаагчийн эрх, үүргийг дараах байдлаар хуульчилжээ.

5 дугаар зүйл. Гал түймрийн улсын хяналт

5.1. Гал түймрийн улсын хяналтыг хяналтын тухай хууль тогтоомжийн дагуу онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

5.2. Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм болон гал түймрийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

5.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагч байх бөгөөд улсын ахлах байцаагч, байцаагчийг томилж, чөлөөлнө.

5.4. Гал түймрийн шалтгаан, нөхцөлийг тогтоох явцад гал түймрийн улсын хяналтын байцаагч **Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172.4-т заасны дагуу хойшлуулшгүй ажиллагаа** явуулна.

5.5. Гал түймрийн улсын хяналтын байцаагч хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтэд үндэслэн шийдвэр гаргана.

5.6. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан гал түймрийн улсын хяналтын байцаагчийн шийдвэрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

6 дугаар зүйл. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн бүрэн эрх

6.1. Гал түймрийн улсын хяналтын байцаагч хяналтын тухай хууль тогтоомжид заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. барилга байгууламжийн байршлыг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж мэргэжлийн дүгнэлт гаргах;

6.1.2. барилга байгууламжийн зураг төсөл галын аюулгүй байдлыг хангасан эсэх талаар гаргасан дүгнэлт болон магадлалд хяналт хийж шийдвэр гаргах;

6.1.3. барилга байгууламжийг барих, ашиглах явцад галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

6.1.4. барилга байгууламжийг ашиглалтад авах улсын комиссын бүрэлдэхүүнд оролцох, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд санал, дүгнэлт гаргах;

6.1.5. гал түймрийн аюултай нөхцөл бий болсон, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг ноцтой зөрчсөн үед хяналтын тухай хууль тогтоомжийн дагуу аж ахуйн үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авч, хэрэгжүүлэх;

6.1.6. аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламжид шууд, тусгай хамгаалалттай обьектод урьдчилан мэдэгдэж, орон сууцанд иргэний хүсэлт, мэдээллийн үндсэн дээр нэвтрэн орж, галын аюулгүй байдлын болон галын техникийн үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгах тухай албан шаардлага, мэдэгдэл бичих, биелэлтэд хяналт тавих;

6.1.7. гал түймэр гарсан тохиолдолд **Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172 дугаар зүйлд заасан** эрх хэмжээний хүрээнд хойшлуулшгүй арга хэмжээ авч гал түймэр гарсан тухай акт тогтоох, эсхүл гал түймэр гарсан тухай тэмдэглэл хөтлөх;

6.1.8. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

Дээрхээс дүгнэвэл, ГАБтХ-д гал түймрийн улсын хяналтын байцаагчийн бүрэн эрх, үүргийг тодорхой байдлаар хуульчилсан байна. */Гэвч тус хуульд 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон ЭБШХ-ийн зохицуулалт хэвээр байгаа нь хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, хууль хоорондын харилцан уялдаа, ойлгомжтой байдлыг алдагдуулж байна./*

Үүнтэй адилаар гамшгаас хамгаалах улсын байцаагчийн үйл ажиллагаа, чиг үүргийн онцлогийг харгалзан ГХтХ-д эрх, үүргийг нь хуульчлах шаардлагатай.

Ийнхүү хуульчлахдаа ГАБТХ-ийн 5 дугаар зүйлд заасантай адил “Гал түймрийн улсын хяналт” гэж ерөнхий байдлаар тусгаж, тус зохицуулалтад улсын хяналтын байцаагчийг томилох, чөлөөлөх, хойшлуулшгүй ажиллагаа явуулах харилцаа болон чиг үүргийг хамааруулан тусгах нь оновчгүй. Харин гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх, үүргийг тусад нь хуульчлах хэрэгтэй.

Мөн Төрийн хяналт шалгалтын тухай хуульд “улсын байцаагч” гэх нэр томъёог хэрэглэсэн тул Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн, хууль хоорондын уялдаа холбоог хангаж, ГХТХ болон ГАБТХ-д заасан “улсын хяналтын байцаагч” гэх нэр томъёог “улсын байцаагч” гэж өөрчлөх, мөн гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн бусад хуульд заасан “улсын байцаагч”-ийн чиг үүрэгтэй давхцах болон ялгаатай байдлыг харгалзан үзэж, үйл ажиллагааны хамрах хүрээ, хариуцах асуудлыг оновчтой, ойлгомжтой байдлаар зааглаж хуульчлах нь зүйтэй.

Түүнчлэн, судалгааны явцад ОББ-ын алба хаагчдаас авсан асуумж, ярилцлагын үр дүнгээс харвал ГХТХ-д заасан гамшгийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтын тулгамдаж буй асуудал, практик хэрэгжилттэй холбоотой дараах саналыг гаргасан байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн орон тоо хүрэлцээгүй байдлыг шийдвэрлэх;
- Гамшгаас хамгаалах хяналтын байцаагчийн бүрэн эрх, үүргийг хуульд тусгах;
- Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд төрийн алба хаагч, төрийн байгууллагад торгууль шийтгэвэр тавих зохицуулалт тусгагдаагүй байгааг нягталж шийдвэрлэх;
- ГХТХ-д заасны дагуу гамшгийн эрсдэлийн үнэлгээг гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хянахгүй гамшгийн эрсдэлийн мэргэжилтэн хянаж байгаагийн улмаас ажил үүрэг давхар хэрэгжиж байгааг засаж залруулах;
- Хуулийн этгээдүүд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэхэд санхүүгийн хувьд хүндрэлтэй байдаг учраас үнэлгээ хийлгэхгүй байх, хяналт хэрэгжүүлэх боломжгүй байдал үүсэж байгааг харгалзан зохицуулалт хийх;
- ГХТХ-д заасан зарим зохицуулалтууд бусад хуультай уялдахгүй байгаагаас үүдэн гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Тухайлбал, Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалтай холбоотой зохицуулалт болох ГХТХ-ийн 51 дүгээр зүйлийн 51.2-т “Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна” гэж заасан боловч төрийн байгууллагад энэ төрлийн зардал тусгагддаггүй зэрэг нөхцөл байдалд дүгнэлт хийж, шаардлагатай арга хэмжээ авах;
- Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчсөн иргэн, хуулийн этгээдийг торгох торгуулийн хэмжээ хэт бага байгааг нягталж, зохих хэмжээг тогтоох;
- Цөөн гишүүнтэй хуулийн этгээд болон иргэдтэй холбоотой асуудлыг шалгах хяналтын хуудсыг боловсронгуй болгох;
- Цацраг, хими, тэсэрч дэлбэрэх бодис, уул уурхай, мал эмнэлгийн чиглэлээр хяналт шалгалт зохион байгуулах ажил Монгол Улсын Хяналт үнэлгээний үндэсний хорооны тогтоолоор батлагдсан төлөвлөгөөнд тусгаагүй

үндэслэлээр хийгдэх, гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүсэж байгааг зохицуулж шийдвэрлэх.

Дээрхээс дүгнэвэл, ГХтХ-ийн 12 дугаар зүйлд заасан гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт нь практикт бүрэн хэрэгжихгүй байх бөгөөд үүнд, тухайлбал, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх, үүргийг хуульд тодорхой байдлаар тусгаагүй, тэдгээрийн орон тоо дутмаг, хууль хоорондын уялдаа холбоо хангалтгүй гэх мэт хүчин зүйл нөлөөлж байгааг шийдвэрлэж, зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэв.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. *ГХтХ-ийн 8, 9 дүгээр зүйлд заасан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх болон гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх*

Үнэлэх зохицуулалт
8 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх
9 дүгээр зүйл. Гамшгийн эрсдэлийг бууруулах

Гамшгийн талаар эрдэмтэн, судлаачид өргөн хүрээтэйгээр тал бүрээс нь судалж, өөрсдийн үзэл бодлын үүднээс өөр хоорондоо илт зөрүүтэй бус олон янзын тодорхойлолт гаргасан байдаг бөгөөд эдгээр тодорхойлолтод нийтлэг байдаг 2 ойлголт бол нэгд, гамшиг нь ямар нэгэн аюул тохиолдох, хоёрт, түүний улмаас учирсан их хэмжээний хохирлыг арилгахад нийгмийн чадавх хүрэхгүй байх нөхцөлөөр гол төлөв тодорхойлогдоно.³⁰

ГХтХ-ийн 2 дугаар бүлэгт “Гамшгийн өмнөх үйл ажиллагаа”-г хуульчилсан байна. Тус хуулийн 6 дугаар зүйлд зааснаар гамшгийн өмнөх үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тулгуурлах бөгөөд дараах төрөлтэй байна. Үүнд:

- 6.1.1. гамшгийн эрсдэлийг үнэлэх;
- 6.1.2. гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;
- 6.1.3. гамшгийн эрсдэлийг бууруулах;
- 6.1.4. гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах;
- 6.1.5. гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх;
- 6.1.6. гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах;
- 6.1.7. гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх гэж заасан.

Дээрх зохицуулалтуудыг тус хуулийн 7-14 дүгээр зүйлд дэлгэрүүлэн хуульчилсан байна. Хэдийгээр тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.7-д тусгагдаагүй боловч энэ хуулийн 2 дугаар бүлэгт заасан гамшгийн өмнөх үйл ажиллагаанд хамааруулан 11 дүгээр зүйлд “Бэлэн байдлын зэрэгт болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэх” зохицуулалтыг тусгасан. Иймд тус зохицуулалтыг “Гамшгийн өмнөх үеийн үйл ажиллагаа” буюу 6 дугаар зүйлд нэмж тусгах нь зүйтэй.

³⁰ Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, (УБ, 2017), 13 дахь тал.

ГХтХ-ийн 8 дугаар зүйлд “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх” талаарх зохицуулалтыг хуульчилсан бөгөөд тус зүйлийн 8.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна” гэж заасан. Дээрх зохицуулалтаас үзвэл Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байхаар хуульд заажээ. Гэвч энэхүү зохицуулалт зорилгодоо хүрч, практикт бүрэн хэрэгжихгүй байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгийн үед байгууллагын тогтвортой байдлыг хангах, гамшгийн хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлаа хангах, хүн хүч хэрэгслийг хуваарилах талаар тусгаж, гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа гэсэн ангиллаар боловсруулсан байдаг.³¹

2024 оны байдлаар манай улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 261157³² байна. Харин 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 108378 байна. Үүнээс 93453 буюу 82.2 хувь нь 1-9 гишүүнтэй.

Хүснэгт 7. Монгол Улсад бүртгэлтэй ААНБ-ын тоо

Д/д	Ангилал	1-9	10-19	20-49	50-аас дээш	Бүгд
1.	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	0	0	0	0	0
2.	Компани	78729	4665	2716	1516	87626
3.	Хоршоо	3255	582	29	3	3869
4.	Нөхөрлөл	1330	168	100	2	1600
5.	ТӨҮГ, ОНӨҮГ	227	95	76	77	475
6.	Төсвийн байгууллага	1072	754	1990	1181	4997
7.	Төрийн бус байгууллага	8380	414	225	37	9116
8.	Бусад	460	128	58	49	695
Бүгд		93453	6806	5194	2865	108378

Хуулийн этгээд гэдэг нь Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д зааснаар “...өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл...” юм. Хуулийн этгээд гэх ойлголт нь маш өргөн хүрээтэй бөгөөд нэг гишүүнтэй хуулийн этгээд ч цөөнгүй байдаг.

ГХтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу 1 гишүүн болон цөөн гишүүнтэй хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх зайлшгүй шаардлагатай эсэх, энэхүү зохицуулалт оновчтой эсэхийг судлан үзэх нь зүйтэй.

Учир нь тус зүйлийн 8.2-т заасны дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг юм.

³¹ 2025.04.22-ны өдөр ОБЕГ-ын алба хаагчдаас авсан асуумжаас.

³² Үндэсний статистикийн хорооны цахим хуудас www.1212.mn, Сүүлд үзсэн огноо: 2025.04.15

Тиймээс гамшгаас хамгаалах хүрээний дотоод баримт бичгийг цөөн гишүүнтэй хуулийн этгээд боловсруулах шаардлагатай эсэх /Тухайлбал, тодорхой байршилд байрлахгүйгээр цахимаар үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн хувьд/, мөн цөөн гишүүнтэй ч үйл ажиллагаагаа тодорхой байршилд явуулдаг бол гамшгийн төлөвлөгөөтэй байх /Тухайлбал, хүнсний дэлгүүр/ гэх мэт шаардлагыг харгалзан үзэж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой зохицуулалтыг оновчтой байдлаар хийж, боловсронгуй болгох нь зүйтэй.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэд ГХтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавьдаг.

Шигтгээ 1.

Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч 2024-2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 21 аймаг, нийслэл, болон хуулийн этгээдийн нийт 2510 гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж ажилласан. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй хуулийн этгээдэд албан шаардлага хүргүүлж, торгуулийн арга хэмжээ авдаг.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгийн үед байгууллагын тогтвортой байдлыг хангах, гамшгийн хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлаа хангах, хүн хүч хэрэгслийг хуваарилахын зэрэгцээ гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа гэсэн ангиллаар боловсруулсан байдаг.

ОББ-ын алба хаагчдын өгсөн саналаас...

ГХтХ-д гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой зохицуулалтад нэг барилга байгууламжид хэд хэдэн хуулийн этгээд үйл ажиллагаа явуулдаг бол гамшгаас хамгаалах төлөвлөгөөг нэгдсэн байдлаар эсхүл тус тусдаа батлуулах эсэхийг тодорхой хуульчлаагүй байна. Харин гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Дугаар 120 тушаалын³³ гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын 1.4-т “Нэг барилга байгууламжид олон төрлийн байгууллага, хүмүүс үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд уг барилгын үндсэн эзэмшигч тухайн барилгад үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллага, хувь хүмүүстэй хамтран гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулна” гэж заасан. Үүнийг журмаар бус, хуульд тодорхой байдлаар тусгах нь оновчтой бөгөөд зохицуулалтын хэрэгжилт, биелэлтийг нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

Энэ мэтчилэн тус хуульд заагаагүй боловч журмаар зохицуулсан, хуульд тусгах шаардлагатай зохицуулалт цөөнгүй байна. Эдгээрийг сайтар судлан үзэж, тухайн харилцааг зарим тохиолдолд журмаар зохицуулахаас илүүтэй хуульд тодорхой тусгах арга хэмжээ авах нь зүйтэй.

³³ Тус тушаалаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг нэгдүгээр хавсралтаар, Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө боловсруулах зааврыг хоёрдугаар хавсралтаар, Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсан.

Мөн дээрх тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан ““Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын 3.3-т “...ГХТХ-ийн 9 дүгээр зүйлд заасан бүтцийн болон бүтцийн бус үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал хамаарна...” гэж заажээ. Гэвч ГХТХ-ийн 9 дүгээр зүйлд “бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ” гэж хуульчилсан. Хэдийгээр дээрх хоёр ойлголт нь утга агуулгын хувьд нэг ойлголт боловч өөр өөрөөр бичигдсэн байна. Иймд тус тушаалаар батлагдсан заавар, аргачлалыг хуульд заасан нэр томъёотой нийцүүлж өөрчлөх шаардлагатай.

Түүнчлэн ГХТХ-д 9 дүгээр зүйлд гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хуулийн этгээд 5 төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр хуульчилсан байна. Энэхүү 5 төрлийн арга хэмжээний нэг нь гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ юм.

Гэхдээ тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3-т “бүтцийн арга хэмжээ”, “бүтцийн бус арга хэмжээ” гэх нэр томъёог тайлбарлан хуульчилсныг тус хуулийн 4 дүгээр зүйлд заасан “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт” хэсэгт тусгах нь илүү оновчтой бөгөөд ойлгомжтой байдлыг нэмэгдүүлнэ.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. *ГХТХ-ийн 10, 11 дүгээр зүйлд заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах болон бэлэн байдлын зэрэгт болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?*

Үнэлэх зохицуулалт
10 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах 11 дүгээр зүйл. Бэлэн байдлын зэрэгт болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэх

Гамшгийн эрсдэлийг бууруулах гол хүчин зүйлүүдийн нэг нь гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах асуудал юм.³⁴

Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурлаас батлан гаргасан Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан НҮБ-ын гамшгийн эрсдэлийг бууруулах газраас гаргасан нэр томъёоны тайлбарт “Бэлэн байдал гэдэг нь болзошгүй, зайлшгүй болох, одоо байгаа гамшгийн үр дагаврыг оновчтой таамаглах, хариу арга хэмжээ авах, сэргээн босгохын тулд хувь хүн, байгууллага, олон нийт, засгийн газрын боловсруулсан хариу арга хэмжээ, сэргээн босгох мэдлэг, чадвар юм”; “Бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа нь гамшгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд бүх төрлийн онцгой нөхцөл байдлын үед үр дүнтэй удирдах, хариу арга хэмжээ авахаас тогтвортой сэргээн босгоход эмх цэгцтэй шилжихэд шаардлагатай чадавхыг бий болгоход чиглэн хийгдэж байгаа арга хэмжээ юм”³⁵ гэж тодорхойлсон байна.

³⁴Б.Ууганбаяр, Гамшгаас хамгаалах бэлэн байдал, үндэсний даван туулах чадавх, Гамшиг судлал инновац сэтгүүл 2023 он, №2 (11) 48 дахь тал.

³⁵ 51 дэх тал. Дам эшлэв.

Харин ГХТХ-ийн 4.1.24-т "бэлэн байдал" гэж гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг ойлгохоор хуульчилжээ.

Судалгааны явцад ОББ-ын алба хаагчдаас авсан асуумж, санал асуулга, ярилцлагын дүнд, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдал зарласан үед авч хэрэгжүүлэхээр хуульд тусгасан арга хэмжээ оновчтой эсэх, орхигдуулсан буюу нэмж тусгах шаардлагатай харилцаа бий эсэх, шаардлагагүй зохицуулалт тусгасан эсэх, түүнчлэн арга хэмжээг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх арга хэлбэрийн зохист хувилбарын талаар дараах хариулт, холбогдох саналыг өгсөн байна. Үүнд:

- Гамшгийн нөхцөл байдлыг шат, шатанд дараалал харгалзахгүйгээр нэн яаралтай горимоор хэлэлцэж, хууль, бусад шийдвэрийг гаргаж байх;
- ҮАБЗ гамшгийн нөхцөл байдлыг шуурхай хэлэлцэж, Улсын Их Хурал, Засгийн газарт чиглэл, зөвлөмж өгөх, онц байдал зарлах шийдвэр гаргах;
- Гамшгийн үед түр орон байраар хангах, нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргах, шийдвэрийн биелэлтийг хангах зохион байгуулах;
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд нэмэлт хүч хэрэгсэл дайчлан гаргах;
- Гамшгийн үед төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг оролцуулах шийдвэрийг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр гаргах;
- Гамшгийн үед шаардлагатай хөрөнгийг яаралтай шийдвэрлэх;
- Гамшгийн үед нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төрийн үйлчилгээг тасралтгүй явуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Гамшгийн үеийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүнс, бараа, материалын нөөц бүрдүүлэх, холбогдох зардлыг шийдвэрлэх;
- Засгийн газар олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийн арга хэмжээг зохион байгуулах шийдвэр гаргах;
- Гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах Шуурхай штаб томилон ажиллуулах;
- Гамшгийн үед аж ахуйн нэгж байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг нөхөн олговортойгоор дайчлан гаргах ажиллагааг зохион байгуулах;
- Яам, агентлаг нь үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Шуурхай штабыг байгуулах дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр хангах;
- Үүссэн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх;
- Гамшгийн нөхцөл байдлыг үнэлэх;
- Үүссэн нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан дараагийн арга хэмжээг төлөвлөх;
- Үүссэн нөхцөл байдлын мэдээллийг байгууллага, олон нийтэд шуурхай хүргэх;
- Гамшгийн голомтод эрэн хайх, аврах, гал түймэр унтраах ажиллагааг зохион байгуулах;
- Гамшгийн голомт, хорио цээрийн бүсэд хамгаалалт зохион байгуулах, зорчих хөдөлгөөний хязгаарлах;
- Гамшгийн голомтод эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэх мэт.

ГХтХ-ийн 11 дүгээр зүйлд “Бэлэн байдлын зэрэгт болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэх” зохицуулалтыг хуульчилсан. Тус зохицуулалт дахь олон улсын хөл хориот өвчин гэдэгт Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.7-д заасны дагуу Олон улсын эрүүл мэндийн дүрэмд заасан өвчин хамаардаг. Тус зүйлийн 11.2-т “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт бүрэн, эсхүл хэсэгчилсэн байдлаар, шат дараалан, эсхүл шууд шилжүүлнэ” гэж заасан бөгөөд гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар шилжих гэдгийг тус зүйлийн 11.2.1-д тайлбарлажээ.

Ийнхүү тус зүйлийн 11.2.1-д “энэ хуулийн 11.2-т заасан "бүрэн" гэдгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг бүхэлд нь, "хэсэгчилсэн" гэдгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим хэсэг, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийн тодорхой хэсгийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхийг ойлгоно” гэж заасныг ГХтХ-ийн 4 дүгээр зүйлд заасан хуулийн нэр томьёоны тодорхойлолт хэсэгт оруулах нь оновчтой гэж үзэж байна.

ГХтХ-ийн 10 дугаар зүйлд заасны дагуу гамшгийн бэлэн байдал дараах 3 зэрэгтэй. Үүнд:

- Өдөр тутмын бэлэн байдал;
- Өндөржүүлсэн бэлэн байдал;
- Бүх нийтийн бэлэн байдал.

Хүснэгт 8. Гамшгийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Д/д	Өдөр тутмын бэлэн байдал/ Бүх нийтийн бэлэн байдал	Өндөржүүлсэн бэлэн байдал/ Бүх нийтийн бэлэн байдал
1.	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах;	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах;
2.	Харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор ажиллах арга, ажиллагаанд хүн амыг сургаж дадлаажуулах;	Харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор ажиллах арга, ажиллагаанд хүн амыг сургаж дадлаажуулах;
3.	Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах;	Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах;
4.	Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний мэдээллийг түгээх;	Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний мэдээллийг түгээх;
5.	Гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэх;	Гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэх;
6.	Гамшгийн үед дайчлан гаргах хүч хэрэгслийн бүртгэл, тооцоог гаргах.	Гамшгийн үед дайчлан гаргах хүч хэрэгслийн бүртгэл, тооцоог гаргах.
7.	Салбар дундын төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах	Салбар дундын төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах
8.		Гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд хүргэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжүүлэх
9.		Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх
10.		Гамшгийн зарлан мэдээллийг хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх;
11.		Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, хүч

	хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах
12.	Гамшгийн нөөцийг улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэрээр, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлэх
13.	Соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарлах, цуцлах, хориглох;
14.	Харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах
15.	Голомтын бүсээс хүн, мал, амьтан, эд хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, түр орон байр, хүнс тэжээлээр хангах арга хэмжээг зохион байгуулах
16.	Нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх
17.	Төрийн болон төрийн өмчит байгууллагын үүрэг, зориулалт, хөдөлмөрийн нөхцөл, ажлын цагийн хуваарийг тогтоосон хугацаагаар өөрчлөх
18.	Улсын онц чухал, төрийн тусгай хамгаалалтад байгаа болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авах
19.	Стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөрөгдөл болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагад чиглэл болгох, хяналт тавих
20.	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх
21.	Эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах
22.	Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед улсын хил хамгаалах байгууллага холбогдох байгууллагатай хамтран хилийн боомтод тусгай дэглэм тогтоож, мөрдүүлэх
23.	Химийн хорт болон аюултай бодис, ачаа тээвэрлэлтийг хязгаарлах, шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар зогсоох
24.	Зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллага, хуулийн этгээдээс холбогдох мэдээллийг авах бөгөөд тухайн мэдээллийн нууцлалыг хадгалах, түүнчлэн гамшгаас хамгаалахаас бусад зорилгоор урвуулан ашиглахгүй байх
25.	Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ,

	мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна.
--	--

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын гурван зэргийг тодорхойлохдоо, өдөр тутмын бэлэн байдлын үед 7 арга хэмжээ, өндөржүүлсэн бэлэн байдлын үед 17 үйл ажиллагаа, бүх нийтийн бэлэн байдлын үед өдөр тутмын бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх 7 үйл ажиллагаан дээр өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх 17 үйл ажиллагаа, нийт 24 үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхээр заасан. Мөн өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулахаар зохицуулжээ.

Гамшгийн бэлэн байдлыг ийнхүү гурван зэрэгт хуваан үзэх нь ач холбогдолтой боловч өндөржүүлсэн бэлэн байдал болон бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг бараг ижил байдлаар хуульчилсан байна.

Манай улсын хувьд Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор:

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлж, Засгийн газрын 2022 оны 66 дугаар тогтоолоор цуцалсан.
- Засгийн газрын 2020 оны 178, 181, 226, 2021 оны 27, 91 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлж ажилласан.³⁶

Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлж ажилласан.

Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдолтой холбоотой:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 226 дугаар тогтоолоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлж ажилласан.

Бүх нийтийн бэлэн байдал зарласан тохиолдлыг судлан үзвэл:

Хүснэгт 9. Бүх нийтийн бэлэн байдал зарласан тохиолдол

Д/д	Бүх нийтийн бэлэн байдал
-----	--------------------------

³⁶ ОБЕГ-аас ирүүлсэн мэдээллээс.

1.	Засгийн газрын тогтоол Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2020.11.11. Дугаар 178
2.	Засгийн газрын тогтоол 2020.11.15. Дугаар 181 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай
3.	Засгийн газрын тогтоол 2020.12.21. Дугаар 226 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай
4.	Засгийн газрын тогтоол 2021.02.10. Дугаар 27 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай
5.	Засгийн газрын тогтоол 2021.04.08. Дугаар 91 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Манай Улсын хувьд дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай тогтоолыг Монгол Улсын Засгийн газраас 2020, 2021 онуудад хэд хэдэн удаа баталсан байна. Монгол улсад КОВИД-19 цар тахлын зөөвөрлөгдсөн анхны тохиолдол 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр бүртгэгдсэн бол 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр дотоодын халдвар анх батлагдсан. Засгийн газрын зүгээс КОВИД-19 цар тахлын халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлж ажилласан.

Тухайлбал, 2020 оны 1 дүгээр сараас хэсэгчилсэн хөл хорио тогтоож, бөөгнөрөл үүсгэхгүй байх, хил хаах, аймаг хот хоорондын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хориглох, зарим худалдаа, үйлчилгээ, олон нийтийн үйл ажиллагаа, бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоох зэрэг арга хэмжээг авахын зэрэгцээ иргэдийг олон нийтийн газарт заавал амны хаалт зүүхийг сануулж байсан. Хэдийгээр дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан ч 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр дотоодын халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотойгоор КОВИД-19 цар тахлын дэгдэлтийг хумихын тулд Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг нэмэгдүүлж бүх нийтийн бэлэн байдлын зэрэг буюу хатуу хөл хорионы дэглэмд шилжүүлсэн.³⁷

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг нь нийгэмд хатуу хөл хорио тогтоож, иргэдийн тодорхой эрхийг хязгаарлах, хэвийн өдөр тутмын амьдралд маш их хязгаарлалт тогтоож буй үйл явдал бөгөөд хохирол, хор уршгийн хэмжээ улам ихэсэхээс сэргийлдэг. Тухайлбал, Монгол Улсын хэмжээнд 2014-2024 онд нийт 50215 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдож үүний улмаас 4491 (Үүнээс Ковид19 цар тахлын улмаас 1815) хүн амь насаа алдаж, 991308 (Үүнээс

³⁷ [COVID-19-Impact-on-Women-and-girls_Mongolian-Final.pdf](#), Сүүлд үзсэн: 2025.05.02.

Ковид19 цар тахлын улмаас 989816) хүн бэртэж гэмтэн, өвчилж, 11.5 сая толгой мал, амьтан хорогдож, 544.3 тэрбус төгрөгийн шууд хохирол учирсан байна.³⁸

Дээрх тоон мэдээнээс үзвэл, Ковид 19 цар тахлын үед бүх нийтийн бэлэн байдал зарлах зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн бөгөөд цар тахлын улмаас нас барсан хүний тоо сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд болсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан, гэмтсэн, өвчилсөн хүний тооноос харьцангуй их байгаагаас цар тахлын хохирол, хор уршгийн хэмжээ харагдаж байна. Өөрөөр хэлбэл, ГХТХ-д заасан бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт тухайн нийгэм, цаг үед маш ноцтой гамшиг, аюулт үзэгдэл, осол гэж үзсэн тохиолдолд шилжүүлэх бөгөөд өндөржүүлсэн бэлэн байдал нь бүх нийтийн бэлэн байдлын зэргээс нэг шат доогуур гэж энгийнээр тайлбарлаж болно.

Гэтэл сүүлийн жилүүдэд өндөржүүлсэн бэлэн байдлыг ГХТХ-д заасан үндэслэл тогтоогдоогүй байхад зарлаж байгаа нь иргэдэд өндөржүүлсэн бэлэн байдал зарласан ч хэвийн амьдралын горимоор амьдарч болохоор буюу сэтгэл зүйн хувьд үл тоох хэв шинжийг бий болгож байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Дугаар 226 тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн бөгөөд тус тогтоолын 1-д *“Нийслэл Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын агууламж нэмэгдэж, стандартад заасан хүлцэх хэмжээнээс хэтэрсэн нь хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ноцтой аюул учруулах нөхцөл үүссэнийг арилгах, сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор нийслэлийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй”* гэж заажээ.

ГХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг” ойлгохоор, мөн зүйлийн 4.1.2-т “аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг” ойлгохоор, 4.1.3-т “осол” гэж уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг” ойлгохоор тус тус тодорхойлжээ. Тус тодорхойлолтоор агаарын бохирдол нь гамшиг, аюулт үзэгдэл, осолд хамаарахгүй бөгөөд “зэрэг” гэдэг ойлголтын хүрээнд агаарын бохирдлыг “аюулт үзэгдэл”, “осол” хэмээн үзэх нь учир дутагдалтай юм.

Түүнчлэн, 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дээрх тогтоолын дагуу иргэдийн өдөр тутмын амьдралд ямар нэгэн өөрчлөлт гараагүй бөгөөд

³⁸ ОБЕГ-аас ирүүлсэн мэдээлэл.

өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн гэх боловч иргэд үүнд ямар ч ач холбогдол өгөөгүй. Мөн хууль, эрх зүйн орчны хувьд авч үзвэл, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдал зарлах нь эдийн засаг, улс төр, нийгмийн олон талт харилцаанд сөрөг нөлөөллийг бий болгодог. Жишээлбэл, гамшгийн үед Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу гэрээ шууд байгуулах боломжтой. Учир нь тус зүйлийн 35.1.2-т “онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй” гэж заасан. Мөн тус хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу нэг эх үүсвэрээс худалдан авах боломж бүрддэг. Учир нь тус зүйлийн 36.1.7-д “гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд олон улсын чанарын шаардлага хангасан мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол” гэж заасан. Эдгээр зохицуулалтаар олгогдсон боломжийг урвуу байдлаар ашиглаж, хууль зөрчихгүйгээр өөрт болон бусдад давуу байдлыг бий болгох, ашиг хонжоо олох, эдийн засгийн болон бусад олон талт харилцаанд сөрөг үр дагавар бий болгох эрсдэлтэй юм.

Иймд ГХтХ-д заасан үндэслэл тогтоогдсон, шаардлагатай тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, шилжсэн тохиолдолд иргэдийн мэдлэг, оролцоог сайжруулахад анхаарч, ач холбогдлыг ойлгуулж, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах нь зүйтэй.

Бүлгийн дүгнэлт, санал

Судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан дүгнэлт, саналыг тус тайлангийн Дүгнэлт, санал, зөвлөмж бүлэгт нэгтгэн байршууллаа.

3.3.Гамшгийн үеийн үйл ажиллагаа

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ГХтХ-ийн 3 дугаар бүлэгт заасан гамшгийн үеийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа гэсэн үе шатаар тасралтгүй явагдах, нэгээс нөгөөд шилжих багц үйл ажиллагаа бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үе шатуудад хэрэгжих арга хэмжээнүүдийн цогц юм.³⁹

ГХтХ-ийн гуравдугаар бүлэгт “Гамшгийн үеийн үйл ажиллагаа”-г хуульчилсан бөгөөд тус хуулийн 15.1-д “Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, аюулт үзэгдэл, ослын үеийн үйл ажиллагаа дараах арга хэмжээнээс бүрдэнэ:

- 15.1.1.гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах;
- 15.1.2.голомтын бүсийг тогтоох;
- 15.1.3.эрэн хайх, аврах;
- 15.1.4.хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх;
- 15.1.5.гамшгийн хор уршгийг арилгах гэж тус тус заажээ.

Дээрх таван үйл ажиллагааг тус хуулийн 16-20 дугаар зүйлд нарийвчлан зохицуулсан. Ингэхдээ ГХтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т “голомтын **бүсийг** тогтоох” гэж тусгасан боловч 17 дугаар зүйлд “Голомтын **бүс** тогтоох” гэж; тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “эрэн хайх, аврах ажиллагааг **томилгоот шуурхай бүлэг** гүйцэтгэнэ” гэж заасан боловч мөн зүйлийн 18.2-т “**Шуурхай бүлгийн** удирдагч...” гэж нэг нэр томъёог ялгамжтай байдлаар тус тус хуульчилжээ. Иймд дээр дурдсан 2 нэр томъёог нэг мөр болгож боловсронгуй болгох шаардлагатай. Мөн тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Энэ хуулийн **18.1-т...**” гэснийг “Энэ хуулийн **18.1-д...**” гэж өөрчлөх нь зүйтэй.

Түүнчлэн, ГХтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.1-15.1.5-д гамшиг, гамшгийн онцгой нөхцөл, аюулт үзэгдэл, ослын үеийн үйл ажиллагааны таван арга хэмжээг хуульчилжээ. Гэтэл Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Дугаар 416 тогтоолын хавсралтаар баталсан “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө” нь бүтэц агуулга, нэр томъёоны хувьд дээрх зохицуулалтаас зарим талаар зөрүүтэй ойлголтыг агуулж байна. Мөн уг төлөвлөгөө болон Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 08 дугаар тушаалд заасан талуудын үүрэг оролцоо, чиг үүрэг

³⁹ Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо: хөгжлийн хандлага, (УБ, 2013), 97 дахь тал.

тодорхойгүй байна.⁴⁰ Иймд хууль тогтоомжийн уялдаа холбоог хангаж, дээрх төлөвлөгөөг шинэчлэн батлах нь зүйтэй.

Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоол “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө”, Шадар сайдын 2017 оны 11 сарын 02-ны өдрийн 08 дугаар тушаал зэрэгт заасан талуудын үүрэг оролцоо тодорхойгүй байна. Иймд дээрх 416 дугаар тогтоолыг ГХтХ, бусад эрх зүйн орчинтой уялдуулах шаардлагатай.

Гамшгийн үед аюулт үзэгдэл, осол тохиолдохын дөнгөж өмнө үед болон дөнгөж тохиолдсон даруйд хүний амь нас үрэгдэх, гэмтэж бэртэх, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд хохирол учрахыг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээнүүд хамаардаг. Өөрөөр хэлбэл, гамшгийн үе шат нь аюулт үзэгдэл, осол нүүрлэсэн цагаас эхлээд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан зарласан онцгой байдлыг цуцлах хүртэл үргэлжилдэг.⁴¹

Гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэг нь гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах юм. Үүнийг ГХтХ-ийн 16 дугаар зүйлд дараах байдлаар зохицуулжээ.

- | |
|--|
| <p>16.1.Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлэг, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэдээлэх зорилгоор зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулна.</p> <p>16.2.Гамшиг болон аюулын тухай мэдээ, мэдээллийг цуглуулах, холбогдох шийдвэрийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хүргэх, түүнчлэн улс хооронд харилцан мэдээлэл солилцоход харилцаа холбооны бүх төрлийн сүлжээг ашиглана.</p> <p>16.3.Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй.</p> <p>16.4.Голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлэгтэй холбоо зохион байгуулах, мэдээлэл солилцох ажиллагааг онцгой байдлын болон төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага гүйцэтгэнэ.</p> <p>16.5.Гамшгийн зарлан мэдээлэл, түүнийг дамжуулах журмыг Засгийн газар батална.</p> |
|--|

Тус хуулийн 16 дугаар зүйлд заасан гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах зохицуулалтууд нь ерөнхий байдлаар хуульчлагдсан бөгөөд тус зүйлийн 16.5-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Дугаар 339 тогтоолын хавсралтаар баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”-аар энэхүү харилцааг нарийвчлан зохицуулсан болох нь харагдаж байна.

Хуулиар нарийвчлан зохицуулаагүй харилцааг журмаар зохицуулах боломжтой хэдий ч зарим зохицуулалтыг хуульд тусгах шаардлага эсхүл ингэснээр оновчтой болох болох юм. Дээрх журмын 1.3-т “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг ГХтХ-ийн 11.4-т заасны дагуу дамжуулна” гэж заажээ. Гэвч ГХтХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийг 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүйд тооцсон байна. Энэ мэтчилэн ГХтХ-д дүрэм, журам, заавар, аргачлал батлахаар заасан зохицуулалтын дагуу батлагдсан захиргааны

⁴⁰ Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн санал.

⁴¹ Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, (УБ, 2017), 124 дэх тал.

хэм хэмжээний актууд нь хуулийн хүчингүй болсон хэм хэмжээ агуулсан буюу өнөөг хүртэл өөрчлөлт оруулаагүй байдал цөөнгүй байна.

Гамшгийн үеийн үйл ажиллагаа нь гамшиг тохиолдсон үед хөнөөлийн голомтод нэрвэгдэгсдийг эрэн хайх-аврах, яаралтай тусламж үзүүлэх хийгээд хор уршгийг арилгах, хойшлуулшгүй бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Эрэн хайх, аврах гэж гамшгийн аюулын үед хүн, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд яаралтай тусламж хүргэх, гамшгийн голомтоос гаргах үйл ажиллагааг, харин хор уршгийг арилгах гэж хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг багасгах, хоёрдогч аюулын шинж чанарыг бууруулах зэрэг гамшгийг хамгийн бага хохиролтойгоор гэтлэн давахад чиглэсэн хойшлуулшгүй үйл ажиллагааг хэлнэ.⁴²

Эрэн хайх, аврах ажиллагаа нь маш өргөн хүрээг хамрах бөгөөд маш хүнд аюултай нөхцөлд явагддаг онцлогтой. Эрэн хайх, аврах ажиллагааны үр дүн нь гамшгаас хамгаалах бэлэн байдал ямар түвшинд хангагдсанаас ихээхэн хамаарна.⁴³ Эрэн хайх аврах ажиллагааны хүрээнд авах нэг гол арга хэмжээ бол гамшигт өртсөн болон өртөж болзошгүй нутаг дэвсгэрээс хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг авран хамгаалах зорилгоор түр хугацаагаар буюу бүрмөсөн аюулгүй орчинд нүүлгэн шилжүүлэлт хийх юм.⁴⁴

Нүүлгэн шилжүүлэлт гэж болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтоос хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг зохион байгуулалттайгаар аюулгүй орчинд шилжүүлэн байрлуулах арга хэмжээг хэлнэ. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ нь гамшгийн аюул тулгарсан үед гамшиг тохиолдохоос урьдаж аюулын тухай зарлан мэдээлэл өгмөгц гамшигт нэрвэгдэж болзошгүй хүмүүсийг хамгаалах зорилгоор хийгдэнэ. Харин гамшгийн дараа гамшигт нэрвэгдсэн голомтоос аюулгүй бүсэд хүмүүсийг шилжүүлэн байршуулах зорилгоор нүүлгэн шилжүүлэлт хийнэ.⁴⁵

ГХтХ-ийн 19 дүгээр зүйлд хүч хэрэгсэл дайчлан гаргах болон нүүлгэн шилжүүлэх зохицуулалтыг хуульчилсан бөгөөд энэхүү зохицуулалтыг ерөнхий байдлаар тусгажээ. Тус зүйлийн 19.2-т “Энэ зүйлийн 24.1-д заасан хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар батална” гэж заасан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Дугаар 182 тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 340 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-ыг шинэчлэн баталсан.

ГХтХ-д хүч хэрэгсэл дайчлан гаргахтай холбоотой хэд хэдэн зохицуулалтыг тусгасныг хуулийн нэр томьёоны тодорхойлолттой холбон тухайн хэсэгт судалж, үр дагаврыг үнэлсэн болно.

⁴² Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо: хөгжлийн хандлага, (УБ, 2013), 99 дэх тал.

⁴³ Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, (УБ, 2017), 126 дахь тал.

⁴⁴ Мөн тэнд, 128 дахь тал.

⁴⁵ Мөн тэнд.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Дугаар 340 тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ын 2.1-д “Нүүлгэн шилжүүлэлт зарлах шийдвэрийг дараахь тохиолдолд гаргана” гэж заасан. Үүнд:

- 1.1.1. Газар хөдлөлт болж хот, суурин газар нурж, хүн амьдрах нөхцөлгүй болсон;
- 1.1.2. Тухайн газар нутагт техникийн холбогдолтой осол, дэлбэрэлт, цацраг идэвхт бодис болон химийн хорт бодис алдагдсанаас хүн ам, мал, амьтан амьдрах орчин үгүй болсон;
- 1.1.3. Террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, алан хядах ажиллагааны улмаас үүссэн нөхцөл байдалд зайлшгүй арга хэмжээ авах;
- 1.1.4. Ган, зуд тохиолдох, хот, суурин газар, газар тариалан, мал аж ахуй усны хомсдолд орох ноцтой үр дагавар үүссэн;
- 1.1.5. Үер буусан болон үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нөхцөл байдал үүссэн;
- 1.1.6. Хүн ам, мал, амьтны болон олон улсын хөл хориот халдварт өвчин үүссэн болон уг голомтын зэргэлдээ орших суурин газрын хүн ам, мал, амьтныг урьдчилан сэргийлэх зайлшгүй арга хэмжээг авах болсон;
- 1.1.7. Ой, хээрийн болон объектын түймэр гарч байгаль экологи, хот, суурин газрын хүн ам, эд хөрөнгө, барилга байгууламжид бодит аюул учирсан бол нүүлгэн шилжүүлэлт зарлахаар заажээ.

Түүнчлэн, энэхүү журмын 2.2-2.4-т түр хугацаагаар нүүлгэн шилжүүлэлт явуулах шийдвэр гаргах үндэслэл, эрх бүхий албан тушаалтныг дараах байдлаар тусгажээ.

2.2. Баг, хороо, сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарч гамшиг үүссэн буюу үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах ажиллагаа явуулах зорилгоор түр хугацаагаар нүүлгэн шилжүүлэлт явуулах шийдвэрийг тухайн сум, дүүргийн Засаг дарга гаргана. 2.3. Хоёр болон түүнээс дээш сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарч гамшиг үүссэн буюу үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах ажиллагаа явуулах зорилгоор түр хугацаагаар нүүлгэн шилжүүлэлт явуулах шийдвэрийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга гаргана. 2.4. Нийслэлийн болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарч гамшиг үүссэн буюу үүсэж болзошгүй үед түр нүүлгэн шилжүүлэлт явуулах шийдвэрийг Улсын Онцгой комиссын саналыг үндэслэн Засгийн газар гаргана. Бүрмөсөн нүүлгэн шилжүүлэлт явуулахыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах шийдвэрийг гаргахад гамшгийн аюулын онцлог шинж, хамрах цар хүрээ, өрнөх хурд зэрэг олон хүчин зүйл нөлөөлнө. Эдгээр хүчин зүйлийг сайтар тооцоолсны үндсэн дээр хүн амд зарлах ажиллагааг зохион байгуулна. Нүүлгэн шилжүүлэх ажиллагааны тухай хүн амд зарлахад дараах шаардлага тавигдана. Үүнд:

- Зарлан мэдээллээр ажиллах бүх хүмүүсийг хамруулах;
- Аль болох богино хугацаанд зарлан мэдээлэл хүрсэн байх;
- Зарлан мэдээллийн агуулга, ойлгомжтой, хоёрмол утга санаагүй байх;

- Зарлан мэдээллийг хүлээн авсан иргэд юу хийхээ мэддэг байх.⁴⁶

Нүүлгэн шилжүүлэх ажиллагаагаар бүх хүн ам, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлж аюулгүй болгох боломжгүй тул олон тооны хүн амь насаа алдахаас сэргийлэх, гамшгийг хор уршиг багатай даван туулах, гамшгийн дараа богино хугацаанд сэргээн босгох боломжийг бүрдүүлэх зорилгоор ангилан ялгаж, ач холбогдлоор нь эрэмбэлэн нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлага үүсдэг.⁴⁷

Гамшгийн үеийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтын хувьд оновчтой, түргэн шуурхай зөв авч хэрэгжүүлснээс учирч болох эрсдэл, хохирол, хор уршгийг бууруулахад ихээхэн ач холбогдолтой.

ГХтХ-ийн Гуравдугаар бүлэгт заасан гамшгийн үеийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт болон дөрөвдүгээр бүлэгт заасан хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой зохицуулалтууд нь ерөнхий байдлаар хуульчлагдсан бөгөөд холбогдох захиргааны хэм хэмжээний актуудад нарийвчилсан зохицуулалтыг тусгасан байна. Гэхдээ эдгээр харилцаанд хүний эрхийг хязгаарлах, хориг тавих, эд хөрөнгөтэй харилцах зэрэг үйл ажиллагаа, арга хэмжээ үүсдэг тул хуулиар зохицуулах асуудал нэлээд дагуулна.

Түүнчлэн бусад хууль тогтоомж өөрчлөгдсөнтэй холбоотой өөрчлөлтүүдийг зарим журамд оруулаагүйгээс хүчингүй болсон хуулийн зохицуулалтыг тухайн журамд хадгалан мөрдөж байгаа зөрчил байна. Иймд зарим журмын зохицуулалтыг хуульчлах шаардлага байна.

Дээрхээс дүгнэвэл, ГХтХ-ийн 3 дугаар бүлэгт заасан гамшгийн үеийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтууд зорилгодоо хүрч байгаа боловч ихэвчлэн журмаар зохицуулагдаж байгааг тухайлан судалж, хууль зүйн болон бусад шаардлагыг хангуулах үүднээс хуульчлах учиртай.

Бүлгийн дүгнэлт, санал

Судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан дүгнэлт, саналыг тус тайлангийн Дүгнэлт, санал, зөвлөмж бүлэгт нэгтгэн байршууллаа.

⁴⁶ Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, (УБ, 2017), 129 дэх тал.

⁴⁷ Мөн тэнд, 130 дахь тал.

3.4. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

Үнэлгээний тайлангийн энэхүү дэд бүлэгт ГХтХ-ийн V, VI бүлгийн хэрэгжилтийг хамтатган үнэллээ. Учир нь хуулийн V бүлэгт гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлагын талаар, хуулийн VI бүлэгт тэдгээрийн бүрэн эрхийн талаар зохицуулсан буюу эдгээр бүлэгт хамаарах зүйл, хэсэг, заалтууд хоорондоо шууд хамааралтай байх тул хэсэгчлэн үнэлгээ хийх нь тохиромжгүй юм. Иймд эдгээр бүлгийн зохицуулалтын зорилго, агуулгад нийцүүлэн дараах шаардлагуудыг урьдчилан тогтоон шалгуур үзүүлэлтийн томъёололд тусган хэрэгжилтийн байдлыг үнэллээ. Үүнд:

- Зохицуулалтын тодорхой байдал: Удирдлага болон байгууллагын бүрэн эрх хуульд тодорхой, ойлгомжтой тусгагдсан эсэх;
- Чиг үүргийн уялдаа: Удирдлага болон байгууллагын чиг үүрэг уялдаатай буюу хуульд давхцал, хийдэлгүй эсэх;
- Эрх, үүргийн тэнцвэр: Удирдлага болон байгууллагын эрх нь тэдэнд хүлээлгэсэн үүрэгтэй харьцуулахад зохистой, бодит эсэх.

Бүтэц, зохион байгуулалтын дүн шинжилгээ

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний хэмжээний тогтолцоо болох талаар ГХтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна” гэж хуульчилсан. Энэ хүрээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын чиг үүрэг тодорхой, уялдаатай байх нь ГХтХ-ийн “гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах” зорилтыг хэрэгжүүлэх суурь болох юм.

Оролцогч талуудын чиг үүрэг, эрх хэмжээ давхардах, харилцан уялдаа холбоо тодорхой бус тохиолдол нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх тул тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан “мэргэжлийн, нэгдмэл удирдлагатай байх” зарчмыг хэрэгжүүлэх асуудал нэн чухал. Үүний практик хэрэгжилт нь оролцогч талуудын бүрэн эрхээр дамжин илэрнэ.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлд дурдсанаар, гамшгийн хариу арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтад цөөнгүй байгууллага, албан тушаалтан оролцдог, шийдвэр гаргах шат дамжлага олон бөгөөд байгууллагуудын бүрэн эрх, чиг үүрэг ойлгомжгүй зэргээс шалтгаалан КОВИД-19 цар тахлын үед хүний эрх зөрчигдөх шалтгаан болсон гэж үзсэн байна.

Шигтгээ.2

Дэлхийн ихэнх улс оронд КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээний шийдвэрийг Засгийн газар нь гаргаж, гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн хэрэгжилтийг удирдаж, эрүүл мэнд, гамшгаас хамгаалах салбар нь хариу арга хэмжээг хэрэгжүүлж байв. Монгол Улсын тухайд Ерөнхийлөгч, Засгийн газар, УОК, УОК-ын Шуурхай штаб, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба КОВИД-19 цар тахлын хариу арга


хэмжээний шийдвэрийг улсын хэмжээнд гаргах, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс, тэдгээрийн шуурхай штаб орон нутгийн хэмжээний шийдвэр гаргаж, хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулиар тогтоосон гамшгаас хамгаалах, хариу арга хэмжээг авах байгууллагуудын тогтолцоо (Засгийн газар, УОК, УОК-ын Шуурхай штаб, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба зэрэг), харилцан ажиллах горим нь шуурхай, үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгохуйц, тодорхой зохицуулалт биш байна.⁴⁸

Хууль тогтоомжийн зохицуулалт практикт хүндрэл учруулж, сөрөг нөлөөлөл үүсгэсэн талаар Хүний эрхийн үндэсний комисс дүгнэсэн тул гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын тогтолцоонд холбогдох зохицуулалтын тулгамдсан асуудлыг илрүүлэх, удирдлага, байгууллага хоорондын чиг үүргийн уялдаа холбоог нийцүүлэх байдлаар зохицуулалтыг шинэчлэх нь хуулийн хэрэгжилтэд эергээр нөлөөлөх юм.

Дараах бүдүүвч зурагт гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын тогтолцооны өнөөгийн байдлыг схемчилсэн байна. Зурагт харуулснаар гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тогтолцоо үндэсний, аймаг нийслэлийн, сум дүүргийн, баг хорооны, ААНБ, иргэд хүртэл бүх түвшинд бүрдсэн байна. Иймд, хуульд заасан голлох байгууллагууд болон бусад байгууллагын чиг үүргийн уялдааг хуулийн зохицуулалтад тулгуурлан шалгая.

⁴⁸ Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл, 62 дахь тал, (УБ, 2022 он)

Зураг 1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага⁴⁹



⁴⁹ Онцгой байдлын ерөнхий газар, Онцгой байдлын байгууллага 20 жил, (УБ.,2024 он)

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага

Үнэлэх зохицуулалт
22.3.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын эрх зүйн байдал, чиг үүрэг хуульд оновчтой тодорхойлогдсон эсэх

Хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгээр гамшиг, гамшгийн онцгой нөхцөл үүссэн үед удирдлагыг төвлөрүүлж, нэгдсэн зохицуулалт бий болгох шаардлагыг хуульчилжээ. Энэ нь гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед шуурхай шийдвэр гаргах, зохион байгуулалт хийх буюу цаашлаад төрийн удирдлага төвлөрсөн шинжтэй байх гол зорилго агуулна. Хуулийн энэ хэсэгт орсон өөрчлөлтийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 10. Хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн харьцуулалт

2017 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн “Гамшгаас хамгаалах тухай хууль”-д тусгагдсан байдал.	2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар өөрчлөн найруулсан.	2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн “Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар өөрчлөлт оруулсан.
22.3.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хяналт тавих зорилгоор Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.	22.3.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.	22.3.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.
УОК-ын чиг үүрэг: Хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хяналт тавих	УОК-ын чиг үүрэг: Үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих	УОК-ын чиг үүрэг: нийслэл, сум гэснийг сум, нийслэл болгон өөрчилсөн байна.

Харьцуулвал, УОК нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүрэгтэй байсныг 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулж УОК-ыг “гамшиг, гамшгийн онцгой байдлын үед” гэж ажиллах хүрээг тогтоон, “...үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах” гэж бүрэн эрхийг өргөтгөсөн байна.

“Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед” гэж тодотгосныг хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт дараах байдлаар тайлбарласан. Үүнд:

4.1.1. “гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

4.1.19. “гамшгийн онцгой нөхцөл байдал” гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг.

Эдгээр тодорхойлолтоос, УОК нь нийтийг хамарсан шинжтэй болоод хохирлын хэмжээ нь эдийн засаг, нийгмийн аюулгүй байдалд нөлөө бүхий гамшгийн үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдан, зохион байгуулахаар байна. Харин шийдвэр гаргах эрхийн тухайд, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, онцгой ажиллагааг удирдан чиглүүлнэ.” гэж Засгийн газрын бүрэн эрхээр тогтоосон тул удирдан чиглүүлэх эрх гагцхүү Засгийн газарт хадгалагдах ба Засгийн газрын шийдвэрийн хүрээнд Улсын онцгой комиссын үйл ажиллагаа буюу шийдвэр гаргах эрх хэрэгжихээр байна. Товчилбол, УОК-ыг Засгийн газраас байгуулж буй тул гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед Засгийн газраас чиглэл авах, санал хүргүүлэх болон Засгийн газрын шийдвэрийн хүрээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй.

Хуульд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдан, зохион байгуулахтай холбоотой Онцгой комисс болон ОББ-ын чиг үүргийг тогтоосон зүйл, заалтуудыг хүснэгт 11-д харуулав. Энэ хүрээнд хууль хэрэглээний хувьд ойлгомжгүй, агуулгын хоёрдмол утгатай дараах зүйл, заалтууд байна. Тухайлбал:

А.Хуулийн 22 дугаар зүйлд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалтын талаар зохицуулсан ба энэ зүйлд УОК нь “гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед” гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах гэж тусгасан боловч Онцгой комиссын бүрэн эрхийн талаар зохицуулсан 27¹ дүгээр зүйлд дээрх **тодотгосон хугацааг орхигдуулж** “гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах” гэж хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, 27^{1.1} дэх хэсэг нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны **бүх үе шатыг** УОК хариуцах агуулгатай болжээ.

Хүснэгт 11. Онцгой комиссын чиг үүрэг

22 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт	27 ¹ дүгээр зүйл. Онцгой комиссын бүрэн эрх
22.3. Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.	27 ^{1.1} . Улсын онцгой комисс гамшгаас хамгаалах асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 27 ^{1.1.1} . гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах , шийдвэр гаргах, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хяналт тавих;

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа гэсэн үе шатаар тасралтгүй явагдах, нэгээс нөгөөд шилжих, багц үйл ажиллагаа бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үе шатуудад хэрэгжих арга хэмжээнүүдийн цогц⁵⁰ тул хуулийн 22 дугаар зүйлд нийцүүлж онцгой комиссын бүрэн эрх хэсэгт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэв.

Б. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт Онцгой байдлын асуудал эрхэлсэн **Засгийн газрын гишүүн** гамшгаас хамгаалах үйл ажиллагааг **чиглүүлэхээр**, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх хэсэгт гамшгаас хамгаалах үйл ажиллагааг **удирдан чиглүүлэхээр** тус тус заасан байна. Мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт ОББ-ын дарга гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаар, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт ОББ гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангахаар тус тус заажээ.

Хүснэгт 12. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага

Онцгой комисс	Онцгой байдлын байгууллага
23 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага	
23.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж , засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ.	
28 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх 28.1.1.гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан чиглүүлэх;	42 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоо 42.1.Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.

Үүнээс үзвэл, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн **удирдан чиглүүлэх** бол **ОББ удирдан зохион байгуулах** үүрэгтэй гэж ГХтХ-д тусгажээ. Эдгээр зохицуулалтууд нь эрх бүхий этгээдүүдийн чиг үүрэгт давхардал үүсгэсэн буюу “удирдан чиглүүлэх болон удирдан зохион байгуулах” чиг үүргийн ялгаатай байдал тодорхой бус, хууль хэрэглээний хувьд нийтэд ойлгомжтой байх шаардлагыг алдагдуулсан шинжтэй байна.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. *Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо үр дүнтэй, шуурхай хэрэгжиж байгаа эсэх*

⁵⁰ Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо: хөгжил, хандлага, (УБ., 2013 он), 97 дахь тал.

Шигтгээ.3

Өнгөрсөн хоёр жилд УОК хоёр удаа, УОК-ын Шуурхай штаб гурван удаа өөрчлөгдсөн байна. КОВИД-19 цар тахлын эхэн үед УОК нь Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолоор баталсан бүрэлдэхүүнээр ажиллаж байсан нь 2020 оны 06 дугаар сард явагдсан УИХ-ын ээлжит сонгуулийн үр дүнд өөрчлөгджээ. Шинээр байгуулсан Засгийн газрын гишүүдээс бүрдсэн УОК мөн оны 07 дугаар сард байгуулагдаж, 2021 оны 01 дүгээр сарын 21- ний өдөр Засгийн газар огцрох хүртэл 6 сар орчим үйл ажиллагаа явуулсан байна. 2020 оны 01 дүгээр сараас 2022 оны 03 дугаар сар хүртэл УОК-ын дарга гурван хүн солигдон ажиллажээ. УОК-ын Шуурхай штабыг 2020 оны 03 дугаар сард ОБЕГ-т, 2020 оны 11 дүгээр сард ЭМЯ-д байгуулсан болохыг өмнө дурдсан. УОК-ын бүрэлдэхүүн өөрчлөгдөхөд УОК-ын Шуурхай штаб мөн өөрчлөгдөж байсан бөгөөд 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр УОК-ын Шуурхай штаб, НОК-ын Шуурхай штабыг нэгтгэж, УОК-ын Нэгдсэн Шуурхай штаб байгуулагдах хүртэл энэ бүтцийг гурван удаа шинэчлэн байгуулж, бүрэлдэхүүнийг өөрчилсөн байна. Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан нийгмийн халдварт өвчний үед хариу арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх үндсэн бүтэц болох Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албыг зохих ёсоор ажиллуулалгүй УОК-ын Шуурхай штабыг байгуулсан, УОК, УОК-ын Шуурхай штаб нэг бүрэлдэхүүнээр тогтвортой ажиллаагүй зэрэг нь хариу арга хэмжээний шийдвэр оновчтой бус байх, хэрэгжилт цалгардах, цар тахалтай тэмцэх бэлтгэл хангах цаг хугацааны боломжийг алдахад хүргэсэн байж болзошгүй юм.⁵¹

Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хариу арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэйгээр Засгийн газраас гадна УОК гэсэн бүтэц байгаа нь давхардал үүсгэж байгаа талаар ХЭҮК-ын тайланд дурдсан байна. УОК-ын үйл ажиллагаа нь тогтворгүй буюу зохицуулалт хэд хэдэн удаа өөрчлөгдсөн нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан “мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх” зарчим хөндөгдсөн гэж хэлж болно. Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед иргэд, олон нийтэд чиглэсэн гамшгаас хамгаалах арга хэмжээ нь хүний эрх, эрх чөлөөг тодорхой хугацаа, хүрээнд хязгаарлах шинжтэй байдаг тул Засгийн газраас шийдвэр гаргах, Засгийн газраас баталсан дүрэм, журам үйлчлэх нь чухал нөлөөтэй. КОВИД-19 цар тахлын үед дэлхийн ихэнх улс оронд Засгийн газраас нэгдсэн удирдлагаар хангах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Харин манай улсад хэд, хэдэн шат дамжлагаар шийдвэр гарах үйл явц хэрэгжсэнээр, тухайн шийдвэр, дүрэм, журмууд нь хоорондоо зөрчилдөх байдлаар хүний эрхийн зөрчил нэлээд гарсан талаар эх сурвалжид тусгажээ.

Зарим жишээг дурдвал, Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоол гарч хот, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хооронд хүнсний болон бусад ачаа тээвэрлэлтийг хэвийн явуулах, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас (ажлын зайлшгүй шаардлага, хойшлуулшгүй ажил, албан томилолт, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ, ар гэрийн гачигдал гэх мэт) хот хооронд зорчих төрийн албан хаагч, иргэдийн нотлох баримтыг үндэслэн хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр хяналтын хэсгээр шалган нэвтрүүлж ажиллахыг НОК-ын даргад үүрэг болгожээ.

Үүний дагуу Нийслэлийн онцгой комиссын дарга 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр “Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай товчоонд коронавируст (Ковид-19) халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн хяналт,

⁵¹ Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл, 67 дахь тал, (УБ., 2022 он)

тандалт хийх түр заавар”-ыг баталсан. Түр зааварт эрүүл мэндийн архаг хууч өвчтэй, гэнэтийн осол гэмтлийн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн үед халдвар хамгааллын хувцас хэрэгсэл бүрэн өмсөж, тусламж үйлчилгээ үзүүлэх, халдварын тохиолдол бүртгэгдсэн орон нутгаас ирж буй иргэдийг орон нутгийн онцгой комиссын шийдвэр, ПГУ шинжилгээний хариу сөрөг гарсныг нотлох баримттай, халдварын тохиолдол гараагүй бүс нутгаас ирсэн иргэнийг асуумж судалгаа, иргэний үнэмлэхийн хаягийг үндэслэж, хот руу нэвтрүүлэхээр зохицуулжээ. Уг зохицуулалтаас үүдэн, эрүүл мэндийн зайлшгүй шалтгааны улмаас Улаанбаатар хотод эмчлүүлэхээр ирсэн иргэнийг шинжилгээнд хамрагдаагүй гэсэн шалтгаанаар олон цаг авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоон дээр саатуулсны улмаас иргэн эрүүл мэндийн тусламж авч чадалгүй амь насаа алдсан тохиолдол гарсан. Уг тохиолдыг зөвлөмжид дүгнэхдээ, Монгол Улсын нэгдэн орсон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пактын 12 дугаар зүйлийн 2 (d) “...өвчилсөн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх, сувилах нөхцөлийг бүгдэд бий болгох...” гэж заасныг зөрчсөн байна. Хөл хорионы үед зөвхөн нийтийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс хуулийн дагуу хязгаарлалт хийж болох хэдий ч энэхүү хязгаарлалт нь хүний амь насанд хүрсэн, хэр хэмжээнээсээ хэтэрсэн хязгаарлалт болсон. Иймд эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйгээс шалтгаалан хүний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрх, улмаар амьд явах эрх зөрчигдсөн байна⁵² гэжээ.

Дээр дурдсан тохиолдолд, УОК-оос гаргасан тогтоолын хүрээнд Нийслэлийн онцгой комисс заавар баталсан байна. Уг заавар нь УОК-ын тогтоолыг биелүүлэх зорилгоор, практикт хэрэгжүүлэх нарийвчилсан үйл ажиллагаануудыг тогтоож өгсөн боловч процесс ажиллагаанаас хамааран хүний амь нас эрсдэх шалтгаан болсон байна. Энэ нь гамшгаас хамгаалах арга хэмжээг шат шатны түвшинд хэрэгжүүлэхэд шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэрт хуулиар хязгаар тогтоогоогүй буюу тухайн түвшний эрх бүхий этгээд нь нийтэд болон тодорхой этгээдэд чиглэсэн шийдвэр гаргахад “хуульд нийцсэн байх” зарчим алдагдаж болохыг харуулж байна. Гамшиг болон гамшгийн онцгой нөхцөл байдлын үед шуурхай арга хэмжээ авах нь нэн чухал боловч шийдвэр нь Монгол Улсын үндсэн хуульд нийцсэн байх, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцид нийцсэн байх болон бусад хууль тогтоомжид нийцсэн байх шаардлага тэргүүн ээлжинд тавигдана. Энэ нь гамшиг болон гамшгийн онцгой байдлын үед хүний эрхийг зөрчихгүй байх суурь нөхцөл болно.

УОК нь Онцгой комиссын үйл ажиллагаа, тэдгээрийн шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, хүний эрхийг зөрчих эрсдэлтэй эсэхэд урьдчилан дүн шинжилгээ хийх шаардлагатайг харуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн 1/улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон бол онц байдал зарлах эрхийг Улсын Их Хурлын бүрэн эрхэд хадгалуулж, Монгол Улсын Засгийн

⁵² Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, (УБ.,2021 он), 11 дэх тал.

газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгээр “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, онцгой ажиллагааг удирдан чиглүүлнэ.” гэж Засгийн газрын бүрэн эрхийг тогтоосон Иймд гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед удирдан чиглүүлэх эрх гагцхүү Засгийн газарт хадгалагдаж байна.

Энэ талаар мөн комиссын илтгэлд “Засгийн газрын 2008 оны 11 дүгээр тогтоолоор “Улсын онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журам” баталжээ. Үүнд тусгасан бүтэц нь 2017 онд баталсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад өвлөгдөн үлдсэн байна. Монгол Улсын гамшгаас хамгаалах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, уялдаа холбоог 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн хянаж үзэхийг КОВИД-19 цар тахал санууллаа” гэжээ.

Мөн гамшгаас хамгаалах хүрээнд дүрэм, журам батлах эрхийг Засгийн газар болон УОК-д олгосон. Хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.9 дэх заалтад “гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж тодотгосон боловч энэ нь практикт “гамшгаас хамгаалах талаар” гэсэн хэсгээс ялгаатай эсэх нь тодорхой бус бөгөөд тохирох шинжээр зааглаагүй байна.

Хүснэгт 13. Дүрэм, журмыг батлах бүрэн эрх

26 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх	27¹ дүгээр зүйл.Онцгой комиссын бүрэн эрх
26.1.1.Монгол Улсын гамшгаас хамгаалах талаар дүрэм, журмыг батлах ;	27 ¹ .1.9.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлах

Хуульд заасан журмын хүрээнд

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.8 дахь заалтад “Тухайн хуулиар нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх”, 29.1.5 дахь заалтад “Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх” нийтлэг шаардлагыг заасан. Хуулийн зургадугаар бүлэгт гамшгаас хамгаалах удирдлагын бүрэн эрх буюу МУИХ, ҮАБЗ, МУЗГ, Үндэсний болон орон нутгийн зөвлөл, УОК, ОК, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, ОБЕГ болон тус газрын дарга, НӨУБ, Засаг дарга, Гамшгаас хамгаалах албаны чиг үүргийг тус тус тогтоосон.

Иймд гамшгаас хамгаалах удирдлагын бүрэн эрхийг тогтоосон зүйл, хэсэгт тухайлан үнэлгээ хийхийн өмнө, нэн тэргүүнд удирдлагын эрх хэмжээ, чиг үүргийг тогтоосон хэм хэмжээнүүд хоорондоо давхардал, зөрчил, хийдэлтэй эсэхийг нягтлах нь зүйтэй. Шат, шатны удирдлагын бүрэн эрх уялдаатай байх нь гамшгаас хамгаалах цогц үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх суурь нөхцөл байх тул чухал ач холбогдолтой гэж үзэв.

Гамшгаас хамгаалах тухай хууль нь энэ хууль болон Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, хэм хэмжээний актаас бүрдэх талаар хуулийн 2 дугаар зүйлд заасан. Энэ хэсэгт ГХтХ-д заасан хэм хэмжээний актыг эрх бүхий байгууллагаас баталж, хэрэгжүүлж байгаа тохиолдолд

зорилгод хүрсэн түвшин шалгуурыг хангасанд тооцох юм. Харин хуулийг дагалдан батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхгүй болно.

ГХтХ-д эрх олгосон буюу журам батлах тухай нийт 27 заалт байгааг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 14. ГХтХ-д заасан журмын жагсаалт

Д/д	ГХтХ-д дүрэм, журам, заавар, аргачлал батлахаар заасан зохицуулалт	Баталсан он, сар, өдөр, дугаар
1.	7.4.Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2020.11.25. Дугаар 190
2.	8.3.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Шадар сайдын тушаал 2018.12.07. Дугаар 120
3.	10.2.Гамшгийн бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.	ОБЕГ-ын даргын тушаал 2023.12.01. А/383
4.	10.8.Энэ хуулийн 10.4.2-т заасан ажлын тусгай горимоор ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.	ОБЕГ-ын даргын тушаал 2018.09.03 А/274
5.	12.2.Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2006.05.12 Дугаар 105
6.	15.3.Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.	ОБЕГ-ын даргын тушаал 2014.12.09 А/339
7.	16.5.Гамшгийн зарлан мэдээлэл, түүнийг дамжуулах журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2011.11.30 Дугаар 339
8.	17.2.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, ажиллах журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2018.08.22 Дугаар 266
9.	18.5.Энэ хуулийн 18.1-д заасан томилгоот шуурхай бүлгийн ажиллах журам, зааврыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.	ОБЕГ-ын даргын тушаал 2024.04.30 А/147
10.	19.2.Энэ хуулийн 24.1-д заасан хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2024.05.01 Дугаар 182
		Засгийн газрын тогтоол 2011.11.30 Дугаар 340
11.	20.3.Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2019.01.09 №1
12.	20.4.Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2019.04.10 Дугаар 133
13.	22.6.Салбар дундын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, уялдуулан зохицуулах, мэдээ, мэдээлэл солилцох, хүч хэрэгсэл, нөөцийг оновчтой хуваарилах зорилгоор төрийн	Шадар сайдын тушаал 2025.01.29 Дугаар 15

	захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус Улсын албыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, сум, нийслэл, дүүрэгт орон нутгийн албыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна.	
14.	22.9.Үндэсний зөвлөл, Улсын онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар, гамшгаас хамгаалах улсын албаны бүрэлдэхүүн, ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн ангийн ажиллах дүрмийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.	Засгийн газрын тогтоол 2008.01.16 Дугаар 11
		Шадар сайдын тушаал 2025.01.29 Дугаар 15
		ОБЕГ-ын даргын тушаал 2024.11.01 Дугаар А/379
15.	26.1.2.Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлах, гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэлийг тогтоох;	Засгийн газрын тогтоол 2018.10.31 Дугаар 327
16.	27 ¹ .1.9.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлах.	-
17.	28.1.5.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавар, салбар хоорондын харилцан ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг батлах;	Шадар сайдын тушаал. 2018.05.03 Дугаар 45
		Шадар сайдын тушаал. 2018.12.13 Дугаар 125
18.	30.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон онцгой байдлын байгууллагад дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, стандартыг баталж мөрдүүлэх;	-
19.	36.4.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Шадар сайдын тушаал 2018.03.13 Дугаар 24
20.	38.1.Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулна.	Засгийн газрын тогтоол. 2020.10.07 Дугаар 133.
21.	40.3.Тусламж үзүүлэгч талын үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр төрийн болон нутгийн захиргааны байгууллага, олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Шадар сайдын тушаал 2018.11.30 Дугаар 117
22.	42.8.Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Шадар сайдын тушаал 2019.06.14 Дугаар 51/өмнөх/
		Шадар сайдын тушаал 2025.06.02 Дугаар 51/шинэ/
23.	46.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны	Ерөнхийлөгчийн зарлиг 2021.12.30 Дугаар 136

	эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.	Засгийн газрын тогтоол 2018.02.06 Дугаар 41 ОБЕГ-ын даргын тушаал
24.	46.4.Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн таних тэмдгийн загвар, хэрэглэх журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Шадар сайдын тушаал 2021.07.02 Дугаар 67
25.	50.6.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Засгийн газрын тогтоол 2018.12.19 Дугаар 380
26.	50.8.Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2018.12.12 Дугаар 374
27.	50.13.Энэ хуулийн 50.10, 50.11, 50.12-т заасан нэмэгдэл, мөнгөн урамшуулал, нөхөн олговор олгох журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2020.11.04 Дугаар 165

Энэхүү хүснэгтэд хуулийн 27 дугаар 27.1.9⁵³, 30 дугаар зүйлийн 30.1.4⁵⁴ -ийн хүрээнд баталсан журмын мэдээллийг оруулаагүй болно. Хуулийн 25 хэсэг, заалтын хүрээнд 31 орчим хэм хэмжээний акт батлагдсан байна. Эдгээр эрх олгосон агуулга бүхий ихэнх заалтад тухайн захиргааны хэм хэмжээний актын ерөнхий нэр, батлах субъектийг томъёолсноос бус ямар төрлийн харилцааг **хэрхэн зохицуулах, түүний хүрээ, хязгаарыг** оновчтой тодорхойлсон нь цөөн юм. Энэ нь хуулиар тогтоосон хэм хэмжээнээс давсан хэм хэмжээг журмаар тогтоосон эсэх, хуулиар зохицуулах харилцааг журмаар зохицуулсан эсэх зэрэг асуудлыг тогтоох шаардлагатайг харуулж байна. Мөн журмын хэрэгжилт болон журам хоорондын харилцан уялдааг үнэлсэн дүн шинжилгээ, судалгаа хийгдээгүй байгааг анхаарах нь зүйтэй байна.

Ийнхүү хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиас гадна хуулиар эрх олгосон 25 заалтын хүрээнд хэм хэмжээ тогтоосон захиргааны актууд гамшгаас хамгаалах харилцааг зохицуулж байгаагаас үзвэл хууль болон хуульчилсан дэд актын бүтцэд захиргааны хэм хэмжээний актын эзлэх хувь давамгайлж, хоорондын тэнцвэр алдагдаж, харилцан нөлөөлөх хэмжээнд хүрч болзошгүй юм.

Хэлбэрийн хувьд хуулийн дагуу журам батлагдсан эсэх нь шаардлага хангаж болох ч агуулгын хувьд журмууд нь зөрчил, хийдэл, давхардал үүсгэсэн эсэхийг шалгаж тогтоох нь чухал байна. Журмын тоо олшрох нь ГХТХ-д холбогдох харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээ “тогтвортой” байх гол шинж алдагдах, улмаар салбарын харилцааг төлөвшүүлэхэд сөрөг үр дагавартай байж болох юм.

⁵³ 27¹.1.9.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлах.

⁵⁴ 30.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон онцгой байдлын байгууллагад дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, стандартыг баталж мөрдүүлэх;

Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн “Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”-д дурдсанаар, өөрийн эрхлэх асуудлын хүрээ, үйл ажиллагаанд хамаарах хэм хэмжээ тогтоосон актаас дараах шинжийг агуулсан актыг хуульд тусгах шаардлагатай гэж үзэж хуулийн төсөл боловсруулах талаар заасан байдаг. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, хориглосон болон ямар нэгэн байдлаар хөндсөн агуулга бүхий зохицуулалттай;
- Тогтмол давтагдах процессын шинжтэй зохицуулалт агуулсан;
- Нэг удаа батлахад удаан хугацаанд тогтвортой мөрдөгддөг хэм хэмжээ агуулсан.

Иймд гамшгаас хамгаалах талаар практикт хэрэгжиж байгаа дүрэм, журам, стандарт, заавар зэрэгт дүн шинжилгээ хийж, дээрх удирдамжид заасан шинжийг агуулсан хэм хэмжээний актаар зохицуулж буй харилцааг хуульчлах шаардлагатай.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны оролцогч талууд

Хүснэгт 15. Чиг үүргийн тодорхой байдал

Д/д	Оролцогч тал	Хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт	Чиг үүрэг хуульд тодорхой эсэх
1.	Монгол Улсын Их Хурал	25 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх	Хуульд тухайлан заасан
2.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	25 ¹ дүгээр зүйл.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүрэн эрх	Хуульд тухайлан заасан
3.	Засгийн газар	26 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх	Хуульд тухайлан заасан
4.	Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл	27 дугаар зүйл. 27 дугаар зүйл.Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэн эрх	Хуульд тухайлан заасан
	Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл	27.2.Орон нутгийн зөвлөл энэ хуулийн 27.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.	Хуульд тухайлан заасан
5.	Улсын онцгой комисс	27 ¹ дүгээр зүйл.Онцгой комиссын бүрэн эрх	Хуульд тухайлан заасан
	Онцгой комисс	27 ¹ .2.Орон нутгийн онцгой комисс нь энэ хуулийн 27 ¹ .1.1, 27 ¹ .1.2, 27 ¹ .1.3, 27 ¹ .1.4, 27 ¹ .1.5, 27 ¹ .1.6, 27 ¹ .1.7, 27 ¹ .1.8-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.	Хуульд тухайлан заасан
6.	Онцгой байдлын байгууллага	29 дүгээр зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	Хуульд тухайлан заасан

7.	Улсын алба	33.1.Гамшгаас хамгаалах улсын алба дараахь чиг үүрэгтэй:	Хуульд тухайлан заасан
	Орон нутгийн алба	33.3.Орон нутгийн гамшгаас хамгаалах алба энэ хуулийн 33.1-д заасан чиг үүргээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлнэ.	Хуульд тухайлан заасан
8.	Мэргэжлийн анги	4.1.17."мэргэжлийн анги" гэж сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, <u>гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн</u> орон тооны бус томилгоот нэгжийг;	Гүйцэтгэх чиг үүрэг/ бүрэн эрх тодорхой бус (дүрмээр зохицуулахаар заасан)
9.	Монголын улаан загалмай нийгэмлэг	39.4.Монголын улаан загалмай нийгэмлэг нь олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэг, холбоонд хандан гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж хүсэх, хүлээж авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.	Гүйцэтгэх үүрэг тодорхой
10.	Шуурхай штаб	27 ¹ .1.6.шаардлагатай тохиолдолд гамшгаас <u>хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах</u> шуурхай штабыг, орон нутагт шуурхай бүлгийг байгуулж, ажиллуулах;	Хуульд гүйцэтгэх чиг үүрэг/ бүрэн эрх тодорхой бус
	Шуурхай бүлэг	18.1.Эрэн хайх, аврах ажиллагааг томилгоот шуурхай бүлэг гүйцэтгэнэ. 18.5.Энэ хуулийн 18.1-т заасан томилгоот шуурхай бүлгийн ажиллах журам, зааврыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.	Хуульд гүйцэтгэх чиг үүрэг/ бүрэн эрх тодорхой бус (журам, заавраар зохицуулахаар заасан)
11.	Нутгийн өөрөө удирдах байгууллага	31 дүгээр зүйл.Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх	Хуульд тухайлан заасан
12.	Засаг дарга	32 дугаар зүйл.Засаг даргын бүрэн эрх	Хуульд тухайлан заасан
13.	Хуулийн этгээд	34 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг	Хуульд тухайлан заасан
14.	Төрийн бус байгууллага	35 дугаар зүйл.Төрийн бус байгууллагын эрх, үүрэг	Хуульд тухайлан заасан
15.	Сайн дурын хэсэг	36 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг	Хуульд тухайлан заасан

16.	Иргэн	37 дугаар зүйл.Иргэний эрх, үүрэг	Хуульд тухайлан заасан
-----	-------	-----------------------------------	------------------------

Бүрэн эрхийн тодорхой бус байдал

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны оролцогч талуудын бүрэн эрхийг хуульд тогтоосон байдлаас үзвэл, мэргэжлийн анги, шуурхай штаб болон шуурхай бүлгийн үйл ажиллагаа хуульд тодорхой бус байна. Хэдийгээр эдгээр оролцогч талуудын үйл ажиллагааны чиглэлийг журмаар зохицуулахаар ГХтХ-д заасан боловч тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлоогүй байна. Тухайлбал:

- “Мэргэжлийн анги” гэдгийг тус хуулийн Нэр томъёоны тодорхойлолт хэсэгт “...гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгж” гэж тодорхойлсон бөгөөд тус хуульд мэргэжлийн анги гэдэг үг хэллэг нийт 14 удаа тусгагджээ.
- Хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.6 дахь заалтад “шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах шуурхай штабыг, орон нутагт шуурхай бүлгийг байгуулж, ажиллуулах” гэж заасан бол үүнээс өөр шуурхай штабын чиг үүргийг тодорхойлсон агуулгатай зохицуулалт байхгүй. Харин шуурхай бүлгийн тухайд хуулийн 18 дугаар зүйлд заасан чиг үүргээс өөр хэрэгжүүлэх чиг үүрэг бий эсэх нь тодорхойгүй. “Шуурхай штаб” гэж 4 удаа, “шуурхай бүлэг” гэж нийт 2 удаа уг хуульд орсон байна.

Хууль хэрэгжүүлэх үүрэг бүхий этгээдтэй холбогдох харилцааг тухайлан журам, дүрмээр нарийвчлан зохицуулж болох ч тухайн этгээдийн үндсэн чиг үүргийг хуулиар тодорхойлох нь зүйтэй. Үүнийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.8 дахь заалтад “тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, **эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг**, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, **нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг** тусгасан байх” шаардлагыг тусгасан.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор өөр хуульд байгаа, эсхүл тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ.” гэж заасныг ГХтХ-ийн 27¹.2-т хэрэглэн “**Орон нутгийн онцгой комисс.....бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ**” гэж заасан боловч чиг үүргийг хэрэгжүүлэх этгээд өөрт хамаарах бүрэн эрхийг **сонгох, тогтоох** нөхцөлийг бүрдүүлжээ.

Хүснэгт 16. Чиг үүргийн тухай тодорхой бус зохицуулалт

Д/д	Хуулийн зүйл	Агуулга
1.	27 дугаар зүйл.Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэн эрх	27.2.Орон нутгийн зөвлөл энэ хуулийн 27.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
2.	27 ¹ дүгээр зүйл.Онцгой	27 ¹ .2.Орон нутгийн онцгой комисс нь энэ хуулийн

	комиссын бүрэн эрх	27 ¹ .1.1, 27 ¹ .1.2, 27 ¹ .1.3, 27 ¹ .1.4, 27 ¹ .1.5, 27 ¹ .1.6, 27 ¹ .1.7, 27 ¹ .1.8-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
3.	30 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх	30.2.Орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга энэ хуулийн 30.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
4.		30.3.Орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.
5.	32 дугаар зүйл.Засаг даргын бүрэн эрх	32.2.Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 32.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
6.	33 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг	33.3.Орон нутгийн гамшгаас хамгаалах алба энэ хуулийн 33.1-д заасан чиг үүргээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах тухай хууль нь гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон боловч хэрэгжүүлэх явц, бүтцийн зохион байгуулалт, хууль хэрэглээний хувьд давхардал, хийдэл, зөрчилтэй, хүндрэл, бэрхшээлтэй асуудал цөөнгүй байгааг V, VI бүлгийн зохицуулалтын хэрэгжилтийн дүн шинжилгээнд үндэслэн тогтоож, дараах дүгнэлт, бодлогын хүрээний саналыг боловсрууллаа.

Бүлгийн дүгнэлт, санал

Судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан дүгнэлт, саналыг тус тайлангийн Дүгнэлт, санал, зөвлөмж бүлэгт нэгтгэн байршууллаа.

3.5.Хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, хариуцлага

Бүх оролцогч талуудыг зайлшгүй бөгөөд сайн дурын үндсэн дээр оролцуулахын тулд талуудын эрх, үүрэг, хариуцлага болон урамшууллын тогтолцоог оновчтой тодорхойлох шаардлагатай. ГХтХ-ийн Долдугаар бүлэгт тусгасан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хуулийн этгээд, иргэн, төрийн бус байгууллага, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эдлэх эрх, хүлээх үүрэгтэй холбоотой болон тус хуулийн Арван нэгдүгээр бүлэгт тусгасан зохицуулалтын хэрэгжилт, тэдгээрийн үр дагаврыг үнэлнэ.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. *ГХтХ-ийн Долдугаар бүлэгт тусгасан талуудын эрх, үүрэг болон Арван нэгдүгээр бүлэгт тусгасан хариуцлагын талаарх зохицуулалт оновчтой эсэх?*

Үнэлэх зүйл
34 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг
35 дугаар зүйл.Төрийн бус байгууллагын эрх, үүрэг
36 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг
37 дугаар зүйл.Иргэний эрх, үүрэг
52 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Хуулийн 34.2.1-т заасан гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх зохицуулалт практикт бүрэн хэрэгжихэд бэрхшээлтэй. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой асуудлыг ГХтХ-ийн 8.1 дэх хэсгийг үнэлсэн үр дүнгээс үзнэ үү. Хуулийн этгээд нь олон төрөл, хэлбэрээр ялангуяа цахимаар үйл ажиллагаагаа явуулах боломжтой бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага бүгд хамарах өргөн хүрээний ойлголт юм. Хуулийн этгээд өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан мэргэжлийн ангийг байгуулна гэсэн заалт нь эдгээр бүх байгууллагад хамаарч байх тул хуулийн этгээд бүрт үүрэг хүлээлгэсэн заалт болж байна. Хэрэв бүх хуулийн этгээд мэргэжлийн ангитай байж чадахгүй бол ГХтХ-ийн 34.2.4 дэх заалт мөн хэрэгжихгүй нөхцөл үүснэ. Энэ асуудлыг Нэр томъёоны тодорхойлолт хэсгийн мэргэжлийн ангитай холбоотой зохицуулалтыг үнэлсэн хэсгээс үзэх боломжтой.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэхтэй холбоотой асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Дугаар 190 тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-аар дэлгэрэнгүй зохицуулдаг. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь ажлын хөлсөө тухайн аж ахуйн нэгжтэй харилцан тохиролцдог бөгөөд үнэлгээ хийлгэх зардал нь 1.5-80 сая хүртэл хэлбэлздэг тул хуулийн этгээд бүр гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжгүйгээс эрсдэлийн үнэлгээг хийлгэхгүй байх тохиолдол элбэг байна. Хэдий ЗтХ-д хуулийн этгээд үүргээ биелүүлээгүй бол шийтгэх зохицуулалт бий ч нэг мянган нэгж буюу нэг сая төгрөгөөр торгох зохицуулалттай тул үнэлгээ хийлгэснээс илүү хямд хэмээн үзэж, торгуулах сонголтыг хуулийн этгээдүүд хийж байна. Иймд хуулийн этгээдэд үүрэг болгосон зарим заалт ГХтХ-ийн зорилгод нийцэхгүй байх тул ЗтХ болон ЗШШтХ-ийн

холбогдох хэм хэмжээтэй уялдуулан, хамтад нь өөрчилж, хэрэгжилтийг хангах бололцоотой.

Төрийн бус байгууллага болон гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүргийг хамтад нь нэгтгэн зохицуулснаар эрх үүргийн зааг ялгааг багасгаж, ойлгомжгүй байдлыг бий болгосон тул зохион байгуулалтын хувьд оновчгүй юм. ГХтХ-д хуулийн этгээд, иргэний эрх, үүргийг тодорхойлсон хэсэгт тэдгээр эрх, үүргийг зааглаж ялгамжтай зохицуулсан байх тул хуулийн бусад хэсэгтэй уялдуулах замаар эрх бас үүргийг ялгаж оруулах нь зүйтэй.

Шадар сайдын 24 дүгээр тушаалаар 2018 онд батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-д сайн дурын хэсгийг шаардлагатай үед нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулж, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах журам”-ын дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцуулна гэж тусгажээ. Харин энэхүү журам хүчингүй болсон байх бөгөөд 2024 онд шинэчлэн баталсан “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-д сайн дурын хэсгийн талаар ямар ч зохицуулалт тусгаагүй байна.

Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн 3.4-т зааснаар “Гамшгийн эрсдэлийг бууруулахад түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх” зорилтын хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэхээр заасан. Иймд гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгаас урьдчилан сэргийлэхэд дан ганц төрийн байгууллагын зүгээс анхаарах бус иргэн, хуулийн этгээдийн хамтын оролцоог хангах нь чухал байна.

ГХтХ-ийн 4.1.7-д зааснаар гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг томоохон арга хэмжээг багтаадаг. Харин тус хуулийн 37.2.5 дахь заалт нь иргэдийг дээр дурдсан гамшгаас хамгаалах бүх үйл ажиллагаанд оролцохыг үүрэг болгожээ. Мөн үүргээ биелүүлээгүй бол ЗтХ-д заасан хариуцлага хүлээдэг. Өөрөөр хэлбэл, энэ заалт нь дээрх үйл ажиллагаанд оролцоогүй бүх иргэдийг шийтгэх боломжтой зохицуулалт гэж харж болно. Гэтэл практикт иргэд газар нутгийн байршил, цаг хугацаа зэрэг олон шалтгааны улмаас дээрх үйл ажиллагаанд оролцох боломжгүй байдаг. Тиймээс оролцохыг үүрэг болгохдоо урьдчилсан нөхцөлийг тусгаж өгвөл практикт үр дүнтэй хэрэгжих боломжийг нэмэгдүүлнэ.

Мөн зарим журам (Жишээ нь: хүч хэрэгсэл дайчлан гаргах журам, Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам)-аар иргэн, хуулийн этгээдэд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг ногдуулжээ. Хуулиар доогуур эрэмбийн хэм хэмжээ тогтоосон акт нь хуульд нийцсэн байх, хуулиар тусгайлан эрх олгогдсон байх, хуулиар эрх олгосноос бусад тохиолдолд хуулиар хориглоогүй

асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх, ялангуяа эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх шалгуур бий.⁵⁵

Холбогдох журмуудад иргэн, аж ахуй нэгжийн зорчих эрх, өмчлөх эрх, сурч боловсрох, аж ахуй эрхлэх зэрэг олон эрхийг хөндөх зохицуулалтууд байж болзошгүй байна. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болох зарчим, хэм хэмжээг баримталж, хуулиар зохицуулагдах харилцааг журмаар зохицуулсан буюу хуулиас давсан журмыг бий болгосон эсэхийг нягталж, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалтыг журмаар бус, хуулиар тухайлан зохицуулах зарчмыг баримтлах нь зүйтэй.

Мөн төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө гэсэн онцгой зарчим, зохицуулалтын хүрээнд гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах ажиллагаанд оролцсон бол нөхөн олговор авах эрхийг иргэн, хуулийн этгээдэд олгох буюу эрх олгосон зохицуулалтыг эрх, үүрэг гэсэн хэсэгт нэмэх шаардлагатай.

Гамшгаас хамгаалах алба, аймаг, сум, нийслэл, дүүргийн дэргэд байх мэргэжлийн анги зэрэг төрийн байгууллагууд холбогдох үүргээ биелүүлээгүй, тухайлбал, дайчилгаанд тоног төхөөрөмжөө ашиглуулаагүй тохиолдолд ногдуулах хариуцлагын тогтолцоо дутмаг байна. Хэдий ГХтХ-ийн 52 дугаар зүйлд хууль зөрчигчдөд хүлээлгэх гэмт хэргээс бусад хариуцлагыг Төрийн албаны тухай хууль болон ЗтХ-аар зохицуулахаар зааж, “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-д тухайн журмыг үл биелүүлсэн төрийн албан хаагч, албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан ба Төрийн албаны тухай хуулийн 37.1.13-т зааснаар албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах үүрэгт хамаарч болох бөгөөд уг үүргээ биелүүлээгүй бол зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчаас бусад албан хаагчид хуульд заасан сахилгын шийтгэл оногдуулж болохоор байна.

Харин ЗтХ-д иргэн, хуулийн этгээдэд хариуцлага тооцохоор байгаа ч албан тушаалтанд хариуцлага ногдуулах зохицуулалт байхгүй. Гэтэл практикт, жишээ нь зарим төрийн байгууллагын албан тушаалтан ОББ-ын шаардлагыг үл тоон хүч хэрэгсэл дайчилгаанд оролцохгүй байх тохиолдлууд гардаг бөгөөд үүнд хариуцлага хүлээдэггүй байна.⁵⁶ Өөрөөр хэлбэл ГХтХ нь зөвхөн иргэн, хуулийн этгээд бус төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд хамаарах өргөн хүрээний агуулга бүхий хууль атлаа хариуцлагын механизм нь хангалтгүй байгаагаас хууль бүрэн хэрэгжихэд бэрхшээл үүсгэж байна гэж үзэх үндэстэй.

Бүлгийн дүгнэлт, санал

⁵⁵ Ц.Цогт, Б.Буянхишиг нар, Хуулиар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох эрхийг захиргааны байгууллагад шилжүүлэх заалтын хүрээ хязгаар, хууль, хэм хэмжээний актын харилцан хамаарлыг тодорхойлох онолын харьцуулсан судалгаа, 2023, 82 дахь тал.

⁵⁶ 2025.04.22-ны өдөр ОБЕГ-ын алба хаагчаас авсан асуумжаас.

Судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан дүгнэлт, саналыг тус тайлангийн Дүгнэлт, санал бүлэгт нэгтгэн байршууллаа.

3.6.Гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж

Дотоодын хүмүүнлэгийн тусламж

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжтай холбоотой харилцааг зохицуулах журмыг Засгийн газраас баталсан эсэх? Журам хангалттай, тодорхой эсэх

Үнэлэх зүйл
38 дугаар зүйл.Дотоодын хүмүүнлэгийн тусламж 38.1.Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулна.

Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийн харилцааг Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолын хавсралтаар баталсан гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журмаар зохицуулж байна. Тус журам нь Улсын болон аймаг, нийслэлийн онцгой комисс болон холбогдох төрийн байгууллага гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зориулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хүмүүнлэгийн тусламж хүсэх, тусламжийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, хуваарилах, олгох, тайлагнах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах зорилготой. Хүмүүнлэгийн тусламж хүсэх, хүлээн авах, бүртгэх, хадгалах, хүмүүнлэгийн тусламжийн чанар, стандарт болон түүнийг хадгалахад тавигдах шаардлага, хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах, зарцуулах, хүргэх, олгох, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах үйл ажиллагааны зардал, тайлагналт гэсэн агуулгын хүрээнд бичигдсэн нь шаардлагатай асуудлыг багтаасан бөгөөд ойлгомжтой байх тул ГХТХ болон журмаар тодорхойлсон зорилгодоо хүрсэн байна гэж дүгнэлээ.

Олон улсын хүмүүнлэгийн тусламж

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зохицуулалтад ойлгомжгүй байдал бий юу

Үнэлэх зүйл
39 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламж 39.2.Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал /цаашид "тусламж үзүүлэгч тал" гэх/ өөрийн дипломат төлөөлөгчийн байгууллагаар дамжуулан гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүсэлт гаргасан бол Засгийн газар уг тусламжийг авах эсэх талаар шийдвэр гаргана.
40 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт 40.7.Тусламж үзүүлэгч талын мөнгөн хөрөнгөөр үзүүлэх тусламжийг хүлээн авах эсэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэх харилцаанд олон улсын гэрээ буюу Засгийн газар хоорондын хэлэлцээр гол эх сурвалж болдог бөгөөд үүгээрээ журмаар зохицуулагддаг гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжаас ялгаатай.

Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал тусламж үзүүлэхдээ дипломат төлөөлөгчийн байгууллагаараа дамжуулан Гадаад харилцааны яаманд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүсэлт гаргах бөгөөд уг тусламжийг авах эсэхийг Засгийн газар шийдэх эрхтэй гэж хуулийн 39.2-т хуульчилсан. Энэхүү хэсэг нь Засгийн газар бүх хүмүүнлэгийн тусламж (Үүнд: мөнгөн хөрөнгөөр үзүүлэх тусламж багтана.)-ийг авах эсэх талаар шийдвэр гаргах эрхийг баталгаажуулсан. Гэтэл ГХтХ-ийн 40.7 дахь хэсэгт мөнгөн хөрөнгөөр үзүүлэх тусламжийг Засгийн газар шийдвэрлэнэ гэж давхардуулж хуульчилжээ. Иймээс энэхүү хоёр хэсгийг нэгтгэх шаардлагатай.

Мөн олон улсын хүмүүнлэгийн тусламжийн хүсэлтийг өөр байдлаар эсхүл өөр байгууллагаар дамжуулж гаргах талаар хуульд зохицуулаагүй мөртөө тус заалт нь бичиглэлийн хувьд “хүсэлт гаргасан бол” гэж өөр арга замаар хүсэлт гаргах боломжтой мэтээр ойлгогдох орон зай үлдээсэн байх тул “Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал өөрийн дипломат төлөөлөгчийн байгууллагаар дамжуулан гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүмүүнлэгийн **тусламж үзүүлэх хүсэлт гаргана**. Тусламж үзүүлэх хүсэлтийг хүлээн авах асуудлыг Засгийн газар **шийдвэрлэнэ**.” гэх мэтчилэн зохицуулалтыг тодорхой томъёолох хэрэгтэй.

Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөөнд олон улсын хүмүүнлэгийн тусламжийн төрөл, тэдгээрийг хариуцах байгууллагын талаар тусгажээ. Үүнд зааснаар олон улсын хүмүүнлэгийн тусламжийг үнэлгээ, зохицуулалтын баг; эрэн хайх, аврах баг; эм, эмнэлгийн үйлчилгээ; хүнс, бараа материал; техник, багаж хэрэгсэл; орон байр; санхүү; бусад гэж ангилсан хэдий ч хуульд заасан “мөнгөн хөрөнгөөр үзүүлэх тусламж” -ийн талаар хэм хэмжээ байхгүй байна. Хэдий санхүүгийн тусламжид хамааруулж хэрэглэх боломжтой ч хууль болон дагалдан гарсан журамд тусгасан нэр томъёог жигдэлж, ашиглах нь зүйтэй.

Түүнчлэн төлөвлөгөөнд тусгасан олон улсын хүмүүнлэгийн тусламжийн төрөл, тэдгээрийг хариуцах байгууллагатай холбоотой харилцаа нь үндэсний аюулгүй байдал, олон улсын эрх зүйн хүлээсэн үүрэг, шударга, ил тод хуваарилалт, иргэдийн итгэл, хяналт зэрэгтэй салшгүй холбоотой байдаг тул олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах асуудлыг Засгийн газрын тогтоолын хавсралтаар буюу доогуур түвшний эрх зүйн актаар шийдэж байгаа нь түр зуурын арга хэмжээ болохоос эрх зүйн тогтвортой тогтолцоог бүрдүүлэхгүй. Дээрх төлөвлөгөөнд “Гамшгийн хор уршиг, хохирол үндэсний эдийн засаг, нийгмийн нөөц боломж, чадавхаас давсан тохиолдолд олон улсаас хүмүүнлэгийн тусламж, дэмжлэг хүсэх уриалгыг Засгийн газар гадаад улс, олон улсын байгууллагад гаргана.” гэж тусгасан зохицуулалт нь ГХтХ-д тусгах шаардлагатай зохицуулалт юм.

Төлөвлөгөөнд тусгасан зарим нэр томъёог шинэчлэх шарадлага үүссэн байна. Тухайлбал, Үндсэн хууль болон Олон улсын гэрээний тухай хуульд заасны

дагуу “олон улсын гэрээ” гэх нэр томъёог албан ёсны баримт бичигт “олон улсын гэрээ, конвенц” гэж биш, дангаар нь буюу “олон улсын гэрээ” гэж хэрэглэх нь оновчтой. Мөн Монголын улаан **загалмай** нийгэмлэгийн нэршлийг “Монголын улаан **загалмайн** нийгэмлэг” гэж, Нэгдсэн Үндэстний Байгууллага гэхийг Нэгдсэн үндэсний байгууллага гэж, нэрээ өөрчилсөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг “Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам” гэж, Гадаад харилцааны яам гэхийг “Гадаад хэргийн яам” гэж, Хууль зүй, дотоод хэргийн яам гэхийг “Хууль зүйн яам”, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам гэхийг “Уул уурхайн яам” зэргээр төрийн болон олон улсын байгууллагын нэрийг монгол хэл зүйн дүрмийн болон бичвэр, бусад байдлаар алдаатай бичсэн байх тул засаж, шинэчлэх шаардлагатай.

Иймд эдгээр зохицуулалт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, хүн амд эрүүл мэнд, нийгмийн ба бусад тусламжийг хүргэх, аюул бүхий газраас нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд нэн шаардлагатай дэмжлэг үзүүлэх, гамшгаас учирсан хор уршгийг арилгах зэрэг зорилгод саад, бэрхшээл учруулж байх тул зарим талаар зорилгодоо хүрээгүй байна гэж дүгнэв.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. *Хууль зүйн техникийн хувьд оновчтой зохицуулагдсан эсэх?*

Үнэлэх зүйл
39 дүгээр зүйл. Олон улсын хүмүүнлэгийн тусламж
40 дүгээр зүйл. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт

ГХТХ-ийн Наймдугаар бүлгийн 39, 40 дүгээр зүйл буюу олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт нь агуулгын хувьд тархай, нэгдсэн бүтэцгүй байгаа нь хэрэглээний тодорхойгүй бөгөөд төвөгтэй байдлыг үүсгэж, зохицуулалтын зааг, ялгааг бүдгэрүүлэх эрсдэлтэй байна. Жишээлбэл, Засгийн газар, байгууллагын чиг үүрэг, зүйлийн нэршил зэрэг нь хоорондоо тохирохгүй, нэг хэсэгт харьяалагдах зүйл, заалтууд салангид байрлажээ. Иймд ГХТХ-д дэд гарчгийг оновчтой, логик бүтэцтэй, хуулийн хэл зүй, найруулгад нийцүүлж бичвэрийн шаардлагыг хангах хэлбэрээр сайжруулах нь зүйтэй. Үүнийг дараах агуулгын хүрээнд хуваарилах нь оновчтой байж болох юм:

1. Олон улсын хүмүүнлэгийн тусламж авах, шийдвэр гаргах журмын тухайд дээр дурдсанчлан олон улсын хүмүүнлэгийн тусламж авах Засгийн газрын уриалгатай холбоотой заалтыг хуулийн тухайн хэсэгт нэмэх;
2. Тусламж үзүүлэгч талын бүртгэл, шаардлага;
3. Хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах, хэрэгжүүлэх байгууллагуудын бүрэн эрх;
4. Хүмүүнлэгийн тусламжийн хилээр нэвтрүүлэх, тээвэрлэх, хуваарилах зохицуулалт;
5. Тусламж үзүүлэгч талын үйл ажиллагаанд тавигдах хязгаарлалт;
6. Мөнгөн тусламж хүлээн авахтай холбоотой зохицуулалт;
7. Хүмүүнлэгийн тусламжийн үр дүн, хяналт, тайлагнал.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Гамшгаас хамгаалах тогтолцоон дахь хүмүүнлэгийн баг, түүний чиг үүрэг тодорхой эсэх

Үнэлэх зүйл
40 дүгээр зүйл. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт 40.3. Тусламж үзүүлэгч талын үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр төрийн болон нутгийн захиргааны байгууллага, олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ГХТХ-аар олгосон эрхийн хүрээнд, Хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг Шадар сайдын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 117 дугаар тушаалаар баталсан байна.

Гамшиг, ослын үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө (загвар)-ний дагуу Улсын онцгой комисс, Шуурхай удирдлагын төв орон нутгийн хүмүүнлэгийн багийг хуралдуулдаг. Монгол Улс дахь Хүмүүнлэгийн тусламжийн баг нь үндсэн ба өргөтгөсөн багаас бүрдэх бөгөөд өргөтгөсөн багийг НҮБ-ын зохицуулагч, ОБЕГ-ын даргын хамт ахлах ба дараах багаас бүрдэнэ.



Зураг 2. Монгол Улс дахь Хүмүүнлэгийн тусламжийн багийн бүтэц.

Эх сурвалж: Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын баримт бичиг, (Бүх шатны төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогчдод зориулсан гарын авлага), ОБЕГ, 2023.

Гэсэн ч практикт эдгээр багуудын хамтын ажиллагаа тааруу бөгөөд зохион байгуулалтын хувьд нэгдэж, хамтран ажиллахад хүндрэлтэй байдаг. Мөн ОБЕГ-ын алба хаагчидтай хийсэн ярилцлагын дүнд цуглуулсан мэдээллээс үзвэл уг журмыг огт хэрэгждэггүй хэмээн дурджээ. Иймд Монгол Улс дахь хүмүүнлэгийн

тусламжийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах бүтэц, журам, чиг үүргийн зохицуулалтыг сайжруулах, үр дүнтэй бөгөөд үр өгөөжтэй хэрэгжих хувилбарыг тусгах шаардлагатай гэж үзэв.

Бүлгийн дүгнэлт, санал

Судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан дүгнэлт, саналыг тус тайлангийн Дүгнэлт, санал бүлэгт нэгтгэн байршууллаа.

3.7.Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал

Судалгааны тайлангийн энэхүү дэд бүлэгт ГХтХ-д заасан онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдалд холбогдох зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлсний үндсэн дээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэхийг зорьсон болно. Агуулга, хэм хэмжээний цар хүрээг харгалзан тус дэд бүлгийн судалгааны үр дүнг “Онцгой байдлын байгууллагын эрх зүйн байдал”, “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал” гэж хоёр хуваан багцалж танилцуулъя.

3.7.1.Онцгой байдлын байгууллагын эрх зүйн байдал

Судалгааны тайлангийн энэ хэсэгт ГХтХ-ийн 42-49 дүгээр зүйл болон тэдгээрийн хэсэг, заалт бүрийн зохицуулалтыг судалж, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийе. Тухайлбал, ГХтХ-ийн 42 дугаар зүйл нь нийт 9 хэсэг, 1 заалттай бөгөөд онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоог тодорхойлоход чиглэсэн.

Үнэлэх зохицуулалт
42 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоо
42.1.Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.
42.2.Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.
42.3.Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бүсийн төв, аймаг, нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, бүлэг, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, эрэлч нохойн алба, шуурхай удирдлага-зарлан мэдээллийн төв, ар тал, тээвэр-ложистик, бүтээн байгуулалт-барилга байгууламж, техник засвар, үйлчилгээ, дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн үйлдвэр, эмнэлэг-сувилал, судалгаа шинжилгээ, сургалт, туршилт үйлдвэрлэл, архив, спорт, соёл урлаг болон бусад нэгжтэй байна.
42.4.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг газар зүйн онцлог, хүн амын нягтрал, аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээг харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд Засгийн газрын шийдвэрээр байгуулна.
42.4.1.энэ хуулийн 42.4-т заасан төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд байгуулсан онцгой байдлын байгууллагын харьяа нэгжийн үйл ажиллагааны бүх зардлыг тухайн байгууллага бүрэн хариуцах.
42.5.Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.
42.6.Онцгой байдлын байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна.
42.7.Нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулна.
42.8.Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
42.9.Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгслийн төрөл, хангамжийг стандартаар тогтооно.

Зохицуулалтын хүрээ, харилцан уялдаа холбоотой байдлыг харгалзан хэм хэмжээг дангаар нь эсхүл багцлах байдлаар үр дүнг танилцуулъя.

Үнэлэх зохицуулалт
42.1.Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.
42.2.Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага байх зорилгод хүрсэн эсэх

Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлж буй тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд Монголын ард түмэн улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож даяар олноо зарлан тунхагласан. Энэхүү эрхэм зорилгыг гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний тогтолцоо, тухайлбал онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа, онцгой байдлын алба хаагчийн үйл хэрэгт чандлан баримталж ирсэн хандлага, ололт амжилт, арвин туршлагыг юун түрүүнд онцлон тэмдэглэе.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан нь гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний үйл ажиллагааны эрх зүйн гол үндэс болдог. Түүнчлэн Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж; Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж тус тус заасан. Мөн Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тусгасан.

Тухайлбал Монгол Улс НҮБ-аас баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг”, “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030”, “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр”-ийг бүрэн дэмжиж, эдгээр баримт бичгийг хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангах дотоодын эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр хүчин чармайлт гаргаж байна. Үүний нэг чиглэл нь онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдлыг оновчтой тодорхойлох, бэхжүүлэхэд оршино.

Монгол Улс Аврах ажиллагааны тухай 1989 оны Лондонгийн конвенц⁵⁷-ийг 2014 онд, Иргэний хамгаалалтын тусламжийн тухай 2000 оны конвенц⁵⁸-ийг 2004 онд тус тус соёрхон баталсан. Харин Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /www.legalinfo/-д эдгээр конвенцийг соёрхон батлах тухай хуулиудыг байршуулсан боловч тухайн олон улсын гэрээний эх бичвэр оруулаагүй байгааг анхаарч цахим санд байршуулах нь зүйтэй.

Монгол Улсын “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг, батлан хамгаалахын багц хуулиудын үзэл санаа, заалтуудтай нийцүүлэн онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн гэж Гамшгаас хамгаалах тухай хуульд тодорхойлсон.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”⁵⁹, 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”⁶⁰, “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030”, 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг⁶¹, түүнтэй нийцүүлэн УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг баримт бичгүүд болон Гамшгаас хамгаалах тухай хуульд нийцүүлэн баталсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”/2015-2025/, “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”/2017-2030/“ зэрэг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Онцгой байдлын байгууллага байгуулагдсан эхэн үед мөрдөгдөж байсан Иргэний хамгаалалтын тухай хууль(1994 он)⁶², Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль(1996 он)⁶³, Галын аюулгүй байдлын тухай хууль(1999 он)⁶⁴, Гамшгаас

⁵⁷ [Аврах ажиллагааны тухай конвенцид нэгдэн орох тухай](#)

⁵⁸ [Иргэний хамгаалалтын тусламжийн тухай конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай](#)

⁵⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208070&showType=1>

⁶⁰ [МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС](#)

⁶¹ [Эрх зүйн акт дэлгэрэнгүй](#)

⁶² Энэ хуулийг 2003 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

⁶³ Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

хамгаалах тухай хууль(2003 он) зэрэг суурь хуулиудын шинэчлэлийн дүнд, өнөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Онц байдлын тухай(1995 он), Үндэсний аюулгүй байдлын тухай(2001 он), Улсын нөөцийн тухай хууль (2007 он), Галын аюулгүй байдлын тухай хууль/шинэчилсэн найруулга/(2015 он), Гамшгаас хамгаалах тухай хууль(2017 он) зэрэг хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн баталсан дүрэм, журам, стандарт, заавар, удирдамжийг хэрэгжүүлэн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Онцгой байдлын байгууллага эрх зүйт төрөөс тогтоосон 68 хууль, хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын 240 гаруй тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтийг Монгол Улсын Шадар сайдын өмнө хариуцан ажиллаж байна.⁶⁵ Эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулсан нийт 40 гаруй захиргааны хэм хэмжээний акт батлан мөрдөж байна.

ГХТХ-ийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа өргөн цар хүрээтэй, олон талын оролцоотой хэрэгжих онцлогтой холбогдон, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16.1.2 дахь заалтад нийцүүлсэн, хэрэгжилт, биелэлтийг хангахад чиглэсэн олон салбарын хууль тогтоомжоор зохицуулагддаг.

Үүний улмаас гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчин, уул уурхай, хүнд үйлдвэр, барилга хот байгуулалт, зам тээвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, хөдөлмөр, нийгэм хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, хууль зүй, дотоод хэрэг болон батлан хамгаалах салбарын нийт 60 гаруй хуульд тусгагдсан байдлыг хамааруулж авч үзвэл онцгой байдлын байгууллага нь Монгол Улсын олон салбарын хууль тогтоомж болон бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэгч өвөрмөц субъект юм.

ГХТХ-ийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалсан үр дүнг тус судалгааны тайлангаас дэлгэрүүлж үзнэ үү. Үүнтэй холбоотойгоор ОББ Монгол Улсын бодлого, холбогдох хууль тогтоомжоор баталгаажсан төрийн цэргийн байгууллагын эрх зүйн байдлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа нь ГХТХ-ийн зорилготой бүрэн нийцэж байна.

Онцгой байдлын байгууллага үйл ажиллагааны чанараа сайжруулан, ахиц дэвшилд хүрэх зорилго тавьж хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг олон жилийн турш, тодорхой хугацаанд тогтмол авч үр дүнг ажил хэрэгтээ ашиглах хандлага хэвшүүлжээ. Судалгааны тайлангуудтай зохих хүрээнд танилцаж, үр дүнг харьцуулахад, иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн төдийгүй гамшгаас хамгаалах үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг сайтар

⁶⁴ Энэ хуулийг 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

⁶⁵ ОБЕГ, “Онцгой байдлын алба-20 жил” ойн ном, 129 дэх тал.

ойлгож, олон талын оролцоо, хамтын ажиллагааг ухамсарлах болсныг илэрхийлж байна.

Тухайлбал, цаашид онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд анхаарах асуудлаар санал авахад, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх болон хөрөнгө, мөнгө хангалттай төсөвлөх хэрэгтэй гэж үзсэн саналын хувь тус тус нэмэгдсэн бол алба хаагчдын ур чадварыг сайжруулах, удирдлагын арга барилыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн саналын хувь тус тус буурсан байна.⁶⁶ Энэ нь нэг талаас онцгой байдлын байгууллага чиг үүргээ зохих түвшинд гүйцэтгэж байгаа төдийгүй байгууллагын чадавх, алба хаагчдын ур чадвар дээшилсэн гэж үзэх үнэлгээ, нөгөө талаас гамшгаас хамгаалах үйл ажиллагааг сайжруулахад тус байгууллагын хөрөнгө, төсвийн хүртээмж, мөн иргэдийн оролцоо, дэмжлэг чухал болохыг илтгэсэн үзүүлэлт гэж хэлж болно.

Үүнээс гадна гамшиг судлал, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бүтээлийн тоо хэмжээ өсөж, чанар, үр өгөөж дээшилсэн бөгөөд үр дүнг эрх зүйн шинэтгэл, хууль зүйн бодлогод тусгах, нөөц бололцоог ашиглах, нөлөөллийг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. *Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага байх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл бий эсэх*

Онцгой байдлын байгууллагын гамшгийн эрсдэлийн удирдлагад гүйцэтгэх үүрэг нь оролцогч талуудын нөөц, бололцоо, үйл ажиллагааг гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглүүлж тэдгээрийн харилцан ажиллагааг хангахад оршино. Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, шинжлэх ухаан, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийт, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлд суурилж гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг тогтолцооны онцлогийг харгалзан онцгой байдлын байгууллагыг төрийн цэргийн байгууллагын статустай болгосон.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 85 дугаар тогтоолоор "Монгол Улсын Батлан хамгаалахын бодлогын үндэс"-ийг баталж, түүний 7.1-д "Монгол Улсын төрийн цэргийн байгуулал нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ", 7.4-т "Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь цэргийн нийтлэг дүрмүүдийг даган мөрдөж, цэргийн алба хаагчийн эрх зүйн хэм хэмжээгээр олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлнэ" хэмээн зааснаар Онцгой байдлын байгууллага нь төрийн цэргийн бүрэлдэхүүнд албан ёсоор багтжээ.

Монгол Улсын Их Хурлаас 2003 онд Гамшгаас хамгаалах тухай хуулийг анх баталснаар Онцгой байдлын байгууллага байгуулах эрх зүйн орчин бүрдсэн.

⁶⁶ Гамшиг судлалын хүрээлэн, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа(УБ:2019) зэрэг энэ төрлийн судалгааны тайлангуудыг тогтмол гаргадаг.

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор Улсын Иргэний хамгаалалтын газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газруудыг нэгтгэж, гамшгаас хамгаалах нэгдсэн тогтолцоо бүхий орчин цагийн онцгой байдлын албыг байгуулсан нь дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн түүхэн шийдвэр болсон юм.⁶⁷ Улмаар Засгийн газрын 2005 оны 48 дугаар тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) гэж нэрлэх болсон.

Үүсэж хөгжсөн 20 гаруй жилийн түүхийг харуулсан эх сурвалж, байгууллагын тайлан зэрэг материал, ОБЕГ-ын албан ёсны цахим хуудсаар олон нийтэд тайлагнасан мэдээллээс үзвэл, онцгой байдлын байгууллагыг олон улсын чиг хандлага, үндэсний онцлогт нийцсэн бүтэц, зохион байгуулалттай болгон, үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, алба хаагчдын мэдлэг боловсрол, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх, техник, тоног төхөөрөмжөө шинэчлэх, гадаад болон дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх, орон нутгийн удирдлага, төр, захиргааны байгууллага, иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, бүх нийтийн оролцоог хангах зэрэг олон талт асуудлыг шийдвэрлэх, хэрэгжилтийг хангах тал дээр анхаарч, дорвитой үр дүнд хүрчээ.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1-д заасны дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулж байна. Анх 120 салбар нэгжтэй байсан тус онцгой байдлын алба өнөөдөр 190 салбар нэгжтэй, агаараас эрэн хайх, аврах ангитай болон өргөжиж, техник хэрэгслийн хангалт 40 гаруй хувиар нэмэгдэж, эх орондоо төдийгүй олон улсын түвшинд үүрэг гүйцэтгэх чадавхид тэмүүлсэн мэргэжлийн байгууллага болон өргөжин хөгжиж байна.

Хүний нөөц, техник, хэрэгслийн хангамж, төсөв, санхүүгийн хүртээмжийн тухайд хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг авч үзье.

Хүний нөөцийн тухайд. Гамшгаас хамгаалах тухай хууль/шинэчилсэн найруулга/-д онцгой байдлын байгууллагын тогтолцоо, чиг үүргийг шинээр томьёолон оруулж, төрийн цэргийн байгууллагын хувьд нэгдмэл байх зарчимд нийцүүлэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, баталгааг төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын нэгэн адил болгон, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн нийгмийн болон бусад баталгааг тусган хэрэгжүүлж байна.

Онцгой байдлын байгууллагын чадавх нь түүний алба хаагч, хүний нөөцийн хөгжилтэй нягт холбоотой. Энэ талаар “Онцгой байдлын байгууллага - 20 жил” ойн номонд “Хүний нөөцийн хөгжил дэвшил” хэсэгт дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Өнөөгийн Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн чадавх 2004 онтой харьцуулахад 69.9 хувиар нэмэгдэж, бие бүрэлдэхүүний нөхөн хангалт 89.8 хувь, офицер бүрэлдэхүүний нөхөн хангалт 87.3 хувь, ахлагч бүрэлдэхүүний нөхөн

⁶⁷ ОБЕГ, “Онцгой байдлын алба-20 жил” ойн ном, 5 дахь тал.

хангалт 86.7 хувь, төрийн үйлчилгээний алба хаагчдын нөхөн хангалт 95.5 хувьд хүрч нийт алба хаагчдын 26.1 хувийг офицер бүрэлдэхүүн, 68.2 хувийг ахлагч бүрэлдэхүүн, 5.7 хувийг төрийн үйлчилгээний албан хаагч эзэлж байна;

- Онцгой байдлын байгууллага нь хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, албан тушаалтнуудын давтан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж ирлээ. Гамшгаас хамгаалах чиглэлээр хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх хүрээнд дотооддоо анхан шатны, дунд шатны, мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх, ахисан түвшний магистр, доктор, удирдлагын түвшний сургалтыг ОБЕГ, төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага, ДХИС-ийн сургалтын материаллаг бааз, багшлах боловсон хүчинд тулгуурлан зохион байгуулж, сургалтын цар хүрээг нэмэгдүүлсэн нь хүний нөөцийн чадавхыг бүрдүүлэх гол хүчин зүйл болж байна;

- Гамшгаас хамгаалах чиглэлээр гадаад улс оронд боловсон хүчин бэлтгэх сургалтын цар хүрээ, тоон үзүүлэлт эрс өссөөр байна. Тухайлбал, ОХУ, БНПУ, БНУУ, БНСУ, БНХАУ, Япон улс, БНАСУ, Вьетнам, Герман, Малайз, Катар, Казахстан, Киргиз, Испани, Индонез, Иран, Словак, Тайланд, Туркменистан, Швейцар, Филиппин зэрэг 20 орчим оронд богино болон урт хугацааны мэргэжил дээшлүүлэх болон мэргэжил олгох, ахисан шатны боловсрол олгох сургалт/магистр, докторын зэрэг олгох/ зохион байгуулагдаж байна;

- Онцгой байдлын байгууллагаас "Алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр"-ийг 2010 оноос хэрэгжүүлж, энэ хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллаж амьдрах ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын хэмжээнд нийслэл болон Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дархан-Уул, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Завхан, Хэнтий зэрэг аймагт 405 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулж, нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд 300 айлын орон сууцыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна;

- Онцгой байдлын байгууллагаас алба хаагчдын эрүүл мэндийг дэмжих, бие бялдрыг хөгжүүлэх, албаны бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах дэд хөтөлбөр"-ийг 2013 оноос эхлэн хэрэгжүүлж байна;

- Алба хаагчдын эрүүл мэндийг дэмжих, бие бялдарыг хөгжүүлэх, албаны бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд тогтмол хамруулан, сэтгэлзүйн болон бие бялдрын танхимуудыг тохижуулан, байнгын бэлтгэл сургуулиалт хийх боломжийг бүрдүүлээд байна;

- Мөн алба хаагчдад сэтгэлзүйн болон сэргээн заслын төв "Онцгой Жаргалант" сувилал, Хөвсгөл аймаг дахь "Гүний усны сургалтын төв"-үүдийг байгуулсан нь алба хаагчдын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх томоохон ажил боллоо гэсэн мэдээлэл⁶⁸ тус тус багтсан байна.

Дээр дурдсан мэдээлэл нь алба хаагчдыг сургаж бэлтгэх, чадавхжуулах болон нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээ, тэдгээрийн үр дүнгийн талаар танилцуулсан байна. Эдгээр нь ГХТХ-д заасан онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, эрх, үүрэг, нийгмийн баталгаатай холбоотой зохицуулалтууд, тэдгээрийн хэрэгжилт хүний нөөцийг бүрдүүлэх,

⁶⁸ ОБЕГ, "Онцгой байдлын алба-20 жил" ойн ном, холбогдох мэдээлэл.

тогтвортой байдлыг хангах, албаны чадавхийг нэмэгдүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлэхийг илэрхийлнэ. Цаашид онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг боловсронгуй болгох чиглэлээр ГХТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийн эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах хүрээнд анхаарах хэрэгцээ, шаардлага бас байгааг практик харуулж байна. /Энэ талаар болон практикт тулгамдсан асуудал, шийдвэрлэх хувилбарын талаар тус судалгааны тайлангийн Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой хэсэгт судалсан болно./

Техник, хэрэгслийн хангамжийн тухайд. Онцгой байдлын байгууллага үүсэн байгуулагдсан он жилүүдэд хүн нэг бүрийн хувцас хэрэгсэл, багаж зэвсэглэмж, техник, тоног төхөөрөмжөөр хангахад тухайн үеийн хөрөнгө оруулалтаар явбал 113 жил шаардлагатай гэсэн тооцоо гарч байжээ.

Өнөө үед гал унтраах зориулалтын автомашин 70.4 хувь, Эрэн хайх аврах зориулалтын автомашин 80.8 хувь, Гал унтраах багаж зэвсэглэмж 55.3 хувь, Аврах багаж хэрэгсэлийн хангалт 48 хувь, албаны хувцас хэрэгслийн хангалт 54.0 хувь, Тусгай зориулалтын хувцас хэрэгсэлийн хангалт 57 хувь, Холбоо зарлан мэдээлэл, техник хэрэгсэл 32 хувь, засвар үйлчилгээ үзүүлэх зориулалтын дэд бүтэц, барилга байгууламж 10 хувийн хангамжтай байна.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага нь бүтцийн нэгжийн хувьд бэхжиж үйл ажиллагааны хүрээ өргөжиж, үндсэн чиглэл болсон гал түймэр унтраах, аврах ангийн чадавх 76.9 хувиар, Эрэн хайх аврах ангийн чадавх 25 хувиар, Эрэн хайх аврах салбарын чадавх 3 дахин, Эрэн хайх аврах бүлгийн чадавх 20 дахин нэмэгдээд байна.⁶⁹

/Техник, хэрэгслийн хангамжийн тухайд практикт тулгамдсан асуудал, шийдвэрлэх хувилбарын талаар тус судалгааны тайлангийн “Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал” бүлгийн 42 дугаар зүйлийн 42.9-д “Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгслийн төрөл, хангамжийг стандартаар тогтооно.” гэж заасан зохицуулалтын хэрэгжилтийг судалсан хэсэгт дэлгэрсэн тусгасан болно./

Хувцасны хангамжийн тухайд. Тус судалгааны тайлангийн 3.7 дэд бүлэг(Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал)-т 46 дугаар зүйлийн 46.1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.” гэж, 46.3-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.” гэж заасан зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг судалсан хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.

⁶⁹ОБЕГ, “Онцгой байдлын алба-20 жил” ойн ном, 65-66 дахь тал.

Энэхүү судалгаанд дээр дурдсан нөөцөөс бусад нөөцийн тухай, тухайлбал хүнсний хангамжийн асуудлыг тухайлан хамруулаагүй болно. Харин нөөц бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага, холбогдох төсөв, санхүүжилт гэх мэт нийтлэг асуудлыг тусгасан учир дам холбогдоно. Онцгой байдлын байгууллага бүхэлдээ MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж эхлээд даруй 5 жил болж байна. Анх ОББ-ын хүнсний нөөцийн салбар уг стандартаар баталгаажсан бол эдүгээ бүх салбар нэгж нэвтрүүлээд байна. MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоо стандартыг нутагшуулах, Онцгой байдлын байгууллагын “Бүтээмжийн хөтөлбөр”-ийг ОБЕГ-ын даргын 2020 оны А/292 дугаар тушаалаар батлуулсан. Энэхүү хөтөлбөр нь байгууллагын алба хаагч, ажилчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, тэдгээрийг шинэ, шинэлэг санаа, дэвшилтэт арга, шийдлийг дэвшүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг дэмжихэд чиглэсэн байна.

Төсөв, санхүүгийн хүртээмжийн тухайд. Хүний нөөц болон техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл болон бусад нөөц, хангалтуудын хувьд батлагдсан төсвийн хүрээнд худалдан авалтыг зохион байгуулдаг. Энэ нь өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн гүйцэд хангаж чаддаггүй. Жил болгоны худалдан авалтаас 5%-ийн нөөц бүрдүүлэлт хийхийг эрмэлздэг боловч тодорхой шалтгаан(шинэ анги салбар байгуулагдах, тэтгэвэрт гарсан болон ажлаас гарсан алба хаагчдын нөхөн бүрдүүлж шинээр томилогдох, бусад), нөхцөл байдлын улмаас нөөцөд авч хадгалсан техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл жил хүрэхгүй хугацаанд зарлагадаад дуусдаг. Иймд алба хаагч нар ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг нэмж батлуулах, аль эсвэл ГХтХ-д онцгой байдлын алба хаагч нар гамшиг ослын үед цаг алдахгүйгээр, шуурхай ажиллахад хэрэгцээтэй бүх төрлийн нөөцийг бүрдүүлэх, ашиглах нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг хуульчлан батлуулах хэрэгцээ, шаардлага тулгамдсан хэвээр байна.⁷⁰

/Тус судалгааны тайлангийн 3.7 дэд бүлэг(Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал)-т ГХтХ-ийн 42 дугаар зүйлийн 42.5-д "Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ." гэж заасан зохицуулалтын хэрэгжилт, тайлангийн 3.8 дэд бүлэг (Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт)-т ГХтХ-ийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн үндэс, эх үүсвэр, хуваарилалт, хариуцах субъектүүдийг тодорхойлсон зохицуулалтын хэрэгжилтийг тус тус судалсан бөгөөд төсөв, санхүүжилтийн хүртээмжийн талаар тусгасан.

Судалгааны тайлангийн холбогдох хэсгүүдэд ОББ-ын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, хүчин чадал, бие бүрэлдэхүүний ур чадвар, албаны чадавхийн талаарх өнөөгийн нөхцөл байдлыг илтгэсэн мэдээлэл мөн багтсан бөгөөд онцгой байдлын төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан, салбар, нэгжийн алба хаагчдын оролцоог тэнцвэртэй хангасны үндсэн дээр практикт тулгамдаж буй асуудлыг түлхүү хөндсөн болно. Энэ талаар судалгааны тайлангийн холбогдох хэсгүүдээс дэлгэрүүлж үзнэ үү.

⁷⁰ Мөн тэнд.

“Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. *Онцгой байдлын байгууллага гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүргийг гадаадад эсхүл гадаад улстай хамтран хэрэгжүүлэх хүрээг тусгах шаардлагатай эсэх*

ГХТХ-ийн 42 дугаар зүйлийн 1-д “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.” гэж заасан. Онцгой байдлын байгууллагын түүхэн хөгжлөөс үзэхэд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлээр сайтар анхаарч үр бүтээлтэй ажиллаж байна. Үүний зэрэгцээ олон улсын харилцаа, хамтын ажиллагаа буюу олон улсын болон гадаад улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан хоёр болон олон талт үйл ажиллагаа, түүнчлэн олон улсын энхийг сахиулах ажиллагаанд онцгой байдлын алба хаагчид амжилттай оролцож ирсэн байна.

Онцгой байдлын байгууллагын цахим хуудаст байршуулсан мэдээ, тайлан болон онцгой байдлын байгууллага үүсэж хөгжсөний 10, 15, 20 жилийн ойн номонд тус байгууллага гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүргийг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж буй талаарх мэдээллийг, түүнчлэн олон улсын байгууллага болон гадаад улс, гадаад улсын байгууллагуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааны үйл ажиллагааг мөн дэлгэрэнгүй танилцуулжээ. Тухайлбал:

Монгол Улсын гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг олон улсад сурталчлан таниулах, харилцан туршлага солилцох, Онцгой байдлын байгууллагын хүн хүч, техник тоног төхөөрөмжийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор бүс нутгийн болон дэлхийн улс гүрнүүдийн ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай хоёр талын болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлсээр ирсэн.⁷¹

НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын иргэний хамгаалалтын байгууллага, Гамшгийн аюулыг бууруулах Азийн бүсийн төв, Азийн гамшгийн бэлэн байдлын төв, Олон улсын галын байгууллагын дарга нарын Азийн холбоо, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Япон Улс, БНСУ, Швейцарийн Холбооны Улс, БНТУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд зэрэг 20 гаруй бүс нутгийн болон дэлхийн хэмжээний олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагаатай ажиллаж байна.⁷² Олон улсын иргэний хамгаалалтын байгууллага, Азийн гамшгийн бэлэн байдлын төв, Олон улсын галын байгууллагын дарга нарын холбоо, Азийн Галын дарга нарын холбоо, Олон

⁷¹ ОБЕГ, “Онцгой байдлын алба-20 жил” ойн ном, 110 дахь тал.

⁷² Мөн тэнд, 114 дэх тал.

улсын галын инженерүүдийн холбоо, Олон улсын галын аюулгүй байдлын шинжлэх ухаан технологийн холбоонд гишүүнчлэлтэй.⁷³

Одоогийн байдлаар ОХУ, БНХАУ, БНСУ, БНАСАУ, Япон Улс, Унгар Улс, БНФранц Улс, АНУ, Австрали Улс, БНБеларусь Улс, БНКазахстан Улс, БНКиргиз Улс, БНПольш Улс, БНСВУ, БНТУ, БНЭУ, ШХУ зэрэг 17 улс орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.⁷⁴

Тухайлбал хөрш орнууд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг улам бүр идэвхтэй хөгжүүлэх чиглэлээр анхаарч, “Үйлдвэрлэлийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар 2006 онд ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яам /ОБЯ/-тай “Монгол Улсын Онцгой байдлын байгууллага, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яам хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх протокол”-д гарын үсэг зурсан. Түүнчлэн “Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, түүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмын хүрээнд “Монгол Улс, БНХАУ-ын Хил орчмын бүсийн ой, хээрийн түймэртэй тэмцэх хамтарсан комиссын хуралдаан”-ыг хоёр жил тутамд зохион байгуулж хэвшсэн нь ихээхэн ач холбогдолтой юм.

Бүгд Найрамдах Киргиз Улстай “Онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Онцгой байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг” (2016), БНСУ-тай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, БНСУ-ын Онцгой байдлын ерөнхий газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг (2006), санамж бичгийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн баримт бичиг (2012), БНХАУ-тай “Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх нарийвчилсан журам (2011), Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, БНХАУ-ын Газар хөдлөлтийн удирдах газар хоорондын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх салбарт хамтран ажиллах санамж бичиг (2013) зэргийг байгуулсан байна. Цаашид хоёр талын болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Бүгд Найрамдах Беларус Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, БНСВьетнам Улс, Колумби зэрэг улстай хамтын ажиллагааг эхлүүлэх, бэхжүүлэхээр ажиллаж байна.⁷⁵ Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зэрэг арга хэмжээ зохион байгуулах хэлбэрээр олон улсын харилцаа, гадаад хамтын ажиллагааг сайтар хөгжүүлж байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

⁷³ Онцгой байдлын ерөнхий газар, Онцгой байдлын байгууллага 20 жил, (УБ.,2024 он), 166 дахь тал.

⁷⁴ Мөн тэнд, 110 дахь тал.

⁷⁵ Онцгой байдлын байгууллагын ойн ном, бусад цаасан суурьтай болон цахим эх сурвалжийн мэдээллээс

Онцгой байдлын байгууллага гадаад улс оронд эрэн хайх, аврах ажиллагааг явуулах чадавхтай олон улсын дунд хэмжээний багтай болохыг зорин, эхний ээлжинд Швейцарийн хамтын ажиллагааны байгууллага, БНХАУ-ын Газар хөдлөлтийн байгууллагатай хамтран үндэсний эрэн хайх, аврах чадавхыг дээшлүүлэх төслийг 2017 оноос эхлүүлсэн байна. Энэ чиглэлээр олон улсын болон гадаад улсын байгууллагатай харилцаж буй гадаад хамтын ажиллагаа улам өргөжих төлөвтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны хоёрдугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар гамшигт нэрвэгдсэн Бүгд Найрамдах Турк Улс, Арабын Бүгд Найрамдах Сири Улсад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, эрэн хайх, аврах баг оролцуулахаар шийдвэрлэсний дагуу онцгой байдлын байгууллагын 24, Зэвсэгт хүчний 11, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, нийт 41 хүний бүрэлдэхүүнтэй эрэн хайх, аврах баг хоёрдугаар сарын 8-ны өдөр буюу газар хөдлөлт болсноос хойш 68 цагийн дараа гамшгийн голомт болох БНТУ-ын Хатай мужийн Хатай хотод очиж ажилласан юм. Монгол Улсын эрэн хайх, аврах баг 10 хоногийн хугацаанд Хатай хотын 20 орчим цэгт ажиллаж нийт найман хүний амь насыг авран хамгаалж, 19 цогцсыг холбогдох байгууллагад, мөн 20.000 доллар болон үнэт эдлэлийг цагдаагийн байгууллага, ар гэрт нь хүлээлгэж өгч, эрэлч нохойн тусламжтайгаар 45 цогцсыг илрүүлжээ. Аврах багийн эмнэлгийн бүлэг нийт 649 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, гамшигт нэрвэгдсэн 115 хүний гар, хөл хугарсан, шоконд орж дотор эрхтний гэмтэл авсан байсныг эмчилжээ. Мөн Монгол Улсаас БНТУ руу илгээсэн махан нөөш, лаа, хөнжил, 20 ширхэг иж бүрэн монгол гэрийг хүлээн авч, гэрийг нь барьж, хүмүүнлэгийн тусламжийн хамтаар гардуулсан юм.⁷⁶ Үүнээс үзэхэд онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг олон улсын хэмжээнд зохион байгуулахад хамтран оролцож байна.

Онцгой байдлын байгууллага олон улсын хэмжээнд, гамшигт нэрвэгдсэн улс оронд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, эрэн хайх, аврах баг оролцуулж амжилттай ажилласан туршлага, жишээлбэл 2011 онд Японд, 2023 онд Турк улсад болсон газар хөдлөлтийн улмаас гамшигт нэрвэгдсэн орчин нөхцөлд очиж ажиллан үүргээ нэр төртэй биелүүлсэн амжилт бий. Өнөөгийн хүрсэн чадавхдаа тулгуурлан эхний ээлжинд дунд түвшний баг болж хөгжих зорилт тавьж бодлогын баримт бичигт тусгасан.⁷⁷

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.4.16-т “Гамшгийн үед хариу арга хэмжээ авах үндэсний чадавхыг сайжруулж, Олон улсын эрэн хайх, аврах зөвлөлдөх бүлэг /INSARAG/-ийн стандартад нийцсэн дунд түвшний ангиллын багтай болж, аврах ажиллагааны дэвшилтэт арга технологи, шинэ техник, багаж төхөөрөмжийг нэвтрүүлнэ.”, мөн хөтөлбөрийн 4.4.5.3-т “Хамтрагч, түншлэгч талууд болон олон нийтэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх, солилцох нөхцөлийг бүрдүүлж, хамтын итгэлцлийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд гадаад болон олон улсын

⁷⁶ [Турк Улсад эрэн хайх, аврах ажиллагаанд оролцсон багийг Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр шагнана – Онцгой байдлын ерөнхий газар](#)

⁷⁷ 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр ОББ-ын албан тушаалтантай хийсэн ярилцлагаас.

хамтын ажиллагааг өргөжүүлнэ.” гэж заасан нь олон улсын хамтын ажиллагаа төдийгүй олон улсын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг, мөн тус хөтөлбөрийн 4.4.4.1-д “Гамшгийн үеийн бэлэн байдал, холбоо, зарлан мэдээллийн тогтолцоонд дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлж, шинэ шатанд гаргана.”; 4.4.4.2-т “Гамшиг, аюулт үзэгдэл, ослыг зарлан мэдээлэх системийг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.”; 4.4.4.3-т “Онцгой байдлын байгууллагын харилцаа холбооны бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэн, сансрын хиймэл дагуулын болон цаг агаарын мэдээллийг шуурхай боловсруулж, хэрэглэгчдэд хүргэх гамшгийн удирдлагын нэгдсэн төвтэй болно.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллахад олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардагдахаар байна.

Түүнчлэн ОБЕГ нь алсын хараагаа үндэсний болон олон улсын хэмжээнд итгэл хүлээсэн, үйл ажиллагааны чадавхтай байгууллага болон хөгжихөд оршино гэж тодорхойлжээ. Үүнд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх чадавхтай байгууллага байх, түүний эрх зүйн байдал, чиг үүрэг, үйл ажиллагаа ба эрх хэмжээг тогтоох асуудал холбогдоно.

Өдгөө хүчин төгөлдөр мөрдөж буй ГХтХ-д олон улсын харилцаа, хамтын ажиллагаанд холбогдох дараах агуулга бүхий хэм хэмжээг тусгасан байна.

Хүснэгт 17. ГХтХ дахь олон улсын харилцаатай холбоотой хэм хэмжээ

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.
28.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 28.1.7.олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд аврах багийг оролцуулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;
29.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь чиг үүрэгтэй: 29.1.9.Засгийн газраас олгосон бараа, материал, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, хяналт тавих; <u>29.1.16.гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж нэгтгэн, боловсронгуй болгох саналыг эрх бүхий байгууллагад танилцуулах</u> ; 29.1.17.гамшгаас хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын болон дотоодын байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх; 29.1.18.олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох багийг бүрдүүлж, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;
21.3.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дотоодын болон гадаад улсын, эсхүл олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэдийн хүмүүнлэгийн тусламжийг авч болно.
39 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламж
39.1.Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн Улсын онцгой комисс олон улсын хүмүүнлэгийн тусламж авах саналыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ.
39.2.Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал /цаашид "тусламж үзүүлэгч тал" гэх/ өөрийн дипломат төлөөлөгчийн байгууллагаар дамжуулан гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүсэлт гаргасан бол Засгийн газар уг тусламжийг авах эсэх талаар шийдвэр гаргана.

39.3.Тусламж үзүүлэгч тал нь тухайн улсын болон олон улсын байгууллагад бүртгүүлсэн байна.
39.4.Монголын улаан загалмай нийгэмлэг нь олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэг, холбоонд хандан гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж хүсэх, хүлээж авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.
40 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт
40.1.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг хууль тогтоомж, заавар, удирдамжийн дагуу Улсын онцгой комисс зохицуулж, хяналт тавина.
40.2.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
40.3.Тусламж үзүүлэгч талын үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр төрийн болон нутгийн захиргааны байгууллага, олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
42.3.Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бүсийн төв, аймаг, нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, бүлэг, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, эрэлч нохойн алба, шуурхай удирдлага-зарлан мэдээллийн төв, ар тал, тээвэр-ложистик, бүтээн байгуулалт-барилга байгууламж, техник засвар, үйлчилгээ, дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн үйлдвэр, эмнэлэг-сувилал, судалгаа шинжилгээ, сургалт, туршилт үйлдвэрлэл, архив, спорт, соёл урлаг болон бусад нэгжтэй байна.

Түүнчлэн ЦАХЭЗБТХ-ийн 6 дугаар зүйлийн 1-д “Цэргийн алба хаагч дараах үүрэгтэй:” гэсний дотор 6.1.6-д “гадаад улсад үүрэг гүйцэтгэхдээ тухайн улсын болон олон улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөх;” үүрэгтэй гэж заасан нь онцгой байдлын байгууллагын алба хаагчид мөн хамаарна.

Иймд ГХТХ-ийн 42 дугаар зүйлийн 1-д “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.” гэж тусгасныг өргөжүүлж, олон улсын хамтын ажиллагаа (олон улсын болон гадаад улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах)-нд холбогдох зохист хүрээг нэмж тусгах нь зүйтэй гэсэн саналтай байна.

Үнэлэх зохицуулалт

42.2. Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл бий эсэх

Онцгой байдлын байгууллага ба гамшгаас хамгаалах системийн бусад байгууллага, эрх бүхий этгээд хоорондын харилцан хамаарал, уялдаа холбоо, бүрэн эрх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагын асуудал, тэдгээрийн хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар тус судалгааны тайлангийн V, VI бүлэг буюу “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт” хэсэг болон бусад бүлгийн холбогдох хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.

Тухайлбал, удирдлагын давхардалтай бүтэц, эрх, үүргийн ялгаа тодорхой бус байдал, захиргааны актуудын хэт хамаарал зэрэг томоохон багц асуудлууд гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, ялангуяа удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилтэд ихээхэн сөрөг үр дагавар бий болгож байгаа нь онцгой байдлын байгууллага нэгдмэл, мэргэжлийн, төвлөрсөн удирдлагатай байх харилцаанд мөн нөлөөлнө.

Судалгааны үр дүнд үндэслэн, удирдлагын төвлөрлийг оновчтой болгох (тухайлбал онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын онцгой комисс, Онцгой байдлын байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээнд давхардал үүсгэсэн буюу тэдгээрийн ялгаатай байдал тодорхой бус, хууль хэрэглээний хувьд ойлгомжтой байх шаардлага алдагдуулсан байгааг залруулах), Эрх, үүргийн уялдааг хангасан зохицуулалт хийх (УОК, Шуурхай штаб, ОБЕГ, Шадар сайд зэрэг эрх бүхий этгээдийн чиг үүргийг давхардалгүй, хоршиж ажиллах байдлаар хуваарилах, “өөрийн эрх хэмжээний хүрээнд” гэх ерөнхий заалтаар бус тодорхой хэм хэмжээгээр орон нутгийн байгууллагуудын эрх, үүргийг тодорхойлох), хуульчилсан журмуудыг цэгцлэх (хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 30 гаруй журамд бүрэн дүн шинжилгээ хийж, давхардал, хийдэл, зөрчилтэй хэсгийг цэгцлэх, хуульд тусгах шаардлагатай харилцааг хэм хэмжээ тогтоосон актаар зохицуулсан байдлыг өөрчлөх), мэргэжлийн нэгжүүдийн эрх зүйн байдлыг тодорхойлох болон хүний эрхийн хамгаалалд суурилсан шийдвэр гаргалтыг баталгаажуулах санал дэвшүүлсэн болно.

Мөн энэхүү судалгааны тайлангийн 9 дүгээр бүлэг буюу “Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал” хэсэгт онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоо, онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журам, онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, алба хаагчийн эрх, үүрэг зэрэг харилцаа нь тус байгууллагын удирдлага мэргэжлийн байх, нэгдмэл байх, төвлөрсөн байх зарчмыг хангахад чухал нөлөөтэй, уялдаа холбоо бүхий асуудлууд юм. Иймд дээр дурдсан харилцааг зохицуулсан хэм хэмжээг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал(УОК, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон ОБЕГ-ын даргын бүрэн эрх, ОББ-ын чиг үүрэг, бүсийн төвийн удирдлага, онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх, үүрэг г.м)-ын талаар судалсан үр дүнг энэхүү бүлгээс тухайлан үзнэ үү.

Жишээлбэл, ГХтХ-ийн 42.6-т “Онцгой байдлын байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна.” гэж, ГХтХ-ийн 46.2-т “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга,

тэргүүн дэд дарга, дэд даргад цэргийн дээд цол олгож болно.” гэж заасан нь онцгой байдлын байгууллагыг улс төрөөс ангид байлгах, тогтвортой байдлыг хангах зорилготой бөгөөд төрийн цэргийн байгууллагын удирдлагын зарчмыг хангахад мөн эерэг нөлөө бүхий зохицуулалт болсон гэж үнэлж байна.

Судалгааны энэ бүлэгт онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтан болон алба хаагчдаас мэдээлэл цуглуулж, тэдгээрийн саналыг тусгахыг зорьсон болно. Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл байх, төвлөрсөн удирдлагатай байх харилцаанд хүндрэл, бэрхшээл бий эсэх асуумжийн дагуу хийсэн ярилцлага болон бичгээр ирүүлсэн мэдээлэл, саналыг нэгтгэвэл⁷⁸:

- Онцгой байдлын байгууллага дотооддоо удирдлагын эрх мэдэлд хамаарах зөрчил байхгүй, төлөвшсөн гэж үзэж байна; Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд удирдлага чухал учир оролцогч байгууллага, дарга нарын эрх хэмжээг нарийвчлан тодорхойлох шаардлагатай;

- ОББ-ын хуульд заасан эрх зүйн байдалд халдах, хөндлөнгөөс оролцох тал нэлээд байна. Тухайлбал, ОББ-ын хуулиар хүлээсэн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд УОК оролцох гээд байдаг тал бий. Энэ байдал ковидын нөхцөл байдал үүссэн үеэс нэлээд үүсэх болсон бөгөөд жишээлбэл УОК-той холбоотой зохицуулалтыг ГХТХ-д түлхүү оруулж, эрх хэмжээг нь нэмэгдүүлсэн. Энэ нь тухайн үед гэнэт үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан хийсэн шинэчлэл учраас тайван цагт хэрэгжүүлэхэд асуудалтай, тухайлбал УОК ба ОБЕГ-ын эрх хэмжээ давхардах, тодорхой бус байх нөхцөл үүсгэсэн. Иймд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг тайван цаг ба онцгой нөхцөл байдлын үе гэж хооронд нь салгаж, ялгамжтай зохицуулах хувилбарыг тусгах нь зүйтэй;

- Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн өмнөх үеийн үйл ажиллагаанд УОК оролцох шаардлагагүй гэж үзэж байна. Гамшгийн үеийн нөхцөл байдал биш байхад УОК оролцож шийдвэр гаргаснаар хүндрэл, бэрхшээл гардаг. Улс төрийн нөхцөл байдлаас хамаарч байна уу гэмээр зүйл бас байдаг. Жишээ нь гамшиг, ослын асуудал болонгуут Шадар сайд руу шүүмжлэл их ирдэг, үүнээс хамаарч Шадар сайд анхаарахаас өөр аргагүй байдалд ордог байж болзошгүй. ОББ-ын хүрээнд хуульд заасны дагуу асуудлыг удирдан зохион байгуулж, зүй ёсоор зохицуулж байтал Нийслэлийн Засаг даргын хэмжээний асуудал болгож хутгалдах байдал их гардаг. Ингэснээр мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлага алдагддаг;

- ОББ-ын алба хаагчийн томилгоонд төрийн албаны мерит буюу шатлан дэвших зарчмыг мөрдүүлэх, албан тушаал, зэрэг дэвийн шат алгасаж томилох, томилогдох явдлыг зогсооход чиглэсэн хэм хэмжээг хуульд тусгах шаардлагатай. Томилгоонд тухайн ажиллах байгууллагын хамт олны албан ёсны санал /Жишээлбэл, ёс зүйн дэд хорооны гэх мэт/-ыг харгалздаг байвал сайн байна. Албан тушаалд шинээр болон дотроосоо дэвшин томилогдоход гаднаас, ялангуяа улс төрд нөлөө бүхий албан тушаалтны дэмжлэгээр томилогдсон буюу хамт олонд хүлээн зөвшөөрөгдөөгүй, ур чадваргүй хүмүүс “ажил унагаж” байна. Ийм шинжтэй томилгоо нь хамт олны ажлын идэвх, урам зоригийг мохоодог;

⁷⁸ 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр ОБЕГ-ын албан тушаалтантай хийсэн ярилцлага, 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр, ОББ-ын харьяа нэгжийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас

- Хууль, эрх зүйн орчны хувьд авч үзвэл, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдал зарлах нь эдийн засаг, улс төр, нийгмийн олон талт харилцаанд сөрөг нөлөөллийг бий болгодог. Жишээлбэл, гамшгийн үед Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу гэрээ шууд байгуулах боломжтой. Учир нь тус хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2-т “онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргыг буруугаар ашиглах байдал ажиглагддаг;

- Бэлэн байдлын зэргийг ангилан үзэх нь ихээхэн ач холбогдолтой боловч хуульд заасан үндэслэл тогтоогдоогүй, зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад мэргэжлийн байгууллагын дүгнэлт, саналыг харгалзахгүйгээр бэлэн байдал /өндөржүүлсэн/ зарлаж байгаа нь иргэдийн сэтгэл зүйд нөлөөлж, цаашид бэлэн байдлыг үл тоох хэв шинжийг бий болгож байна. Энэ нь иргэдийн сэтгэл зүй болон эдийн засаг, улс төр, нийгмийн олон талт харилцаанд сөрөг нөлөөллийг бий болгох эрсдэлтэй гэх мэтчилэн санал, дүгнэлтийг өгсөн байна.

Дээр дурдсан нөхцөл байдлууд нь онцгой байдлын байгууллагын мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагын зарчмыг алдагдуулахад хүргэх үр дагавартай. Ингэснээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, онцгой байдлын алба, алба хаагчийн эрх зүйн байдал, иргэд, олон нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хүртэл сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ талаар судалгааны холбогдох хэсгүүдэд тусгав.

Үнэлэх зохицуулалт
42.3.Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бүсийн төв, аймаг, нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, бүлэг, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, эрэлч нохойн алба, ар тал, тээвэр-ложистик, бүтээн байгуулалт-барилга байгууламж, техник засвар, үйлчилгээ, дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн үйлдвэр, эмнэлэг-сувилал, судалгаа шинжилгээ, сургалт, туршилт үйлдвэрлэл, архив, спорт, соёл урлаг болон бусад нэгжтэй байна.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн тухай

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллагын бүтэц, салбар, нэгжийг тодорхойлсон зохицуулалтын хэрэгжилт, ололт амжилт, тулгамдсан асуудал?

Улсын иргэний хамгаалалтын газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газрыг нэгтгэн Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор “Гамшгаас хамгаалах ерөнхий газар”-ыг байгуулж, Монгол Улсын Ерөнхий сайдын 1 дүгээр сарын 13-ны өдрийн 8 дугаар захирамжаар “Гамшгаас хамгаалах байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, орон тоо”-г баталж мөрдүүлсэн түүхтэй. Онцгой

байдлын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, Онцгой байдлын ерөнхий газрын бүтэц, салбар, нэгжийн талаар тус байгууллагын 10, 15, 20 жилийн ойн номонд түүхчлэн, дэлгэрэнгүй танилцуулж ирсэн нь тус албаны хөгжлийн өнгөрсөн, өнөө, ирээдүй цагт хамааралтай үнэ цэнтэй сурвалжид тооцогдоно.⁷⁹

Онцгой байдлын байгууллага нь 2004 онд гамшгаас хамгаалах төрийн бодлого, үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэгтэйгээр Аврах тусгай анги, Хангалт үйлчилгээний анги, аймаг, нийслэл, дүүргийн Гамшгаас хамгаалах штаб, Гал түймэр унтраах аврах анги, Эрэн хайх, аврах отряд, Улсын нөөцийн салбарууд гэсэн бүтэцтэйгээр зохион байгуулагдсан. Хөгжин дэвшсэн 20 жилд Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа өргөжин тэлж Үндэсний аврах бригад, нийслэлийн Онцгой байдлын газар, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Уул уурхайн аврах 09 дүгээр анги, Агаараас эрэн хайх аврах 111 дүгээр анги, Жаргалант сэргээн засах төв 113 дугаар анги, Ар талын 115 дугаар анги, Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв 119 дүгээр анги, Аврагч биеийн тамиртехник спортын хороо 120 дугаар анги, “Онцгой” тусгай хувцас, хэрэгслийн туршилт үйлдвэрлэлийн төв 121 дүгээр анги, Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа, туршилт үйлдвэрийн төв 123 дугаар анги, 112, 179, 185 дугаар анги, Эрэлч нохойн сургалтын төв, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Бүсийн төвүүд, аймгийн Онцгой байдлын газар, сумын Онцгой байдлын хэлтэс, орон нутгийн Улсын нөөцийн анги, салбар, Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.⁸⁰

“Салбар нэгжийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын хавсралтаар “Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгж”-ийг баталсан.⁸¹ Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2016 оны 170, 183 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 192 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 114 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны 331 дүгээр тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон. Тухайн тогтоолд ГХтХ-ийн 15.5-д заасныг үндэслэн тогтоох нь гэж заасан боловч өнөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ГХтХ-д 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг гэж байхгүй байна. Уг тогтоолын хавсралтад 1/. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх салбар болон салбарын нэр; Орон нутаг дахь салбар, нэгж (бүсчилсэн байдлаар) болон бүсийн нэр, аймаг, нийслэлийн онцгой байдлын газар, нэгжийн нэрийг заажээ.

Дээрх тогтоолоор орон нутгийн Онцгой байдлын хэлтсүүдийг газар болгон өргөтгөж, Баруун бүс, Зүүн бүс, Хойд бүс, Өмнөд бүс, Улаанбаатар гэсэн 5 бүсийн төв болгон хуваах замаар томоохон бүтцийн өөрчлөлт хийж, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, бригад, анги, эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, салбар, бүлэг, салааны зохион байгуулалтаар гамшгаас хамгаалах үйл ажиллагааг Засгийн газрын тохируулагч агентлагийн статустай байгууллагын хувиар хэрэгжүүлж ирсэн. Шадар сайдын 2025 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 93 дугаар тушаалаар баталсан “Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журам”-д

⁷⁹ [Онцгой байдлын ерөнхий газар - Монгол улсын засгийн газрын тохируулагч агент](#), албан ёсны цахим хуудас

⁸⁰ Онцгой байдлын ерөнхий газар, Онцгой байдлын байгууллага 20 жил, (УБ.,2024 он), 66 дахь тал

⁸¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11665>, Сүүлд үзсэн: 2025.5.15

онцгой байдлын бүсийг 7 болгож, бүс тус бүр төвтэй байхаар тогтоож, бүсчилсэн зохион байгуулалт, үйл ажиллагаанд тулгардаг байсан хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхээр зорьсон байна. /Уг шинэ журмын хэрэгжилт, үр дагаврыг одоогоор үнэлж, дүгнэлт хийх бололцоогүй ч ГХТХ-ийн 42 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэг буюу онцгой байдлын байгууллагын бүсийн харилцааг тусгасан зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн хэсэгт зохих мэдээлэл тусгав./

Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоолын хавсралт (Онцгой байдлын байгууллагын харьяа салбар, нэгж), Онцгой байдлын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, Онцгой байдлын ерөнхий газрын бүтэц, нэгжийн танилцуулга, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа байгууллагуудын бүдүүвч зураг, танилцуулгыг ОБЕГ-ын албан ёсны цахим хуудас болон ОБЕГ үүсэж хөгжсөний 10, 15, 20 жилийн ойн номонд тухай бүр тусгаж, өөрчлөлт, хөгжлийн талаар дэлгэрэнгүй дүгнэсэн байв.

Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүд, чиг үүрэг. 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Онцгой байдлын ерөнхий газар Ажиллагааны удирдлагын газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газар, Мэдээллийн технологийн хэлтэс, Бодлого төлөвлөлтийн газар, Захиргааны удирдлагын газар, Санхүү, ар талын газар, Урьдчилан сэргийлэх газар, Эрсдэлийн удирдлагын газар, Хяналт шалгалтын газар гэсэн нэгжүүдтэйгээр онцгой байдлын төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж байна. Бүтцийн нэгжүүдийг чиглэлээр нь авч үзвэл Төлөвлөх, Хэрэгжүүлэх, Хянах, Дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын чиглэл, хуваарийн дагуу тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж байна гэж дүгнэж байна. ГХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх хүрээнд хуулийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах явцад ОБЕГ-ын холбогдох нэгжийн удирдлага, мэргэжилтэн, алба хаагчдын төлөөлөл асуудлыг түүхчлэн, өнөөгийн бодит байдал, цаашдын хэрэгцээ, шаардлага, шийдвэрлэх боломж, бололцоог бодлогын түвшинд авч үзэж байсныг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 8 дугаар тушаалаар “Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр”-ийг шинэчлэн баталжээ. Шинэчилсэн бүтцээр Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжид бие бүрэлдэхүүний сургалтын асуудал хариуцсан дэд нэгж, Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийг дотоод хяналт-шалгалт, аюулгүй байдал /дүн шинжилгээ, үнэлгээний тасагтай/-ын асуудал хариуцсан дэд нэгжтэй байхаар баталсан байна.⁸²

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа байгууллагууд, чиг үүрэг. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны хүрээ томрон, бүтэц өргөжиж бүх аймаг, нийслэлд Онцгой байдлын газар, дүүрэг, зарим сумдад Онцгой байдлын хэлтэстэй, харин аймаг, нийслэл, сум, дүүрэгт гал унтраах, эрэн хайх аврах анги, салбар, улсын нөөцийн салбар нэгжтэй болжээ.

⁸² Эх сурвалж, ОБЕГ-ын мэдээлэл

ОБЕГ-ын харьяанд дараах газар, анги, салбарууд хуулиар хүлээсэн тусгайлсан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна Үүнд: Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах анги, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Аврагч биеийн тамир, техник спортын хороо, Улсын нөөцийн хүнс, өвс тэжээл, шатахууны салбар, Эрэлч нохойн алба, Давтан сургалт, сэргээн заслын төв багтана. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага нь бүтцийн нэгжийн хувьд бэхжиж үйл ажиллагааны хүрээ өргөжиж, үндсэн чиглэл болсон гал түймэр унтраах, аврах ангийн чадавх 76.9 хувиар, Эрэн хайх аврах ангийн чадавх 25 хувиар, Эрэн хайх аврах салбарын чадавх 3 дахин, Эрэн хайх аврах бүлгийн чадавх 20 дахин нэмэгдээд байна.

ОБЕГ-ын харьяа байгууллагууд хууль тогтоомж, салбарын дүрэм, журмын дагуу чиг үүргээ хэрэгжүүлэн үр бүтээлтэй ажиллаж байна. Тухайлбал, ОБЕГ-ын дэргэдэх орон тооны бус Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн чиг үүрэг, үйл ажиллагаа, амжилт бүтээл онцгой байдлын байгууллагын гамшаас хамгаалах системд эзэлж буй байр суурь, чадавхийг илэрхийлж байна. ОББ нь тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллагын хувиар нэгдмэл, төвлөрсөн, мэргэшсэн удирдлагыг хэрэгжүүлэхэд шинжлэх ухаанд суурилсан мэдлэг, ур чадвар, хандлагын ач холбогдол, үр өгөөж их юм.

Анх 2004 онд байгуулагдаж, 2006 онд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2006 оны 210 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан Шинжлэх ухаан, технологийн зөвлөл нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад мэргэжлийн зөвлөмжөөр хангах, судалгааны захиалга хэлэлцэх, хүлээн авах, сургалт эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаа, үзэл баримтлалыг тодорхойлох үндсэн чиг үүрэгтэй ажиллаж ирсэн. Түүхэн хугацаанд ШУТЗ нь 6 удаа шинэчлэгдэж үйл ажиллагаагаа өргөжүүлэн, Олон улсын ISSN2790-1181, ISSN2790-119X дугаар бүхий “Гамшиг судлал, инновац” мэргэжлийн сэтгүүлийг жилд 2 удаа гаргаж, шинжлэх ухаан, технологи, инновацад тулгуурласан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг явуулахад хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Гамшиг судлалын үндэсний хүрээлэн 2005 онд байгуулагдсан бөгөөд үүсэж хөгжсөн 20 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл 448, судалгааны тайлан 142, хуулийн төсөл 2, журам 24, заавар 26, стандарт 21, шинжлэх ухаан, технологийн төсөл 5, үнэлгээний аргачлал 34-ийг тус тус боловсруулж, гарын авлага, сурах бичиг 43, эрдэм шинжилгээ, судалгааны ном товхимол 48, эрдэм шинжилгээний өгүүлэл дотоодын хэвлэлд 143, гадаадын хэвлэлд 23-ыг тус тус хэвлүүлж, шинж бүтээлийн патент 2-ыг авсан байна. Эдгээр бүтээлийн 60 гаруй хувь нь онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах бодлого, үйл ажиллагаанд инновац болон хэрэгжиж зохих үр дүнгээ өгч байна.⁸³

⁸³ Гамшиг судлалын хүрээлэнгийн 20 жилийн ойн хурлын үндсэн илтгэлийн тэмдэглэлээс.

Гамшиг судлалын ухаан нь байгалийн болон нийгмийн шинжлэх ухаан, аюулгүй байдал судлал, цэргийн шинжлэх ухаантай холбогддог бөгөөд салбар дундын шинжлэх ухаан юм. Энэ нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны цар хүрээ, үүрэг, ач холбогдлыг илтгэхээс гадна онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай, онол, практикийн хосолсон арга хэлбэрээр, олон улсын чиг хандлага, үндэсний онцлогт нийцсэн ажил үйлчилгээ явуулахад шинжлэх ухааны байгууллагын оролцоо, дэмжлэг чухал гэдгийг баталгаажуулж байна гэж үнэлэв.

ГХТХ-д тухайлан тусгасан зохицуулалтаар дамжуулан онцгой байдлын байгууллагын бусад харьяа байгууллага, салбар нэгжийн чиг үүрэгтэй холбоотой зарим асуудал, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, бодлогын талаар энэхүү судалгааны холбогдох хэсэгт тусгасан.

“Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Онцгой байдлын байгууллагын бүтцэд нэмж салбар, нэгж байгуулах хэрэгцээ, шаардлага бий эсэх

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.4.4-т “Гал түймэр унтраах болон эрэн хайх, аврах нэгжийг орон нутагт өргөтгөж, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.”, 4.4.4.5-д “Хүн амын нягтаршил ихтэй болон алслагдсан байршилд гал түймэр унтраах, аврах анги шинээр байгуулна.”, 4.4.4.6-д “Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгсэл, агуулахын аж ахуйн технологийг хөгжүүлж, гамшгийн үеийн болон стратегийн зориулалттай бараа материалын нөөц, хангамжийн хэмжээг нэмэгдүүлнэ.”, 4.4.4.7-д “Хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан агуулах барьж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангана.”, 4.4.4.8-д “Шатахуун, шатах, тослох материалын бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулах барина.” гэж тус тус заасан нь нэмж нэгж, салбар байгуулах хэрэгцээ, шаардлага байгааг тандан судалж бодлогын баримт бичигт тусгасны илрэл юм.

ОБЕГ-ын мэдээллээр, 2025 оны байдлаар ОББ-ын нийт 128 салбар, нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ГХТХ-ийн 42.3-т тоочиж нэрлэснээс өөр чиглэлээр нэгж байгуулаагүй байна. ОББ-ын салбар, нэгжийн хүртээмж, нэмж байгуулах хэрэгцээ, шаардлагын талаар лавлаж тодруулахад:

- ОББ-ын Гал түймэр унтраах, аврах нэг анги 96.0 мянган хүн амд, нэг аврагч, гал сөнөөгч 4800 хүнд, газар нутгийн хэмжээгээр тооцож үзвэл гал түймэр унтраах, аврах нэг анги 3133 км² талбайд байрлах эд хөрөнгө, иргэдийг хамгаалахаар үүрэг гүйцэтгэж байна;

- Өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавигдах шаардлага MNS 6412:2013 стандартын дагуу Монгол Улсын хэмжээнд гал түймэр унтраах 171 анги байхаас 77 анги үйл ажиллагаа явуулж байна. Улс орны нийгэм, эдийн засгийн чадавх тохиолдож буй гамшиг, ослын нөхцөл байдалтай уялдуулан цаашид I-зэрэглэлийн **3**, II-зэрэглэлийн **10**, III-зэрэглэлийн **24**, IV-зэрэглэлийн **57** анги буюу нийт **94** гал түймэр, унтраах анги байгуулах хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна;

- Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага MNS 6740:2018: улсын стандартын дагуу шаардлагатай сумдад Эрэн хайх аврах нэгж байгуулахад 6000-аас доошгүй хүн амтай байх шаардлага тавигддаг. Гэвч салбар нэгж байгуулагдаагүй сумдын хүн ам дунджаар 2,000–5,000 байна. Үүнтэй холбогдуулан Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавигдах шаардлага буюу MNS 6412:2013 стандарт, “Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага” буюу MNS 6740:2018: улсын стандартыг шинэчлэх ажлын хэсгийг ОБЕГ-ын даргын тушаалаар томилон ажиллуулж байна;

Шинээр анги, салбар нээх үед нөөцөө тийш хуваарилдаг. Албаны чадавхийг нэмэгдүүлэх хэрээр хөрөнгө шаардагдах нь мэдээж. Үүнд төсвийн байдал ихээхэн хүндрэл, бэрхшээл үүсгэдэг, үүнд Сангийн яам төсвийн хэмнэлтийн өнцгөөр ханддаг. Онцгой байдлын албаны онцлогоос хамаарч бусад байгууллагатай нэгэн адил төсвийн хэмнэлтийн горим баримтлах нь зүйд нийцэхгүй. Гэвч Сангийн яам үүнийг ойшоодоггүй байдал ажиглагддаг⁸⁴;

ОББ-ын бүтэц, байршлын талаарх мэдээлэл ил тод, хүртээмжтэй байх ёстой. Гэтэл үүнийг төрийн цэргийн байгууллага гэдэг үүднээс авч үзэж нууцын зэрэглэлд оруулах байдал бий. Энэ утгаараа практикт асуудал дагуулах, албаны зарим үйл ажиллагаа, алба хаагчийн үйлдэл, тухайлбал ил тод байдлын шалгуур хангах үүднээс байршилтай холбоотой мэдээлэл тавих, олон нийтэд мэдээлэх үйлдэл нь сахилга, хариуцлагын асуудалтай холбогдож болзошгүй тал үүсдэг. Ер нь ГХТХ болон холбогдох эрх зүйн актын хэм хэмжээ төрийн болон албаны нууцын харилцааг зохицуулж буй хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг нягталж шийдвэрлүүлэх хэрэгцээ, шаардлага бий. ОББ-ын байршлыг нууцлах бус харин бүр ил тод мэдээлж таниулах учиртай. Зарим чиг үүргийн нэгжийг иргэдэд улам ойртуулж, нүсэр бус бүтэц, зохион байгуулалтаар ойр ойрхон зайд байршиж үйл ажиллагаа явуулдаг Япон зэрэг улсын сайн жишгийг нэвтрүүлбэл үр ашигтай гэж үздэг байна.

Үнэлэх зохицуулалт

42.4. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг газар зүйн онцлог, хүн амын нягтрал, аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээг харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд Засгийн газрын шийдвэрээр байгуулна.

⁸⁴ 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр ОБЕГ-ын албан тушаалтантай хийсэн ярилцлагаас

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. *“Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг газар зүйн онцлог, хүн амын нягтрал, аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээг харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд Засгийн газрын шийдвэрээр байгуулна.” гэж заасан зохицуулалтын хэрэгжилт, эерэг, сөрөг нөлөөлөл*

ГХТХ-ийн 42.4-т “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг газар зүйн онцлог, хүн амын нягтрал, аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээг харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд Засгийн газрын шийдвэрээр байгуулна.” гэсэн зохицуулалт үйлчилж байна. Үүний дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дэргэд харьяа нэгж байгуулагдан ажиллаж байна.

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т “гал түймрийн аюулаас хамгаалах зорилгоор гал түймэр унтраах нэгж, улсын байцаагчийг ажиллуулах”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Гал түймэр унтраах аврах ангийг улсын төсвөөс, гал түймэртэй тэмцэх гэрээт ангийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс, гал түймэртэй тэмцэх хэсгийг тухайн иргэн, байгууллага, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг тухайн орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлнэ” гэж заасны дагуу улсын хэмжээнд 14 ТӨҮГ болон аж ахуйн нэгжид гэрээт галын байцаагчийг ажиллуулдаг.⁸⁵ ГХТХ-ийн 42 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд байгуулсан онцгой байдлын байгууллагын харьяа нэгжийн үйл ажиллагааны бүх зардлыг тухайн байгууллага нь бүрэн хариуцахаар заасан зохицуулалт бүрэн хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь практикт нийцсэн, төсөвт ачаалал үүсгэдэггүйгээрээ ач холбогдолтой хэм хэмжээ юм.

“Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. *Төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд үүрэг гүйцэтгэн ажиллаж буй онцгой байдлын байгууллагын харьяа бус нэгж бий эсэх, онцгой байдлын байгууллагатай харилцан хамаарал шаардлагатай эсэх*

Дээр дурдсан ТӨҮГ-ын дэргэд ЗГ-ын шийдвэрээр байгуулсан ОББ-ын харьяа нэгжээс гадна төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр гэхээсээ илүүтэй хувийн хэвслүүд, тэр дундаа томоохон уул уурхайн компани, тухайлбал “Оюутолгой” ХХК дэргэдээ гал унтраах анги байгуулан ажиллаж байна. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон онцгой байдлын

⁸⁵ ОБЕГ-ын мэдээлэл, 2025.06.15

албаны онцлог, баримтлах зарчим, мэргэжлийн байх хэрэгцээ, чиг үүргийн ач холбогдлыг харгалзан “Оюутолгой” ХХК-ийн дэргэдэх гал унтраах ангитай төсөөтэй буюу онцгой байдлын байгууллагын харьяа бус холбогдох нэгжийн бүртгэл, хяналт, сахилга, хариуцлага, харилцаа ба хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлагыг тандан судлах нь зүйтэй гэж үзэж байна.

Үнэлэх зохицуулалт
42.5.Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ гэж заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл бий эсэх

Тус судалгааны тайлангийн 3.8 дэд бүлэг (Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт)-т тусгасан Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн үндэс, эх үүсвэр, хуваарилалт, хариуцах субъектүүдийг тодорхойлсон зохицуулалтын хэрэгжилт, үр дагаврыг үнэлж, өнөөгийн орчны сул талыг илрүүлсний үндсэн дээр цаашид боловсронгуй болгох чиглэлд дэмжлэг үзүүлэх хүрээнд гадаад орнуудын зохицуулалтын талаарх лавлагаа, зөвлөмж боловсруулсныг үзнэ үү. Түүнчлэн тайлангийн 3.7 дэд бүлэгт онцгой байдлын алба хаагчийн эрх зүйн байдалд хамаарах зарим хэм хэмжээний хэрэгжилтийн үр дагаврын мэдээлэл мөн төсөв, санхүүжилттэй холбогдоно.

Онцгой байдлын албыг бэхжүүлэхэд үе, үеийн Засгийн газраас онцгой анхаарч хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсээр ирсэн байна. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төсөв жил бүр нэмэгдэж ирсэн бөгөөд үүний хэрээр байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн материаллаг болон оюуны бүтээн байгуулал өрнүүлж ихээхэн амжилт үзүүлжээ.⁸⁶

Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ гэсэн заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх хүрээнд боловсруулсан шалгуур үзүүлэлтийн асуумжийн дагуу ОБЕГ-ын мэргэжилтнээс өгсөн мэдээллийг танилцуулбал⁸⁷:

- Онцгой байдлын байгууллага нь ОБЕГ болон Улсын нөөцийн бараа бүрдүүлэлт сэлгэлт шинэчлэлт, Улсын төсвийн хөрөнгө оруулалт гэсэн 3 данс, 21 аймгийн онцгой байдлын газар, Нийслэлийн онцгой байдлын газар, нийслэлийн дүүргүүдийн 9 хэлтэс, харьяа 15 анги салбараас бүрдсэн бүтцийн нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. 2024 онд төсвийн төсөөллөө гаргаж, ОББ-ын одоо байгаа салбар нэгжийн тоогоор хэрэгцээ, шаардлагыг хангах хэмжээнд тооцоо хийж үзэхэд 153 тэрбум төгрөг шаардагдахаар байгаа талаарх мэдээллийг ЭЗХЯ,

⁸⁶ ОБЕГ, “Онцгой байдлын алба-15 жил” ойн номоос зарим мэдээллийг авсан.

⁸⁷ ОБЕГ-ын мэргэжилтнээс өгсөн мэдээлэл

СЯ-нд хүргүүлсэн. Хэдхэн жилийн өмнө 170 тэрбум шаардлагатай гэсэн тооцоо гарсан байсныг богино хугацааны дотор бууруулсан үр дүнд хүрснийг илэрхийлж байгаа үзүүлэлт гэдгийг дурдах нь зүйтэй;

- Төсвийн санал, дэмжигдэх түвшингийн тухайд: Сүүлийн 3 жилд буюу 2023-2025 онуудад төлөвлөн хүргүүлсэн төсвийн төслийн саналыг дундажлан тооцвол ОБЕГ-аас хүргүүлсэн саналын 50.5 хувийг шийдвэрлэн баталж ирсэн байна. Батлагдсан төсвийг өр авлага үүсгэлгүй, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах тал дээр төсвийн шууд захирагчийн зүгээс хяналт тавьж ажилладаг. Төсвийн санал дэмжигдэх түвшний тухайд, санхүү төсвийн асуудал эрхэлсэн байгууллагын хувьд онцгой байдлын байгууллагын чиг үүргийн хүрээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж, боломжит байдлаар дэмжин ажиллаж, төсвийг баталж ирсэн гэж хардаг. Гэхдээ салбар, үйл ажиллагааны онцлогоос хамаарч онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд шаардагдах нэмэлт зардал ба нөөц хөрөнгийг зайлшгүй төсөвлөж байх шаардлагатай;

Төсвийн хэмжээ, хангалт хүрэлцээтэй эсэх тухайд: Салбарын хэмжээнд стандартын дагуу шинээр байгуулах салбар, нэгж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хувцас хангалт, барилга байгууламжийн хүрэлцээ-стандартын нийцэл, алба хаагчдын нийгмийн баталгаа, ахмад настны нийгмийн баталгаа зэрэг холбогдох хууль тогтоомжуудад заасан хүрээнд авч үзвэл төсөв хангалтгүй, хүрэлцээтэй бус байдаг;

ГХтХ-д заасан төсөв, санхүүтэй холбоотой зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр тухайлсан саналын тухайд: “Онцгой байдлын байгууллагын мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам”-ын 2.3.2-т “мэргэшлийн зэргийн шалгалтад хамрагдах алба хаагчийн холбогдох баримт бичгийг хянаж, шалгах,” гэж заасныг бусад хүчний байгууллагын адил шалгалтгүйгээр, зөвхөн ажилласан жилээр олгодог байх саналтай байна. Учир нь бие бүрэлдэхүүний зонхилох хувийг эзэлдэг ахлагч бүрэлдэхүүн нь хууль, эрх зүй, онолын мэдлэгийн шалгалт буюу 1 дүгээр шатны шалгалтад тэнцээгүй гэсэн үндэслэлээр мэргэшлийн зэргийн нэмэгдэл авах боломж хомс болдог. Энэ нь ГХтХ-ийн холбогдох заалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Дээр дурдсанаас гадна ГХтХ-ийн онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой, түүний дотор алба хаагчийн эрх, нийгмийн баталгаа, тэтгэмж, урамшуулалтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт, үр дагаврыг үнэлсэн судалгааны хэсгүүдэд төсөв, санхүүжилтийн өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудал, шийдлийн хувилбарын талаарх мэдээлэл мөн багтсан тул тайлангийн холбогдох хэсэгт тусгасан. Эдгээр мэдээллийг шинжлэн дүгнэсэн судалгааны үр дүнг тайлангийн Дүгнэлт, зөвлөмж хэсэгт байршуулав.

“Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Онцгой байдлын байгууллагын төсвийн санхүүжилтийн хэлбэрийг өргөжүүлэх шаардлагатай эсэх

ГХТХ-ийн 42 дугаар зүйлийн 5-д “Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.” гэж заасан хүрээнд тухайн байгууллагын санхүүжилтийг шийдвэрлэх эрх зүйн орчин үйлчилж байна. Гэтэл гамшгаас хамгаалах үйл ажиллагаа улс дотоодод төдийгүй гадаад орнуудын болон олон улсын харилцааны шинжтэй цар хүрээгээ улам тэлж, оролцогчдын хамтын ажиллагааг чухалчилж байгаа чиг хандлагыг дагаж онцгой байдлын байгууллагын хөрөнгө, санхүүжилтийг зүй зохистой шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Иймд ГХТХ-ийн 42.5-д “Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.” гэж заасныг өргөжүүлж, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу гадаадын зээл, буцалтгүй тусламж, дотоодын тусламж хандив гэх мэт бусад орлогоос бүрдэх нөхцлийг тусгах нь зүйтэй. Ингэснээр онцгой байдлын байгууллагын санхүүжилт сайжрахын зэрэгцээ төсвийн зарцуулалт, хяналтыг сайжруулах эрх зүйн үндэслэл мөн бүрдэнэ. Түүнчлэн тус хуулийн бусад зохицуулалт, тухайлбал онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаатай холбогдох бусад хэм хэмжээг хэрэгжүүлэх бодит нөхцлийг бүрдүүлж /тухайлбал холбогдох журмыг боловсронгуй болгох эсхүл хүний нөөцийг чадавхжуулах/, улсын төсөвт тусгуулах, төсвийг зарцуулах, хэрэгжилтийг хянах механизмыг сайжруулах шаардлагатай.

Цагдаагийн албаны тухай хуулийн 93 дугаар зүйлд Цагдаагийн байгууллагын төсвийн талаар тусгасан бөгөөд тус хуулийн 93.1-д “Цагдаагийн байгууллагын төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах шаардлагыг хангасан байна.” гэж, мөн хуулийн 93.2-д “Энэ хуулийн 93.1-д заасан шаардлагын хүрээнд цагдаагийн алба хаагчийн хүнсний болон эдийн хангалт, сургалтын байр, сургалт, бэлтгэл, холбоо, мэдээлэл технологийн үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ, хамгаалах болон тусгай хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, техник хэрэгслийн зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.” гэж заажээ.

Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах шаардлагыг хангасан байх, мөн төсвийн зориулалтыг заасан хэм хэмжээ зэргийг харгалзан ГХТХ-ийн ОББ-ын санхүүжилттэй холбоотой зохицуулалтыг сайжруулах бололцоотой гэж үзэж байна. Ингэснээр онцгой байдлын байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай хэмжээнд төсвийг төлөвлөх, батлах, зарцуулах, хяналт тавих үйл ажиллагааны эрх зүйн орчин сайжирна.

Түүнчлэн онцгой байдлын салбарын онцлог, нөөцийн хэрэгцээг харгалзан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж ажиллах, тухайлбал Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.4.11-д “Гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, мэдлэгийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг бодитойгоор нэмэгдүүлнэ.” гэж заасныг дорвитой хэрэгжүүлэх нь зүйтэй.

Үнэлэх зохицуулалт

42.6. Онцгой байдлын байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна.

“Практикт нийцсэн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна гэсэн зохицуулалт практикт нийцсэн эсэх

ГХТХ-ийн 42.6-т заасан “Онцгой байдлын байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна.” гэсэн хэсгийг 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн. Энэ нь онцгой байдлын байгууллагын удирдлага, түүний бүрэлдэхүүнийг тодорхойлохын зэрэгцээ орон тоог тогтоож өгсөн хэм хэмжээ болно. Онцгой байдлын байгууллагын дарга, тэргүүн дэд дарга нь цэргийн дээд цолтой байх зохицуулалтыг 2017 оны ГХТХ-ийн шинэчилсэн найруулгад тусгасан. Эдгээр зохицуулалт нь онцгой байдлын байгууллагыг улс төрөөс ангид байлгах, тогтвортой байдлыг хангах зорилгоор хийгдсэн эрх зүйн арга хэрэгсэл мөн.

ГХТХ-ийн 30 дугаар зүйлд Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрхийг тодорхойлсон бөгөөд 30 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Онцгой байдлын байгууллагыг төлөөлөх, төсөв, хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргах эрхээ харьяа санхүүгийн нэгжийн дарга, эсхүл энэ хуулийн 42.6-д заасан албан тушаалтанд шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэж заасан байна. Үүнийг уг хуулийн 42.6-т “Онцгой байдлын байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна.” гэсэн хэсэгтэй холбож авч үзвэл тус байгууллагын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд дарга нь онцгой байдлын байгууллагыг төлөөлөх, төсөв, хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргах эрхийг онцгой байдлын байгууллагын даргаас эрх шилжүүлсний дагуу эдлэхээр байна.

Өнөөдрийн байдлаар Онцгой байдлын ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд дарга хуульд заасан эрх хэмжээний хүрээнд, хуваарилагдсан ажил үүргийг хариуцан ажиллаж байна. Тус байгууллагын удирдлагын бүрэлдэхүүний хэлбэрийг оновчтой бөгөөд практикт нийцэж байна гэж үзэж байна.⁸⁸ Харин ГХТХ-ийн 42 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт Онцгой байдлын байгууллагын даргын албан тушаалыг орхигдуулж тусгасныг өөрчилж “Онцгой байдлын байгууллага нь дарга, тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна.” гэж томъёолох саналтай байна.

⁸⁸ 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр ОБЕГ-ын албан тушаалтантай хийсэн ярилцлагаас

Эдгээр албан тушаалд томилох шалгуурын талаар ГХтХ-ийн 45 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн хэрэгжилтийг үнэлэх хүрээнд судалсан.

Үнэлэх зохицуулалт

42.7.Нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулна.

42.8.Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ГХтХ-ийн 42 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсгийн зохицуулалт нь онцгой байдлын байгууллагын бүсийн харилцааг тусгасан байх тул хамтад нь судалж, хэрэгжилтийн үр дагаврыг үнэлье.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж буй байдал, тулгамдсан асуудал, шийдэл бий эсэх

Нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулахаар хуульчилсан нь үндэснийхээ өвөрмөц байдлыг шингээсэн эрх зүйн зохицуулалт юм. Уг харилцааг журамлах эрх олгож “Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж ГХтХ-ийн 42 дугаар зүйлийн 8-д заасан. Энэхүү эрх хэмжээний хүрээнд, Шадар сайдын 2019 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 51 дүгээр тушаалаар “Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журам” батлуулж мөрдсөн. Тус журам гамшгаас хамгаалах шуурхай удирдлага зохицуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах, бүсийн онцгой байдлын байгууллагуудын бэлэн байдал, харилцан ажиллагааг хангах зорилготой хэдий ч хэрэгжүүлэх явцад зөрчил, хийдэл гарч байв. Тухайлбал, журмын зарим зохицуулалт ГХтХ болон бусад хуультай зөрчилдөж, тухайлбал бүсийн удирдлага (бүсийн төв оршин байгаа аймгийн Засаг дарга бүсийн төвийн захирагч байх зохицуулалтын улмаас тухайн бүсэд харьяалагдаж буй бусад аймгийн Засаг даргыг удирдах, үүнтэй холбоотой засаг захиргаа, түүний нэгжийн удирдлагын болон бусад асуудал хөндөгдөх) бүсийн статус, үйл ажиллагаа, санхүүжилт, зарцуулалт зэрэг харилцаанд хүндрэл, бэрхшээл гардаг⁸⁹ байсан.

⁸⁹ Онцгой байдлын байгууллагын алба хаагчтай 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр хийсэн ярилцлагаас

Онцгой байдлын бүсийн ажиллагаа, зохион байгуулалтыг боловсронгуй болгох үүднээс Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 93 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журам”⁹⁰ батлагдсан. Үүнтэй холбогдуулан ОБЕГ-ын Ажиллагааны удирдлагын газраас 21 аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын дарга нартай цахим хурал хийж, журмыг танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтэд анхаарч ажиллахыг чиглэл болгосон байна.⁹¹

Дээрх шинэ журмын дагуу Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх анги, салбараас бусад орон нутгийн салбар, нэгжийг Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн 7 бүсэд хувааж, гамшиг, томоохон осол, аюулт үзэгдлийн үеийн удирдлага зохицуулалтыг бүсчилсэн тогтолцоогоор зохион байгуулна. Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Өвөрхангай, баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Хойд бүсэд Булган, Орхон, Хөвсгөл, Төвийн бүсэд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Зүүн бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий, говийн бүсэд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Улаанбаатарын бүсэд нийслэл Улаанбаатар хот хамаарна.

Тус журмаар гамшиг, томоохон осол, аюулт үзэгдэлтэй тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах, бүсийн онцгой байдлын байгууллагуудын төлөвлөлт, бэлтгэл, бэлэн байдал, харилцан ажиллагааг хангаж зохицуулах болсноор томоохон хэмжээний гамшгийн үеийн удирдлага зохицуулалтыг бүсийн харьяа онцгой байдлын байгууллагуудын чадавхад түшиглэн шуурхай, оновчтой зохион байгуулах, түүнчлэн бүсчиллийн тогтолцоог Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлснээр онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах чадавхыг улсын хөгжлийн бодлого, шаардлагатай уялдуулан нэмэгдүүлэх дэвшил гарна гэж төсөөлж байна.⁹²

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 7.3.3-т “орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, тогтолцоог бэхжүүлнэ.”⁹³ гэж заасныг баримтлан онцгой байдлын байгууллагын бүсчилсэн үйл ажиллагааны зохистой байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн хүрээний хүчин чармайлт тодорхой үр дүнд хүрч байгааг дурдах нь зүйтэй.

Үнэлэх зохицуулалт

42.9. Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгслийн төрөл, хангамжийг стандартаар тогтооно.

“Зорилгод хүрсэн түвшин “ шалгуур үзүүлэлтийн дагуу

⁹⁰ [Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журам\(1\).pdf](#)

⁹¹ МҮОНТ, “Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журам”-ыг танилцуулж, хэрэгжилтэд анхаарч ажиллахыг чиглэл болгов. Сүүлд үзсэн: 2025.06.06

⁹² ОБЕГ-аас авсан тодруулга мэдээлэл, 2025 оны 6 дугаар сарын 9

⁹³ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211213&showType=1>

Шалгуур үзүүлэлт 1. Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгслийн төрөл, хангамжийг стандартаар тогтооно гэсэн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх

ГХТХ-ийн 42.9-д “Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгслийн төрөл, хангамжийг стандартаар тогтооно” гэж заасан. Энэ хэсэгт заасан стандарт гэдэг бол техник, багаж хэрэгслийн төрөл, түүний тоо хэмжээг илэрхийлнэ.⁹⁴ Өөрөөр хэлбэл гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник, багаж, хэрэгслийн тоо хэмжээг заасан боловч чанарын стандартыг хөндөөгүй байгаа нь өрөөсгөл юм. Техник, багаж, хэрэгслийн төрөл, тоо хэмжээний стандарт хэдий чухал боловч гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүргийг гүйцэтгэхэд чанарын шаардлага хангахгүй бол ямар ч ашиггүй, бүр эрсдэл дагуулах магадлалтай. Иймд гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгслийн чанарын стандартын талаарх зохицуулалтыг бас нэмж тусгах нь зүйтэй.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.3.20-д “Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хамгаалах үйл ажиллагаанд сансрын болон бусад дэвшилтэт арга технологи, техник хэрэгсэл, багаж төхөөрөмж нэвтрүүлж, гамшигтай тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүргэнэ” гэж, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.4.4-т “Гал түймэр унтраах болон эрэн хайх, аврах нэгжийг орон нутагт өргөтгөж, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” гэж тус тус тусгасан.

ОББ-д CS 11-0425:2019 “Онцгой байдлын байгууллагын гал түймэр унтраах тусгай зориулалтын тоноглол бүхий автомашинд тавих Ерөнхий шаардлага”, CS 11-0440:2020 “Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага”, CS 11-0439:2020 “Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага”, CS 11-0441:2020 “Гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгсэл. Ерөнхий шаардлага” гэсэн байгууллагын стандарт батлан хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай юм.

ГХТХ-д заасныг хэрэгжүүлж баталсан стандартын биелэлт буюу хангалтын талаар ОБЕГ-аас лавлаж тодруулахад:

- Өнөөдрийн байдлаар ОББ-ын техник, тоног төхөөрөмжийн хангалт 50.8 хувьтай байна. Тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэгсэл /цацраг, хими, усны ослын үед эрэн хайх аврах ажиллагааны хувцас, гал унтраах хөөс гэх мэт/-ийн хангалт дутагдалтай, цацраг, химийн ослын үед ашиглах хүн нэг бүрийн хамгаалах хувцас стандартаар 124 байхаас бэлэн байгаа нь 36, мөн цацраг химийн аврах ажиллагаанд ашиглагдах 657 нэр төрлийн багаж хэрэгсэл байхаас бэлэн байгаа нь 311 байна.

⁹⁴ Ярилцлагаас

- Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2020-2024 онд **9** Гал түймэр унтраах, аврах ангийг шинээр байгуулсан. Ингэснээр MNS 6412:2013 “Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага” стандартаар улсын хэмжээнд нийт **169** Гал унтраах анги байх шаардлагатай ч өнөөдрийн байдлаар **77** нэгж үүрэг гүйцэтгэж, үйлчлэх хүрээ 45.6 хувьтай болсон.

- “Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага” MNS 6740:2018 стандартаар улсын хэмжээнд нийт **66** эрэн хайх аврах нэгж байхаар тогтоосон. Өнгөрсөн 4 жилд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр **12** нэгжийг шинээр байгуулсан ба өнөөдрийн байдлаар **48** нэгжтэй, үйлчлэх хүрээ **72,7** хувьтай үйл ажиллагаа явуулж байна.

- Цаашид 2025-2028 онд гал унтраах **12** ангийг шинээр байгуулж, үйлчлэх хүрээг **52.7** хувьд, мөн **8** эрэн хайх, аврах нэгж байгуулж үйлчлэх хүрээг **84,8** хувьд хүргэхийг зорьж байна. Түүнчлэн цаашид Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гамшгийн үеийн бэлэн байдал, стандарттай гамшгийн удирдлага, зохицуулалт, эрсдэлийн менежментийн чиглээр туссан 16 арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд гал унтраах, эрэн хайх анги салбарын стандарт болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мөрдөж буй стандартуудыг шинэчилж батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлт 2. *Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгслийн төрөл, хангамж практик хэрэгцээ, шаардлагыг хангаж байгаа эсэх*

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд алба хаагчдаас авсан мэдээллийг нэгтгэвэл⁹⁵:

- Техник, багаж хэрэгслийн төрөл, хангамж тааруу гэж хэлнэ. Жишээлбэл, усны ослоос аврах ажиллагаанд, түүнчлэн алба хаагч гүний шумбалт хийгээд гарч ирэхэд цусны эргэлтийг хэвийн болгож, азотын хордлого тайлах ёстой. Үүнд тухайлбал барокамер буюу өндөр даралтат хүчилтөрөгчийн үйлчилгээний хэрэгсэл шаардагддаг. Гэтэл ийм хэрэгсэл байхгүй учир аврах ажиллагаанд хүндрэл бэрхшээл үүсэх алба хаагчийн эрүүл мэнд ихээр хохирох тохиолол гардаг. Туршлагатай эмч нарын “буян”-аар л гайгүй болдог ч онцгой алба ийм байж таарахгүй. Иймд онцгой албаны ажиллагаа, түүний дотор гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгсэлтэй холбоотой зохицуулалтыг нарийвчилж тусгах шаардлагатай;

- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэхэд ашиглах техник, багаж, хэрэгслийн төрөл, чанар, хангамжийг олон улсын жишигт хүргэж, техник, багаж хэрэгслийг ашиглах талаар алба хаагчдыг сургаж дадлагажуулах хөтөлбөртэй байх, жилд 1 удаа зохион байгуулах саналтай байна;

⁹⁵ ОБЕГ, түүний салбар, нэгжийн алба хаагч нартай хийсэн ярилцлага, асуумж, саналын мэдээллээс.

- Усны хувцас олон төрөлтэй, алба хаагч хүн тус бүрт төрөл бүрээс байх ёстой. Гэтэл энэ стандарт алдагдсанаас алба хаагчид дундаа 1 хувцас хэрэглэх, размер таарахгүй байх гэх мэт асуудал үүсдэг. Ингэснээр арьсны өвчин халдах, хулмастай болох гэх мэт асуудал тулгардаг. Иймд ажиллагааны хувцасны хангамжийг сайжруулах нэн шаардлагатай;

- Онцгой байдлын албанд техникч мэргэжлийн хүний нөөц чухал байдаг. Олон улсын стандарт бүхий техник, багаж хэрэгслийн хэрэгцээ, шаардлагыг тооцоолох, худалдан авах, суурилуулах, аюулгүй ажиллагааг бүрдүүлэх, хангах, ашиглах, хэрэглэх, алба хаагчдыг сургаж дадлагажуулах асуудал үүнд хамаарна. Жишээлбэл аврах багаж, хэрэгслийн тохиргоо маш чухал бөгөөд мэдлэг, ур чадвар их шаарддаг. Практикаар мэдлэг олж авсан туршлагатай хүмүүс энэ ажлыг “нугалж” явдаг байсан. Орчин үед техник технологи хөгжихийн хэрээр техникч зэрэг нарийн мэргэшсэн алба хаагчдын хэрэгцээ, шаардлага улам бүр өсөж байна зэрэг мэдээлэл болон санал өгсөн.

Нэгтгэн дүгнэвэл, гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгслийн төрөл, хангамж тааруу байна. Энэ нь төсөв, хөрөнгө шаардагдахын зэрэгцээ онцгой байдлын албаны мэргэжилтэн, алба хаагчдыг бэлтгэх, сургаж дадлагажуулах асуудлыг хамтад нь анхаарах чухал харилцаа болно. Үүнд энэ чиглэлийн мэргэжилтэй хүний нөөц бүрдүүлэх, сургах, сургалтад хамрагдсан хугацааг онцгой байдлын албанд ажилласан жилд тооцох, суралцах хугацааны цалин хангамжийг шийдвэрлэх гэх мэт асуудлыг цогцоор нь, зайлшгүй шийдвэрлэх шаардлага тулгамдаж байна.

Үнэлэх зохицуулалт

43 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдэг

43.1.Онцгой байдлын байгууллага нь туг, бэлгэ тэмдэгтэй байна.

43.2.Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдгийн загварыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

43.3.Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдгийг тус байгууллагаас бусад төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэн хэрэглэхийг хориглоно.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага бий эсэх

ГХТХ-ийн 43 дугаар зүйлд онцгой байдлын байгууллага туг, бэлгэ тэмдэг хэрэглэх харилцаа, туг, бэлгэ тэмдгийн загвар батлах эрх олгосон заалтыг тусгасан. Үүнээс 43 дугаар зүйлийн 43.1-д “Онцгой байдлын байгууллага нь туг, бэлгэ тэмдэгтэй байна.”, 43.3-т “Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдгийг

тус байгууллагаас бусад төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэн хэрэглэхийг хориглоно.” гэж заасан тус агентлаг өөрийн туг, бэлгэ тэмдэгтэй байх, туг, бэлгэ тэмдэг хэрэглэх харилцааг тусгасан байна. Монгол Улсын Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын 2005 оны гуравдугаар сарын 31-ний өдрийн 36 дугаар тушаалаар Онцгой байдлын байгууллагын Бэлгэ тэмдгийн тодорхойлолт, загвар, хэрэглэх журмыг баталж мөрдөж байна.

Агентлагийн тамга, тэмдэг, бэлгэдлийн талаар Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан бөгөөд тус 16 дугаар зүйлийн 16.4-т “Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийн бэлгэдлийн загвар, тодорхойлолт хэрэглэх журмыг агентлагийн дарга тогтооно” гэж заасан. Үүнийг үндэслэн ГХтХ-ийн 43.2-т “Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдгийн загварыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг “агентлагийн дарга батална” гэж өөрчлөх ⁹⁶ санал алба хаагчдаас гаргасныг шийдвэр гаргах түвшинд нягтлах нь зүйтэй.

Үнэлэх зохицуулалт

44 дүгээр зүйл. Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэг
44.1. Онцгой байдлын байгууллага нь дараахь үндсэн чиг үүрэгтэй:
44.1.1 гамшгаас урьдчилан сэргийлэх;
44.1.2 гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах;
44.1.3. гамшгийн хор уршгийг арилгах;
44.1.4. хойшлуулшгүй сэргээн босгох;
44.1.5. улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүргийг ГХтХ-д оновчтой тодорхойлсон эсэх

ГХтХ-ийн 44 дүгээр зүйлд ОББ-ын чиг үүргийг тодорхойлохдоо гамшгаас урьдчилан сэргийлэх; гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах; гамшгийн хор уршгийг арилгах; хойшлуулшгүй сэргээн босгох; улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах чиг үүрэгтэй гэж заасан. Мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүрэгтэй гэж тусгасан. Үүнд:

29.1.1. гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлого, Засгийн газрын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах, хяналт тавих;
29.1.2. Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;
29.1.3. өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх удирдамжийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх;
29.1.4. орон нутгийн онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих;

⁹⁶ Үндэсний аврах бригадийн санал

29.1.5.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон болон аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, эсхүл шууд мэдээлэх, заавар, зөвлөмжөөр хангах;

29.1.6.шаардлагатай мэдээлэл, судалгааг гаргаж, гамшгийн цагийн байдлыг нэгтгэн дүгнэж онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах;

29.1.7.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хүч хэрэгслийг дайчлан оролцуулах;

29.1.8.гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэхэд гарсан зардал, нөхөн төлбөрийн талаар санал боловсруулан хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэх;

29.1.9.Засгийн газраас олгосон бараа, материал, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

29.1.10.гамшгаас хамгаалах алба, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх;

29.1.11.гамшгийн нөөц бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, нөхөн сэлбэх;

29.1.12.гамшгийн судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах, ашиглах;⁹⁷

29.1.13.гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, заавар, стандарт боловсруулах;

29.1.14.гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

29.1.15.гамшгаас хамгаалах талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

29.1.16.гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж нэгтгэн, боловсронгуй болгох саналыг эрх бүхий байгууллагад танилцуулах;

29.1.17.гамшгаас хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын болон дотоодын байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;⁹⁸

29.1.18.олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох багийг бүрдүүлж, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

29.1.19.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүн амыг сургах, бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Тэгвэл ГХтХ-ийн 44 дүгээр зүйлээр тодорхойлсон “Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэг” болон тус хуулийн 29 дүгээр зүйлд тусгасан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг” гэсэн зохицуулалтыг оновчтой томьёолж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.1-д заасан хуулийн төслийн бүтэц, 28.2-т заасан хуулийн төслийн бүтцэд тавигдах шаардлага, 28.3-т заасан хуулийн төслийн бүтцийн дарааллыг баримталж боловсронгуй болгох шаардлагатай. Түүнчлэн онцгой байдлын байгууллагын чиг үүрэг болон чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бүрэн эрхийг ялгамжтай, оновчтой тодорхойлж хуульчлах нь зүйтэй.

Гамшгаас хамгаалах бодлого, олон улсын чиг хандлага улс орнуудыг нэгдмэл байр суурьтай болгодог ч онцгой байдлын байгууллагын статус, чиг үүргийг улс орнууд харилцан адилгүй тодорхойлж байна.

ГХтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд

⁹⁷ Энэ заалтад 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан.

⁹⁸ Энэ заалтад 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан.

өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна” гэж хуульчилсан. Энэ нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, ОББ болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах тухай ГХтХ-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хэм хэмжээ мөн.

Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн зорилтын хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулахад олон талын түншлэлийг өргөжүүлэхээр заасныг баримтлан, одоогийн хуульд тусгасан онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ бусад талын оролцоог хангах ажлыг зохион байгуулах чиг үүргийг нэмж тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүргийн талаар алба хаагч, удирдах албан тушаалтнуудтай хийсэн ярилцлага болон бичгээр өгсөн мэдээлэл, саналыг нэгтгэвэл⁹⁹¹⁰⁰:

- Гурван байгууллагыг нийлүүлж ОБЕГ-ыг байгуулсан нь олон улсын чиг хандлагад нийцүүлсэн зөв алхам байсан. Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүргийг хуульд зөв тодорхойлсон, ГХтХ-ийн зорилтод нийцэж байна. Гэхдээ гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд бусад төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог бүрдүүлэхтэй холбоотой чиг үүргийг нэмж тусгах хэрэгтэй;

- ГХтХ-д заасан онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн хүрээнд нэмж тусгах шаардлагатай чиг үүргийн тухайд “Барилга байгууламжийн байршлыг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж мэргэжлийн дүгнэлт гаргах”, “Барилга байгууламжийг ашиглалтад авах улсын комиссын бүрэлдэхүүнд оролцох, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд санал, дүгнэлт гаргах”, “Барилга байгууламжийн зураг төсөлд гамшиг ослоос хамгаалагдсан эсэхэд гаргасан дүгнэлт болон магадлалд хяналт хийж шийдвэр гаргах,” чиг үүргийг нэмж тусгах шаардлагатай;

- ОББ нь гамшигтай тэмцэх тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмжийн нөөцтэй байх, холбоотой харилцааг тус хуулийн 29 дүгээр зүйл, эсвэл 30 дугаар зүйлд нэмж тусгах хэрэгтэй;

- Мэргэжлийн байгууллагын хувиар талуудын оролцоог зохион байгуулах, гамшгийн өмнөх үеийн ажиллагаа, гамшгаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг хувийн хэвшил, ТББ, иргэдтэй хамтран хэрэгжүүлэх, гэрээгээр гүйцэтгүүлэх, хамтын ажиллагааг зохицуулан холбох чиг үүргийг хуульд тусгах нь зүйтэй;

- Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын нэг чиглэл болох мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиг үүргийг энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд шилжүүлэх, гэрээгээр гүйцэтгүүлэх гэх мэт хувилбар тохиромжтой;

⁹⁹ ОБЕГ-ын алба хаагчтай 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр хийсэн ярилцлага болон асуумжийн дагуу бичгээр өгсөн саналаас

¹⁰⁰ ГХтХ-ийг боловсронгуй болгох чиглэлээр Онцгой байдлын байгууллагын салбар нэгжүүдээс ирүүлсэн саналаас, 2025 он.

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэдийн сайн дурын оролцоог хангах замаар онцгой байдлын байгууллагын сургалтын төв, сургагч багш нарт сургалтын ажлыг даалгах боломжтой. Гэхдээ бодит оролцоог бүрдүүлэх хэрэгтэй, эс бөгөөс гамшгаас хамгаалах ажиллагаа, онцгой байдлын албаны ажилд оролцдог нэрийдлээр олон улсын байгууллагаас төсөл хөтөлбөр олж авах сонирхлын улмаас хэлбэр төдий болгох явдлаас бас сэргийлэх нь зүйтэй;

- Гамшгаас урьдчилан сэргийлэх, тухайлбал эргүүл хийх ажилд иргэд, албанаас тэтгэвэрт гарсан хүмүүс сайн дураар оролцох, оролцоог үнэлэх, урамшуулах механизмыг бүрдүүлэх бололцоотой. Учир нь цалин хөлснөөс бус ажлын ачааллаас болж албанаас гарах хандлага их байдаг талаар дурдвал, алба хаагчийг 24 цагаар жижүүрт гарсны дараа, хүний нөөцийн орон тоо дутуугийн улмаас амраахгүйгээр урьдчилан сэргийлэх ажиллагаа, арга хэмжээнд явуулах тохиолдол элбэг гардаг; Ингэснээр алба хаагчийн эрүүл мэнд доройтох, гэр бүлдээ зориулах хугацаа хомстож зөрчил үүсэх зэрэг таагүй байдлын улмаас албанаас гарахаас өөр аргагүй байдалд ордог талаар жишээ татсан байна.

Дээр дурдсан зарчмын шинжтэй ерөнхий саналууд, онцгой байдлын байгууллагын салбар, нэгжийн алба хаагчдаас бичмэл хэлбэрээр болон ярилцлагын аргаар цуглуулж нэгтгэсэн саналууд нь ГХТХ-д заасан онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтыг сайжруулах, эсвэл хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх мэдээлэл болно.

3.7.2.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал

Судалгааны тайлангийн энэ хэсэгт ГХТХ-ийн 45-50 дугаар зүйлд заасан зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг судалж, үнэлгээ хийе.

Үнэлэх зохицуулалт
45 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагч
45.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчаар Төрийн албаны тухай болон Цэргийн албаны тухай хуульд заасан шаардлага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, боловсролын болон ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан иргэнийг авч ажиллуулна.
45.2. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна.
45.3. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хязгаарлалт нэгэн адил хамаарна.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчаар ажиллах иргэнийг сонгон шалгаруулах, томилох харилцаа, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хэрэгжилтэд тулгамдсан асуудал бий эсэх

Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараахь албан тушаал хамаарна: “ гэж заасан бөгөөд 13.1.4-т “зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, гадаадын иргэн, харьяат, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүх шинжилгээний байгууллагын удирдлага;” гэж, 13.1.6-д “зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон шүүх шинжилгээний байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүх шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн, гадаадын иргэн, харьяатын байгууллагын ажилтан;” гэж тухайлан заасан.

Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтаар “цэргийн алба” гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг ойлгоно” гэж тодорхойлсон. Цэргийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд цэргийн албыг цэргийн жинхэнэ алба, цэргийн бэлтгэл алба гэж ойлгохоор заасан.

Цэргийн алба хаагч төрийн тусгай албаны онцлог төрөл болох цэргийн албаны хатуу сахилга бат, бусдаас ялгагдах эрхийн хязгаарлалт эдэлдэг. Эдгээр нь цэргийн алба хаагч буюу онцгой байдлын алба хаагчийг тодорхойлох шинж, алба хаагчид тавигдах шаардлагыг мөн агуулна.

Шадар сайдын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 67 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Онцгой байдлын байгууллагад алба хаах журам” хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Тус журмын зорилго нь онцгой байдлын байгууллагад алба хаахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах бөгөөд түүний дотор алба хаагчийг сонгон шалгаруулах, сургах, мэргэшүүлэх, томилох, дэвшүүлэх зэрэг үйл ажиллагаа багтах бөгөөд эдгээр үйл ажиллагаанд хууль дээдлэх, шударга, ёс зүйтэй, ил тод, нээлттэй, авлигаас ангид байх зарчмыг баримтална гэж заасан.

Дотоод хэргийн их сургууль, түүний харьяа Онцгой байдлын албаны сургууль нь онцгой байдлын байгууллагад ажиллах мэргэжлийн офицер, алба хаагчдыг бэлтгэдэг мэргэжлийн сургалтын байгууллага юм. Сургуулийн зорилго нь онцгой байдлын албанд ажиллах, эрсдэл, аюулыг бууруулах, аврах, гал унтраах, гамшгийн үеийн удирдлага, хариу арга хэмжээ авах чадвартай, мэргэшсэн офицер, мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Элсэлтийн ерөнхий шаардлагын хувьд, ерөнхий боловсролын сургууль төгссөн байх (12-р анги), ЭЕШ (Монгол хэл, математик, физик эсвэл хими зэрэг шалгалт) өгч босго болон түүнээс дээш оноо авсан байх, насны хувьд ерөнхийдөө 18–25 насны иргэд (цэргийн алба хаасан бол насны босго өөр байж болно) байх бөгөөд эрүүл мэнд (бие бялдар, сэтгэл зүй, хараа, сонсгол)-ийн үзлэг, бие бялдын сорил (Спортын норматив /гүйлт, суниалт, сууж босолт/ гэх мэт) өгнө.

Тусгай шалгалтын хувьд зарим тохиолдолд сэтгэл зүйн болон ярилцлагын шалгалт авна.

Суралцах мэргэжлийн чиглэлийн тухайд Онцгой байдлын тактик, командлал; Аврах ажиллагаа ба гамшгийн удирдлага; Гал түймэртэй тэмцэх инженер; Гамшгийн үеийн сэргийлэлт, хариу арга хэмжээ; Химийн, биологийн, цацраг идэвхт бодисоос хамгаалах зэрэг чиглэл багтсан. Сургалтын онцлогийн хувьд цэргийн зохион байгуулалттай (эрэмбэ, дүрэм сахих); хээрийн бэлтгэл, практик дадлага ихтэй, сургалтын хугацаанд дотуур байранд амьдарч, дүрэмт хувцастай явах; Амжилттай төгссөн тохиолдолд ахлагч эсвэл дэслэгч цол олгож, Онцгой байдлын байгууллагад шууд ажиллах боломжтой.

Ийнхүү ДХИС-ийн баталсан журам, хөтөлбөрийн дагуу оюутан элсүүлж, сургалтын үйл ажиллагааны үр дүнд мэргэжилтэн бэлтгэж байна. Төгсөгчдөөс онцгой байдлын албанд ажилд авах, томилох бөгөөд мөн зар байршуулж ажилд авдаг. Мөн хууль зүйн болон бусад мэргэжилтэн бэлтгэх гадаад, дотоодын сургуулиуд онцгой байдлын албаны хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж байна.

Онцгой байдлын байгууллагад алба хаах журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Тус журамд зааснаар:

- Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн болон сургалтын бодлогыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлно;

- Хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэх, боловсрол, мэргэжлийн чадвартай, мэргэшсэн алба хаагчдыг сонгож бэлтгэхэд Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн болон сургалтын бодлогын үндсэн зорилго оршино;

- Онцгой байдлын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд албан хаагчийн мэдлэг, чадварыг бүрэн дайчлах, алба хаагчдын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад хүний нөөцийн бодлого чиглэгдэнэ;

- Онцгой байдлын байгууллагын төрийн тусгай албан тушаалын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын ангилал, зэрэглэл, цолны зэрэглэлийг Цэргийн албаны тухай хуулийн 26.6-д заасны дагуу онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална;

- Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний албан хаагчид албан тушаалын тодорхойлолт буюу ажил үүргийн хуваарийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулах бөгөөд төрийн тусгай албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж ажиллана.

Онцгой байдлын алба хаагчийг сонгон шалгаруулж ажилд авах, томилох харилцаа, түүнд тулгамдаж буй асуудлын талаар ОБЕГ-ын албан тушаалтантай хийсэн ярилцлагын дүнг нэгтгэвэл:

- Алба хаагчийг сонгон шалгаруулах, сургах, мэргэшүүлэх, томилох, дэвшүүлэх зэрэг харилцааг Онцгой байдлын алба хаах журмын дагуу зохицуулж, тухайн журам болон бусад холбогдох журам, стандарт шаардлагыг боловсронгуй болгох, зарим хэм хэмжээг өөрчлөх (жишээ нь шивээстэй хүнийг ажилд авахыг хориглодог байсныг өөрчилсөн.) зэргээр орчин цагийн нөхцөл байдлыг харгалзан уян хатан бодлого, шийдвэр гарган ажиллаж байна;

- ДХИС-д элсэн суралцах журмаар гамшиг судлалын мэргэжилтэн, алба хаагчдыг бэлтгэж байгаа бөгөөд төгсөгчдийг ажилд авч, томилж хүний нөөцөө бүрдүүлдэг;

- Боловсрол, биеийн эрүүл мэндийн шаардлагаас гадна ёс зүйн шаардлага буюу Төрийн албаны тухай хуульд заасан зарчим, хэм хэмжээнд нийцэх шаардлага болон гэмт хэрэгт холбогдоогүй байх шаардлага тавигддаг;

- 1990 оны үеэс “цонхны үе” гэж нэрлэгддэг зүй тогтол онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн харилцаанд мөн нөлөөлж байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг харгалзан хүний нөөц бэлтгэх, ажилд орох хүсэлтийн дагуу ажилтан авах, ажлын байрны нээлттэй зар түгээх байдлаар хүний нөөц бүрдүүлэн ажиллаж байна;

- Төгсөгчид гадагшаа явах, уурхайд өндөр цалинтай ажил эрхлэх зэрэг сонголт хийдэг. ОББ-д ажиллаж байсан туршлагатай гэсэн үндэслэлээр томоохон компаниуд ажилд авах сонирхол их байгаа тул тус албанд нэг жил орчим хугацаанд ажиллаад гарч өөр ажилд орох хандлага их ажиглагддаг. Ялангуяа уул уурхайн үйлдвэрлэл хөгжсөн бүсэд хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөн нэлээд гарч байна.

- Урьд өмнө нь цалин бага байна гэдэг байсан бол 2023 оноос хойш цалин, урамшуулал гайгүй болсон. Гэсэн ч хүний нөөц хангалтгүй, ажлын ачаалал их, чиг үүргийн онцлог, хөдөлмөрийн хүнд, хортой нөхцлөөс хамаарч онцгой байдлын албанаас гарч өөр салбарт шилжих байдал элбэг. Мөн 36 сарын тэтгэмжийг зогсоох тухай гэх мэт бодлогын өөрчлөлт, улс төрийн үйл ажиллагаатай холбоотой албан бус, баталгаагүй, тэнцвэргүй мэдээллийн улмаас тэтгэвэрт олноор гарах үзэгдэл хүний нөөцийн тогтворгүй байдлыг мөн үүсгэдэг бэрхшээл бий.

- Онцгой байдлын алба хаагчийн суралцах эрх, алба хаагч бэлтгэх, чадавхжуулах асуудал чухал боловч практикт нийцэхгүй эрх зүйн зохицуулалт саад болж байна. /Энэ талаар судалгааны тайлангийн холбогдох хэсэгт дэлгэрэнгүй тусгасан./

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг оновчтой, бүрэн тусгасан эсэх

Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлохын тулд “онцгой байдлын алба”, “онцгой байдлын алба хаагч”, онцгой

байдлын албаны үйл ажиллагаа, удирдлагын зарчмыг оновчтой тодорхойлж, ГХтХ-д тусгах шаардлагатай.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д зааснаар цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал нь бүх төрлийн хангамж нь албан үүргээ гүйцэтгэхэд нийцсэн байх; албаны үүргээ гүйцэтгэх үеийн халдашгүй байдал хамгаалагдсан байх; захирах, захирагдах; улс төрийн үйл ажиллагаанаас ангид байх зарчимд тулгуурлана хэмээн заасан. Онцгой байдлын алба хаагчийн эрх зүйн байдал нь эдгээр зарчимд тулгуурлаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийе.

ГХтХ-ийн 45 дугаар зүйлийн 2-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна.” гэж заасан. Үүнд заасан хууль тогтоомж нь цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон бөгөөд энэ нь онцгой байдлын байгууллага нь төрийн цэргийн байгууллагад хамаардагтай холбоотой.

Үүнээс гадна онцгой байдлын байгууллага нь төрийн байгууллага, алба хаагч нь төрийн тусгай албан хаагч учир Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Иймд ГХтХ-ийн 45 дугаар зүйлийн 2-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна.” гэж заасан хэсэгт Төрийн албаны тухай хуулийг нэмж тусгавал зохино. Учир нь төрийн албаны бодлого, үзэл баримтлалын хувьд нийт төрийн алба хаагчдад нэгдмэл стандарт, үнэт зүйлийг аль болох голчлох чиг хандлагыг дагаж байна. Төрийн албаны тухай хуульд төрийн албаны нийтлэг зарчим, төрийн албан хаагчийн нийтлэг эрх, үүрэг, үндсэн ба нэмэгдэл баталгаа гэх мэт эрх зүйн зохицуулалтууд тусгагдсан.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. *Онцгой байдлын байгууллагын алба хаагчид Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хязгаарлалт нэгэн адил хамаарах нь оновчтой эсэх*

ЦАХЭЗБтХ-ийн 8 дугаар зүйлд заасны дагуу цэргийн алба хаагч улс төрийн нам, эвсэл, холбооны гишүүн байх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох; цэргийн нэгтгэл, анги, байгууллагад улс төрийн үйл ажиллагаа зохион байгуулах; төрийн бодлого, хууль тогтоомж, захирагч, даргын тушаалыг эсэргүүцэх, биелүүлэхээс татгалзах; захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох; хугацаат цэргийн алба хаагч цэргийн анги, байгууллагын зохион байгуулснаас бусад сургууль, дамжаанд суралцах; захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр гадаад улсад зорчих; хуулийн дагуу нууцын зэрэгт хамаарах баримт бичиг, зэвсэг, техник хэрэгсэлтэй ажиллаж байсан цэргийн алба хаагч цэргийн албанаас бэлтгэлээр халагдсаны дараа гурван жилийн дотор гадаад улсад байнга оршин суухаар явах; цэргийн анги, байгууллагад шашин сурталчлах; албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон цэргийн дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх; мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодис хэрэглэх, хууль тогтоомжид заасан ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд

аливаа дарамт, шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхах үйл ажиллагааг хориглоно. ГХтХ-ийн 45.3-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хязгаарлалт нэгэн адил хамаарна.” гэж заасны дагуу дээр дурдсан хэм хэмжээг онцгой байдлын байгууллагын алба хаагч мөн сахиж мөрдөнө.

Алба хаагчдаас авсан асуумжид дээрх зохицуулалтын дагуу хязгаарлалтыг дагаж мөрдөхөд хүндрэл бэрхшээл байхгүй гэсэн мэдээлэл өгсөн.

Үнэлэх зохицуулалт
45.4.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын албан тушаалд онцгой байдлын албанд 15-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг томилно.

“Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын албан тушаалд тавигдах шаардлагыг ойлгомжтой тусгасан эсэх

ГХтХ-ийн 45.4-т “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын албан тушаалд онцгой байдлын албанд 15-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг томилно.” гэж заасан. Хэл, найруулга зүйн үүднээс авч үзвэл Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын албан тушаалд онцгой байдлын албанд 15-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 10-аас доошгүй жил, нийтдээ 25 жил ажилласан байх, эсвэл дурдсан хоёр шалгуурын аль нэгийг хангасан байх; онцгой байдлын албанд 15-аас доошгүй жил ажиллаж, үүнээс 10-аас доошгүй жил нь удирдах албан тушаалд ажилласан байх буюу тус албанд нийтдээ 15-аас доошгүй жил ажилласан байх; түүнчлэн удирдах албан тушаалд 10-аас доошгүй жил гэдэг нь аль ч салбарын удирдах албан тушаалд ажилласан байж болох гэх мэт салаа утгыг агуулсан байна. Иймд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын албан тушаалд томилогдох алба хаагчид тавигдах шалгуурыг боловсронгуй болгож ГХтХ-ийн 45 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг оновчтой томьёолох шаардлагатай.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бусад удирдлагад тавигдах шаардлагыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага бий эсэх

ГХтХ-д онцгой байдлын төрийн захиргааны байгууллагын даргад тавигдах шалгуурыг заасан ч тус байгууллагын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргаар томилоход тавигдах шаардлагыг тодорхойлоогүй байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 20.1-д “Цагдаагийн төв байгууллагын даргаар цагдаагийн албанд 20-оос доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй,

удирдах болон мэргэжлийн ажлын дадлага туршлагатай, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй Монгол Улсын иргэнийг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.” гэж заасан. Мөн хуулийн 20.3-т “Цагдаагийн төв байгууллага тэргүүн дэд дарга болон хоёр дэд даргатай байна.” гэж, тус хуулийн 20.4-т “Энэ хуулийн 20.3-т заасан тэргүүн дэд дарга, дэд даргаар цагдаагийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй, нийтийн хэв журам хамгаалах, гүйцэтгэх болон мөрдөн байцаах ажлын дадлага туршлагатай, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй Монгол Улсын иргэнийг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.” гэж заасан.

Иймд ЦАТХ-д заасны адил, онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргыг томилоход тавигдах шаардлагыг ГХТХ-д тусгах нь зүйтэй. Ингэснээр ГХТХ-ийн 42.1-д “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн”, 42.2-т “Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.” гэж тус тус заасан зохицуулалтын хэрэгжилтийг хангах, тус албанд шатлан дэвших зарчим баримтлах, энэ нь эргээд онцгой байдлын албаны чадавхийг дээшлүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад хувь нэмэр оруулна.

Үнэлэх зохицуулалт
45.5.Төрийн болон албаны нууцад хамаарах бараа, материалыг бүртгэх, хадгалах, хамгаалах асуудал эрхэлж байгаа ажилтан нь энэ хуульд заасан алба хаагчийн нэгэн адил эрх, үүрэг хүлээж эрх зүйн баталгаагаар хангагдана.

“Практикт нийцсэн байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. *Төрийн болон албаны нууцад хамаарах бараа, материалыг бүртгэх, хадгалах, хамгаалах асуудал эрхэлж байгаа ажилтны эрх зүйн байдлыг тухайлан тусгах хэрэгцээ, шаардлага бий эсэх*

ГХТХ-ийн 45 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Төрийн болон албаны нууцад хамаарах бараа, материалыг бүртгэх, хадгалах, хамгаалах асуудал эрхэлж байгаа ажилтан нь энэ хуульд заасан алба хаагчийн нэгэн адил эрх, үүрэг хүлээж эрх зүйн баталгаагаар хангагдана.” гэж заасан. Хэл, найруулга зүйн үүднээс авч үзвэл “төрийн болон албаны нууцад хамаарах бараа, материал бүртгэх, хадгалах, хамгаалах асуудал эрхэлж байгаа ажилтан” гэж заасан нь тухайн ажилтан аль ч салбарынх байж болох утгыг агуулах бөгөөд энэ хуульд заасан алба хаагчийн

нэгэн адил эрх, үүрэг хүлээж эрх зүйн баталгаагаар хангагдахаар хэт өргөн ойлголтыг агуулсан байна.

Үүнийг практикт, улсын нөөцийн анги, салбарт төрийн болон албаны нууцад хамаарах бараа, материалыг бүртгэх, хадгалах, хамгаалах асуудал эрхэлж байгаа ажилтан гэж ойлгох бөгөөд өмнө нь төрийн тусгай алба хаагч бус “энгийн иргэн” тухайн ажлыг эрхэлдэг/гэрээ байгуулж/ байсантай холбоотой зохицуулалт юм. Одоо улсын нөөцийн анги, салбарын алба хаагч төрийн тусгай алба хаагч болсон тул ГХтХ-ийн 45 дугаар зүйлийн 5-д заасан хэм хэмжээ ач холбогдолгүй болсныг харгалзан хуулиас хасах нь зүйтэй. ¹⁰¹

Үнэлэх зохицуулалт
46 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцас, цол, таних тэмдэг
46.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.

Практикт нийцсэн байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцас хэрэглэхтэй холбоотой зохицуулалтын хэрэгжилт, тулгамдсан асуудал бий эсэх

ГХтХ-ийн 46 дугаар зүйлийн 1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.” гэж заасан нь төрийн цэргийн байгууллагын шинж, статустай холбоотой зохицуулалт юм. Уг зохицуулалтад алба хаагчийн дүрэмт хувцас ба цэргийн цол хэрэглэх хоёр харилцааг тусгасан. Үүнийг задалж авч үзье.

ОББ-ын алба хаагчийн дүрэмт хувцас, бусад хувцасны тухайд

Онцгой байдлын байгууллагын алба хаагч албаны онцлогоос хамаарч дүрэмт хувцас хэрэглэхээс гадна албан үүрэг гүйцэтгэх ажиллагааны хувцас буюу тусгай зориулалтын хувцас хэрэглэдэг. ГХтХ-д заасан алба хаагчийн хувцастай холбоотой зохицуулалтыг авч үзье.

Хүснэгт 18. ГХтХ-ийн алба хаагчийн хувцастай холбоотой хэм хэмжээ

28.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 28.1.10.барилга байгууламж, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчлэн сайжруулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх.
30.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3-т заасан бүрэн эрхээс гадна доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

¹⁰¹ Энэхүү судалгааны ярилцлага, асуумж

30.1.9.барилга байгууламж, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хангамжийн талаархи бодлогыг боловсруулж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах, шийдвэрлүүлэх;

42.3.Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бүсийн төв, аймаг, нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, бүлэг, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, эрэлч нохойн алба, шуурхай удирдлага-зарлан мэдээллийн төв, ар тал, тээвэр-ложистик, бүтээн байгуулалт-барилга байгууламж, техник засвар, үйлчилгээ, дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн үйлдвэр, эмнэлэг-сувилал, судалгаа шинжилгээ, сургалт, туршилт үйлдвэрлэл, архив, спорт, соёл урлаг болон бусад нэгжтэй байна.

46 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцас, цол, таних тэмдэг

46.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.

46.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

48.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүргийг хүлээнэ:

48.1.3.хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

Тус хуулийн 42.3, 46.1, 46.3-т алба хаагчийн дүрэмт хувцасны талаар тусгаснаас 46.1, 46.3 дахь хэсэгт **дүрэмт** хувцас хэрэглэх болон холбогдох харилцааг зохицуулах эрх хэмжээний талаар заажээ. Харин тус хуулийн 28.1.10, 30.1.9, 48.1.3-т **тусгай зориулалтын** хувцасны талаар тусгасны дотор 28.1.10, 30.1.9 дэх заалт нь тусгай зориулалтын хувцас, хангамжтай холбоотой бодлого боловсруулах, шийдвэрлүүлэхтэй холбоотой удирдлагын бүрэн эрхийн тухай, харин 48.1.3-т онцгой байдлын байгууллагын алба хаагч нь хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах үүрэгтэй гэж тусгасан. Үүнээс үзвэл, онцгой байдлын алба хаагч тусгай зориулалтын хувцас хэрэглэх агуулга ГХТХ-д байхгүй буюу орхигдсон байна.

ОББ-ын алба хаагчийн дүрэмт хувцасны тухайд. “Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварыг батлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 81 дүгээр зарлигийн хавсралтаар баталсан “Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, онцгой байдлын байгууллага, тагнуулын байгууллага, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цэргийн алба хаагчийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварын нэр, код”¹⁰²-д заасны дагуу ОББ-ын алба хаагч дүрэмт хувцас өмсөнө. Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Цэргийн дүрэмт хувцас

¹⁰² [zarlig-2017-04-17-81.pdf](#)

өмсөх дүрэм батлах тухай” А/777 Дугаартай тушаал¹⁰³-аар цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрмийг тодорхойлсон.

ОББ-ын алба хаагч үүрэг гүйцэтгэх ажиллагааны хувцас буюу тусгай зориулалтын хувцасны тухайд. Нийт тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн хангалт 2024 оны байдлаар 45.8 хувьтай байна. Төрөл тус бүрээр авч үзвэл гал түймрээс хамгаалах хувцас хэрэглэлийн хангалт 80-90%, бусад төрлийн тусгай зориулалтын хувцас хэрэглэл /инженер сапёрын хувцас, шүхэрчний хувцас, цацраг, хими, биологийн хорт бодисоос хамгаалах хувцас г.м/-ийн хангалт 20-30% байна. Тухайн тусгай зориулалтын хувцас хэрэглэл /10 төрөл/-ийн MNS стандарт 2012 онд батлагдсан бөгөөд 2025 онд Стандарт, хэмжил зүйн газар, ШУТИС-ийн Хувцас судлалын төвтэй хамтарсан ажлын хэсэг /шинэчлэн батлуулах/ ажиллаж байна. Уг стандартыг шинэчлэн батлуулах ажил алба хаагчдаас хувцасны загвар, чанар байдал, үүрэг гүйцэтгэхэд тохиромжтой эсэх талаар судалгаа, олон улсын стандартын шаардлага зэрэгт тулгуурлан хийгдэж байна.¹⁰⁴ ОББ-ын алба хаагч үүрэг гүйцэтгэхдээ өмсөх тусгай зориулалтын хувцасны загвар, чанар байдлыг тухайлан анхаарч байгааг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 41 дүгээр тогтоол¹⁰⁵-ын 1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг хавсралт ёсоор баталсугай.”, 2-т “Энэ тогтоолд зааснаас бусад тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн нэр төрөл, эдэлгээний хугацааг алба хаагчдын гүйцэтгэх үүргийн онцлогтой уялдуулан шинэчлэн баталж мөрдүүлэхийг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд даалгасугай.” гэжээ. Үүнээс үзвэл тусгай зориулалтын хувцас хэрэглэх харилцааг журмаар зохицуулахаар, баталж мөрдүүлэх эрхийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд олгосон байна.

Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм батлах тухай” А/777 Дугаартай тушаалын 1.9-д “Цэргийн дүрэмт хувцаснаас бусад тусгай зориулалтын болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийг асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журам, зааврын дагуу өмсөж хэрэглэнэ.” гэж заажээ.

Иймд онцгой байдлын албаны онцгой, тусгай байдлыг харгалзан тухайн салбарын алба хаагч тусгай зориулалтын хувцас өмсөхтэй холбогдох харилцааг ГХтХ-д тусгах саналтай байна. Ингэхдээ ГХтХ-ийн 46 дугаар зүйл (Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцас, цол, таних тэмдэг), ГХтХ-ийн 46 дугаар зүйлийн 1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.” гэж заасны адил онцгой байдлын байгууллагын алба хаагч үүрэг гүйцэтгэх ажиллагаанд тусгай зориулалтын хувцас өмсөх харилцааг хуульчлан тусгах; эсхүл Онцгой байдлын алба хаагчийн хувцас /дүрэмт хувцас, тусгай зориулалтын

¹⁰³ [А. 777 Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм батлах тухай 88bba55c-9bad-42fa-b860-58e18fcd24be 1.pdf](#)

¹⁰⁴ ОББ-ын алба хаагчаас авсан асуумжийн мэдээлэл, 2025.4.29

¹⁰⁵ [ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦААГ БАТЛАХ ТУХАЙ](#)

хувцас/ ба цэргийн цолтой холбоотой хэм хэмжээг салгаж төрөлжүүлэн, тус тусдаа зүйл, хэсэг, заалт болгож хуульд тусгах зэрэг хувилбараас сонгох бололцоотой.

Тухайлбал ГХтХ-ийн 46.3-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.” гэж заасан нь цэргийн цол ба дүрэмт хувцас хэрэглэхтэй холбоотой 46 дугаар зүйлийн 1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.” гэж заасан хэсэгтэй холбогдож байгааг харгалзан боловсронгуй болгох саналтай байна.

Цэргийн цол хэрэглэх зохицуулалтын тухайд. 2005 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталж, “Гамшгаас хамгаалах байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагч нь ажил мэргэжлийн онцлогт тохирсон цол, ялгах тэмдэг бүхий дүрэмт хувцас хэрэглэнэ” гэсэн нэмэлт оруулсан. Үүнийг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн “Цол олгох журам батлах” тухай 51 дүгээр зарлиг батлагдаж цол хэрэглэх болсон түүхтэй. Энэ нь онцгой байдлын байгууллагыг төрийн цэргийн байгууллага болгож чадавхжуулахад томоохон дэвшил болсон.

Цэргийн цол хэрэглэхтэй холбоотой зохицуулалын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг тус тайлангийн ГХтХ-ийн 46.5 (“Онцгой байдлын байгууллагад цэргийн цолыг хэрэглэх, олгох, бууруулах, хураан авах, сэргээх харилцааг Цэргийн албаны тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу зохицуулна.”), 46.3 (Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.) дахь хэсгийн хэрэгжилтийг судалсан үр дүнгээс тус тус үзнэ үү.

Үнэлэх зохицуулалт
46.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд даргад цэргийн дээд цол олгож болно.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд даргад цэргийн дээд цол олгож болно гэсэн зохицуулалтын зорилгод хүрсэн түвшин

ГХтХ-ийн 42.6-т “Онцгой байдлын байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна.” гэж заасан. ГХтХ-ийн 46.2-т “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд даргад цэргийн дээд цол олгож болно.” гэж заасан.

Анх 2017 оны ГХтХ-ийн шинэчилсэн найруулгад Онцгой байдлын байгууллагын дарга, тэргүүн дэд дарга нь цэргийн дээд цолтой байх зохицуулалтыг тусгасан бол ГХтХ-д 2020 онд нэмэлт, өөрчлөлт оруулснаар дэд даргад мөн цэргийн дээд цол олгож болно гэсэн эрх олгосон. Цэргийн албаны тухай хуулийн 26 дугаар 1 дэх хэсэгт “Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч дээд офицерын цолыг олгоно.” гэж заасны дагуу тэдгээрт олгох цэргийн дээд цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч олгоно. Энэ нь онцгой байдлын байгууллагыг улс төрөөс ангид байлгах, тогтвортой байдлыг хангах зорилготой.¹⁰⁶

Үнэлэх зохицуулалт
46.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ОББ-ын алба хаагчийн дүрэмт хувцасны загвар, эдэлгээний хугацаа, хангалтын заавар практикт нийцэж байгаа эсэх

Судалгааны тайлангийн энэ хэсэгт ГХтХ-ийн 46.3-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.” гэж заасны дагуу холбогдох эрх зүйн актууд батлагдсан эсэх, хэрэгжилтийн хүрээнд тулгамдсан асуудал бий эсэхийг хөндөх болно. /Онцгой байдлын алба хаагчийн дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэх тухай заасан ГХтХ-ийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хэрэгжилт мөн үүнд хамаарна./

Цол олгох журмын тухайд. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 12 дугаар сарын 30 -ны өдрийн 136 дугаар зарлигийн хавсралтаар “Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журам”¹⁰⁷ –ыг баталсан. Энэ журмын зорилго нь цэргийн алба хаагчид цэргийн цол олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Уг журам батлан хамгаалах, төрийн цэргийн байгууллагууд, тагнуул, төрийн тусгай хамгаалалтын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад цэргийн цол олгоход хамаарах тул онцгой байдлын байгууллагын алба хаагчид цол олгох харилцаанд үйлчилнэ.

Тус журамд Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох үйл ажиллагаанд баримтлах зарчим, цэргийн цол олгох үндэслэл, баримтлах хугацаа, цол олгуулах санал гаргах, цол олгох, цол олгохгүй байдал болон тухайн журмын хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, журам зөрчвөл хүлээлгэх хариуцлага зэрэг харилцааг тусгасан байна.

¹⁰⁶ Хуулийн төслийн танилцуулгаас

¹⁰⁷ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960643016571>

Дээрх журамд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 12 сарын 18 өдрийн 142 дугаартай "Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журам"-д өөрчлөлт оруулах тухай зарлигаар дараах өөрчлөлт оруулсан. Үүнд:

- "Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журам"-ын 3.1.3 дахь заалтын "...48-аас 72 сарын хооронд" гэснийг "48 сар" гэж буюу ахмадаас-хошууч хүртэл цолыг 48 сар болгож, 3.1.4, 3.1.5 дахь заалтын "...60-аас 84 сарын хооронд" гэснийг "60 сар" гэж буюу хошуучаас-дэд хурандаа, дэд хурандаагаас-хурандаа хүртэл тус тус 60 сар гэж өөрчлөх;

- Журмын 1.6 дахь хэсгийг "Эрх бүхий албан тушаалтан цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг тогтоохдоо нийт офицерын албан тушаалд эзлэх хурандаа цолны зэрэглэлтэй албан тушаалын тоог 3 хувиас хэтрүүлэхгүй байх зарчмыг баримтална" гэж өөрчлөн найруулах;

- Журмын 3.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцохыг тусгасан байна.

Алба хаагчийн дүрэмт хувцасны загварын тухайд. "Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварыг батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 81 дүгээр зарлигийн хавсралтаар "Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, онцгой байдлын байгууллага, тагнуулын байгууллага, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цэргийн алба хаагчийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварын нэр, код"¹⁰⁸ батлагдаж мөрдөгдсөн. Үүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 141 дүгээр зарлигаар шинэчилж "Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загвар" баталсан.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 41 дүгээр тогтоол¹⁰⁹-ын хавсралт¹¹⁰-аар батлан мөрдөж байна. Тус тогтоолын 1-д "Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг хавсралт ёсоор баталсугай.", 2-т "Энэ тогтоолд зааснаас бусад тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн нэр төрөл, эдэлгээний хугацааг алба хаагчдын гүйцэтгэх үүргийн онцлогтой уялдуулан шинэчлэн баталж мөрдүүлэхийг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд даалгасугай." гэжээ. Үүнээс үзвэл тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн нэр төрөл, эдэлгээний хугацааг шинэчилж баталж мөрдүүлэхийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд даалгасан байна.

Алба хаагчийн дүрэмт хувцасны эдэлгээний хугацааны тухайд. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг ОБЕГ, ОБ-ын газар, хэлтсийн захиргааны албан хаагч ба анги, салбар, бүлгийн албан хаагч гэж хоёр ангилан, ялгамжтай тогтоосон байна. Мөрдэс, цолны тэмдгийг цол авах бүрт, таних тэмдэг (4-136), байгууллагын ялгах тэмдэг (4-138),

¹⁰⁸ [zarlig-2017-04-17-81.pdf](#)

¹⁰⁹ [Дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг батлах тухай](#)

¹¹⁰ [Эрх зүйн акт дэлгэрэнгүй](#)

монгол тэмдэг (4-140), цусны бүлэг тодорхойлсон тэмдэг (4-141), нэрийн тэмдгийг (4-142) хувцастай дагалдуулан тус тус олгоно гэж жич заажээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 141 дүгээр зарлигаар Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хувцас хэрэглэл шинэчлэгдэн батлагдсанаар холбогдох тогтоолыг мөн шинэчлэн батлуулах хэрэгцээ, шаардлага үүссэн. Эдэлгээний хугацааг батлуулахдаа шинээр нэмэгдсэн буюу шинэчлэн батлагдсан хувцас хэрэглэлийг төв, орон нутгийн анги байгууллагын алба хаагчдад олгож, тухайн хувцасны хийц, материалыг бодитоор туршин үзэж, алба хаагчдаас авсан судалгааны үндсэн дээр тодорхойлж батлуулах нь практикт нийцнэ.¹¹¹

Ар талын журам /хангалтын заавар/-ыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/392 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журмыг батлуулах ажлын хэсэг нь ОББ-ын ар тал, хангалтын асуудал хариуцсан газар, хэлтэс болон 2021 онд шинээр байгуулагдсан ар талын анги буюу 115 дугаар анги, 121 дүгээр ангийн хоорондох ажлын уялдаа холбоо, хариуцах ажил, газар, хэлтэс, анги, нэгж бүрийн эрх үүргийг нарийн тодорхойлж, ар тал, хангалтын асуудал хариуцах нэгж бүрээс хариуцах алба хаагчийг ажлын хэсэгт оруулж батлуулснаар практикт нийцсэн журам болсон¹¹² гэж үзэж байна.

Үнэлэх зохицуулалт
46.4.Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн таних тэмдгийн загвар, хэрэглэх журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”
46.5.Онцгой байдлын байгууллагад цэргийн цолыг хэрэглэх, олгох, бууруулах, хураан авах, сэргээх харилцааг Цэргийн албаны тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу зохицуулна.”

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллагад алба хаах журмын хэрэгжилт, тулгамдсан асуудал бий эсэх

Онцгой байдлын байгууллагад алба хаах журам нэлээд дэлгэрэнгүй агуулгатай, Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгосон, тэдгээрийн үзэл баримтлал, зарчим, хэм хэмжээнд нийцсэн, хууль зүйн техник, хууль тогтоомжийн төслийн бичвэрт тавигдах шаардлага, хэл зүй, найруулгын шаардлагыг хангасан баримт бичиг байна.

Харин тус журамд тусгасан зарим харилцаа, ялангуяа алба хаагчийн эрхийг хөндсөн, хориглолт, хязгаарлалт тавьсан хэм хэмжээг журмаар бус, ГХтХ-д тусгаж

¹¹¹ ОБЕГ-ын албан тушаалтантай хийсэн ярилцлагаас

¹¹² ОБЕГ-ын албан тушаалтантай хийсэн ярилцлагаас

зохицуулах нь зүйтэй. Уг журмын хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар судалгааны бусад хэсэгт дэлгэрүүлж үзсэн.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. *Хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн таних тэмдгийн загвар, хэрэглэх журам бий эсэх*

Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварыг батлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 81 дүгээр зарлигийн хавсралтаар баталсан “Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, онцгой байдлын байгууллага, тагнуулын байгууллага, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цэргийн алба хаагчийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварын нэр, код” -ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 141 дүгээр зарлигаар шинэчилж “Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загвар” баталсан.

Хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн таних тэмдгийн загвар, хэрэглэх журам бий эсэх талаар ОББ-ын мэргэжитнээс тодруулахад, офицер, ахлагчийн таних тэмдгийн загвар байх шаардлагагүй, цолны тэмдгээрээ ялгаатай байдаг тул заавал нэмэлт таних тэмдэгтэй байх шаардлагагүй байдлыг харгалзан уг хэм хэмжээг хасах санал гаргасан.

ГХтХ-ийн 46.5-д “Онцгой байдлын байгууллагад цэргийн цолыг хэрэглэх, олгох, бууруулах, хураан авах, сэргээх харилцааг Цэргийн албаны тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу зохицуулна.” гэж заасныг хэрэгжүүлж байна. Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл байхгүй бөгөөд цол хураан авах харилцаа тодорхой бус байгааг нягтлах нь зүйтэй.

Үнэлэх зохицуулалт
47 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх 47.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нийтлэг эрхээс гадна дараахь эрх эдэлнэ: 47.1.1. гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хоол, хүнс, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах; 47.1.2. гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор шаардлагатай объектод саадгүй нэвтрэх.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлийн томъёолол 1. *Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эдлэх эрхийг ГХтХ-д оновчтой тусгасан эсэх, зорилгод хүрсэн түвшин*

ГХтХ-ийн 47.1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагч энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нийтлэг эрхээс гадна ГХтХ-ийн 47.1.1-д

заасан “гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хоол, хүнс, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах”, мөн хуулийн 47.1.2-т заасан “гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор шаардлагатай объектод саадгүй нэвтрэх” эрхийг эдэлнэ гэж тусгасан.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-д заасны дагуу онцгой байдлын албан хаагч дараах нийтлэг эрхийг эдэлнэ. Үүнд:

- 5.1.1.байлдааны бэлэн байдал, хууль бус үйлдэл, хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн асуудлаар санал, хүсэлт, гомдлоо бүх шатны захирагч, дарга нарт амаар болон бичгээр тавьж, шийдвэрлүүлэх;

- 5.1.2.цэргийн алба хааж байгаагийн төлөө албан тушаалын ангиллын, алба хаасан хугацааны, цэргийн цолны мөнгөн хангамж эдлэх;

- 5.1.3.албаны үүргээ гүйцэтгэх үедээ цэргийн дүрэмт хувцас, техник, материал хэрэгсэл, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдах;

- 5.1.4.эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрснөөр цэргийн мэргэжлийн боловсрол олгох дипломын, бакалаврын, магистрын, докторын болон давтан, мэргэжил дээшлүүлэх сургалтад төрийн зардлаар суралцах;

- 5.1.5.мэргэжил, мэргэшил, ур чадвар, ёс зүйн болон дадлага туршлагаараа албан тушаал дэвшин томилогдох;

- 5.1.6.эрүүл мэндээ хамгаалуулах;

- 5.1.7.цэргийн алба хаах үүргээ гүйцэтгэх явцад өөрийн эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирлоо хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлэх эрх хамаарна.

Дүгнэвэл, онцгой байдлын алба хаагч нь ЦАХЭЗБТХ-д заасан нийтлэг 7 эрх, ГХТ-д заасан тухайлсан 2 эрх, нийтдээ 9 эрхийг эдлэхээр ГХТХ-д тусгажээ. Ийнхүү тусгасан нь оновчтой эсэх, албан үүргээ гүйцэтгэхэд нийцсэн эсэх, зөрчил бий эсэх асуудлаар алба хаагчдаас ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан. Нэгтгэн танилцуулбал:

- Цэргийн байгууллагын буюу онцгой байдлын байгууллагын алба хаагчийн хувьд эдлэх эрхийг нэгтгэж тусгасан нь оновчтой. Харин эдгээр эрхийг хангах, зөрчигдөөс урьдчилан сэргийлэх, зөрчихийг хориглох, зөрчигдсөн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг мөн хуульд тусгах нь зүйтэй. Ингэснээр алба хаагчийн эрх хангагдах нөхцөл бүрдэнэ.

- ЦАХЭЗБТХ-д заасан цэргийн алба хаагчийн нийтлэг эрхийн тухайд:

1/ Байлдааны бэлэн байдал, хууль бус үйлдэл, хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн асуудлаар санал, хүсэлт, гомдлоо бүх шатны захирагч, дарга нарт амаар болон бичгээр тавьж, шийдвэрлүүлэх; цэргийн алба хааж байгаагийн төлөө албан тушаалын ангиллын, алба хаасан хугацааны, цэргийн цолны мөнгөн хангамж эдлэх эрхийг хангах нөхцөл бүрдсэн;

2/ Албаны үүргээ гүйцэтгэх үедээ цэргийн дүрэмт хувцас, техник, материал хэрэгсэл, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдах эрхийн хэрэгжилт хангалтгүй байна.

Бүх төрлийн хангамж гэдэгт албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой хангамж орно. Тухайлбал тусгай зориулалтын хувцасны хангамж тааруу, жишээлбэл усны хувцас авах төсөв тааруу, тоо хэмжээ цөөн байдаг. Гэтэл усны хувцас хэрэглэх алба хаагчдын биеийн хэмжээнээс хувцасны хэд хэдэн размер авах шаардлагатай ч төсөв санхүүгийн хүндрэлээс болж хэрэгждэггүй.

Ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдах гэдэгт алба хаагчийн халдашгүй байдал хамгаалагдах асуудал орно. Тухайлбал “7.1-ний үймээн”-ий үеэр гал унтраахад оролцсон алба хаагч гэмтэж хохирсон. Гүйцэтгэх үеийн халдашгүй байдлыг хамгаалах асуудал яригдаж болно, гэтэл эрсдэлээс хамгаалагдана гэсэн ойлголт байхгүй нь тус албаны онцлог юм. Иймд онцгой байдлын алба хүнд, тусгай албанд тооцогддог. Нийгэм эмх замбараагүй үед, эсвэл гал гарсан үед цагдаагийн алба хаагч “коридор” нээж өгдөг. Гамшиг, ослын үеэр цагдаа хамгаалалт авдаг. Энэ бол цэргийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирсны илэрхийлэл юм.

Гамшгаас хамгаалах салбар, онцгой байдлын албанд иргэдийн төлөө нөөц бүрдүүлэх чиглэлд анхаарч тодорхой үр дүнд хүрээд байна. Харин алба хаагчийн төлөө нөөц бүрдүүлж чаддаггүй. Ялангуяа ОББ-ын алба хаагч нарын гамшгийн үед ашиглах нөөцтэй байх эрх, алба хаагчдад зориулсан нөөц, хангалтыг бүрдүүлэх үүргийг ГХТХ болон холбогдох журамд тусгаж баталгаажуулах саналтай байна. Алба хаагч нар ашиглах хангалттай нөөцтэй байвал үүргээ гүйцэтгэх нөхцөл хангагдана.

3/ Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хэрэгжилт хангалтгүй байна. /Энэ талаар *судалгааны тайлангийн ГХтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийг хэрэгжилтийн байдалд дэлгэрэнгүй тусгасан болно.*/

4/ Мэргэжил, мэргэшил, ур чадвар, ёс зүйн болон дадлага туршлагаараа албан тушаал дэвшин томилогдох эрх удирдах албан тушаалтныг томилох харилцаанд улс төрийн нөлөөллийн улмаас зөрчигдөх тохиолдол гардаг.

5/ Эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрснөөр цэргийн мэргэжлийн боловсрол олгох дипломын, бакалаврын, магистрын, докторын болон давтан, мэргэжил дээшлүүлэх сургалтад төрийн зардлаар суралцах эрхтэй гэж заасан ч онцгой байдлын алба хаагчийн хувьд энэ эрх бүрэн хангагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, онцгой байдлын албанд цэргийн мэргэжлээс гадна гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, онцгой байдлын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад мэргэжлийн боловсрол эзэмших, мэргэжлийн зэрэг ахиулах, мэргэжил дээшлүүлэх, үргэлжилсэн сургалтад төрийн зардлаар суралцах эрх хангагдахгүй байна.

ЦАХЭЗБТХ-д цэргийн мэргэжлийн сургуульд суралцах эрхийг тусгаснаар, төрийн зардлаар суралцах, цалин хангамж авах, ажилласан жилд тооцогдох зэрэг давуу талууд бий болж байгаа нь сайшаалтай. Харин онцгой байдлын алба хаагч

цэргийн мэргэжлээс өөр, бусад мэргэжлээр гамшгаас хамгаалах иргэний сургуульд, гамшгийн менежмент зэрэг үндсэн чиг үүрэг, холбоо, мэдээлэл, технологи, хиймэл оюун ухаан гэх мэт чиглэлээр суралцахад эрх зүйн орчин, дэмжлэг дутмаг хэвээр байгааг анхаарч эрх зүйн орчинг сайжруулах нь зүйтэй. /Энэ талаар судалгааны тайлангийн холбогдох хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно./

- ГХтХ-д тухайлан заасан хоёр эрхийн тухайд:

1/ Гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хоол, хүнс, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах эрхийн хэрэгжилт тааруу байна. Үүнтэй холбоотой алба хаагчдын зүгээс:

- Хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажлаар явахдаа албаны унаа, хоол, хүнсээр хангагдах. /Хяналт шалгалт болон албаны ажлаар явахдаа өөрийн машин техникээр явдаг. Энэ нь осол аваар гарах, ХАБЭА дүрэм зөрчигдөх эрсдэл бий болдог. /

- Албан хаагчид гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэлтэй байх хангамжийг бүрдүүлэх. /Энгийн камер, гэрэлтүүлэх хэрэгсэл, хүн тус бүрийн амьсгалын бие даасан төхөөрөмж г.м/

- Гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг аймаг, орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, онцгой комиссын нөөц хөрөнгөөс шийдвэрлэх.

- Аймаг орон нутгийн газар орон, цаг уурын онцлогт тохирсон байдлаар дийлэнх тохиолддог гамшиг ослын төрөл тус бүрээр хангалт хийх тал дээр анхаарч өгөхийг санал болгосон байна.

Дээр дурдсан асуудлууд төсөв, санхүүжилт, нөөцийн хүртээмжтэй холбоотой. /Энэ талаар судалгааны тайлангийн бусад хэсэгт дэлгэрэнгүй тусгасан./

2/ Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор шаардлагатай объектод саадгүй нэвтрэх эрхийн хэрэгжилт хангалттай бус байна. Гамшиг, осол болсон үед алба хаагчдыг дуртай оруулдаг бол гамшгаас урьдчилан сэргийлэх журмаар нэвтрэхэд хүндрэлтэй, иргэд, ялангуяа томоохон аж ахуйн нэгжүүд алба хаагчдыг оруулахгүй гэдэг. ГХтХ-д гамшгаас хамгаалах улсын байцаагчийн эрхийг хуульчлах, ингэхдээ нэвтрэх эрхийг тусгахаар зорьж байна.

Шалгуур үзүүлэлийн томьёолол 2. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эдлэх эрхийн хүрээг өргөжүүлэх шаардлагатай эсэх

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдаас ярилцлагын аргаар болон санал авах хүрээнд цуглуулсан мэдээллийг нэгтгэвэл, ГХтХ-ийн 47 дугаар зүйлд тусгасан онцгой байдлын алба хаагчийн эрхийн хүрээг өргөжүүлж:

- “Онцгой байдлын байгууллагын алба хаагч гамшиг ослын голомтын бүсэд ажиллахдаа гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох зорилгоор тэмдэглэл, илтгэх хуудас бичих, гар зураг үйлдэх, гэрэл зураг авах, дууны-дүрсний бичлэг хийх болон бусад шаардлагатай арга хэмжээ авах” эрхийг ГХтХ-ийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 3 дахь заалт болгож нэмэх;

- “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагч шаардлагатай тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламжийг өмчийн хэлбэр үл харгалзан, бүх шатны эрүүл мэндийн байгууллагаас дараалал харгалзахгүйгээр авах эрх”-ийг тухайлан нэмж тусгах¹¹³;

- “Эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрснөөр цэргийн мэргэжлийн боловсрол олгох дипломын, бакалаврын, магистрын, докторын болон давтан, мэргэжил дээшлүүлэх сургалтад төрийн зардлаар суралцах эрхтэй” гэж заасан зохицуулалтад онцгой байдлын албанд хамаарах мэргэжлийн боловсролыг нэмж тусгах;

- ГХтХ-д гамшгаас хамгаалах улсын байцаагч зэрэг алба хаагч гамшгаас хамгаалах албаны зорилгоор объектод саадгүй нэвтрэх эрхийг хуульчлах зэрэг санал дэвшүүлснийг дэмжих нь зүйтэй гэж үзэв.

Үнэлэх зохицуулалт
48 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүрэг 48.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүргийг хүлээнэ: 48.1.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, оролцох; 48.1.2.аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд сахих, байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх; 48.1.3.хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

“Практикт нийцсэн байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргийг ГХтХ-д оновчтой тусгасан эсэх, хэрэгжилтийн байдал

ГХтХ-ийн 48.1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүргийг хүлээнэ:

¹¹³ Үндэсний аврах бригадийн санал.

48.1.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, оролцох;

48.1.2.аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд сахих, байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх;

48.1.3.хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах.” гэж заасан.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан дараах нийтлэг үүргийг тодорхойлсон. Үүнд: 6.1.1.эх орон, төр, ард түмнээ хүндэтгэн дээдлэх; 6.1.2.өргөсөн тангарагтаа үнэнч байх; 6.1.3.Монгол Улсын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмийг чанд сахин биелүүлэх; 6.1.4.албан тушаалын үүргээ биелүүлэх; 6.1.5.захирах, захирагдах зарчмыг мөрдөх; 6.1.6.гадаад улсад үүрэг гүйцэтгэхдээ тухайн улсын болон олон улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөх; 6.1.7.цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих; 6.1.8.хариуцсан зэвсэг, цэргийн техникийг чадамгай эзэмшиж, хамгаалах; 6.1.9.төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг алба хаах хугацаандаа болон албанаас чөлөөлөгдсөний дараа задруулахгүй байх; 6.1.10.мэдлэг, мэргэшлийн түвшнээ ахиулж байх. 6.2.Захирагч, даргын гаргасан тушаал, шийдвэрийг цэргийн алба хаагч үг дуугүй биелүүлэх үүрэгтэй. 6.3.Захирагч, даргын тушаал, шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна.

Дүгнэвэл, онцгой байдлын алба хаагч дээр дурдсан ЦАХЭЗБТХ-д заасан нийтлэг үүргээс гадна ГХТ-д заасан тухайлсан 3 үүрэгтэй байхаар ГХТХ-д тусгажээ. Ийнхүү тусгасан нь оновчтой эсэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх практикт нийцсэн эсэх, зөрчил бий эсэх асуудлаар алба хаагчдаас ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан. Нэгтгэн танилцуулбал:

- Цэргийн байгууллагын буюу онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргийг нэгтгэж тусгасан нь оновчтой. Харин эдгээр үүргийг хэрэгжүүлж ажиллах нөхцөл, бололцоог бүрдүүлэх арга хэмжээг мөн хуульд тусгах нь зүйтэй. Ингэснээр алба хаагчийн үүргээ биелүүлэх, биелэгдэх байдал сайжирна.

- ЦАХЭЗБТХ-д заасан цэргийн алба хаагчийн нийтлэг үүргийн тухайд:

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан эх орон, төр, ард түмнээ хүндэтгэн дээдлэх; өргөсөн тангарагтаа үнэнч байх; Монгол Улсын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмийг чанд сахин биелүүлэх; албан тушаалын үүргээ биелүүлэх; захирах, захирагдах зарчмыг мөрдөх; гадаад улсад үүрэг гүйцэтгэхдээ тухайн улсын болон олон улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөх; цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих; хариуцсан зэвсэг, цэргийн техникийг чадамгай эзэмшиж, хамгаалах; төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг алба хаах хугацаандаа болон албанаас чөлөөлөгдсөний дараа задруулахгүй байх үүргийг хэрэгжүүлэх асуудал хувь алба хаагчаас шалтгаалах талтай. Харин мэдлэг, мэргэшлийн түвшнээ ахиулж байх үүрэгтэй гэснийг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл, тулгамдсан асуудал байна. Энэ талаар тус хуулийн 47 дугаар зүйлд заасан онцгой байдлын алба хаагчийн эрхийн хэрэгжилттэй холбоотой хэсэгт тусгасан болно.

Мөн ЦАХЭЗБТХ-ийн 6 дугаар зүйлийн 2-т “Захирагч, даргын гаргасан тушаал, шийдвэрийг цэргийн алба хаагч үг дуугүй биелүүлэх үүрэгтэй.”, 6 дугаар зүйлийн 3-т “Захирагч, даргын тушаал, шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна.” гэж заасантай нийцсэн, уялдаа холбоотой хэм хэмжээ ГХТХ-д нэлээд бий. Тухайлбал ГХТХ-ийн 48.2-т “Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр алба хаагчаар энэ хуулийн 44.1-д заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэж, 48.3-т “Энэ хуулийн 48.2-т заасан албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.” гэж заасан нь нэг талаас алба хаагч удирдах албан тушаалны тушаал шийдвэрийг дагах тухай ойлголт боловч нөгөө талаас чиг үүрэгт хамааралгүй ажил үүрэг гүйцэтгэхээс сэргийлж, албан тушаалтны хууль бус шийдвэрийг хязгаарлах үр нөлөөг давхар агуулсан байна.

- ГХТХ-д тухайлан заасан гурван үүргийн тухайд:

ГХТХ-ийн 48.1.1-д заасан гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, оролцох үүрэг; 48.1.2-т заасан аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд сахих, байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх үүрэг онцгой байдлын алба хаагчид хүлээлгэвэл зохих үүрэг бөгөөд хэрэгжүүлэхэд алба хаагчдыг сургаж бэлтгэх, чадваржуулах асуудал чухал юм.

Харин ГХТХ-ийн 48.1.3-т заасан хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах үүргийн хэрэгжилт нь бусдаас буюу гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагад оролцогч байгууллагууд болон онцгой байдлын байгууллагаас, төсөв санхүүгээс ихээхэн хамааралтай байна. Төсвийн дутагдалтай байдал нь ОББ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, онцгой байдлын байгууллагын алба хаагч эрхээ эдлэхэд саад, бэрхшээл үүсгэж байна. /Энэ талаар судалгааны тайлангийн холбогдох хэсэгт тусгасан./

Үнэлэх зохицуулалт
48.2. Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр алба хаагчаар энэ хуулийн 44.1-д заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.
48.3.Энэ хуулийн 48.2-т заасан албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Онцгой байдлын байгууллагын алба хаагч хуульд заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүрэг гүйцэтгэдэг эсэх, эерэг, сөрөг сөрөг нөлөө бий эсэх

ГХТХ-ийн 48.2-т “Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр алба хаагчаар энэ хуулийн 44.1-д заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэж, 48.3-т “Энэ хуулийн 48.2-т заасан албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.” гэж тус тус заасан. Энэ нь 2017 онд батлагдсан ГХТХ-д шинээр орсон бөгөөд алба хаагчаар

чиг үүргийн бус ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглосон, албан тушаалтан эрх мэдлээ ашиглаж дур зоргоор авирлахаас сэргийлсэн зохицуулалт юм.

Эдгээр хэм хэмжээний хэрэгжилт, үр нөлөөний талаар алба хаагчдаас авсан мэдээллийг нэгтгэвэл:

- Чиг үүрэгт хамааралгүй ажлаас татгалзах үндэслэл болсон, бас албан тушаалтнууд болгоомжлох болсон учир ач холбогдолтой, үр нөлөөтэй зохицуулалт юм.

- Хуульд заасан чиг үүрэгт хамааралгүй ажил нэлээд хийдэг. Жишээлбэл: Муур, нохой устгах, хүний цогцос гаргах/чиг үүргийн бус хүрээнд/, халиа түвшинтэй холбоотой ажил гүйцэтгэх, ажлын байрны тав тухыг хангах зорилгоор барилгын засвар, үйлчилгээ хийх, зарим тохиолдолд барилга барих ажил гүйцэтгэх гэх мэт.

- ОББ-ын төсөв хүртээмжгүй, төсвийн буруу тогтолцооноос хамаарч чиг үүрэгт хамааралгүй ажил хийхэд хүргэдэг. Орон нутгийн Засаг даргаас төсвийн хамааралтай байдаг учир ЗДТГ-ын хэлсэн ОББ-ын чиг үүрэгт хамааралгүй ажил гүйцэтгэх, оролцохоос аргагүй байдалд ордог. Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулж техник, технологи өгч дэмждэг. Үүнийг бодоод ажилд нь дайчлагдаж, уян хатан байхыг хичээдэг тал бий.

- тусгай чиг үүрэг, ажиллагаанд оролцуулах, дайчлах тохиолдол элбэг. Жишээлбэл, гэр бүлийн хүчирхийлэл, эхнэр нөхөр, иргэд хоорондын зодоон гэх мэт таарамжгүй харилцааны үед цагдаагийн алба хаагч тухайн айлын орон байранд нэвтрэх зорилгоор онцгой байдлын албанд дуудлага өгч, алба хаагчаар хаалга онгойлгуулдаг гэх мэт асуудал цөөнгүй гардаг.

- Онцгой байдлын анги, салбарууд гүйцэтгэж буй үүрэг, стратегийн ач холбогдлоос шалтгаалж, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлогоос хамаарах гэрээний харилцааг бий болгож, гэрээгээр үүрэг гүйцэтгэж болно.

Дээрх байдлаас дүгнэвэл, ГХтХ-ийн 48.2-т “Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр алба хаагчаар энэ хуулийн 44.1-д заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэж, 48.3-т “Энэ хуулийн 48.2-т заасан албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.” гэж тус тус заасан нь үр нөлөөтэй зохицуулалт болсон байна. Ялангуяа албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээнэ гэж заасан нь онцгой байдлын алба хаагчийн хуулиар хүлээсэн үүрэг, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх харилцаа төдийгүй алба хаагчийн эрх, алба хаагч үүргээ биелүүлэх баталгааг хангах тал дээр мөн дэвшил гаргасан гэж үнэллээ.

Харин дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх шатанд зөрчил, дутагдал байгааг анхаарах нь зүйтэй. Иймд онцгой байдлын байгууллагын алба хаагчаар хуульд заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглосон зохицуулалтын талаар алба хаагчдад эрх зүйн мэдлэг, зөвлөгөө, туслалцаа, дэмжлэг үзүүлэх зэрэг дотоод арга хэмжээг зохион байгуулж ажиллавал үр дүнтэй гэж үзэж байна.

Онцгой байдлын анги, салбарын гүйцэтгэж буй үүрэг, стратегийн ач холбогдлоос шалтгаалж аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдийн үйл

ажиллагааны онцлогоос хамааран гүйцэтгэх бусад үүргийн харилцаа, хамтын ажиллагааг тусгасан зохицуулалт хийх хэрэгцээ, шаардлагыг тандаж шийдвэрлэх нь зүйтэй.

Үнэлэх зохицуулалт
49. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох тэтгэвэр, тэтгэмж 49.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авна. 49.2.Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино. 49.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.

Гамшгаас хамгаалах алба хаагч өргөсөн тангарагтаа үнэнч зүтгэж, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх эрх зүйн баталгааг бий болгоход анхаарч ирсэн нь зүйн хэрэг билээ. Дээр дурдсан 3 хэсэгт тусгасан зохицуулалт тус бүрийн хэрэгжилт, тулгамдсан асуудал бий эсэхийг шинжилж үзье.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авах зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл бий эсэх

Онцгой байдлын байгууллага нь төрийн цэргийн байгууллагын хувьд онцгой байдлын байгууллагын алба хаагч хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд цэргийн байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдалд хамаарна. Түүний нэг нь тэтгэвэр, тэтгэмж авахтай холбоотой харилцаа юм. ГХтХ-ийн 49 дүгээр зүйлийн 1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авна.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 4.1.4-т “Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид ... эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааг дээшлүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн Батлан хамгаалах бодлого гэсэн хэсэгт “цэргийн албан хаагчдын эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулах” хэмээн тусгагдсаны дагуу 2016 онд цэргийн алба болон төрийн цэргийн байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн батлах үйл явц өрнөсөн.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай¹¹⁴, Цэргийн албаны тухай¹¹⁵, Монгол Улсын Хилийн тухай хууль 2016 онд, Дотоодын цэргийн тухай,

¹¹⁴ 2016.09.01-ний Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Төрийн мэдээлэл №36, 2016

¹¹⁵ 2016.09.01-ний Цэргийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл №36. 2016

Цагдаагийн албаны тухай, Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 онд тус тус шинэчлэн батлагджээ. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль¹¹⁶ 1994 оны 6 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан бөгөөд 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйлчилж эхэлснээс хойш олон удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.

Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч /энэ хуульд цаашид "цэргийн алба хаагч" гэх/ нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хууль зүйн үндэсний хүрээлэн 2021 онд "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ" сэдвээр бодлогын судалгаа хийж, цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн харилцаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага, зохицуулалтын хувилбарын талаар хөндсөн нь онцгой байдлын алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн харилцаанд мөн хамаарна.¹¹⁷ Тухайлбал дээрх судалгаанд хууль, эрх зүйн шинэтгэлийн улмаас цэргийн албан хаагч олноор тэтгэвэрт гарснаар хүний нөөц, төсөв санхүүжилт зэрэг харилцаанд сөргөөр нөлөөлж, хүндрэл, бэрхшээл үүсгэснийг дүгнэж, бодлогын шийдвэрийг ул суурьтай боловсруулж, урьдчилсан бэлтгэл хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн зөвлөмж өгсөн байна.¹¹⁸

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр нь 1/цэргийн жинхэнэ алба болон тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад алба хаасан тэтгэвэр /цаашид "цэргийн алба хаасны тэтгэвэр" гэх/; 2/ хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр; 3/тэжээгчээ алдсаны тэтгэвэр гэсэн төрөлтэй. Тус хуульд заасны дагуу эдгээр тэтгэврийг тогтоох, олгох ажлыг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэж байна.

Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэмж 1/ хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж; 2/ нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж; 3/ нэг удаагийн тэтгэмж; 4/ жирэмсний болон амаржсаны тэтгэмж гэсэн төрөлтэй.

Тус хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу цэргийн тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй албан хаагчийг тодорхойлохдоо зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ албаны

¹¹⁶ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль Төрийн мэдээлэл №8. 1994

¹¹⁷Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2021 он, <file:///D:/%D0%A1%D0%A3%D0%94%D0%90%D0%9B%D0%93%D0%90%D0%90%202025/Tailan%20tsergiin-alban-haagchiin-tetgever%20tetgemjiin%20tuhai%20huuli%202021.pdf>

¹¹⁸ Мөн тэнд, 12 дахь тал.

генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч; хилийн цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч; тагнуулын болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын генерал, офицер, ахлагч; цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, байлдагч; дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн; авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч; цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч; дотоодын цэргийн албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч гэж заасан.

Мөн тус хуулийн 6 дугаар зүйлд цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацааг тогтоосон. “Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.14-д онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно гэж заажээ. ГХТХ-ийг боловсронгуй болгох чиглэлээр алба хаагчдаас өгсөн саналын нэг нь “Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, онцгой байдлын алба хаагчаар ажиллах мэргэжлээр суралцсан, уул уурхайн аврах алба, улсын нөөцийн албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагын генерал, офицер, ахлагч, байлдагчаар төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцох” санал юм. Үүнийг хэрэгжүүлбэл онцгой байдлын алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн харилцаанд мөн эерэгээр нөлөөлнө.

Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацаа, цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тодорхойлох арга зэрэг асуудлыг мөн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нарийвчлан тусгасан. Үүнийг хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл гарсныг мөн онцгой байдлын байгууллага мөрдөж байна. Цэргийн албан хаагчийн тэтгэврийн харилцаанд тэтгэвэр өвлөгддөг байх зохицуулалтыг хуульчлан баталгаажуулах шаардлагатай гэсэн саналыг онцгой байдлын алба хаагч нар мөн дэмжиж байгаа¹¹⁹ төлөв ажиглагдсан.

Үнэлэх зохицуулалт
49.2.Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор

¹¹⁹ 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр ОББ-ын салбар нэгжийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас

нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчих зохицуулалтын хэрэгжилт, хэрэгцээ, шаардлага бий эсэх

ГХТХ-ийн 49 дүгээр зүйлийн 2-т “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино.” гэж заасан боловч хэрэгжээгүй зохицуулалт юм. Үүний шалтгаан нь нэг талаас төрийн байгууллагын эс үйлдэл, нөгөө талаас хуулийг алба хаагч, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ хангалтгүй байсантай холбож болох юм.

Уг зохицуулалтын хэрэгцээ, шаардлага бий гэж салбарын алба хаагчдын төлөөлөл үзэж байгаа бөгөөд хэрэгжүүлэх хувилбарын тухайд:

- Монгол Улсын Шадар сайд, Зам тээврийн сайдын хамтарсан тушаал батлах, эсхүл Онцгой байдлын ерөнхий газрын дарга Нийслэлийн нийтийн зам тээврийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулж хэрэгжилтийг хангах¹²⁰;

- “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино.” гэснийг “Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот доторх нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино” гэж өөрчилж хамрагдах алба хаагчдын хүрээг өргөжүүлэх¹²¹ санал тус тус дэвшүүлсэн байна.

Түүнчлэн энэхүү 49.2 дахь хэсгийг “Онцгой байдлын алба хаагчид олгох тэтгэвэр, тэтгэмж” гэсэн 49 дүгээр зүйлд бус, “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа” гэсэн 50 дугаар зүйлд хамааруулах нь зүйтэй гэж үзэв.

Үнэлэх зохицуулалт
49.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд тэтгэмж олгох зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсдэг эсэх

ГХТХ-ийн 49.3-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.” гэж заасан. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд нэг удаагийн тэтгэмж авах тохиолдлыг заасан. Үүнд:

¹²⁰

¹²¹ Алба хаагчдын санал/Баян-Өлгий аймэг/

1.Цэргийн алба хаагч нас барах, тэтгэвэрт гарах, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр болон цэргийн алба хаах нас хэтэрч чөлөөлөгдсөн тохиолдолд нэг удаагийн тэтгэмж олгоно.¹²²

2.Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.¹²³

3.Цэргийн алба хаагч энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан шалтгаанаар нас барсан бол тухайн цэргийн алба хаагчийн гэр бүлд 80 метр квадратаас доошгүй талбай бүхий орон сууцыг нэг удаа олгоно.¹²⁴

Иймд дээр дурдсан тохиолдлын хүрээнд онцгой байдлын байгууллагын алба хаагч нэг удаагийн тэтгэмж авах эрхтэй. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд нэг удаагийн тэтгэмжийн хэмжээний талаар заасантай мөн нийцэж байна.

Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд тэтгэмж олгох зохицуулалтыг хэрэгжүүлэхэд төсөв санхүүгийн хүндрэл, бэрхшээл гэхээсээ илүүтэй тухайн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж хуульчлах шаардлагатай гэсэн санал нэлээд гардаг¹²⁵ байна.

Үнэлэх зохицуулалт
50 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа
50.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно /дүйцүүлэн тооцох хугацааг 1999 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцно/.
50.2.Голомтын бүсэд ажилласан онцгой байдлын байгууллагын алба хаагч болон бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.
50.3.Албан үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагч болон бусдын эд хөрөнгөд учирсан хохирлыг төр хариуцна.
50.4.Онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, ой, хээрийн түймэр, халдварт өвчин, цар тахлын голомт, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамрагдана.
50.5.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно.
50.6.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
50.7.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс

¹²² Энэ хэсэгт 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.

¹²³ Энэ хэсгийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн.

¹²⁴ Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

¹²⁵ 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр салбарын албан тушаалтантай хийсэн ярилцлагаас

шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.”

50.8.Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.

50.9.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиас доошгүй байна.

50.10.Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн харьяалалгүй алба хаагчийг томилон ажиллуулбал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг улирал тутамд олгоно.

50.11.Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно.

50.12.Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно.

50.13.Энэ хуулийн 50.10, 50.11, 50.12-т заасан нэмэгдэл, мөнгөн урамшуулал, нөхөн олговор олгох журмыг Засгийн газар батална.

50.14.Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно” гэж заасан. Төрийн албаны тухай хуулийн 6 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, нийгмийн баталгаа”-ны талаарх зохицуулалтыг тодорхойлсон бөгөөд төрийн албан хаагч нь нийтлэг болон нэмэгдэл баталгаагаар хангагдахаар зохицуулжээ. Төрийн албан хаагчид нэг талаас хууль тогтоомжоор тодорхой хязгаарлалт тогтоодог бол нөгөө талаар төрийн зүгээс хууль ёсны тодорхой баталгаагаар хангах хэрэгцээ, шаардлага бий болдог.

Төрийн албаны тухай хуулийн “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, нийгмийн баталгаа” гэсэн VI хэсэгт төрийн албан хаагч нь нийтлэг болон нэмэгдэл баталгаагаар хангагдахаар зохицуулсан. Тус хуулийн 61 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрийн албан хаагчийн 10 нийтлэг баталгаа, 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дээрх нийтлэг баталгаанаас гадна төрийн жинхэнэ албан хаагч нь нэмэгдэл 4 баталгаагаар хангагдана гэж заасан. Хуульд заасан төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан 16 журмыг Засгийн газраас батлан хэрэгжүүлж байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Засаглалын талаар баримтлах бодлогын 5.4 дэх зорилтын хүрээнд 2050 он гэхэд “төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа сайжирч, амьдралын баталгаа бүрэн хангагдсан байна” гэж заасан. Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлэхийн тулд төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал болохыг тодорхойлсон.

Иймд Онцгой байдлын алба хаагчийн нийгмийн баталгааг хангахтай холбоотой ГХтХ-ийн зохицуулалтын хэрэгжилт, үр дагаврыг судалж, нийгмийн баталгааны төлөв байдлыг дүгнэж, цаашид боловсронгуй болгоход чиглэсэн алба

хаагчдын саналыг тодруулахыг зорьсон. Үүний хүрээнд ГХтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1 - 50.14 дэх хэсгийн зохицуулалт бүрийг “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу боловсруулсан дараах ерөнхий 3 томьёоллын дагуу авч үзье:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. *Онцгой байдлын алба хаагчийн нийгмийн баталгааг хуульд оновчтой, бүрэн тусгасан эсэх;*

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. *Онцгой байдлын алба хаагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд батлахаар ГХтХ-д тусгасан журмын хэрэгжилт, хүндрэл, бэрхшээл бий эсэх;*

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. *Онцгой байдлын алба хаагчийн нийгмийн баталгааг сайжруулах санал, нөлөөлөх хүчин зүйл бий эсэх*

ГХтХ-ийн 50.1 дэх хэсэг буюу Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцож байгаа өнөөгийн байдал зохистой эсэх тухайд:

ГХтХ-ийн 50.1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно. /дүйцүүлэн тооцох хугацааг 1999 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцно/” гэж заасан. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацааг тогтоосон. Тэтгэвэр, тэтгэмжийн харилцааны суурь асуудлын нэг нь алба хаасан хугацаа юм.

“Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.14-д Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно гэж заасан зохицуулалтад улсын нөөцөд ажилласан хугацааг тооцох, түүнчлэн “Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, онцгой байдлын алба хаагчаар ажиллах мэргэжлээр суралцсан, уул уурхайн аврах алба, улсын нөөцийн албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагын генерал, офицер, ахлагч, байлдагчаар төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцох” санал гаргасан талаар өмнө нь дурдсан.

Түүнчлэн онцгой байдлын албаны зарим ажлын байр хүнд, хортой нөхцөлд багтсаныг харгалзаж ажилласан хугацааг тооцохоор хуульд тусгах/ Аврагч-гал сөнөөгч г.м/, хил хамгаалах байгууллагын зохицуулалттай уялдуулах, жишээлбэл өдрийн 8 цагаар албан үүрэг гүйцэтгэдэг алба хаагч баяр, амралтын өдрүүдэд/ /хагас,бүтэн сайн өдрүүдэд/ орон нутгийн онцлогтой холбогдуулан үүрэг

гүйцэтгэсэн тохиолдолд ажилласан баяр амралтын, хагас, бүтэн сайн өдрүүдийн амралтыг биеэр эдлүүлэх (Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу) гэх мэт уян хатан зохицуулалт хэрэгжүүлэх санал¹²⁶ дэвшүүлжээ.

ГХтХ-ийн 50.2-т “Голомтын бүсэд ажилласан онцгой байдлын байгууллагын алба хаагч болон бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно” гэж заасан зохицуулалтын тухайд:

ГХтХ-ийн 50.2-т заасан онцгой бүсэд ажилласан алба хаагчийн томилолтын зардал олгохтой холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ Сангийн сайдын баталсан албан томилолтын зардлаас зөвхөн хоолны зардлыг 3 дахин нэмэгдүүлж олгож байна. Учир нь алба хаагчид голомтын бүсэд үүрэг гүйцэтгэхдээ тухайн бүсэд байранд байрлах боловч үүнтэй холбоотой баримт бүрдүүлэх боломжгүй тул аудитын хяналт шалгалтаар байрны зардал олголтыг зөвшөөрдөггүй. Иймд голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн хугацаанд суурилж хоол, байрны зардлыг бүрэн олгох талаар тусгах, эсхүл хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаар тусгайлсан журам баталж мөрдөх шаардлагатай байна. Дээрх заалтын дагуу ОБЕГ-ын “Байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах” хөтөлбөрийн арга хэмжээнд 2021 онд 8 тэрбум төгрөгийг шийдвэрлэсэн. Харин Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд энэ ангиллын төсөв жилээс жилд буурч батлагдаж байна. Үүний зэрэгцээ Сангийн сайдын баталсан албан томилолтын зардал нэмэгдэж байгаа тул төсвийг аль болох бууруулахгүй байх, харин ч нэмэгдүүлж батлах шаардлага үүсэж байна ¹²⁷ гэсэн мэдээлэл өгсөн.

Дүгнэвэл, уг зохицуулалтын хэрэгцээ, шаардлага, ач холбогдол их боловч хэрэгжилтийн шатанд Сангийн яамны зүгээс баримталж байгаа хандлагын нөлөө, төрийн хэмнэлтийн бодлогын улмаас зөрчил, хүндрэл, бэрхшээл үүсдэг байна.

ГХтХ-ийн 50.3-т “Албан үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагч болон бусдын эд хөрөнгөд учирсан хохирлыг төр хариуцна” гэж заасан зохицуулалтын тухайд:

Онцгой байдлын алба хаагч албан үүргээ биелүүлснээс алба хаагч болон бусдын эд хөрөнгөд хохирол учрах тохиолдол нэлээд бий. Гал унтраах ажиллагаатай холбогдуулан зам тээврийн осол түгээмэл гардаг. Энэ тохиолдолд нөхөн төлбөрийн асуудлыг даатгалаар зохицуулж байна. Бусад харилцаанд, тухайлбал эд хөрөнгө, хүч хэрэгсэл дайчлан авахдаа нөхөн олговор олгох харилцааг зохицуулах хэрэгцээ, шаардлагын талаар тус Тайлангийн “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт”, “Гамшгийн үеийн ажиллагаа” бүлгийн холбогдох хэсэгт судалж дүгнэсэн.

Албан үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагч болон бусдын эд хөрөнгөд учирсан хохирлыг төр хариуцах механизмын зохицуулалт болон хэрэгжилтийн түвшин хангалтгүй хэвээр байна.

ГХтХ-ийн 50.4-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, ой, хээрийн

¹²⁶ Салбар, нэгжийн алба хаагчдын саналаас.

¹²⁷ ОБЕГ-ын холбогдох мэргэжилтний өгсөн мэдээлэл, 2025 оны 6 дугаар сар.

түймэр, халдварт өвчин, цар тахлын голомт, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамрагдана.” гэж заасан зохицуулалтын тухайд:

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд алба хаагчийн нийтлэг эрхийг тусгасны дотор 5 дугаар зүйлийн 5.1.6-д эрүүл мэндээ хамгаалуулах, 5.1.7-д цэргийн алба хаах үүргээ гүйцэтгэх явцад өөрийн эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирлоо хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлэх эрхтэй гэж заасан. Үүний дагуу ГХтХ-ийн 50.4-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, ой, хээрийн түймэр, халдварт өвчин, цар тахлын голомт, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамрагдана.” гэж тусгасан.

Уг зохицуулалтын хэрэгжилтийн талаар, тулгамдсан асуудал бий эсэх талаар албан тушаалтан болон алба хаагчдын аль алины байр суурийг тодруулах хандлагаа баримталж дараах мэдээллийг цуглуулсан.

Шаардлагатай тохиолдолд алба хаагч эмчилгээ хийлгэдэг. Сувилах үйлчилгээний тухайд, тухайлбал ой хээрийн түймэрт олон хоногоор явсан хүн өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд цөөн хоногоор сувилалд хэвтдэг. Онцгой байдлын албанд сэтгэл зүйч мэргэжилтний тусламж, үйлчилгээний хэрэгцээ, шаардлага их байдаг. Гэтэл сэтгэл зүйчийн тухайлсан орон тоо байхгүйн улмаас эмч мэргэжилтнийг нэн тэргүүнд авч ажиллуулахаас өөр аргагүй бөгөөд сэтгэл зүйчийн ажлыг эмч давхар гүйцэтгэж байна. Сэтгэл зүйчийн орон тоо батлуулахаар анхаарч байна. Эхэндээ онцгой байдлын албаны чадавхи техник тоног төхөөрөмжөөс хамаарна гэж анхаарч ирсэн үе байсан бол одоо эргээд хүний нөөцөө анхаарах тал дээр ажиллаж байна.

Албан тушаалтантай хийсэн ярилцлагаас¹²⁸

Мөн ОБЕГ-ын алба хаагчдын зүгээс ГХтХ-ийн хэрэгжилт, цаашид шийдвэрлэх асуудал, гарцын талаар өгсөн саналаас түүвэрлэвэл:

- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйг нөхөн сэргээх эмчилгээний урт, богино хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэх /113/;

- ОББ-ын салбар, нэгж бүрт ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийн талаар жил бүр мэргэжлийн байгууллагаар үзлэг хийх, үзлэг хийлгэх зардлыг төрөөс хариуцах /Хөвсгөл/;

- ГХтХ-ийн 50.4 дэх хэсгийг “Онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, ой, хээрийн түймэр, халдварт өвчин, цар тахлын голомт, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд тухайн байгууллагын тодорхойлсон баримт, бичгийг үндэслэж үнэ төлбөргүй хамрагдана” гэж нэмэлт, өөрчлөлт оруулж тусгах/Сүхбаатар/;

¹²⁸ 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр ОБЕГ-ын албан тушаалтантай хийсэн ярилцлагаас.

- ГХтХ-ийн 50.4 дэх хэсэгт заасан нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд алба хаагч үнэ төлбөргүй хамрагдахаар зохицуулах /Говьсүмбэр/;

- Онцгой байдлын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах талаар тусгагдаагүйг харгалзан ГХтХ-ийн 50 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт онцгой байдлын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах, үүнтэй холбогдох зардлыг онцгой байдлын байгууллагын төсөвт тусгаж байх тухай заалт нэмэх /Өвөрхангай/ саналыг тус тус дэвшүүлсэн байна.

Дээр дурдсан мэдээлэл, саналыг үзэхэд ГХтХ-ийн 50.4-д заасан онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, ой, хээрийн түймэр, халдварт өвчин, цар тахлын голомт, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамрагдана гэсэн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй гэдэг дээр талууд санал нэгтэй байгааг дурдах нь зүйтэй. Энэ нь онцгой байдлын алба хаагчийн эрүүл мэнд, улмаар тус албаны харилцаанд сөрөг нөлөөтэй гэдгийг ойлгож бодлогын төвшинд анхаарах шийдлийн хувилбар дэвшүүлснийг ажил хэрэг болгох нь зүйтэй.

ГХтХ-ийн 50.5-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно.” гэж заасан зохицуулалтын тухайд:

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 118 дугаар тушаалаар баталсан “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг үндэслэн 2018 оноос эхлэн онцгой гавьяа байгуулсан алба хаагчдад мөнгөн урамшуулал олгодог болсон. Энэ журмын дагуу гамшиг, осол, аюулт үзэгдлийн бүс болон хүний гоц халдварт өвчний голомтод аврах, эмчлэх, сувилах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд эр зориг, мэргэжлийн ур чадвар гарган оролцсон таван алба хаагч тус бүрт 16 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олголоо¹²⁹ зэрэг мэдээ (энэ төрлийн урамшуулал олгосон алба хаагчдын ажилласан жил /10-27 жил/, гүйцэтгэсэн үүргийг онцолсон байв.) болон алба хаагчдаас авсан бусад мэдээллээс дүгнэлт хийхэд, онцгой гавьяа гэдэгт нэг удаагийн байгуулсан онцгой гавьяа буюу онцгой тохиолдлыг бус, удаан жил, тогтвор сууршилтай ажиллахдаа байгуулсан гавьяа зүтгэлийн талаар дурдсан байна.

Тус заалтын хэрэгжилтийн талаар албаны байр суурийг тодруулбал:

Тухайн ангиллын урамшуулал олгогдож байгаа боловч төсвийн байдлаас хамаарч урамшууллыг хангалттай хэмжээнд олгож чадахгүй байгаа. Онцгой байдлын албаны тухайд нэг ажиллагааны дуудлагад олон алба хаагч зэрэг явж, багаараа үр дүн, амжилт, гавьяа байгуулдаг онцлог мөн нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл урамшууллыг хүртээмжтэй олгох талыг харгалзахаас өөр аргагүй байгаа./ Албан тушаалтантай хийсэн ярилцлагаас/

¹²⁹ ОБЕГ-ын цахим хуудас, Дотоод мэдээ/Онцгой гавьяа байгуулсан алба хаагчдад 16 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олголоо/, <https://nema.gov.mn/post/151439> , 2023

Түүнчлэн алба хаагчдын зүгээс ГХтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.5-д заасан онцгой гавьяа байгуулсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл гэснийг “50-100 дахин” гэж өөрчлөн, урамшууллын доод хэмжээг тогтоох санал¹³⁰ дэвшүүлсэн байна.

Дүгнэвэл, урамшуулал олгох хөрөнгийн хүртээмжийн асуудал нь төсвийн хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудал бөгөөд тухайн хэм хэмжээний үр нөлөө, хэрэгжилтийг сайжруулах хувилбарын тухайд ГХтХ-ийн 50.5-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно.” гэж заасны “олгож болно” “олгоно” гэж өөрчлөх, мөнгөн урамшууллын доод хязгаарыг тусгах нь зүйтэй гэж үзлээ.

ГХтХ-ийн 50.6-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж заасан зохицуулалтын тухайд:

МУ-ын Шадар сайдын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 118 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд мөнгөн урамшуулал олгох журам”-аар уг харилцааг зохицуулж байна.¹³¹

2017 онд ГХтХ-ийг шинэчлэн баталсны дараа, Шадар сайд, Сангийн сайдын 2015 онд хамтран баталсан журмыг шинэчилж батлуулахаар төслийг боловсруулж, саналыг Сангийн яаманд хүргүүлэхэд урамшууллын тарифыг нэмэгдүүлэх боломжгүй гэсэн санал ирүүлж байв. Журмыг шинэчилж батлуулахаар төслийг Шадар сайд, Сангийн сайд нарт дахин хүргүүлсэн. Шинэчлэн боловсруулсан журмын төсөл нь ГХтХ-ийн 50.5-д заасантай бүрэн нийцнэ. Уг төсөл батлагдсанаар тухайн заалт хүндрэл, бэрхшээлгүй хэрэгжих болно.

Дээрх заалтын дагуу ОБЕГ-ын “байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах” хөтөлбөр, арга хэмжээнд 2021 онд 8 тэрбум төгрөгийг шийдвэрлэсэн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд энэ ангиллын төсөв жилээс жилд буурч батлагдаж байна. Жилд дунджаар 4-5 алба хаагчид 16 сая төгрөг олгож байна. Алба хаагчдын зүгээс, албан үүргээ гүйцэтгэж байгаад эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх тохиолдолд олгох мөнгөн урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх саналтай байна.

Иймд 2015 онд батлагдсан журмын дагуу тухайн урамшууллыг олгож байгааг өөрчилж 2017 онд батлагдсан ГХтХ-ийн дагуу журмыг шинэчлэн батлах, улмаар төсвийг бууруулахгүй байх, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлж батлах замаар хэрэгжилтийг анхаарах шаардлагатай.

ГХтХ-ийн 50.7-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал

¹³⁰ Үндэсний аврах бригадийн санал

¹³¹ ОБЕГ-аас ирүүлсэн мэдээллээс

даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.” гэж заасан зохицуулалтын тухайд:

Онцгой байдлын байгууллагын алба хаагч бүр гэнэтийн ослын даатгалд хамрагддаг. Бусад байгууллагатай харьцуулахад ОББ-ын алба хаагчид эрсдэл ихтэй нөхцөлд ажилладаг учраас гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах, зардлыг төр хариуцахаар заасан. Нөхөн төлбөрийн асуудлыг эрсдэл ихтэй нөхцөлд ажилладаг алба хаагч /анги, нэгжийн алба хаагчид/, эрсдэл багатай нөхцөлд ажилладаг алба хаагч /ОБЕГ, төв, орон нутгийн газар, хэлтсийн алба хаагчид/ гэсэн 2 өөр нөхцөлөөр зохион байгуулдаг. Нөхөн төлбөр олгох процесс гэрээнд заасны дагуу олгогддог.

ОББ-ын алба хаагчдын үнэлгээг тухайн жилд батлагдсан төсөвт багтаан тогтоодог бөгөөд жил бүр анги салбарууд шинээр нэмэгдэж байгаа, ОББ-ын бүтэц шинэчлэгдэн өргөжиж байгаатай холбогдуулан гэнэтийн осол, ажил мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, зардлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх шаардлага үүсдэг.

Тухайн зохицуулалттай холбоотой онцгой байдлын байгууллагын алба хаагчдын саналыг нэгтгэвэл:

- Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд алба хаагчийг нэг зуун сая төгрөгөөр заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна гэж өөрчлөх /Дархан- Уул/;

- Онцгой байдлын байгууллагын алба хаагч ажил үүргээ гүйцэтгэж байгаад хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд ажилласан жилээс шалтгаалан нийгмийн даатгалийн сангаас олгосон цалингийн зөрүү хувь хэмжээг ажил олгогчоос олгох/Говьсүмбэр/;

- Албан үүрэг гүйцэтгэх үеэр учирч болзошгүй эрсдэлээс сэргийлж алба хаагчийн эрүүл мэнд, амь насанд даатгалын тогтолцоог сайжруулах/113/ санал гаргасныг нягталж шийдвэрлэх нь зүйтэй.

Түүнчлэн анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед болон энгийн үед иргэдийн хайхрамжгүй байдлаас үүдэн гарсан дуудлага, мэдээлэл дэх ОББ-д хамаарах дуудлагын хариу арга хэмжээг тухайн иргэн бүрэн эсхүл тодорхой хувийг хариуцахаар, эсхүл ийм шинж чанартай дуудлагыг бусад /хувийн байгууллагад үлдээх, даатгалаар зохицуулах зэрэг/ хувилбараас сонгож зардал шийдүүлэх замаар төрийн байууллагаас гарах зардлыг бууруулах бололцоотой гэж энэхүү судалгааны тайланд дурдсан билээ. Энэ мэтчилэн онцгой байдлын алба хаагчийн даатгалтай холбоотой асуудлыг шийдвэрлэх олон талын арга замыг хуульчилбал зохистой гэж үзэж байна.

ГХмХ-ийн 50.8-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан зохицуулалтын тухайд:

Засгийн газрын 2018 оны 374 дүгээр тогтоол¹³² - оор “Онцгой байдлын байгууллагын мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам” батлагдсан. Уг журмын дагуу алба хаагчдад мэргэжлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгож байна.

Тус журмын зорилго нь онцгой байдлын байгууллагын алба хаагчийн мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх зорилгоор мэргэшлийн зэрэг олгох, хамгаалах, ахиулах, бууруулах, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Алба хаагчийн мэргэшлийн зэрэг нь Төрийн албаны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшинг илэрхийлнэ.

Мэргэшлийн зэргийг офицерын, ахлагчийн гэж ангилж байна. Алба хаагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин, алба хаасан хугацаанд нийцүүлэн мэргэшлийн зэргийг олгоно. Мэргэшлийн зэрэг нь I, II, III гэсэн 3 шатлалтай байх бөгөөд дараахь хугацаанд хүчинтэй:

- Мэргэшлийн I зэрэг 4 жил;
- Мэргэшлийн II зэрэг 3 жил;
- Мэргэшлийн III зэрэг 2 жил.

Тус журмын 2.3.2-т “мэргэшлийн зэргийн шалгалтад хамрагдах алба хаагчийн холбогдох баримт бичгийг хянаж, шалгах” талаар заасан. Гэтэл онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний зонхилох хувийг эзэлдэг ахлагч бүрэлдэхүүний тухайд хууль, эрх зүй, онолын мэдлэгийн шалгалт буюу 1 дүгээр шатны шалгалтад тэнцээгүй гэсэн үндэслэлээр мэргэшлийн зэргийн нэмэгдэл авах боломж хомс болдог. Энэ нь ГХтХ-ийн холбогдох заалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Үүнийг харгалзан бусад цэргийн байгууллагын адил шалгалтгүйгээр, зөвхөн ажилласан жилийг харгалзаж мэргэшлийн зэргийг олгодог байх хувилбарыг санал болгожээ.¹³³ Энэ мэтчилэн онцгой байдлын алба хаагчид мэргэшлийн зэрэг олгох үндэслэл, шалгуур, процессыг оновчтой тодорхойлж практикт нийцүүлэх, хэрэгжилтийг хангах цогц асуудлыг анхаарах нь зүйтэй.

ГХтХ-ийн 50.9-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиас доошгүй байна.” гэж заасан зохицуулалтын тухайд:

Засгийн газрын 2018 оны 380 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”¹³⁴ мөрдөгдөж байна. Тус журамд онцгой байдлын байгууллагын алба хаагчид алба хаах хугацаанд нь албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох бөгөөд уг нэмэгдлийг тухайн алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хувиар тооцож, сар бүр олгох тухай

¹³² [ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ \(Онцгой байдлын байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам\)](#)

¹³³ ОБЕГ-ын газар, хэлтсээс ирүүлсэн саналаас

¹³⁴ [ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ \(Онцгой байдлын байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам\)](#)

өөрчлөлтийг Засгийн газрын 2020 оны 166 дугаар тогтоолоор оруулсан. Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг ОББ жил бүрийн төсөвтөө тусгана.

Энэхүү журмын хэрэгжилтийн тухайд “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиас доошгүй байна” гэснийг “50 хувиас доошгүй байна” гэж өөрчлөх зэргээр нэмэгдлийн хэмжээг өсгөх саналыг алба хаагчдаас гаргадаг талаар дурдах нь зүйтэй.

ГХтХ-ийн 50.10-т “Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн харьяалалгүй алба хаагчийг томилон ажиллуулбал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг улирал тутамд олгоно.” гэж заасан зохицуулалтын тухайд:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.13 дахь хэсэгт “Энэ хуулийн 50.10, 50.11, 50.12-т заасан нэмэгдэл, мөнгөн урамшуулал, нөхөн олговор олгох журмыг Засгийн газар батална” гэж заасан нь тухайн эрхийг Засгийн газарт тусгайлан шилжүүлсэн зохицуулалт юм. “Алслагдсан” гэдэг ойлголтыг тогтоогоогүй нь хэрэгжилтэд нөлөөлсөн.¹³⁵ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.4 дэх хэсэгт 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж “Алслагдсанд тооцох анги, салбарын жагсаалтыг Засгийн газар тогтоох бөгөөд мөнгөн тусламж, урамшуулалд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгана.” гэж заажээ.

Засгийн газраас батлагдсан 2020 оны 165 дугаар тогтоолын хавсралтад тусгасан бөгөөд тухайн тогтоол батлагдах үеийн мэдээллээр өөр аймаг, суманд томилогдон ажиллаж байгаа 860 гаруй алба хаагчийн 10 хувь нь айлын хажуу өрөөнд, 35 хувь нь түрээсийн орон сууц, 50 хувь нь түрээсийн хашаа байшинд, таван хувь нь байгууллагын орон сууцанд амьдарч байна; Алба хаагчдын 81 хувь нь цалингийн зээлтэй, гэр бүлийн гишүүдийн 74 хувь нь ажилгүй гэсэн судалгаа гарчээ.¹³⁶ Өнөөдрийн байдлаар алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид ажиллаж буй тухайн аймаг, сумын харьяалалгүй алба хаагчийн тоо, алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгж хоорондын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой албан ёсны мэдээлэл олдоогүй.

Өдгөө тогтоол батлагдсан боловч ГХтХ-ийн 50.10-т заасан нэмэгдлийг олгож эхлээгүй байна. Тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаан нь төсвийн хүндрэл, хэмнэлтийн горимын шаардлага, шалтаг байгаад шүүмжлэлтэй хандах ёстой.

Түүнчлэн алба хаагчдын зүгээс үүнийг мөн онцолж, тухайн хуулийн 50.10-т “Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн харьяалалгүй алба хаагчийг томилон ажиллуулбал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг

¹³⁵ Албан тушаалтантай хийсэн ярилцлагаас

¹³⁶ Itoim.mn 2020.11.4-ний мэдээ: [Онцгой байдлын алба хаагчдын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 30 хувь болголоо](#) . Сүүлд үзсэн: 2025.05.01

улирал тутамд олгоно.” гэсний “Алслагдсан” гэдэг үгийг хасах, тухайн алба хаагч төрийн үйлчилгээ авахын тулд томилогдсон аймгийнхаа хаягт шилжих шаардлага гардаг учир нэмэгдэл олгох харилцаанд үндсэн захиргааг үндэслэх гэх мэт тохиромжтой хувилбар бүхий санал гаргасныг харгалзан үзэх нь зүйтэй.

ГХтХ-ийн 50.11-д “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно.” гэж заасан зохицуулалтын тухайд:

ГХтХ-ийн 50.11 дэх хэсгийг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 188 дугаар тогтоолоор “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”¹³⁷-ыг баталж, 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Үүний дагуу, онцгой байдлын албан хаагч суманд тасралтгүй 5 жил буюу 60 сар ажилласан байх нь тухайн урамшууллыг олгох гол урьдчилсан нөхцөл юм.

Дээрх хэм хэмжээг хэрэгжүүлэх хувилбарын талаар онцгой байдлын байгууллагын алба хаагчдын төлөөллийн саналыг тандвал:

- Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний, аймгийн төв /сум/-д ажилладаг онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тус тус олгоно гэж ялгамжтай болгож өөрчлөх;

- “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно” гэснийг “Улаанбаатар хотоос 500 км алслагдсан аймаг, суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно” гэж тодорхой өөрчлөлт оруулах хувилбарыг тус тус дэвшүүлжээ.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлгийн 39.7-д “Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн салбарт 50 хувь, суурин бус газарт байрладаг хилийн цэргийн ангид 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн цэргийн ангид 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно” гэх заалтыг дүйцүүлэн тусгах хувилбарыг бас санал болгосныг дэмжиж байна.

¹³⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530309921941&showType=1>

ГХтХ-ийн 50.12-т “Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно. “ гэж заасан зохицуулалтын тухайд:

2020 оны 165 дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралтаас хойш хамаарах тохиолдол гараагүй буюу алба хаагч энэ төрлийн нэг удаагийн нөхөн олговор авсан тохиолдол бүртгэгдээгүй байна. Алба хаагчдын зүгээс:

- ОББ-ын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах, холбогдох зардлыг төрөөс хариуцах;

- ОББ-ын алба хаагч албан үүргээ биелүүлж явах үедээ эрүүл мэнд хохирсон тохиолдолд үзлэг оншилгоо, нөхөн сэргээх эмчилгээний зардлыг төрөөс хариуцах;

- Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 45, 80, 95 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно гэж хэмжээг нэмэгдүүлж өөрчлөх саналыг тус тус гаргасан байна.

ГХтХ-ийн 50.12-д “Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно.” гэж заасан хэсгийг тус хуулийн “Онцгой байдлын алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмж” хэсэгт нэгтгэвэл тохиромжтой гэж үзлээ.

ГХтХ-ийн 50.13-т “Энэ хуулийн 50.10, 50.11, 50.12-т заасан нэмэгдэл, мөнгөн урамшуулал, нөхөн олговор олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан зохицуулалтын тухайд:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5-д заасны дагуу онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн “гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавар, салбар хоорондын харилцан ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг батлах” эрхтэй. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.13 дахь хэсэгт “Энэ хуулийн 50.10, 50.11, 50.12-т заасан нэмэгдэл, мөнгөн урамшуулал, нөхөн олговор олгох журмыг Засгийн газар батална” гэж заасан нь Засгийн газарт тусгайлан эрх шилжүүлсэн зохицуулалт юм.

Эдгээр журамд заасан зохицуулалтын хэрэгжилтийн талаар ГХтХ-ийн 50.10, 50.11, 50.12-т заасан хэм хэмжээ бүрээр авч үзсэн болно. Дүгнэж хэлбэл, ГХтХ-д заасан эдгээр зохицуулалтын 1 буюу тус хуулийн 50 дугаар зүйлийн 50.10 дахь хэсэгт заасан нэмэгдэл олгох журам хэрэгжээгүй, 50.11-т заасан хэм хэмжээг боловсронгуй болгох хувилбарын талаар санал дэвшүүлсэн байгааг үзнэ үү.

ГХтХ-ийн 50.14-т “Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно.” гэж заасан зохицуулалтын тухайд:

Уг зохицуулалтын хэрэгжилтээс гадна зохих субъектийг бүрэн хамруулсан эсэх, оновчтой томьёолсон эсэх, ажилласан хугацааг дүйцүүлэн тооцохтой холбоотой асуудал бий эсэх, цаашид зохицуулалтыг боловсронгуй болгох, үр дүнтэй хэрэгжүүлэх хувилбарын талаар тандан судаллаа. Ингэхдээ ОБЕГ-ын холбогдох албан тушаалтан болон харьяа байгууллага, түүний алба хаагчдаас мэдээлэл, санал авсан.

Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно.” гэж заасан хэсэгт улсын нөөцийн албанд ажилласан хугацааг нэмж тусган онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцох санал¹³⁸-ыг нэлээд дэвшүүлсэн байна.

Түүнчлэн онцгой байдлын албанд тулгамдсан, анхаарах шаардлагатай асуудлын нэг нь цэргийн мэргэжлээс гадна гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, онцгой байдлын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад мэргэжлийн боловсрол эзэмших, мэргэжлийн зэрэг ахиулах, мэргэжил дээшлүүлэх, үргэлжилсэн сургалтад төрийн зардлаар суралцах эрх хангагдахгүй, ажилласан жилд тооцогдохгүй байгаагийн улмаас алба хаагчийн суралцах эрх хангагдахгүй, ялгаварлал үүсэж, үүний улмаас “энгийн сургууль” гэдэг шалтгаанаар гадаад улсад нарийн мэргэжлээр алба хаагчийг бэлтгэх, чадавхжуулах хэрэгцээ, шаардлага хангагдахгүй, онцгой байдлын албаны мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх бодлого хэрэгжих боломжгүй байдалд оржээ. /Энэ талаар судалгааны тайлангийн “Онцгой байдлын алба хаагчийн эрх” хэсэгт дэлгэрэнгүй тусгасан./

Иймд ГХтХ-ийн 50.14 дэх зохицуулалтад онцгой байдлын албанд хамаарах мэргэжлийн сургуульд суралцсан хугацааг ажилласан жилд оруулж тусгах шаардлагатай гэж үзэв.

Онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацааг тооцохтой холбоотой зохицуулалтын оновчгүй байдал тус хуулийн бусад зохицуулалтыг хэрэгжүүлэхэд мөн сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал ГХтХ-ийн

¹³⁸ Энэхүү судалгааны хүрээнд 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр ОБЕГ-ын холбогдох албан тушаалтантай хийсэн ярилцлага болон бичгээр боловсруулсан асуумжийн дагуу ирүүлсэн санал, ОБЕГ-ын харьяа салбар нэгжээс ирүүлсэн санал.

49.1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авна” гэж заасныг хэрэгжүүлж тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгох, авах харилцаанд хүндрэл, бэрхшээл байгаа тухай, мөн хэрхэн шийдвэрлэх саналыг тус судалгааны хүрээнд ГХтХ-ийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн хэсэгт тусгасан.

Бүлгийн дүгнэлт, санал

Судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан дүгнэлт, саналыг тус тайлангийн Дүгнэлт, санал, зөвлөмж бүлэгт нэгтгэн байршууллаа.

3.8. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт

Үнэлэх зохицуулалт
51 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт 51.2. Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна. 51.3. Аймаг, нийслэл, сум дүүрэг нь тухайн жилийн төсвийн 1.0 хувийг орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулна.

“Практикт нийцэж буй байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. *Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт нь практикт бодитой эсэх*

Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна. Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана. Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна гэж ГХтХ-ийн 51 дүгээр зүйлд заасан. Түүнчлэн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлдэг. Үүнд:

- Улсын болон орон нутгийн төсөв;
- Орон нутгийн хөгжлийн сан;
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын болон иргэний байгууллагын хандив, тусламж;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд зориулагдсан олон улсын сан, буцалтгүй тусламж, зээл;
- Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр багтдаг.

ГХтХ-д тусгасан гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэртэй холбоотой зохицуулалтыг задалж авч үзье.

Засгийн газрын нөөц сан

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын нөөц сан нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, гамшиг, аюулын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, дэд бүтэц эвдэрсэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн зэрэг үр дагаврыг зогсоох, бууруулах, хохирол багатай даван туулахад чиглэсэн хойшлуулшгүй арга хэмжээг шат дараатай зохион байгуулах зорилгоор

улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна. Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах, эрсдэлийг бууруулах, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах арга хэмжээг санхүүжүүлнэ.

Засаг даргын нөөц хөрөнгө

Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд зааснаас гадна Сангийн сайдын тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-д зааснаар санхүүжүүлнэ. Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 болон 2.1.2-т заасны дагуу байгалийн гамшигт үзэгдэл, ослын үед хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах, таслан зогсоох, хохирлыг арилгах арга хэмжээг санхүүжүүлнэ.¹³⁹

Гамшгаас хамгаалах арга хэмжээний санхүүжилтийн зохицуулалт нь практикт нийцэж буй эсэхийг тогтоохын тулд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн жишиг тогтоосон БНСУ, Япон улс, ХБНГУ, БНТУ-ыг сонгож, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн зохицуулалтыг харьцуулж үзье.

Хүснэгт 17. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт-харьцуулалт

Сонгосон улс	Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилттэй холбогдох зохицуулалт
Бүгд Найрамдах Солонгос Улс Framework Act on the Management of Disasters and Safety)	10-2 дугаар зүйл. (Гамшиг болон аюулгүй байдлын удирдлагын төслүүдийн төсөвтэй холбоотой урьдчилсан зөвшилцөл гэх мэт) 1. Холбогдох төв захиргааны байгууллагын дарга нь Улсын санхүүгийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Сангийн сайдад хүргүүлэх дунд хугацааны төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнүүдээс, Гамшиг болон аюулгүй байдлын удирдлагын төслүүдэд (энэ зүйл болон 10-3 дугаар зүйлд мөн адил хамаарна) хамаарах дунд хугацааны төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө болон холбогдох байгууллагын хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийн талаарх санал дүгнэлтийг жил бүрийн нэгдүгээр сарын 31-ний дотор Нийтийн аюулгүй байдлын сайдад ирүүлнэ. 2. Холбогдох төв захиргааны байгууллагын дарга нь Улсын санхүүгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1

¹³⁹ ОБЕГ, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын баримт бичиг, (УБ, 2023 он) 7 дахь тал.

	дэх хэсэгт заасны дагуу Сангийн сайдад хүргүүлэх төсвийн хүсэлтүүдээс, гамшиг болон аюулгүй байдлын удирдлагын төслүүдтэй холбоотой хүсэлтийг тавдугаар сарын 31-ний дотор Нийтийн аюулгүй байдлын сайдад ирүүлнэ. 3. Нийтийн аюулгүй байдлын сайд нь дээр дурдсан (1) болон (2) дахь хэсгүүдийн дунд хугацааны төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийн санал болон төсвийн хүсэлтийг шалгаж үзээд, Төв хорооны хэлэлцүүлгийн дараа жил бүрийн зургадугаар сарын 30-ны дотор Сангийн сайдад дараах зүйлсийг мэдэгдэнэ: a. Гамшиг болон аюулгүй байдлын удирдлагын төслүүдийн хөрөнгө оруулалтын чиглэл; b. Тухайн төв захиргааны байгууллага бүрээр хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын зохистой байдал, хэрэгжилтийн тэргүүлэх чиглэлийн талаарх асуудлууд; c. Гамшиг болон аюулгүй байдлын төслүүдийн ижил төстэй байдал, давхардлыг хянан үзсэн үр дүн; d. Гамшиг болон аюулгүй байдлын төслүүдийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд шаардлагатай бусад асуудлууд. 4. Сангийн сайд нь дээр дурдсан (3) дахь хэсэгт заасан үр дүнг үндэслэн, санхүүгийн удирдлагын зарчимд нийцэхгүй үндэслэлтэй нөхцөл байдал (жишээ нь, улсын санхүүгийн байдал муу байх гэх мэт)-аас бусад тохиолдолд, гамшиг болон аюулгүй байдлын удирдлагын төслүүдийн төсвийн төлөвлөгөөг боловсруулна.
Япон Улс Disaster Countermeasures Basic Act	VII БҮЛЭГ: Санхүүгийн зохицуулалт 91 дүгээр зүйл. Гамшгаас урьдчилан сэргийлэх болон яаралтай арга хэмжээний зардлын хариуцлага Хуульд өөрөөр заагаагүй, эсхүл төсвийн хүрээнд тусгай арга хэмжээ аваагүй тохиолдолд, гамшгаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн эсрэг яаралтай арга хэмжээний зардал, мөн энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүх зардлыг хэрэгжилтийг хариуцсан этгээд хариуцна. 92 дугаар зүйл. Бусад орон нутгийн засаг захиргааны дэмжлэгтэй холбоотой санхүүгийн хариуцлага 1. Хэрэв орон нутгийн нэгжийн удирдагч нь бусад орон нутгийн нэгжийн удирдагчаас (эсвэл түүний харьяа байгууллага, гишүүнээс) 67, 68 эсвэл 74 дүгээр зүйлийн дагуу дэмжлэг авсан бол, тус дэмжлэгтэй холбоотой үүссэн зардлыг дэмжлэг авсан орон нутгийн

	нэгж бүрэн хариуцна. 2. Хэрэв дэмжлэг авсан орон нутгийн нэгж нь тухайн зардлыг цаг хугацаанд нь төлж чадахгүй бол, дэмжлэг үзүүлсэн орон нутгийн удирдагчаас зардлыг түр хугацаанд зээл хэлбэрээр гаргуулж болно. 93 дугаар зүйл. Мужийн засаг захиргааны түвшинд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлын хуваарилалт 1. Хэрэв хот, тосгон, сумын захирагч нь мужийн захирагчийн заавраар (72 дугаар зүйл) яаралтай арга хэмжээ авсан бол, түүний хүрээнд гарсан зардлын дотор тухайн орон нутгийн нэгжээр гаргуулах боломжгүй эсвэл зохимжгүй гэж үзсэн хэсгийг мужийн төсвөөс бүрэн эсвэл хэсэгчлэн гаргах бөгөөд энэ нь Засгийн газрын хариуцах зардалд хамаарахгүй байна. 2. Эдгээр тохиолдолд, мужийн захиргаа тухайн зардлыг түр хугацаанд хот, сум, тосгоноор гаргуулж, дараа нь нөхөн төлүүлэх боломжтой. 94 дүгээр зүйл. Засгийн газрын санхүүжилт ба татаас (яаралтай арга хэмжээтэй холбоотой) Гамшгийн урьдчилан сэргийлэхтэй холбоотой яаралтай арга хэмжээний зардлыг Засгийн газар хуульд заасан болон төсвийн хүрээнд бүрэн болон хэсэгчлэн хариуцах, эсвэл татаас олгох боломжтой. 95 дугаар зүйл. Засгийн газрын нэмэлт татаас (төв штабаас өгсөн заавраар хэрэгжүүлсэн арга хэмжээ) 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн 28-6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэсний гамшгийн хяналтын төв штабын даргын заавраар орон нутгийн удирдагч хэрэгжүүлсэн яаралтай арга хэмжээнүүдтэй холбоотойгоор, тухайн орон нутгийн зүгээс хариуцах боломжгүй буюу зохимжгүй зардлын хэсгийг зөвлөмжийн дагуу Засгийн газар бүрэн эсвэл хэсэгчлэн татаас олгож болно. 96 дугаар зүйл. Сэргээн босголтын зардлын хуваарилалт Гамшгийн улмаас хэрэгжүүлж буй сэргээн босголт болон холбогдох бусад хөтөлбөрүүдийн зардлыг Засгийн газар зөвлөмж болон төсвийн хүрээнд бүрэн эсвэл хэсэгчлэн хариуцах, татаас олгох боломжтой.
Холбооны Бүгд Найрамдах Герман улс Civil Protection and Disaster Relief Act (ZSKG)	<u>Үүрэг хариуцлагын тухайд</u> <u>Холбооны Засгийн газар:</u> Иргэний хамгаалалт, гамшгийн тусламжийн үндэсний бодлого, зохицуулалтыг хариуцдаг. Холбооны Дотоод хэргийн яам (BMI) нь энэ чиглэлийн гол байгууллага бөгөөд Холбооны Иргэний Хамгаалалт ба Гамшгийн Тусламжийн Алба (BBK) болон Холбооны Техникийн Тусламжийн Агентлаг (THW)-ийг хариуцдаг байна.

	<u>Муж улсууд (Länder):</u> Гамшгийн үед шууд хариу арга хэмжээ авах, орон нутгийн гамшгийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Муж улсын дотоод хэргийн яамд нь орон нутгийн гамшгийн удирдлагыг зохицуулдаг. Санхүүжилтийн тухайд <u>Төвлөрсөн болон төвлөрсөн бус санхүүжилт:</u> Германд гамшгийн удирдлагын санхүүжилт нь холбооны болон муж улсын төсвөөс хуваарилагддаг. Холбооны Засгийн газар нь үндэсний хэмжээний бодлого, судалгаа, сургалт, тоног төхөөрөмжийн хангалт зэрэгт хөрөнгө оруулалт хийдэг бол муж улсууд нь орон нутгийн түвшний хариу арга хэмжээ, аврах ажиллагаа зэрэгт санхүүжилт гаргадаг. <u>Тусгай сангууд (Sondervermögen):</u> Гамшгийн үед шуурхай санхүүжилт хийх зорилгоор тусгай сангуудыг байгуулдаг. Эдгээр сангууд нь холбооны төсвөөс тусдаа байж, тодорхой зорилгоор ашиглагддаг.
Бүгд Найрамдах Турк Улс Law No. 5902 on the Establishment and Duties of the Disaster and Emergency Management Authority	23 дугаар зүйл – Санхүүгийн зохицуулалт 1. Энэхүү хуулийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулж, Ерөнхий газрын (AFAD-ын) төсөвт гамшиг болон онцгой байдлын үйл ажиллагааны зардлыг тусгайлан заана. Ерөнхий газрын төсөвт зардал болгон бүртгэж, тусгай дансанд шилжүүлэн зарцуулах боломжтой бөгөөд шаардлагатай тохиолдолд, Ерөнхий газрын шийдвэрээр төрийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагын данс руу мөнгө шилжүүлж болно. Мөн төрийн байгууллага, орон нутгийн захиргаанууд ч дээрх зорилгоор Ерөнхий газрын данс руу мөнгө шилжүүлж болно. Ийнхүү шилжүүлсэн хөрөнгийг тухайн байгууллагуудын төсөвт орлого болгон бүртгэхгүй бөгөөд тусгай дансанд хяналт тавьж ашиглана. Гамшиг болон онцгой байдал үүссэн үед гарсан хэрэгцээг хангах зорилгоор тусгай данснаас хийх зарцуулалтыг 5018 дугаар “Төрийн санхүүгийн удирдлага, хяналтын тухай хууль”, 4734 дугаар “Төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль”-д хамааруулахгүй. Шилжүүлсэн хөрөнгийг зарцуулах, бүртгэх, шалгах, худалдан авалтад ямар аргаар тендер шалгаруулах талаар Сангийн яам болон Ерөнхий газар хамтран журам тогтооно. 2. Ерөнхий төсвийн байгууллагуудын гамшиг ба онцгой байдлын удирдлагатай холбоотойгоор улсын төсвөөс хийх хөрөнгө оруулалтыг Ерөнхий газар хянаж, уялдуулна. Тусгай төсөвтэй байгууллага болон орон нутгийн захиргаа нь гамшиг, онцгой байдлын үед ашиглах зорилгоор тодорхой хэмжээний зардлыг өөрийн

	төсөвтөө тусгаж болно. 3. Ерөнхий газар нь хуульд заасан үүрэг биелүүлэх явцад үйлчилгээ худалдан авэх эрхтэй.
--	---

Дээрх улс орнуудын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн хэсэгтэй холбогдох зохицуулалтыг харьцуулан дүгнэе.

Солонгос Улс: Санхүүжилтийн хувьд тодорхой хувь хэмжээ заагаагүй, харин салбарын сайд, стратеги, санхүүгийн сайдын хамтын зөвшилцлөөр гамшгийн удирдлагын дунд хугацааны төсөл, төсвийн төлөвлөгөөг жил бүр тодорхой хугацаанд хүлээлгэн өгөх, төлөвлөгөөг үндэслэн төсвийн төслийг гаргах зохицуулалттай байна. Үүнээс гадна гамшгийн төсөл, хөрөнгө оруулалтын давхцал ба үр ашигт шинжилгээ хийж, Засгийн газарт санал хүргэдэг байна.

Япон Улс: Санхүүжилтийн хувьд тодорхой хувь хэмжээ заагаагүй ба орон нутгийн засаг захиргааны удирдлагууд гамшгийн үед гарсан зардлыг хариуцаж, бусад орон нутгаас тусламж авсан бол үүний зардлыг эргүүлэн төлөх зохицуулалттай. Түүнчлэн Засгийн газар гамшгийн урьдчилан сэргийлэх, яаралтай арга хэмжээ болон сэргээн босголтын зардлыг төсвийн хязгаартайгаар тодорхой хувь хэмжээгээр санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх боломжтой.

Герман Улс: Гамшиг, онцгой байдлын үед орон нутгийн болон холбооны засаг захиргаа өөрийн үүрэгтээ тохирох санхүүжилтийг хийдэг. Гамшгийн хариу арга хэмжээний зардлыг холбогдох засаг захиргаа хариуцаж, тодорхой хувиар төрийн сангаас дэмжлэг авах боломжтой зохицуулалттай. Гамшгийн үед шуурхай санхүүжилт хийх зорилгоор тусгай сангуудыг байгуулдаг.

Турк улс: Төсвийн хөрөнгө тусгай дансанд төвлөрүүлж, зарцуулах журам, шилжүүлэг болон зарцуулалтын хариуцлагыг зохицуулсан байдаг. Харин төсвийн хувь хэмжээ, хөрөнгө оруулалтын тодорхой хэмжээ, хувь эсвэл квотыг тусгайлан зааж өгдөггүй.

Монгол Улс гамшгийн эрсдэлийг бууруулах төсвийн тодорхой хувь хэмжээг хуульчилсан, ингэснээр орон нутгийн түвшинд санхүүжилт үргэлж тодорхой хэмжээгээр баталгаатай хийгдэх суурь бий болгосон байна. Судалсан улсуудын хувьд төсөв батлах, хөрөнгө хуваарилахдаа хувь хэмжээг заадаггүй, харин төсөл төлөвлөгөө, хамтын удирдлагаар уян хатан зохицуулалт хийдэг байна. Япон улс орон нутгийн түвшинд хамтын санхүүжилтийн зохицуулалттай. Герман улс нь төсвийн хувьд орон нутгийн болон холбооны засаг захиргааны үүрэг, хариуцлагыг нарийвчлан хуульчилсан бөгөөд зарим хувийг төрийн сангаас дэмждэг зохицуулалттай байна.

Санхүүжилттэй холбоотой практикт тулгарч байгаа зарим асуудлыг асуумжийн судалгааны явцад тогтоосон ба үүнээс дурдвал:

Шигтгээ.4

Хуульд тухайн жилийн төсвийн 1.0 хувийг гамшгийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулна гэж заасан боловч бодит байдалд төрийн байгууллагын төсвийн системд уг төсвийг суулгах, зарцуулах ангилал байдаггүй. Төсөв суулгах санал явуулдаг ч батлагдаж ирдэггүй.

Шигтгээ.5

Хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгана гэж заасан. Ихэнх аймаг, сумын хувьд төсвийнхөө 1.0 хувиар төсөвт суулгадаг ч энэ нь хангалттай хэмжээний төсөв байж чаддаггүй. Төсөв дутдаг, хүрэлцдэггүй байдал нэлээд их гардаг.

Онцгой байдлын алба хаагч

Гамшгаас хамгаалах зардлыг, төрийн байгууллагуудын төсвийн 1.0% ба түүнээс дээш, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5%-аас дээш гэж тогтмол хувь хэмжээ заах нь санхүүгийн боломж муутай жижиг дунд, үйлдвэрлэл эрхлэгч байгууллага, гамшгийн эрсдэл багатай салбаруудад хүндрэл учруулж, үр дүнгүй зарцуулалт үүсгэх эрсдэлтэй байж болох юм. Түүнчлэн хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд жил бүр төсөв төлөвлөж, түүнийг зарцуулах шаардлага тавигддаг нь бодит нөхцөлд хэрэгждэг эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, хуулийн уг заалтын хэрэгжилтийг үнэлэх суурь нөхцөл тодорхойгүй ба хувийн хэвшлийн хувьд хэрэгжилтийг хянах механизм байхгүй юм.

Төрийн байгууллагуудын хувьд жил бүрийн санхүүжилт нь гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд зарцуулах зорилгод нийцэн зарцуулагдаж байгаа эсэхэд бодит хяналт, үнэлгээ сул байна. Үүнийг үр ашигтай зарцуулах, нэгдсэн үнэлгээ, хяналтын тогтолцоо бүрдээгүй гэж үзлээ.

Гамшгийн эрсдэл нь бүс нутаг, салбар бүрт өөр түвшинд байдаг боловч хуульд энэ ялгамжтай байдлыг харгалзан үзэх боломжгүй. Газар хөдлөлтөд өндөр эрсдэлтэй бүс нутаг болон эрсдэл багатай бүс нутгууд ижил хувь хэмжээг хариуцах заалт нь **нөөцийн оновчгүй хуваарилалт** үүсгэх магадлалтай. БНСУ, Япон улсын адил санхүүгийн эрэмбэлсэн төлөвлөлт дутмаг байгааг анхаарч, гадаад орнуудын сайн жишгийг судалж нэвтрүүлэх боломжтой.

Монгол Улс гамшгийн эрсдэлийг бууруулах зардлыг хуульчилж тодорхойлсон бөгөөд хувь хэмжээний тогтолцоо нэвтрүүлсэн нь сайн жишиг боловч түүнийг хэрэгжүүлэх уян хатан байдал, эрсдэлийн ялгамжтай үнэлгээ, хяналт-шинжилгээний систем, цогц шинэчлэл шаардлагатай хэвээр байна. БНСУ, Япон зэрэг орны жишгээр уян хатан төлөвлөлт, салбар дундын зохицуулалт, хөрөнгө оруулалтын үр ашигт суурилсан хандлага нэвтрүүлэх шаардлагатай.

Алба хаагчдаас өгсөн саналын тухайд, ГХтХ-ийн 51 дүгээр зүйлд “Энэ хуулийн 51.2-т заасан хөрөнгийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулсан хуулийн этгээдийг татвараас чөлөөлнө” гэсэн заалт нэмэх байдлаар урамшууллын механизм ашиглах¹⁴⁰, гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр төлбөртэй гүйцэтгэх зарим ажил үйлчилгээний жагсаалтыг хуульчлах (аж ахуйн нэгж байгууллагад зохион

¹⁴⁰ Үндэсний аврах бригадийн санал.

байгуулах гамшгаас хамгаалах сургалт; лабораторийн зарим туршилт шинжилгээ, үйлчилгээ г.м), ОББ-ын техник хэрэгсэл, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг хувь хүний болон хуулийн этгээдийн илт буруутай үйлдлээс шалтгаалан ашигласан тохиолдолд тухайн үйл ажиллагаанд зарцуулагдсан машин тоног төхөөрөмжийн ашиглалт, хэмжилт, туршилт хийсэн нарийн мэдрэмжит багаж, бодис урвалжийн төлбөрийг төлүүлэх зэрэг хэлбэрээр гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлэх хувилбарыг хуульд тусгах санал тус тус дэвшүүлсэн байгааг нягталж шийдвэрлэх нь зүйтэй.

Бүлгийн дүгнэлт, санал

Судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан дүгнэлт, саналыг тус тайлангийн Дүгнэлт, санал, зөвлөмж бүлэгт нэгтгэн байршууллаа.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

4.1.Дүгнэлт, санал

Монгол Улс төрийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим, иргэнийхээ өмнө хариуцах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүн төрөлхтний соёл иргэншлийн ололт, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим, арга механизмыг өргөн ашиглаж байна. Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу, Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоо сайжирч иржээ.

Энэхүү судалгаагаар, 2017 онд батлагдсан, өдгөө 8 дахь жилдээ хэрэгжиж байгаа Гамшгаас хамгаалах тухай хууль/Шинэчилсэн найруулга/-ийн нэр томьёоны тодорхойлолт, гамшгийн өмнөх үйл ажиллагаа, гамшгийн үеийн үйл ажиллагаа, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, хариуцлага, гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж, онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт гэсэн суурь асуудлыг хөндөж, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв.

Ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу ЗГ-ын 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал”, “Бусад үр дагавар” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон, асуудал бүрт тохиромжтой шалгуур үзүүлэлтийн томьёолол боловсруулсны үндсэн дээр судалж, үнэлгээ хийсэн.

Монгол Улсын төрийн бодлого, эрх зүйн шинэтгэлийн нөлөөгөөр гамшгаас хамгаалах эрх зүйн орчин сайжирч, хэрэгжилтийг хангах тал дээр хүчин чармайлт гаргасны үндсэн дээр ахиц дэвшил нэлээд гарсан байна. Гамшгаас хамгаалах үндэсний механизмын байгууллагууд, түүний дотор онцгой байдлын байгууллага, түүний алба хаагч нар Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим, хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагаа, чиг үүргийг хэрэгжүүлж байна.

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулах; Геополитикийн тогтворгүй байдал, цар тахлын үеийн болон түүний дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логистикийн доголдол, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал, дэвшилтэт технологийн хурдацтай шилжилтийн тодорхой бус байдал, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл болон бусад эрсдэлийг даван туулах, хариу бэлтгэл арга хэмжээг шуурхай авах зорилгоор холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангасан эрсдэлийн удирдлагын цогц бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх зэрэг цогц стратегийн үзэл баримтлал тусгасан нь гамшгаас хамгаалах үндэсний тогтолцоонд

тавигдаж буй сорилт, даван туулах арга зам, холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага, үндэслэл болно.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судалсан үр дүн, үнэлгээнд тулгуурлан дүгнэлт, санал боловсруулж, тайлангийн Үнэлэх үе шат бүлгийн дэд бүлэг бүрээр танилцуулъя.

ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ТУХАЙД

Төрийн бодлого зорилго, зорилтдоо хүрэх, үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэх учир нэр томьёог хуульд тусгайлан тайлбарладаг.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэр томьёог шинжлэх ухааны үндэстэй оноон тодорхойлох, тайлбар хийх, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх, хэл зүй, найруулгын нийтлэг шаардлага хангах зарчмыг баримталсан байна.

Гэвч “гамшиг”, “аюулт үзэгдэл”, “аюул” зэрэг үндсэн нэр томьёоны тодорхойлолт олон улсын баримт бичиг, стандартад зарим талаар нийцээгүй, өөр утга илэрхийлэхээс гадна аюулт үзэгдэл, аюултай үзэгдэл, гамшигт үзэгдэл, гэнэтийн аюул, осол зэрэг нэр томьёо ангилал, агуулгын хувьд бусад хуульд жигдрээгүй, өөр өөр агуулга тусгасан, нэгэн төрлийн ойлголт боловч Гамшгаас хамгаалах тухай хуулиар тодорхойлоогүй шинэ нэр томьёо хэрэглэсэн зэрэг зөрчил байна. Тухайлбал, олон улсад “байгалийн гамшиг” гэж нэрлэх нь бодит байдалд хариуцлага хүлээхээс зайлсхийж буй хэрэг гэж үзэн тухайн ойлголтыг үгүйсгэх, халах хандлага нэмэгдэж байгааг харгалзан нэр томьёог оновчтой тодорхойлох шаардлагатай.

Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоонд оролцогч талуудыг ГХТХ-ийн Нэр томьёоны тодорхойлолт хэсэгт тусгасан ч гамшгийн эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой субъект болох гамшгийн алба, хүмүүнлэгийн баг, штаб, бүлэг зэрэг бүтцийн талаар тусгаагүй нь оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд ойлгомжгүй байдал үүсгэжээ.

Анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед болон энгийн үед иргэдийн хайхрамжгүй байдлаас үүдэн гарсан дуудлага, мэдээлэл нь гамшгаас хамгаалах тогтолцоонд ачаалал үүсгэж, хариу арга хэмжээний үндсэн чиг үүргээс хазайх, санхүүгийн үр ашиггүй байдлыг нэмэгдүүлэх зэрэг хүндрэл, бэрхшээл, эрсдэл дагуулж болзошгүй тул эрх зүйн арга хэрэгслээр зохицуулах шаардлагатай.

Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэлтэй холбоотой зарим нэр томьёог тодорхойлохгүйгээр хуульд тусгаж, гамшгийн үеийн дайчилгаанд хамрагдах этгээдийг хууль, журамд ялгаатай байдлаар заасан нь практик хэрэглээнд асуудал үүсгэж байгааг цэгцэлж, нийцэл, уялдаа холбоог хангах нь зүйтэй.

Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид хувийн өмч, хүч хэрэгслийг дайчлан гаргах шаардлагатай тохиолдолд зөвхөн нөхөн олговортойгоор дайчлах зарчмыг тусгасан. Гэсэн ч Гамшгаас хамгаалах тухай хуульд дайчилгаанд оролцсон иргэн, хуулийн этгээдийн эрхийг үүнд нийцүүлж тусгаагүй байна. Түүнчлэн Засгийн газрын “Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журам”-д тухайн журмаар зохицуулах шаардлагатай субъект болох хуулийн этгээдийн бүрдүүлэх баримт бичиг болон нөхөн төлбөр гаргуулах процессын талаар зохицуулалт байхгүй. Мөн иргэнээс гарсан зардлыг хэрхэн нөхөн төлөх процесс тодорхойгүй, үүнтэй холбоотой журам батлагдаагүй байгааг шийдвэрлэх хэрэгтэй.

Дайчилгааны тухай хуулийн зохицуулах харилцаа нь гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах зохицуулалтаас өөр бөгөөд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хууль тогтоомжид дайчилгааны тухай хууль багтаагүй байхад Зөрчлийн тухай хуульд дайчилгааны тухай хууль тогтоомж зөрчих буюу хүч хэрэгсэл дайчлах зохицуулалтыг тусгасан нь оновчгүй. Үүнийг залруулж, хууль тогтоомж хоорондын нийцлийг бүрдүүлж боловсронгуй болгох шаардлагатай.

ГХтХ-д заасан гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, мэргэжлийн ангийг байгуулах зэрэг заалт бүхий л хуулийн этгээд буюу Иргэний хуульд заасан ашгийн болон ашгийн төлөө бус этгээдийг хамруулж байгаа нь зарим хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг, цөөн тооны хүнтэй хуулийн этгээдийн хувьд хэрэгжих боломжгүйн зэрэгцээ ОББ-аас тавих хяналт, хариуцлагын тогтолцоог сулруулах эрсдлийг бий болгожээ. Мөн “мэргэжлийн анги” гэсэн нэр томъёог онцгой байдлын байгууллагын мэргэжилтнүүд, салбар нэгж гэж ойлгох хандлага ажиглагдаж байх тул тухайн оролцогчийн нэршлийг өөрчилж, оновчтой тодорхойлох хэрэгтэй.

Түүнчлэн, ГХтХ-ийн 22.8 дахь хэсэг, 4.1.17 дахь заалтад мэргэжлийн анги байгуулах засаг захиргааны нэгжийг өөрөөр зааж зөрчил үүсгэсэн байх тул аймаг, нийслэлийг хамруулах, оновчтой тодорхойлох хэрэгцээ, шаардлага бий гэж үзэв. Дээр дурдсан байдал, буруу ойлголтоор дамжин сөрөг үр дагаврууд үүсэж, тухайлбал “Мэргэжлийн ангийн дүрэм” зэрэг бусад эрх зүйн баримт бичиг хэрэгжихгүй байх шалтгаан, нөхцөл болж байгааг анхаарч шийдвэрлэх нь зүйтэй.

Санал:

1. Гамшиг, аюул, осол, аюулт үзэгдэл зэрэг ойлголтыг бусад хуульд ГХтХ-д зааснаас өөрөөр хуульчилсан тохиолдлууд байгаа тул тэдгээрийг нэгтгэж, ГХтХ-д заасантай нийцүүлэх шаардлагатай. Мөн гамшиг, аюул, аюулт үзэгдэл, гамшигт үзэгдэл, бэлэн байдал болон тэдгээрт хамаарах шинээр гарч ирж буй ангилал, нэр томъёог анхаарч, хуульд заасан нэр томъёог олон улсын баримт бичигт нийцүүлэх, шаардлагатай нэр томъёог хуульд нэмж тусгах нь зүйтэй.
2. Гамшгаас хамгаалах алба, штаб, бүлэг, баг зэрэг бүтцийн нэгжийн үйл ажиллагаа, ойлголтыг хуулийн холбогдох хэсэгт тодорхой тусгах саналтай

байна. Энэ нь ОББ-ын алба хаагч төдийгүй иргэд, олон нийт хууль тогтоомжийг ойлгох, биелүүлэх байдлыг нэмэгдүүлнэ.

3. Хуулийн 30.1.1-д зааснаар ОБЕГ-ын дарга тус байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох ёстой ч ийм төрлийн баримт бичиг байхгүй бөгөөд МУ-ын Шадар сайдын баталсан Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах журмаар тодорхойлж байх тул уг зөрчлийг арилгаж, зохистой хэлбэрийг сонгож шийдвэрлэх, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгах нь зүйтэй.
4. Анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед болон энгийн үед иргэдийн хайхрамжгүй байдлаас үүдэн гарсан дуудлага, мэдээлэл дэх ОББ-д хамаарахгүй дуудлагын хариу арга хэмжээг тухайн иргэн бүрэн эсхүл тодорхой хувийг нь хариуцахаар, эсвэл тэдгээр дуудлагыг бусад/хувийн байгууллагуудад үлдээх, даатгалаар зохицуулах зэрэг хувилбараас сонгох замаар төрийн байууллагаас гарах зардлыг бууруулах нь зүйтэй.
5. ГХтХ-ийн “нэмэлт хүч хэрэгсэл” гэсэн нэр томъёог тодорхойлж ойлгомжтой болгох шаардлагатай. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг гаргахтай холбоотой харилцааг хууль, журамд өөр өөрөөр зохицуулсан байгааг залруулж нийцэл, уялдаа холбоог хангах шаардлагатай.
6. Үндсэн хууль болон бусад хуульд заасан, дайчилгаанд оролцуулсан бол нөхөн олговор олгох зарчмыг тусгаж, хуулийн этгээд, иргэн зэрэг дайчилгаанд хүч хэрэгслээ дайчлуулсан этгээдэд нөхөн олговор авах эрхийг ГХтХ-д хуульчлан баталгаажуулах, улмаар нөхөн олговор олголтыг процессжуулсан журам баталж хэрэгжүүлэх хэрэгтэй.
7. Зөрчлийн тухай хууль дахь дайчилгааны тухай хууль зөрчих зохицуулалт нь Дайчилгааны тухай хуулиар зохицуулсан харилцаа биш байх тул ГХтХ-ийн холбогдох зохицуулалттай уялдуулах шаардлагатай.
8. Нэр томъёоны хувьд эргэлзээтэй байдлыг бий болгож байгаа хэм хэмжээ хоорондын зөрчилдөөнийг арилгах нь зүйтэй.

Дээр дурдсанаас гадна судалгааны тайлангийн бусад бүлгийн судалгаанд холбогдох хэсгийн нэр томъёог мөн хамруулж судалсан тул холбогдох саналыг тухайн хэсгүүдээс үзнэ үү.

ГАМШГИЙН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙД

ГХтХ-д гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн эрсдэлийг үнэлэх, гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийг үнэлэх, гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх ГХтХ-д гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, бэлэн байдлын зэрэгт болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэх зэрэг гамшгийн өмнөх үйл ажиллагаатай холбоотой харилцааг тусган хэрэгжүүлж байна. Эдгээр зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах, сайжруулах чиглэлээр анхаарах асуудал нэлээд байна.

ГХтХ-д гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах байгууллага, албан тушаалтныг сургалтын ангиллаас хамаарахгүй тусгасан нь сургалтыг ангилах зорилт, ач холбогдлыг бууруулж байна. Нэг гишүүнтэй хуулийн этгээд зэрэг сургалт хүлээн авагч байгууллагын онцлогийг харгалзах байдлаар зохицуулалтыг уян хатан байдлаар боловсронгуй болгох шаардлагатай. Гамшгаас хамгаалах сургалттай холбоотойгоор оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалтын зохицуулалт хэвээр байгаа ч зохион байгуулах байгууллага, албан тушаалтантай холбоотой зохицуулалтыг хүчингүй болгосноор хууль хоорондын уялдаа холбоо алдагдаж, тухайн зохицуулалт практикт хэрэгжихгүй байх шалтгаан болжээ.

Эдгээр нөхцөл байдал нь гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахтай холбоотой зохицуулалт зорилгодоо бүрэн хүрч чадахгүй байна гэж дүгнэхэд хүргэж байна. Сургалтын арга хэмжээ нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой ач холбогдолтой учир холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах хувилбарыг тусгах, сургалт явуулах хүний нөөц, сургалтын хүртээмж, чанарыг сайжруулах зэрэг асуудлыг цогцоор нь авч үзэх шаардлагатай гэж үзэж байна.

ГХтХ-д зааснаар гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгосон байгууллага тухайн эрсдэлийн үнэлгээний тайлан, гүйцэтгэлд хяналт тавьж байгаа нь ил тод байдал, хариуцлагын хүрээнд сөрөг үр дагавар бий болгож болзошгүй юм. Түүнчлэн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх зардал харилцан адилгүй байхын зэрэгцээ тухайн үнэлгээг хийлгэхэд хуулийн этгээдээс гарах зардлын хэмжээ хэт өндөр байгаагийн улмаас хуулийн этгээд нь эрсдэлийн үнэлгээ хийлгэх бус ЗтХ-д заасны дагуу торгууль төлөх сонголт хийхэд хүргэж, улмаар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, хийлгэхтэй холбогдох зохицуулалт хэрэгжих боломжгүй, үр нөлөөгүй байдалд оржээ.

Галын аюулгүй байдлын тухай хуульд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн бүрэн эрхийг хуульчилсан ч гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх, үүргийг ГХтХ-д тусгаагүй байгаа нь эрх зүйн хийдлийг үүсгэж байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байна. Тухайлбал, цөөн гишүүнтэй, цахимаар үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх заавал шаардлагатай эсэх, цөөн гишүүнтэй ч үйл ажиллагаагаа тодорхой байршилд явуулдаг бол гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх шаардлагатай гэх мэт онцлог байдалд тохирсон, уян хатан зохицуулалт хийх нь зүйтэй.

Бэлэн байдлын зэргийг ангилан үзэх боловч хуульд заасан үндэслэл тогтоогдоогүй, зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, иргэдэд сэтгэл зүйн хувьд үл тоох хэв шинжийг бий болгож байгаа практикийг өөрчилж, бэлэн байдлын зэрэгт шилжсэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх иргэдийн мэдлэг, үүрэг

оролцоог сайжруулах, ач холбогдлыг ойлгуулах, үүрэг хариуцлагыг ухамсарлуулахад чиглэсэн хууль хэрэглээний асуудлыг анхаарах шаардлагатай.

ГАМШГИЙН ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙД

ГХтХ-ийн Гуравдугаар бүлэгт заасан гамшгийн үеийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтууд ерөнхий байдлаар хуульчлагдсан бөгөөд захиргааны хэм хэмжээний актаар нарийвчлан зохицуулсан байдлыг нягталж, зайлшгүй хуулиар тодорхойлох асуудлыг суурь хуульд тусгах, хууль тогтоомжийн өөрчлөлтийг тусгаагүй журмыг боловсронгуй болгох, шаардлагатай бол хүчингүй болгох, хуульчлах зэрэг арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Гамшгийн үеийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтууд зорилгодоо хүрч байгаа боловч ихэвчлэн хуулиар бус, журмаар зохицуулагдаж байгаа нь эрх зүйн эрэмбэ, хууль хэрэглээний тогтвортой байдал, хэрэгжилтийн найдвартай, баталгаат байдалд сөрөг нөлөөлөл бий болгох эрсдэлтэй юм.

ГХтХ-аар эрх олгосны дагуу баталсан захиргааны хэм хэмжээний актуудад хүчингүй болсон, хэдийн өөрчлөлт орсон хууль тогтоомжийн хэм хэмжээ агуулагдаж, өдий хүртэл мөрдөгдөж байгаа зөрчил, эрх зүйн эрэмбэ алдагдсан тохиолдол цөөнгүй байна. Хууль тогтоомжид нэг нэр томьёог өөр өөрөөр тусгасан, хууль зүйн техникийн хувьд алдаатай бичвэр цөөнгүй байгаа нь хууль зүйн нэр томьёо, хууль хоорондын уялдаа холбоо, ойлгомжтой байдлыг алдагдуулж байна. Түүнчлэн зарим харилцааг хуульд хэт ерөнхий тусгасантай холбоотой, эсвэл эрх олгоогүй асуудлыг журмаар нарийвчлан зохицуулж байгааг тухайлан судалж, боловсронгуй болгох нь зүйтэй.

Санал:

1. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгож буй байгууллага нь тухайн төрлийн үнэлгээний гүйцэтгэл, тайланд хяналт тавьж байгааг өөрчлөх нь зүйтэй.
2. ГХтХ-ийн зарим зохицуулалтад тусгасан нэр томьёоны тодорхойлолтыг тус хуулийн 4 дүгээр зүйлд заасан “Хуулийн нэр томьёоны тодорхойлолт” хэсэгт байршуулах нь тохиромжтой.
3. Хуульд заасан үндэслэл тогтоогдсон, зайлшгүй шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, шилжсэн тохиолдолд иргэдийн мэдлэг, оролцоог сайжруулахад анхаарах, ач холбогдлыг ойлгуулж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ тогтмол авах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг сайжруулах бололцоотой.
4. Гамшгаас хамгаалах хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд гамшгаас хамгаалах улсын байцаагчийн үйл ажиллагаа, чиг үүргийн онцлогийг харгалзан гамшгаас хамгаалах улсын

хяналтын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлж хуульд тусгах, орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

5. Гамшгаас хамгаалах сургалттай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй.
6. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн тухайн объектод үнэлгээ хийх (объектын хэмжээ, онцлог шинж чанарыг харгалзан ялгаатай байдлаар тогтоох) ажиллагаанд шаардагдах зардлын үнийн хязгаарлалтыг тогтоох зэргээр боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.
7. Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд аж ахуйн нэгж байгууллагад зохион байгуулах гамшгаас хамгаалах сургалт, лабораторийн зарим туршилт шинжилгээ, үйлчилгээ, ОББ-ын техник хэрэгсэл, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг хувь хүний болон хуулийн этгээдийн илт буруутай үйлдлээс шалтгаалан ашигласан тохиолдолд тухайн үйл ажиллагаанд зарцуулагдсан машин тоног төхөөрөмжийн ашиглалт, хэмжилт туршилт хийсэн нарийн мэдрэмжит багаж, бодис урвалжийн төлбөрийг төлүүлэх зэрэг төлбөртэй гүйцэтгэх зарим ажил үйлчилгээний жагсаалтыг хуульчлах.
8. Хууль зүйн техник, хууль хоорондын уялдаа холбоо, ойлгомжтой байдлын хангах, хууль зүйн нэр томъёог нэг мөр болгох, эрх зүйн хийдлийг арилгахын тулд тус хуульд заасан зарим нэр томъёог өөрчлөх, нэр томъёог нэг мөр болгох, хуулиар эрх олгогдсоны дагуу батлагдсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хуульд нийцүүлэх, бусад хууль тогтоомжийн дагуу хүчингүй болсон, өөрчлөлт орсон зохицуулалтыг судалж, хууль тогтоомж хоорондын нийцлийг хангах, шаардлагатай тохиолдолд шинээр батлах нь зүйтэй.

ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙД

ГХТХ-ийн V бүлэгт гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлагын талаар, хуулийн VI бүлэгт гамшгаас хамгаалах удирдлагын бүрэн эрхийн талаар зохицуулжээ. Эдгээр бүлэгт хамаарах зүйл, хэсэг, заалтууд хоорондоо шууд хамааралтай байх тул хэрэгжилтийн үр дагаврыг нэгтгэн дүгнэвэл:

Удирдлагын давхардалтай бүтцийн тухай. Онцгой комисс, Засгийн газар, ОББ, Шуурхай штаб, Шадар сайд зэрэг хэд хэдэн байгууллага, албан тушаалтанд “удирдан зохион байгуулах”, “удирдан чиглүүлэх” эрх хуваарилагдаж, чиг үүрэг давхацсан, удирдлагын уялдаа холбоо алдагдсан байдал ажиглагдсан. Жишээ нь, хуулийн 22.3, 23.1, 28.1.1, 42.1 зэрэг хэм хэмжээгээр удирдлагын түвшний үүргийг давхардуулан тогтоосон байна. Түүнчлэн гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед нэгдсэн удирдлагаар хангах чиг үүргийг КОВИД-19 цар тахлын үед УОК-т өгснөөр Засгийн газрын эрх хэмжээг тодорхой бус болгож, Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, зарчим болоод Монгол Улсын Засгийн газрын тухай

хуулийн зарчмыг хөндсөн шинжтэй байна. КОВИД-19 цар тахлын үед УОК-ын бүтэц, бүрэлдэхүүн 3 удаа өөрчлөгдсөн нь тогтвортой, нэгдмэл удирдлагагүй байгааг илтгэв. Энэ нь мэргэжлийн байгууллагын онцлог, хариуцлагын уялдааг алдагдуулж, хүний эрх зөрчигдөх нөхцөл бий болгосныг нотлон харуулж байна.

Эрх, үүргийн ялгаа тодорхой бус байдлын тухай. "Удирдан зохион байгуулах", "удирдан чиглүүлэх", "нэгдсэн удирдлагаар хангах" зэрэг нэр томъёо хуульд олонтаа давтагдсан ч тэдгээрийн ялгаа, хүрээ, хэрэгжих нөхцөл тодорхой бус байна. Ийм тодорхойгүй байдал нь практикт зөрчилдөөн үүсгэх, хариуцлагын механизмыг сулруулах эрсдэлтэй. Мөн мэргэжлийн анги, шуурхай бүлэг зэрэг нэгжийн эрх зүйн статус, чиг үүргийг шилжсэн нь эрх зүйн тодорхой бус байдалд хүргэж байна.

Захиргааны актуудын хэт хамаарлын тухай. Гамшгийн удирдлагын нэлээд олон заалтыг хэрэгжүүлэх харилцаа зөвхөн журмаар зохицуулагдаж байгаа нь эрх зүйн хязгааргүй, тогтворгүй орчин бий болгож байна. Хуулийн 25 гаруй заалттай уялдсан 30 гаруй журам тусгайлан батлагдсан ч тэдгээр нь хоорондоо давхардалгүй, агуулгын хийдэлгүй, уялдаатай эсэхийг тогтоох, тодорхойлох шаардлагатай. Хуулийн заалтуудыг журмаар "тодруулах" бус, харин "тодорхойгүй байдлыг нөхөж буй" шинжтэй учир **тогтвортой, системтэй эрх зүйн орчин бүрдээгүй** байна. Үндсэн эрх зүйн харилцаа журмаар биш, хуулиар зохицуулагдах нь салбарын эрх зүйн тогтвортой байдлыг дэмжих тул үүнд чиглэсэн шинэчлэл хийх нь тохиромжтой юм.

Санал:

1. Удирдлагын төвлөрлийг оновчтой болгох

- "Онцгой комисс" ба "Засгийн газар"-ын **удирдлагын түвшний чиг үүргийг ялгаж**, зөвхөн Засгийн газар шийдвэр гаргах, УОК гүйцэтгэл хариуцах бүтэц бий болгох;
- "Удирдан чиглүүлэх" ба "удирдан зохион байгуулах" гэх мэт нэр томъёог **хуульд тодорхой тайлбартайгаар зааглах.**

2. Эрх, үүргийн уялдааг хангасан зохицуулалт хийх

- УОК, Шуурхай штаб, ОБЕГ, Шадар сайд зэрэг эрх бүхий этгээдийн чиг үүргийг **давхардалгүй, өөр хоорондоо хоршиж ажиллах байдлаар** хуваарилах;
- Орон нутгийн байгууллагуудад "өөрийн эрх хэмжээний хүрээнд" гэх **ерөнхий заалтаар** бус, тодорхой хүрээнд эрх олгож, үүрэг хүлээлгэх.

3. Хуульчилсан журмуудыг цэгцлэх

- Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 30 гаруй журамд **бүрэн дүн шинжилгээ хийх**, давхардсан, зөрчилтэй хэсгийг нэгтгэж цэгцлэх;
- Хэм хэмжээ тогтоосон актаас дараах шинжийг агуулсан актыг хуульд тусгах шаардлагатай гэж үзэж хуулиар зохицуулах. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, хориглосон болон ямар нэгэн байдлаар хөндсөн агуулга бүхий зохицуулалттай;

2. Тогтмол давтагдах процессын шинжтэй зохицуулалт агуулсан;
3. Нэг удаа батлахад удаан хугацаанд тогтвортой мөрдөгддөг хэм хэмжээ агуулсан.
4. **Мэргэжлийн нэгжүүдийн эрх зүйн байдлыг тодорхой болгох**
 - Шуурхай бүлэг, шуурхай штаб, мэргэжлийн ангиудын **эрх зүйн статус, чиг үүрэг, хариуцлагыг** хуулиар тодорхойлж, журмаар бус **хуулийн түвшинд зохицуулах нь** зүйтэй.
5. **Хүний эрхийн хамгаалалд суурилсан шийдвэр гаргалтыг баталгаажуулах**
 - Гамшгийн үед гарч буй шийдвэр бүрт хүний эрхийг зөрчихгүй байх **хуулийн хязгаар, шалгуур, үндэслэл бүхий заалт** оруулах.
 - Хуулиар тогтоосон арга хэмжээ, эрх олголт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэхийг урьдчилан дүгнэх **механизм** бий болгох.

ХУУЛИЙН ЭТГЭЭД, ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫН ТУХАЙД

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь олон талын оролцоо, түншлэлд суурилах механизмыг чухалчилж буй олон улсын чиг хандлагыг ГХтХ-д тусгасан байна. Зохицуулалтыг боловсронгуй болгох, үр нөлөөтэй хэрэгжих хувилбарыг тодорхойлох, оновчтой зохион байгуулах асуудал тулгарч байна.

ГХтХ-ийн хуулийн этгээдэд үүрэг болгосон зарим заалт нь ГХтХ-ийн зорилгод нийцэхгүй байгааг болон ЗтХ болон ЗШШтХ-ийн холбогдох хэм хэмжээтэй зөрчилтэй байгааг нийцүүлж уялдуулах, өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг хангах асуудлыг анхаарах шаардлагатай.

ГХтХ-д төрийн бус байгууллага болон гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг хэсгийг хамтад нь нэгтгэн зохицуулснаар эрх үүргийн зааг ялгааг багасгаж, ойлгомжгүй байдлыг бий болгосон тул хуулийн агуулга, хэлбэрийн шаардлагад нийцүүлж, бичиглэлийн техникийг сайжруулах нь зүйтэй.

Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журамд сайн дурын хэсгийн үйл ажиллагааг хүч хэрэгсэл дайчлан гаргахтай холбоотой эрх зүйн актын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байх бөгөөд шинээр баталсан “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-д тухайн харилцааг зохицуулаагүн улмаас сайн дурын хэсгийг гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлахад хэрхэн оролцуулах асуудал бүрхэг болжээ.

Иргэдийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохыг үүрэг болгохдоо урьдчилсан нөхцөлийг тусгалгүй нийтэд нь хамааруулсан нь практикт үр дүнтэй хэрэгжих боломжийг бууруулсан байна. Зарим журамд иргэн, аж ахуй нэгжийн зорчих эрх, өмчлөх эрх, сурч боловсрох, аж ахуй эрхлэх зэрэг олон талын эрхийг хөндөх зохицуулалтууд байж болзошгүй тул хуулиар доогуур эрэмбийн хэм хэмжээ тогтоосон актад тавигдах шалгуур, зохицуулалтыг анхаарч, хуулиар зохицуулагдах харилцааг журмаар зохицуулсан буюу хуулиас давсан журмыг бий болгосон эсэхийг нягталж, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалтыг журмаар биш хуулиар тухайлан зохицуулах зарчмыг баримтлах нь зүйтэй.

Мөн төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлөх зохицуулалт, хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хариуцлага хүлээлгэх тогтолцоо төрийн байгууллага, албан тушаалтны хувьд хангалттай хэрэгжихгүй байгаа бөгөөд энэ нь зохицуулалт дутмаг байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл ГХтХ нь зөвхөн иргэн, хуулийн этгээд бус, төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд хамаарах өргөн хүрээний агуулгатай хууль боловч хариуцлагын механизм хангалтгүй байгаагаас хууль бүрэн хэрэгжихэд асуудал үүсгэж байна гэж үзэх үндэстэй.

Санал:

1. Хуулийн этгээдийн бүрэлдэхүүний тоо болон ажиллах хэлбэрээс шалтгаалж хуулийн этгээд нэг бүр гамшгаас хамгаалах төлөвлөгөө ба мэргэжлийн ангитай байх боломжгүй тул холбогдох зохицуулалтуудыг практикт нийцүүлж өөрчлөх шаардлагатай.
2. ГХтХ-д хуулийн этгээд, иргэний эрх, үүргийг тодорхойлсон хэсэгт эрх, үүргийг зааглаж ялгамжтай зохицуулсан байх тул хуулийн бусад хэсэгтэй уялдуулах замаар эрх, үүргийн хэм хэмжээг салангид оруулах нь зүйтэй.
3. Холбогдох журмуудад сайн дурын хэсгийн хуулиар тодорхойлсон үүргийг тусгаагүй байх тул эдгээр үүргийг баталгаажуулан нэмж тусгах хэрэгтэй.
4. Иргэдэд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохыг үүрэг болгохдоо нийтлэг байдлаар хамааруулсан нь практикт үр дүнтэй хэрэгжих боломжийг багасгасан байх тул урьдчилсан нөхцөл буюу гипотез агуулсан хэм хэмжээгээр нарийвчлан зохицуулах нь үүргээ биелүүлээгүй иргэнд хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлнэ.
5. Хүч хэрэгсэл дайчлан гаргах журам, Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө зэрэг зарим хууль зүйн баримт бичигт үндсэн эрхийг хөндсөн, хуулиас давсан харилцааг зохицуулсан байж болзошгүй байгааг нягталж шийдвэрлэх шаардлагатай.
6. Иргэн, хуулийн этгээдийн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчилж гаргуулсан бол нөхөх олговор олгохоор тусгасан ч иргэн, хуулийн этгээдийн эрхтэй холбоотой хэм хэмжээнд тусгаагүй байх тул нөхөн олговор, төлбөр буцаан авах эрхийг хуульчилж тусгах нь зүйтэй.
7. Төрийн байгууллага, албан тушаалтанд үүргээ биелүүлээгүй бол хүлээлгэх хариуцлагын тогтолцоо сул байх тул ЗтХ, ЗШШтХ зэрэг холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага бий гэж үзэж байна.

ГАМШГААС ХАМГААЛАХ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН ТУХАЙД

ГХтХ-д гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламжийн харилцааг дотоод ба гадаад хэмээн ангилж тусгасан нь оновчтой юм.

Харин зохицуулалтын хувьд зарим хэм хэмжээ ойлгомжгүйн зэрэгцээ хууль зүйн техникийн хувьд агуулгын зохион байгуулалт, дараалал алдагдсан, бичвэрийн шаардлага хангахгүй зэрэг ХТХ-д заасан хууль тогтоомжийн төслийн агуулга, хэлбэрийн болон хэл, найруулга зүйн шаардлагад нийцээгүй тал нэлээд байна. Тус хуулийн бүлэгт бүрэн эрх олгосон зохицуулалт давхардаж, зарим зохицуулалт салаа утгатай, хууль болон журамд өөр өөр нэр томьёо хэрэглэсэн зэрэг жишээг нягталж боловсронгуй болгох шаардлагатай.

Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжтай холбоотой харилцааг журам гарган дэлгэрэнгүй зохицуулсан хэдий ч олон улсын хүмүүнлэгийн тусламжийн багт холбогдох харилцааны зохицуулалт хангалтгүй, хэрэгжилт тун тааруу байна.

Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах асуудлыг Засгийн газрын тогтоолын хавсралтаар буюу доогуур эрэмбийн эрх зүйн актаар шийдэж байгаа нь олон улсын байгууллага болон гадаад улсын байгууллага, бусад этгээдтэй холбогдох онцлог харилцаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлах, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ сахин биелүүлэх баталгааг алдагдуулах болон хуулиар зохицуулах зарчмыг хөндсөн зэрэг эрх зүйн асуудал үүсгэсэн байна.

Санал:

1. Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэхтэй холбоотой зохицуулалтууд болох ГХТХ-ийн 39, 40 дүгээр зүйл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай байх тул бүтцийн хувьд өөрчлөлт оруулбал тохиромжтой.
2. ГХТХ-ийн 39.2, 40.7 дахь хэсэг хоорондоо давхардсан байх тул агуулгыг нэгтгэж тусгах нь зүйтэй.
3. Хоёрдмол, салаа утгатай үг хэллэг бүхий зохицуулалтын томьёоллыг залруулж ойлгоход хялбар, товч, тодорхой болгох, ГХТХ болон холбогдох журамд өөр өөр нэр томьёо хэрэглэснийг жигдлэх шаардлагатай.
4. Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөнд заасан төрийн байгууллагын болон олон улсын байгууллагын нэршлийг хэл зүйн дүрэм, ХТХ-д заасан бичвэрийн шаардлагыг хангах байдлаар засаж сайжруулах нь зүйтэй.
5. Хуульчлан зохицуулах шаардлагатай олон улсын хүмүүнлэгийн тусламжтай холбоотой харилцааг журмаар шийдвэрлэж байгааг өөрчилж, ГХТХ-д тусгах шаардлагатай.

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙД

Монгол Улс төрийн үйл ажиллагаандаа баримтлах үндсэн зарчим, Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу, иргэнийхээ өмнө хариуцах чиг үүргийн нэг болгож гамшгаас хамгаалах тогтолцоог онцгой анхаарч байна. Үүний нэг чиглэл нь онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдлыг оновчтой тодорхойлох, гамшгаас хамгаалах ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, үр нөлөөг сайжруулах, бэхжүүлэхэд оршдог.

ГХтХ-ийн 9 дүгээр бүлгийн хэрэгжилтийн үр дагаврыг судалж дараах хоёр хүрээнд дүгнэлт хийж, санал дэвшүүлэв.

Агуулга, хэм хэмжээний цар хүрээг харгалзан тус дэд бүлгийн дүгнэлт, саналыг “Онцгой байдлын байгууллагын эрх зүйн байдал”, “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал” гэж хоёр хуваан багцалж танилцуулъя.

Онцгой байдлын байгууллагын эрх зүйн байдлын тухайд

Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага байх харилцаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, ГХтХ болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдсан олон талт асуудлыг хамарч байна. Үүнийг төрийн бодлогын түвшинд анхаарч, эрх зүйн орчинг сайжруулах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж иржээ.

Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зохицуулалтыг хэрэгжүүлж ажиллахад практикт хүндрэл, бэрхшээл багагүй үүсдэг. Энэ нь ГХтХ-ийн зөрчил, хэм хэмжээний давхардал, хийдлээс үүдэлтэй байх(тухайлбал гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч байгууллага, удирдлагын эрх хэмжээний зааг, ялгаа тодорхой бус г.м/, зарим тохиолдолд хууль хэрэгжүүлэх шатны алдаа, дутагдал, мэргэжлийн бус, улс төрөөс хамааралтай, захиргааны дур зоргын шинжтэй шийдвэр гаргах ажиллагаа (тухайлбал, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдал зарлах, үүний улмаас төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, зардал өсөх г.м) -тай холбоотой.

Монгол Улсын бодлого, холбогдох хууль тогтоомжоор баталгаажсан төрийн цэргийн байгууллагын эрх зүйн байдлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа нь ГХтХ-ийн зорилготой бүрэн нийцэж байна. ГХтХ-д онцгой байдлын байгууллагыг улс төрөөс ангид байлгах, тогтвортой байдлыг хангах зорилготой бөгөөд төрийн цэргийн байгууллагын удирдлагын зарчмыг хангахад мөн эерэг нөлөө бүхий зохицуулалтууд бий. Гэвч ОББ-ын алба хаагч, удирдах албан тушаалтныг тодорхойлох, түүнд тавигдах шаардлага, эрх, үүрэг, хариуцлагын хэм хэмжээг тусгах нь зүйтэй.

Түүнчлэн гэнэтийн нөхцөл байдал (тухайлбал Ковид-19 цар тахлын үе)-ыг харгалзан ГХтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах, тодорхой хугацаанд мөрдөх хууль баталж хэрэгжүүлэх зэрэг түр зуурын шинжтэй зохицуулалт хийх замаар асуудлыг шийдвэрлэх хандлага ажиглагдаж байна. Ингэснээр тухайн нөхцөл байдал арилсан буюу энгийн, тайван цагт тэдгээр зохицуулалт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, түүний удирдлага, зохион байгуулалт, ОББ-ын үндсэн чиг үүрэгт сөргөөр нөлөөлж, хууль тогтоомжийн чанар, тогтвортой байдал алдагдахад хүргэж байна.

Онцгой байдлын байгууллагын мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагын зарчим алдагдсанаар гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, удирдлага, зохион

байгуулалт, онцгой байдлын алба, алба хаагчийн эрх зүйн байдал, иргэд, олон нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөх хандлагатай байна. Улмаар эдийн засаг, улс төр, нийгмийн олон талт харилцаанд сөрөг нөлөөллийг бий болгодог.

Онцгой байдлын байгууллага хуулиар хүлээсэн тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөц бүрдүүлэх, чадавхжуулахаас гадна алба хаагчдын үүрэг гүйцэтгэх ажиллагааны хувцас хэрэглэл, техник хэрэгсэл зэрэг ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг хангалттай хэмжээнд, зохистой эх үүсвэрээс бүрдүүлэх, ялангуяа гамшиг ослын үед цаг алдахгүйгээр, шуурхай ажиллахад хэрэгцээтэй бүх төрлийн нөөц бүрдүүлэх, ашиглах боломжоор хангахад чиглэсэн зохицуулалтыг хуульчлан батлуулах хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна. Товчоор хэлбэл онцгой байдлын албаны чадавхийг нэмэгдүүлэхэд төсөв хөрөнгө чухал атал Сангийн яам болон бусад шийдвэр гаргагчдын зүгээс ОББ-ыг бусад байгууллагатай адилтгаж төсвийн хэмнэлттэй горим баримтлах шаардлага тавьдаг байдал зохисгүй гэж үзлээ.

ОББ-ын харьяа байгууллага, салбар нэгжүүд ГХТХ болон бусад хууль тогтоомж, стандартыг мөрдөж, өөр өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэн, бүтцийн нэгжүүд нь төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын чиглэл, хуваарийн дагуу тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж байна. Тухайлбал ОББ-ын дэргэдэх орон тооны бус Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, онолын ололт амжилт, олон улсын чиг хандлага, сайн туршлага нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг.

Онцгой байдлын байгууллага, түүний харьяа салбар, нэгжтэй холбоотой зохицуулалтууд хэрэгжиж байгаа бөгөөд бүсчилсэн удирдлага, зохион байгуулалт, төсөв, санхүүжилт, түүний зарцуулалтад хүндрэл, бэрхшээл тулгамдаж байгаа боловч Онцгой байдлын бүсийн ажиллах журмыг 2025 оны 6 дугаар сард шинэчлэн баталсан нь эрх зүйн орчинд төдийгүй практикт эерэг нөлөө үзүүлнэ гэж төсөөлж байна.

Онцгой байдлын байгууллага өнөөгийн хүрсэн хөгжлийн түвшин, туршлагадаа суурилан гадаад улс оронд эрэн хайх, аврах ажиллагааг явуулах чадавхтай олон улсын дунд хэмжээний багтай болохыг зорин, олон улсын болон гадаад улсын байгууллагатай харилцаа, гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна. Олон улсын чиг хандлага, төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилт, арга хэмжээний чиглэл нь ГХТХ-д заасан онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх хангалттай үндэслэл болно.

Үндэсний болон олон улсын хэмжээнд итгэл хүлээсэн, үйл ажиллагааны чадавхтай байгууллага болон хөгжих алсын харааг дэмжсэн эрх зүйн орчин, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх чадавхийг бүрдүүлэх, бэхжүүлэх эрх зүйн байдал, хууль зүйн баталгаа нэн чухал юм.

Санал:

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч байгууллага, удирдлагын эрх хэмжээг нарийвчлан тодорхойлох, УОК ба ОБЕГ-ын бүрэн эрхтэй холбоотой хэм хэмжээний давхардал, хийдэл, зөрчлийг залруулах замаар ОББ мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчим, эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх;

- ГХтХ-ийн 42 дугаар зүйлийн 1-д “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.” гэж тусгасныг өргөжүүлж, олон улсын хамтын ажиллагаа (олон улсын болон гадаад улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах)-нд холбогдох зохист хүрээг нэмж тусгах;

- Бодлогын баримт бичигт заасны дагуу ОББ-ын салбар, нэгж нэмж байгуулах, зарим чиг үүргийн нэгжийг иргэдэд ойртуулж, нүсэр бус бүтэц, зохион байгуулалтаар ойр ойрхон зайд байршиж үйл ажиллагаа явуулдаг Япон зэрэг улсын сайн жишгийг нэвтрүүлэх, үүнд онцгой байдлын албаны онцлогоос хамаарч бусад байгууллагатай нэгэн адил төсвийн хэмнэлтийн горим баримтлахгүй байх тал дээрх анхаарах;

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон онцгой байдлын албаны онцлог, баримтлах зарчим, мэргэжлийн байх хэрэгцээ, чиг үүргийн ач холбогдлыг харгалзан гал унтраах ангитай төсөөтэй буюу онцгой байдлын байгууллагын харьяа бус холбогдох нэгжийн бүртгэл, хяналт, сахилга, хариуцлага, харилцаа ба хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх;

- ОББ-ын бүтэц, байршлын талаарх мэдээлэл ил тод, хүртээмжтэй байх зорилгын үүднээс төрийн болон албаны нууцын харилцааг зохицуулж буй хууль тогтоомж ба ОББ-ын салбарын хууль тогтоомж, дүрэм, журмын уялдаа холбоо, нийцлийг судалж, зохист хувилбараар шийдвэрлэх;

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, онцгой байдлын албаны онцлогоос хамаарч улсын төсөв, шаардагдах нэмэлт зардалд зориулсан нөөц хөрөнгийг зайлшгүй, шуурхай гаргаж байх эрх зүйн зохицуулалт тусгах, хэрэгжилтийг хангах, ГХтХ-ийн онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой, түүний дотор алба хаагчийн эрх, нийгмийн баталгаа, тэтгэмж, урамшуулалтай холбоотой зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх;

- Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаатай холбогдох бусад хэм хэмжээг хэрэгжүүлэх бодит нөхцлийг бүрдүүлж /тухайлбал холбогдох журмыг боловсронгуй болгох эсхүл хүний нөөцийг чадавхжуулах/, улсын төсөвт тусгуулах, төсвийг зарцуулах, хэрэгжилтийг хянах механизмыг сайжруулах;

- ГХтХ-ийн 42.5-д “Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.” гэж заасныг өргөжүүлж, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу гадаадын зээл, буцалтгүй тусламж, дотоодын тусламж хандив гэх мэт бусад орлогоос бүрдэх нөхцлийг тусгах;

- ГХтХ-ийн 42 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт Онцгой байдлын байгууллагын даргын албан тушаалыг орхигдуулж тусгасныг өөрчилж “Онцгой байдлын байгууллага нь дарга, тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна.” гэж томъёолох, эдгээр болон бусад удирдах албан тушаалд томилох шалгуурыг тодорхойлж хуульд тусгах;

- Онцгой байдлын байгууллагын бүсчилсэн үйл ажиллагааны зохистой байдлыг хангахад чиглэсэн шинэ журмаар томоохон хэмжээний гамшгийн үеийн удирдлага зохицуулалтыг бүсийн харьяа онцгой байдлын байгууллагуудын чадавхад түшиглэн шуурхай, оновчтой зохион байгуулах, түүнчлэн бүсчиллийн тогтолцоог Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлснээр онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах чадавхыг улсын хөгжлийн бодлого, шаардлагатай уялдуулан нэмэгдүүлэх дэвшил гарна гэсэн төсөөллийг бодитой хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх;

- ГХтХ-д заасныг хэрэгжүүлж баталсан стандартын биелэлт буюу хангалт, тухайлбал гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгслийн төрөл, хангамжаас гадна чанар, хүртээмжийн шаардлагыг хуульд тусгах замаар хэрэгжилтийг хангах;

- Олон улсын стандарт бүхий техник, багаж хэрэгслийн хэрэгцээ, шаардлагыг тооцоолох, худалдан авах, суурилуулах, аюулгүй ажиллагааг бүрдүүлэх, хангах, ашиглах, хэрэглэх, алба хаагчдыг сургаж дадлагажуулах, үүнтэй холбоотой хүний нөөц бүрдүүлэх, сургах, сургалтад хамрагдсан хугацааг онцгой байдлын албанд ажилласан жилд тооцох, суралцах хугацааны цалин хангамжийг шийдвэрлэх;

- ГХтХ-ийн 43.2-т “Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдгийн загварыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг “агентлагийн дарга батална” гэж өөрчлөх;

- ГХтХ-ийн 44 дүгээр зүйлээр тодорхойлсон “Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэг” болон тус хуулийн 29 дүгээр зүйлд тусгасан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг” гэсэн зохицуулалтыг оновчтой томъёолж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.1-д заасан хуулийн төслийн бүтэц, 28.2-т заасан хуулийн төслийн бүтэцэд тавигдах шаардлага, 28.3-т заасан хуулийн төслийн бүтцийн дарааллыг баримталж боловсронгуй болгох;

- Онцгой байдлын байгууллагын чиг үүрэг болон чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бүрэн эрхийг ялгамжтай, оновчтой тодорхойлж хуульчлах;

- Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн зорилтын хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулахад олон талын түншлэлийг өргөжүүлэхээр заасныг баримтлан, онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ бусад талын оролцоог хангах ажлыг зохион байгуулах чиг үүргийг нэмж тусгах;

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд бусад төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог бүрдүүлэхтэй холбоотой чиг үүрэг, хариуцлагатай холбоотой хэм хэмжээг нэмж тусгах;

- “Барилга байгууламжийн байршлыг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж мэргэжлийн дүгнэлт гаргах”, “Барилга байгууламжийг ашиглалтад авах улсын комиссын бүрэлдэхүүнд оролцох, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд санал, дүгнэлт гаргах”, “Барилга байгууламжийн зураг төсөлд гамшиг ослоос хамгаалагдсан эсэхэд гаргасан дүгнэлт болон магадлалд хяналт хийж шийдвэр гаргах,” зэрэг чиг үүргийг ГХтХ-д заасан онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн хүрээнд нэмж тусгах;

- ОББ нь гамшигтай тэмцэх тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмжийн нөөцтэй байх, холбогдох харилцааг тус хуулийн 29 дүгээр зүйл, эсвэл 30 дугаар зүйлд нэмж тусгах;

- Мэргэжлийн байгууллагын хувиар талуудын оролцоог зохион байгуулах, гамшгийн өмнөх үеийн ажиллагаа, гамшгаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг хувийн хэвшил, ТББ, иргэдтэй хамтран хэрэгжүүлэх, гэрээгээр гүйцэтгүүлэх, хамтын ажиллагааг зохицуулан холбох чиг үүргийг хуульд тусгах;

- Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын нэг чиглэл болох мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиг үүргийг энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд шилжүүлэх, гэрээгээр гүйцэтгүүлэх;

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэдийн сайн дурын оролцоог хангах замаар онцгой байдлын байгууллагын сургалтын төв, сургагч багш нарт сургалтын ажлыг даалгах, бодит оролцоог бүрдүүлэх, хэлбэр төдий болгох явдлаас сэргийлэх зохицуулалт тусгах;

- Гамшгаас урьдчилан сэргийлэх, тухайлбал эргүүл хийх ажилд иргэд, албанаас тэтгэвэрт гарсан хүмүүс сайн дураар оролцох, оролцоог үнэлэх, урамшуулах механизмыг бүрдүүлэх.

Дээр дурдсан зарчмын шинжтэй ерөнхий санал болон мэргэжилтэн, алба хаагчдаас өгсөн тухайлсан саналууд нь ГХтХ-д заасан онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтыг сайжруулах, эсхүл хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх мэдээлэл болно.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлын тухайд

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу, түүнчлэн ГХтХ-д тухайлан тодорхойлох хэлбэрээр онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн нэгэн адил болгон, үйл ажиллагааны онцлогт нийцүүлж бүрдүүлэх, хэрэгжүүлэх чиглэлээр нэлээд ахиц гарсан байна.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, түүний дотор онцгой байдлын алба хаагчийг тодорхойлох, эрх, үүрэг, нийгмийн баталгаа, удирдах албан тушаалтны бүрэн эрх, үүрэг, сахилга, хариуцлагын талаарх зохицуулалтыг оновчтой тусгаж, хэрэгжилтийг хангах механизмыг цогцоор нь бүрдүүлэх шаардлагатай.

Түүнчлэн төрийн цэргийн бусад байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль, тухайлбал Цагдаагийн байгууллагын тухай хууль, Хилийн тухай хуулийн зохицуулалтын зарим хувилбарыг ГХтХ-д зохистой

байдлаар тусгах бололцоотой. Үүнээс гадна Төрийн албаны тухай хуулийн шинэтгэлийн үр нөлөөг ГХтХ-д тусгаж, алба хаагчийн нийгмийн баталгаа /үндсэн болон нэмэгдэл/ хангагдах эрх зүйн үндэслэлийг ГХтХ-д суулгах боломжтой.

Онцгой байдлын алба хаагчийн эрх зүйн байдал, эрх, үүрэг, нийгмийн баталгаатай холбоотой зохицуулалтууд, тэдгээрийн хэрэгжилт нь хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой байлгах, албаны чадавхийг нэмэгдүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлж байна. Тухайлбал, Онцгой байдлын алба хаагчийн эрх, түүний дотор цэргийн мэргэжлээс бусад мэргэжил, чиглэлээр суралцах эрх хангагдахгүй байгаа нь эргээд онцгой байдлын албаны хүний нөөц, улмаар албаны чадавхийг дээшлүүлэхэд саад болж байгааг анхаарч, эрх зүйн орчинг шинэчлэх шаардлага тулгамдаж байна.

Дээрх дурдсан онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой ГХтХ-ийн зохицуулалтуудыг хэрэгжүүлэх болон цаашид хэрэгцээ, шаардлагатай харилцааг хуульчлан тусгахын зэрэгцээ төсөв, санхүүгийн баталгаат байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн орчин бүрдүүлэх, хамгийн гол нь төсвийн хэмнэлтийн горимоор хандаж, танах ёсгүй тусгай алба, онцгой харилцаа гэсэн хандлагыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу ГХтХ ба бусад хууль тогтоомж хоорондын нийцэл, уялдаа холбоог сайжруулах, ГХтХ-ийн бүтэц, төслийн эх бичвэрийн агуулга, хэлбэр, хэл зүй, найруулгад тавигдах шаардлагыг хангах тал дээр анхаарах нь зүйтэй.

Санал:

- Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлохын тулд “онцгой байдлын алба”, “онцгой байдлын алба хаагч”, онцгой байдлын албаны үйл ажиллагаа, удирдлагын зарчмыг оновчтой тодорхойлж, ГХтХ-д тусгах;

- ГХтХ-ийн 45 дугаар зүйлийн 2-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна.” гэж заасан хэсэгт Төрийн албаны тухай хуулийг нэмж тусгах;

- ГХтХ-ийн 45.4-т “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын албан тушаалд онцгой байдлын албанд 15-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг томилно.” гэж заасан нь хэл, найруулга зүйн ойлгомжгүй, салаа утгыг агуулсан байх тул онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын албан тушаалд томилогдох алба хаагчид тавигдах шалгуурыг боловсронгуй болгож, ГХтХ-ийн 45 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг оновчтой томъёолох;

- ЦАтХ-д заасны адил, Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргыг томилоход тавигдах шаардлагыг ГХтХ-д тусгах;

- Улсын нөөцийн анги, салбарын алба хаагч төрийн тусгай алба хаагч болсон тул ГХтХ-ийн 45 дугаар зүйлийн 5-д “Төрийн болон албаны нууцад

хамаарах бараа, материалыг бүртгэх, хадгалах, хамгаалах асуудал эрхэлж байгаа ажилтан нь энэ хуульд заасан алба хаагчийн нэгэн адил эрх, үүрэг хүлээж эрх зүйн баталгаагаар хангагдана.” гэж заасан хэм хэмжээ ач холбогдолгүй болсныг харгалзан хуулиас хасах;

- Онцгой байдлын алба хаагч дүрэмт хувцас хэрэглэхтэй холбоотой харилцааг хууль, журмаар сайтар зохицуулсан боловч алба хаагч тусгай зориулалтын хувцас хэрэглэх агуулга ГХтХ-д байхгүй буюу орхигдсон байгааг анхаарч, ОББ-ын алба хаагч үүрэг гүйцэтгэхдээ өмсөх тусгай зориулалтын хувцас өмсөхтэй холбогдох харилцааг ГХтХ-д тусгах, энэ ангиллын хувцасны загвар, чанар байдлыг тухайлан хэм хэмжээгээр зохицуулах;

- Онцгой байдлын алба хаагчийн хувцас /дүрэмт хувцас, тусгай зориулалтын хувцас/ ба цэргийн цолтой холбоотой хэм хэмжээг салгаж төрөлжүүлэн, тус тусдаа зүйл, хэсэг, заалт болгож хуульд тусгах;

- Онцгой байдлын байгууллагад алба хаах журмын зарим харилцаа, ялангуяа алба хаагчийн эрхийг хөндсөн, хориглолт, хязгаарлалт тавьсан хэм хэмжээг ГХтХ-д тусгах;

- Хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн таних тэмдгийн загвар, хэрэглэх журам шаардлагагүй гэж үзвэл холбогдох хэм хэмжээг ГХтХ-аас хасах.

ОББ-ын алба хаагчийн эрхтэй холбоотой санал:

- Цэргийн байгууллагын буюу онцгой байдлын байгууллагын алба хаагчийн хувьд эдлэх эрхийг нэгтгэж тусгасан нь оновчтой боловч эдгээр эрхийг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчихийг хориглох, зөрчигдсөн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг хуульд тусгах;

- Онцгой байдлын алба хаагчийн суралцах эрх, алба хаагч бэлтгэх, чадавхжуулах зорилтод нийцэхгүй эрх зүйн зохицуулалтыг өөрчилж, дэмжихэд чиглэсэн хэм хэмжээ тусгах;

- ОББ-ын алба хаагч нарын гамшгийн үед ашиглах нөөцтэй байх эрх, алба хаагчдад зориулсан нөөц, хангалтыг бүрдүүлэх үүргийг ГХтХ болон холбогдох журамд тусгаж баталгаажуулах;

- Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хэрэгжилт хангалтгүй байгааг сайжруулах хэм хэмжээг цогц байдлаар хуульчлах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах, ялангуяа сэтгэл зүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг баталгаажуулах зохицуулалтыг тусгах;

- Мэргэжил, мэргэшил, ур чадвар, ёс зүйн болон дадлага туршлагаараа албан тушаал дэвшин томилогдох эрх удирдах албан тушаалтныг томилох харилцаанд улс төрийн нөлөөллийн улмаас зөрчигдөхөөс сэргийлсэн хэм хэмжээ тусгах;

- Онцгой байдлын албанд цэргийн мэргэжлээс гадна гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, онцгой байдлын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд

шаардлагатай бусад мэргэжлийн боловсрол эзэмших, мэргэжлийн зэрэг ахиулах, мэргэжил дээшлүүлэх, үргэлжилсэн сургалтад төрийн зардлаар суралцах эрх, түүнийг хэрэгжүүлэх хэм хэмжээг тусгах;

- Онцгой байдлын алба хаагч цэргийн мэргэжлээс өөр, бусад мэргэжлээр гамшгаас хамгаалах иргэний сургуульд, гамшгийн менежмент зэрэг үндсэн чиг үүрэг, холбоо, мэдээлэл, технологи, хиймэл оюун ухаан гэх мэт чиглэлээр суралцахад эрх зүйн орчин, дэмжлэг дутмаг хэвээр байгааг анхаарч эрх зүйн орчинг сайжруулах;

- Хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажлаар явахдаа албаны унаа, хоол, хүнсээр хангагдах, албан хаагчид гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэлтэй байх хангамжийг бүрдүүлэх, гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг аймаг, орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, онцгой комиссын нөөц хөрөнгөөс шийдвэрлэх, газар орон, цаг уурын онцлогт тохирсон байдлаар дийлэнх тохиолддог гамшиг ослын төрөл тус бүрээр хангалт хийх;

- Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор шаардлагатай объектод саадгүй нэвтрэх эрхийг хэрэгжүүлэх баталгаа бүрдүүлэх;

- Гамшгаас хамгаалах улсын байцаагчийн эрхийг хуульчлах, шаардлагатай объектод саадгүй нэвтрэх эрхийг үүнд тусгах;

- “Онцгой байдлын байгууллагын алба хаагч гамшиг ослын голомтын бүсэд ажиллахдаа гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох зорилгоор тэмдэглэл, илтгэх хуудас бичих, гар зураг үйлдэх, гэрэл зураг авах, дууны-дүрсний бичлэг хийх болон бусад шаардлагатай арга хэмжээ авах” эрхийг ГХтХ-ийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 3 дахь заалт болгож нэмэх;

- “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагч шаардлагатай тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламжийг өмчийн хэлбэр үл харгалзан, бүх шатны эрүүл мэндийн байгууллагаас дараалал харгалзахгүйгээр авах эрх”-ийг тухайлан нэмж тусгах;

- “Эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрснөөр цэргийн мэргэжлийн боловсрол олгох дипломын, бакалаврын, магистрын, докторын болон давтан, мэргэжил дээшлүүлэх сургалтад төрийн зардлаар суралцах эрхтэй” гэж заасан зохицуулалтад онцгой байдлын албанд хамаарах мэргэжлийн боловсролыг нэмж тусгах.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүрэгтэй холбоотой санал:

- Цэргийн байгууллагын буюу онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргийг нэгтгэж тусгасан нь оновчтой боловч хэрэгжүүлж ажиллах нөхцөл, бололцоог бүрдүүлэх арга хэмжээг хуульд тусгах;

- ГХтХ-ийн 48.1.1-д заасан гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, оролцох үүрэг; 48.1.2-т заасан аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд сахих, байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх үүрэг онцгой байдлын алба хаагчид хүлээлгэвэл зохих үүрэг бөгөөд хэрэгжүүлэхэд алба хаагчдыг сургаж бэлтгэх, чадваржуулах асуудал, ГХтХ-ийн 48.1.3-т заасан хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах үүргийн хэрэгжилт нь бусдаас буюу гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагад оролцогч байгууллагуудаас, төсөв санхүүгээс ихээхэн хамааралтай байгааг анхаарч, шаардлагатай хэм хэмжээг хуульд тусгах.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой санал:

- Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, онцгой байдлын алба хаагчаар ажиллах мэргэжлээр суралцсан, уул уурхайн аврах алба, улсын нөөцийн албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагын генерал, офицер, ахлагч, байлдагчаар төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцох ;

- ГХтХ-ийн 49 дүгээр зүйлийн 2-т “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино.” гэж заасан боловч хэрэгжээгүй зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Шадар сайд, Зам тээврийн сайдын хамтарсан тушаал батлах, эсхүл Онцгой байдлын ерөнхий газрын дарга Нийслэлийн нийтийн зам тээврийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулж хэрэгжилтийг хангах¹⁴¹; “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино.” гэснийг “Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот доторх нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино” гэж өөрчилж хамрагдах алба хаагчдын хүрээг өргөжүүлэх, түүнчлэн 49.2 дахь хэсгийг “Онцгой байдлын алба хаагчид олгох тэтгэвэр, тэтгэмж” гэсэн 49 дүгээр зүйлд бус, “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа” гэсэн 50 дугаар зүйлд хамааруулж тусгах.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой санал:

- Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг

¹⁴¹ ОББ-ын алба хаагчийн санал

онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно гэж заасан зохицуулалтад улсын нөөцөд ажилласан хугацааг тооцох;

- Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, онцгой байдлын алба хаагчаар ажиллах мэргэжлээр суралцсан, уул уурхайн аврах алба, улсын нөөцийн албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагын генерал, офицер, ахлагч, байлдагчаар төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцох;

- Онцгой байдлын албаны зарим ажлын байр хүнд, хортой нөхцөлд багтсаныг харгалзаж ажилласан хугацааг тооцохоор хуульд тусгах / Аврагч-гал сөнөөгч г.м/, хил хамгаалах байгууллагын зохицуулалттай уялдуулах, жишээлбэл өдрийн 8 цагаар албан үүрэг гүйцэтгэдэг алба хаагч баяр, амралтын өдрүүдэд/ /хагас,бүтэн сайн өдрүүдэд/ орон нутгийн онцлогтой холбогдуулан үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд ажилласан баяр амралтын, хагас, бүтэн сайн өдрүүдийн амралтыг биеэр эдлүүлэх (Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу) гэх мэт уян хатан зохицуулалт хэрэгжүүлэх;

- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйг нөхөн сэргээх эмчилгээний урт, богино хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэх, зардлыг төрөөс хариуцах;

- ГХтХ-ийн 50.4 дэх хэсгийг “Онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, ой, хээрийн түймэр, халдварт өвчин, цар тахлын голомт, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд тухайн байгууллагын тодорхойлсон баримт, бичгийг үндэслэж үнэ төлбөргүй хамрагдана” гэж нэмэлт, өөрчлөлт оруулж тусгах;

- ГХтХ-ийн 50.4 дэх хэсэгт заасан нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд алба хаагч үнэ төлбөргүй хамрагдахаар зохицуулах;

- Онцгой байдлын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах талаар тусгагдаагүйг харгалзан ГХтХ-ийн 50 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт онцгой байдлын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах, үүнтэй холбогдох зардлыг онцгой байдлын байгууллагын төсөвт тусгаж байх тухай заалт нэмэх;

- ГХтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.5-д заасан онцгой гавьяа байгуулсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл гэснийг “50-100 дахин” гэж өөрчлөн, урамшууллын доод хэмжээг тогтоох гэх мэт урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх саналыг үе шаттай хэрэгжүүлэх хувилбарыг тодорхойлох;

ГХтХ-ийн 50.5-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно.” гэж заасны “олгож болно” гэснийг “олгоно” гэж өөрчлөх, мөнгөн урамшууллын доод хязгаарыг тусгах;

- Эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх тохиолдолд олгох мөнгөн урамшууллыг 2015 онд батлагдсан журмын дагуу олгож байгааг өөрчилж, 2017 онд

батлагдсан ГХтХ-ийн дагуу журмыг шинэчлэн батлах, улмаар төсвийг бууруулахгүй байх, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлж батлах замаар хэрэгжилтийг анхаарах;

- Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд алба хаагчийг заавал даатгуулах хэмжээний доод хязгаар тавих, зардлыг төр хариуцна гэж өөрчлөх;

- Онцгой байдлын байгууллагын алба хаагч ажил үүргээ гүйцэтгэж байгаад хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд ажилласан жилээс шалтгаалан нийгмийн даатгалийн сангаас олгосон цалингийн зөрүү хувь хэмжээг ажил олгогчоос олгох;

- Албан үүрэг гүйцэтгэх үеэр учирч болзошгүй эрсдэлээс сэргийлж алба хаагчийн эрүүл мэнд, амь насанд даатгалын тогтолцоог сайжруулах;

- Анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн үед болон энгийн үед иргэдийн хайхрамжгүй байдлаас үүдэн гарсан дуудлага, мэдээлэл дэх ОББ-д хамаарах дуудлагын хариу арга хэмжээг тухайн иргэн бүрэн эсхүл тодорхой хувийг хариуцахаар, эсхүл ийм шинж чанартай дуудлагыг бусад /хувийн байгууллагад үлдээх, даатгалаар зохицуулах зэрэг/ хувилбараас сонгож зардал шийдүүлэх замаар төрийн байууллагаас гарах зардлыг бууруулах;

- Онцгой байдлын байгууллагын мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгохдоо бусад цэргийн байгууллагын адил шалгалтгүйгээр, зөвхөн ажилласан жилийг харгалзаж мэргэшлийн зэргийг олгодог байх, онцгой байдлын алба хаагчид мэргэшлийн зэрэг олгох үндэслэл, шалгуур, процессыг оновчтой тодорхойлж практикт нийцүүлэх, хэрэгжилтийг хангах цогц асуудлыг анхаарах;

- “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиас доошгүй байна” гэснийг “50 хувиас доошгүй байна” гэж өөрчлөх зэргээр нэмэгдлийн хэмжээг өсгөх саналыг харгалзан үзэх;

- ГХтХ-ийн 50.10-т “Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн харьяалалгүй алба хаагчийг томилон ажиллуулбал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг улирал тутамд олгоно.” гэснийг “Алслагдсан” гэдэг үгийг хасах, тухайн алба хаагч төрийн үйлчилгээ авахын тулд томилогдсон аймгийнхаа хаягт шилжих шаардлага гардаг учир нэмэгдэл олгох харилцаанд үндсэн захиргааг үндэслэх саналыг харгалзан үзэх;

- Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний, аймгийн төв /сум/-д ажилладаг онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тус тус олгоно гэж ялгамжтай болгож өөрчлөх саналыг судалж шийдвэрлэх;

- “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно” гэснийг “Улаанбаатар хотоос 500 км алслагдсан аймаг, суманд тасралтгүй тав болон

түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно” гэж тодорхой өөрчлөлт оруулах хувилбарыг судалж шийдвэрлэх;

Монгол Улсын Хилийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлгийн 39.7-д “Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн салбарт 50 хувь, суурин бус газарт байрладаг хилийн цэргийн ангид 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн цэргийн ангид 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно” гэх заалтыг дүйцүүлэн тусгах хувилбарыг судалж шийдвэрлэх;

- ОББ-ын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах, холбогдох зардлыг төрөөс хариуцах; ОББ-ын алба хаагч албан үүргээ биелүүлж явах үедээ эрүүл мэнд хохирсон тохиолдолд үзлэг оншилгоо, нөхөн сэргээх эмчилгээний зардлыг төрөөс хариуцах; Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 45, 80, 95 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно гэж хэмжээг нэмэгдүүлж өөрчлөх саналыг харгалзан үзэх;

- ГХтХ-ийн 50.12-д “Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно.” гэж заасан хэсгийг тус хуулийн “Онцгой байдлын алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмж” хэсэгт нэгтгэх;

- Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно.” гэж заасан хэсэгт улсын нөөцийн албанд ажилласан хугацааг нэмж тусган онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцох;

- ГХтХ-ийн 50.14 дэх зохицуулалтад онцгой байдлын албанд хамаарах мэргэжлийн сургуульд суралцсан хугацааг ажилласан жилд оруулж тусгах.

Дээр дурдсан судалгааны үндсэн дээр дэвшүүлсэн зарчмын шинжтэй ерөнхий санал болон мэргэжилтэн, алба хаагчдаас өгсөн тухайлсан саналууд нь ГХтХ-д заасан онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой зохицуулалтыг сайжруулах, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх мэдээлэл болно.

ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙД

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа зохион байгуулах, мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагаар хангах, онцгой байдлын байгууллага чиг үүргээ зүй зохистой хэрэгжүүлэх чадавхитай байх, хүний нөөц зэрэг бүх талын нөөц бүрдүүлэх хэрэгцээ, шаардлагыг хангаж ажиллахад зардал ихээхэн шаардагдана. Иймд гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, тусгай албаны онцлогийг харгалзан төсөв хуваарилалтад хэмнэлтийн горим тулгахгүй байх, хөрөнгө хуваарилах, санхүүжилтийн олон талт хэлбэрийг бүрдүүлэх, зарцуулалтыг хянах зэрэг зүй зохистой нөхцөл бүрдүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн Х бүлэгт гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн үндэс, эх үүсвэр, хуваарилалт, хариуцах субъектүүдийг тодорхойлсон зохицуулалт тусгагдсан бөгөөд энэхүү бүлэгт туссан 51 дүгээр зүйл нь хууль тогтоомжийн түвшинд тодорхой тоон үзүүлэлт, хувь хэмжээг заасан цөөн жишээний нэг юм.

Монгол Улс төрийн байгууллага, орон нутгийн захиргаа, хуулийн этгээдэд тодорхой хувь хэмжээний (1.0%, 1.5%) санхүүгийн үүрэг ногдуулсан нь гамшгаас хамгаалах санхүүжилтийг тогтмол, төлөвлөгөөт байдлаар баталгаажуулах чухал алхам болсон. Гэсэн ч хэрэгжүүлэх явцад дараах сул тал практикт ажиглагдаж байна. Үүнд:

1. Хатуу тогтоосон хувь хэмжээ уян хатан бус байдал

Аймаг, сум, дүүрэг, хуулийн этгээдэд нэг төрлийн хувь хэмжээ (1.0%, 1.5%) тогтоосон нь бүс нутгийн эрсдэлийн ялгаа, байгууллагын санхүүгийн боломжийг харгалзсан зохицуулалт биш юм. Үүний дүнд бага орлоготой орон нутгууд, жижиг аж ахуйн нэгжүүдэд дарамт үүсэх, эсвэл хийсвэр төлөвлөлт хийх зэрэг эрсдэлтэй үр дагавар үүсэх магадлал бий.

2. Хэрэгжилтийн хяналтгүй байдал

Судалгаанд оролцсон төрийн байгууллагын ажилтнуудын хэлж байгаагаар, төсвийн ангилал, санхүүгийн системд гамшгаас хамгаалах зориулалт бүхий 1.0% зардлыг суулгах тусгай ангилал байхгүй, мөн гүйцэтгэлд нь хяналт тавих, үнэлэх механизм тодорхой бус байна. Хувийн хэвшлийн хувьд ч уг 1.5%-ийн хэрэгжилтийг хянадаг бодит хяналтын тогтолцоогүй байна.

3. Эрсдэлийн ялгамжтай үнэлгээ тусгагдаагүй байдал

Гамшгийн эрсдэлийн түвшин нь бүс нутгийн болон салбарын онцлогоос хамаарч харилцан адилгүй байдаг. Гэтэл хуулиар бүх засаг захиргааны нэгж, орон нутагт болон нийт хуулийн этгээдэд ижил хувь хэмжээг ногдуулсан нь нөөцийн оновчгүй хуваарилалт үүсгэх, өндөр эрсдэлтэй бүс нутаг дорвитой хөрөнгө оруулалт авахгүй байх нөхцөл болдог байх магадлалтай.

4. Санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал.

Санал:

1. Хувь хэмжээг уян хатан, эрсдэлийн түвшинд тулгуурласан байдалтай болгох: Эрсдэл өндөртэй бүс нутаг, салбарт илүү өндөр хувь, эрсдэл багатай орчинд доогуур хувь тогтоох санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх;
2. Хяналт, тайлагналын механизм бий болгох: Төсөвт туссан гамшгийн зардлын ангиллыг Сангийн яамны төсвийн системд тусгайлан ангилж, тайлагнах шалгуур, зарцуулалтад тавих хяналтын стандарт бий болгох;
3. Уян хатан зардлын бүтэц төлөвлөх: Түргэн хариу өгөх боломжтой тусгай сан (орон нутгийн болон улсын түвшинд), хуримтлал бүхий механизм нэвтрүүлж, ашиглалтын журмыг ил тод, хариуцлагатай болгох;
4. Салбар хоорондын төлөвлөлт, хамтын оролцоог нэмэгдүүлэх: Гамшгийн эрсдэлийг бууруулахад зөвхөн тухайн байгууллагын бус, салбар дундын төлөвлөлт, санхүүжилтийн хороо эсвэл зөвлөл ажиллуулах боломжийг судлах;
5. Эдийн засгийн нөхцөлд нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлэх хандлага: Хувийн хэвшлийн 1.5%-ийн заалтыг тодорхой шалгууртайгаар хэрэгжүүлж эхлэх, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зөөлөвчилсөн хувилбар санал болгохыг онцолж байна.

Түүнчлэн энэхүү судалгааны хүрээнд тандан судалсан гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн жишиг бүхий улс орнууд (БНСУ, Япон улс, ХБНГУ, БНТУ)-ын зохицуулалтаас нутагшуулах боломж, бололцоо бий эсэхийг харгалзан үзэх нь зүйтэй.

4.2.Зөвлөмж

Гамшгаас хамгаалах тухай хуулийг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх, үндэсний хууль тогтоомжийн нийцэл, уялдаа холбоог сайжруулах, төслийн бүтэц, хэлбэр, хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагаас гадна агуулгад тавигдах нийтлэг шаардлага, тухайлбал Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх; тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан, хуулийн хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх; хуулийн зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх; бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол эш татах, тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх шаардлагыг хангах хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.2-т тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол; 25.1.4-т тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт

гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай бол хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахаар заасныг үндэслэн гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, түүний удирдлага, зохион байгуулалт, түншлэлийн харилцааны зохицуулалтыг боловсронгуй болгох, онцгой байдлын алба, онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдлыг цогцоор нь тодорхойлох, хэрэгжих боломжтой, харилцан уялдаатай хэм хэмжээг тусгах байдлаар Гамшгаас хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй гэж үзэв.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, тодорхой шалгуур үзүүлэлтэд үндэслэсэн дүгнэлт, үнэлгээ; эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох ажилд дэмжлэг үзүүлэх санал, зөвлөмж; эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүд, онцгой байдлын байгууллагын алба хаагчдын үзэл бодлыг нэгтгэн дүгнэх, өмнө судлагдсан үр дүнг тусгах, судлагдаагүй орон зайг хөндөх зэрэг бүтээлч хандлага нь хууль зүйн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлж, эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ хэмээн найдаж байна.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 1963.
3. Эрүүгийн хууль, 2016, №7;
4. Эрүүл мэндийн тухай хууль,
5. Гамшгаас хамгаалах тухай хууль,
6. Галын аюулгүй байдлын тухай хууль,
7. Иргэний хууль, 2002.
8. Боловсролын ерөнхий хууль, 2023.
9. Дайчилгааны тухай хууль, 1998.
10. Онц байдлын тухай хууль, 1995.
11. Авто замын тухай хууль, 2017.
12. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 2002.
13. Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль, 2008.
14. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, 1997.
15. Эрчим хүчний тухай хууль, 2001.
16. Төмөр замын тээврийн тухай хууль, 2023.
17. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016.
18. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2019.
19. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995.
20. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, 2020.
21. Ард нийтийн санал асуулгын тухай хууль, 2016.
22. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012.
23. Аялал жуулчлалын тухай хууль, 2023.
24. Татварын ерөнхий хууль, 2019.
25. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2019.
26. Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль, 2016.
27. Зөрчлийн тухай хууль, 2017.
28. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017.
29. МУ-ын 2016 оны Төсвийн тухай хууль, 2015.
30. МУ-ын 2023 оны Төсвийн тухай хууль, 2022.
31. МУ-ын батлан хамгаалах тухай хууль, 2016.
32. МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, 2020
33. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2023.
34. Сонгуулийн тухай хууль, 2015 /хүчингүй болсон./
35. Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоол, Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө.
36. Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Журам, жагсаалт, хуваарь батлах тухай 286 дугаар тогтоол.
37. Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолын хавсралт, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр.
38. Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолын хавсралт, Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам.
39. Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 182 дугаар тогтоолын хавсралт, Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам.

40. Засгийн газрын 2018 оны 327 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Гамшгийн зэрэглэл тогтоох журам.
41. Засгийн газрын 2018 оны 327 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт.
42. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Дугаар 190 тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”;
43. 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 40 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм”;
44. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Дугаар 120 тушаал
45. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Дугаар 226 тогтоол
46. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Дугаар 340 тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”
47. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Дугаар 339 тогтоолын хавсралтаар баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”
48. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Дугаар 182 тогтоол
49. Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолын хавсралт, Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө.
50. Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 03 дугаар сарын 12-ны Маягт, заавар батлах тухай 22 дугаар тушаал.
51. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 03 дугаар сарын 13-ны Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам, Дугаар 24.
52. Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 15 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах улсын алба, тэдгээрийн түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллагын жагсаалт, чиг үүрэг”, “Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”, “Гамшгаас хамгаалах улсын албаны штабын бүтцийн загвар”.
53. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/379 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан мэргэжлийн ангийн дүрэм.

Гадаад хэл дээр

1. Ministry of Public Safety and Security (Korea). (2022). *Framework Act on the Management of Disasters and Safety*. https://climate-laws.org/documents/framework-act-on-the-management-of-disasters-and-safety_75e7?id=framework-act-on-the-management-of-disasters-and-safety_2137
2. Law No. 5902 on the establishment and duties of the Disaster and Emergency Management Authority https://climate-laws.org/document/law-no-5902-on-the-establishment-and-duties-of-the-disaster-and-emergency-management-authority_0a39

3. Gesetz über den Zivilschutz und die Katastrophenhilfe des Bundes (Act on Federal Civil Protection and Disaster Assistance), Germany, 1997 https://disasterlaw.ifrc.org/media/3441?language_content_entity=de
4. National Land Agency, Japan. Disaster Countermeasures Basic Act, https://climate-laws.org/documents/disaster-countermeasures-basic-act-405c?id=disaster-countermeasures-basic-act_d638

Ном сурах бичиг, судалгааны тайлан, өгүүлэл

Монгол хэлээр

1. Гамшгийн нэр томъёоны тайлбар толь, Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэн, (УБ, 2012).
2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын баримт бичиг, (Бүх шатны төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогчдод зориулсан гарын авлага), ОБЕГ, 2023.
3. Ц.Цогт, Б.Буянхишиг, Б.Нинжин, Б.Дөлгөөн, Г.Давааням, М.Нинжбадгар, Хуулиар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох эрхийг захиргааны байгууллагад шилжүүлэх заалтын хүрээ хязгаар, хууль, хэм хэмжээний актын харилцан хамаарлыг тодорхойлох онолын харьцуулсан судалгаа, 2023.
4. Гамшгийн эрсдэлийн удирдлага бүх шатны Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, Гамшгаас хамгаалах албадын бүрэлдэхүүнд зориулсан гарын авлага, ОБЕГ, 2023.
5. Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, (УБ, 2017 он).
6. Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо: хөгжлийн хандлага, (УБ, 2013 он).
7. Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл, (УБ, 2022 он).
8. Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, (УБ, 2023 он).

Гадаад хэлээр

1. Report of the open-ended intergovernmental expert working group on indicators and terminology relating to disaster risk reduction, Un General Assembly, 1 December 2016, A/71/644, Accessed 4 May 2025, https://www.preventionweb.net/files/50683_oiewgreportenglish.pdf
2. United Nations Office for Disaster Risk Reduction (UNDRR), 2017, The Sendai Framework Terminology on Disaster Risk Reduction, "Disaster", Accessed 4 May 2025. <https://www.undrr.org/terminology/disaster>.
3. UN/ISDR. Geneva 2004. World Conference on Disaster Reduction 18-22 January 2005, Kobe, Hyogo, Japan, Hyogo Framework for Action 2005-2015: I S D R International Strategy for Disaster Reduction International Strategy for Disaster Reduction www.unisdr.org/we/in/ia Building the Resilience of Nations and Communities to Disasters.

Цахим эх сурвалж

1. No natural disasters, UNDRR, Accessed 4 May 2025, <https://www.undrr.org/our-impact/campaigns/no-natural-disasters>, see also

- <https://www.undrr.org/news/sendai-framework-6th-anniversary-time-recognize-there-no-such-thing-natural-disaster-were>.
2. TERMIUM Plus®, the Government of Canada's terminology and linguistic data bank, <https://open.canada.ca/data/en/dataset/94fc74d6-9b9a-4c2e-9c6c-45a5092453aa>
 3. United Nations Office for Disaster Risk Reduction (UNDRR). 2017. The Sendai Framework Terminology on Disaster Risk Reduction. "Preparedness". Accessed 6 May 2025. <https://www.undrr.org/terminology/preparedness>.

Бусад

1. 2025.04.22, 2025.04.29, 2025.05.15-ны өдөр ОБЕГ-ын албан тушаалтан, алба хаагчдаас авсан ярилцлага
2. ОБЕГ-ын бүтцийн нэгж, салбар байгууллага, түүний алба хаагчдын санал
3. ОББ-ын алба хаагчдаас асуумжийн дагуу цуглуулсан мэдээлэл